

# Байгаль орчин, нийгмийн менежментийн хүрээ

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ХОЛБОЛТ БА ЛОГИСТИКИЙГ  
САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ (P174806)

1.

## ГАРЧИГ

1. ТОВЧ ХУРААНГУЙ.....	4
2. УДИРТГАЛ.....	6
Төслийн суурь мэдээлэл.....	6
БОНМХ-ны зорилго болон цар хүрээ.....	6
Төсөл хэрэгжүүлэх зохион байгуулалт.....	16
3. БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭ.....	17
Монгол Улсын холбогдох хууль тогтоомжууд.....	17
Дэлхийн банкны байгаль орчин ба нийгмийн стандартууд.....	20
Монгол Улсын хууль тогтоомж болон Дэлхийн банкны байгаль орчин, нийгмийн стандарт хоорондын зөрүүтэй байдалд хийсэн дүн шинжилгээ.....	22
4. БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН СУУРЬ СУДАЛГАА.....	25
Байгаль орчны суурь судалгаа.....	25
Байгаль орчны одоогийн нөхцөл байдал, томоохон асуудлууд.....	29
Нийгмийн суурь мэдээлэл.....	41
Хүн ам, хөдөөгийн хөгжил.....	41
Эмзэг байдал ба жендэрийн асуудал.....	43
Жендэрт суурилсан хүчирхийлэл.....	45
Төрийн үйлчилгээний хүртээмж.....	46
Тээврийн үйлчилгээ.....	47
Замын аюулгүй байдлын асуудлууд.....	47
Ковид-19.....	49
5. БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ БА БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ.....	49
Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ.....	49
Уур амьсгалын өөрчлөлт.....	49
Байгаль орчинд үзүүлэх нөлөө.....	51
Нийгэмд үзүүлэх ашиг тус.....	58
6. ТӨСЛИЙН БҮХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ.....	67
7. ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА МЭДЭЭЛЛИЙГ НЭЭЛТТЭЙ БАЙЛГАХ.....	73
8. ТАЛУУДЫН ОРОЛЦОО БА ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ МЕХАНИЗМ.....	75
Олон нийтэд мэдээлэх.....	75
Талуудын оролцоо.....	75
Гомдол шийдвэрлэх механизм.....	78
10. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЛТИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАРИУЦАХ ИНСТИТУЦИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	82

Төсөл хэрэгжилтийн зохион байгуулалт: чиг үүрэг, хариуцлага.....	82
Чадавхыг бэхжүүлэх.....	84
Диаграмм 1. Дэд төслийн байгаль орчин, нийгмийн менежментийн журам.....	67
Диаграмм 2. Төслийн санал болгож буй өргөдөл, гомдол барагдуулах механизм.....	78
Диаграмм 3. Оролцогч талуудыг тодорхойлох.....	133
График 1. 2019 онд Монгол Улсын хэмжээнд ширгэсэн болон сэргэсэн усны эх үүсвэрийн тоо.....	33
График 2. 2020 онд Монгол Улсын хэмжээнд ширгэсэн болон сэргэсэн усны эх үүсвэрийн тоо. (Улбар шар өнгөөр ширгэсэн болон эх булаг алдагдсан, хөх өнгөөр сэргэсэн усны эх үүсвэрийг тэмдэглэсэн болно).....	34
График 3. Монгол улсын газар нутаг дахь нуурийн эзлэх хэмжээ, тоон динамик.....	35
График 4. Монгол Улс дахь авто замаас шалтгаалсан үхэл.....	46
График 5. Хүлэмжийн хийн ялгарлын суурь болон зорилтот хувилбарын харьцуулсан үзүүлэлт.....	47
Зураг 1. Монгол Улсын Зам тээврийн холболт ба ложистикийг сайжруулах төсөл.....	11
Зураг 2. Ургамлын төрлүүд.....	23
Зураг 3. Агаар дахь нүүрсхүчлийн хийн агууламж (CO <sub>2</sub> ).....	27
Зураг 4. Агаарын жилийн дундаж температурын өөрчлөлт ААТ (1981-2010 дундаж ААТ). 28	
Зураг 5. Цаг агаарын гамшгийн давтамж.....	28
Зураг 6. Цасны зузаан, 2019 оны 1-р сарын 31-ний байдлаар.....	29
Зураг 7. Цасны зузаан, 2020 оны 1-р сарын 31-ний байдлаар.....	30
Зураг 8. Зудын эрсдэлийн зураг 2019 оны 11-р сарын 20-ны өдрийн байдлаар.....	30
Зураг 9. Зудын эрсдэлийн зураг 2020 оны 11-р сарын 20-ны өдрийн байдлаар.....	31
Зураг 10. Монгол Улсын малын тоо 1970-2020 онуудад. Статистикийн ерөнхий хороо.....	31
Зураг 11. 2020-2021 оны өвөл, хаврын бэлчээрийн даа.....	33
Зураг 13. Хангайн бүсийн ой модонд малын бэлчээрийн үзүүлж буй нөлөөлөл (НҮБ-ын REDD хөтөлбөр 2017).....	38
Зураг 14. Малын бэлчээрээс үүдэн ойн гүнд үзүүлэх дарамт (UN-REDD 2017 хөтөлбөр).....	38
Хүснэгт 1. Төсөлд хамааралтай Монгол Улсын холбогдох хуулиуд.....	16
Хүснэгт 2. Төслийн холбогдох Байгаль орчин, нийгмийн стандартууд.....	17
Хүснэгт 3. Байгаль орчин ба нийгмийн бодлогын зөрүүтэй байдалд хийсэн дүн шинжилгээ .....	19
Хүснэгт 4. Соёлын үнэт өв, соёлын болон шашны дурсгалт газрын жагсаалт.....	24
Хүснэгт 5. Озоныг задлагч бодисын гидрохлорфтор нүүрстөрөгчийн импорт, 2015-2020..	26
Хүснэгт 6. Монгол Улсын тусгай хамгаалалттай газрын ангилал.....	32
Хүснэгт 7. 2019, 2020 онуудын нийт усны хэрэглээ.....	33
Хүснэгт 8. 2020 оны байдлаарх хүн ам, өрхийн мэдээлэл.....	38
Хүснэгт 9. 2020 оны байдлаарх өрхийн мэдээлэл.....	40

Хүснэгт 10. Монгол Улсын аюулгүй байдлын хийт үзүүлэлтүүд.....	44
Хүснэгт 11. Хүлэмжин хий ялгарлын анализ.....	48
Хүснэгт 12. Шинэ замын хүлэмжийн хийн хэмжээ буурах тооцоолол.....	48
Хүснэгт 13. ХАБЭА-ны болзошгүй нөлөөлөл, тэдгээрийг бууруулах арга хэмжээ.....	54
Хүснэгт 14. Биет хөрөнгө оруулалт, техник туслалцааны байгаль орчин, нийгмийн эрсдэлийн урьдчилсан үнэлгээ.....	64
Хүснэгт 15. Төслийн хасалтын жагсаалт.....	67
Хүснэгт 16. Нийтийн хэлэлцүүлэгийн бүртгэлийн хүснэгт.....	69
Хүснэгт 17. Оролцогч талуудын олон нийтийн хэлэлцүүлэгийн уулзалтын жишээ товъёог .....	71
Хүснэгт 18. Оролцогч талууд ба үүрэг.....	73
Хүснэгт 19. Удирдлагын чиг үүрэг, хариуцлага.....	79
Хүснэгт 20. БОНМХ-ны хариуцах институцын чиг үүрэг, хариуцлага.....	80
Хүснэгт 21. Төслийн хэрэгжилтийн эхэнд зохион байгуулах аюулгүй байдлын сургалтын хураангуй.....	82
Хүснэгт 22. Монгол Улсын хууль тогтомж болон Дэлхийн банкны албадан нүүлгэн шилжүүлэлтийн шаардлага хоорондын харьцуулалт.....	91
Хүснэгт 23. Хөдөлмөрийн гомдол барагдуулах хүчин төгөлдөр үйлчилж буй зохицуулалт .....	124
Хүснэгт 24. Оролцогч талуудыг тодорхойлох.....	130
Хүснэгт 25. Төсөл хэрэгжиж эхлэх үед явагдах үеийн аюулгүй байдлын сургалтын хураангуй.....	141
Хүснэгт 26. Байгаль орчны нийгмийн менжментийн хүрээ /БОНМХ/-г гаргахад чадваржуулах сургалт.....	141
Хүснэгт 27. БОНМТ-нд чиглэсэн чадваржуулах сургалтын төлөвлөгөө.....	143

## 2. ТОВЧ ХУРААНГУЙ

**Төслийн хөгжлийн зорилго нь (ТХЗ)** нь нь Монгол Улсын махны өртгийн сүлжээн дэх тээврийн холболтын уур амьсгалд тэсвэртэй байдал, ложистикийн үр ашгийг сайжруулах юм.

Төсөл нь дөрвөн бүрэлдэхүүнтэй.

**Бүрэлдэхүүн 1: Дэд бүтцийн хөрөнгө оруулалт (тооцоолсон нийт өртөг: 80 сая ам. доллар; Олон улсын Сэргээн босголт, Хөгжлийн банкны [ОУСБХБ] зээл 70 сая ам. доллар, Олон Улсын хөгжлийн ассоциацийн зээл 10 сая.ам доллар)**

Махны өртгийн сүлжээнд хамаарах дэд бүтцийн хязгаарлалтад анхаарсан, энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь илүү үр ашигтай махны нийлүүлэлтийн сүлжээг бий болгох тээврийн холболтыг сайжруулна. Хөрөнгө оруулалт болон арга хэмжээ нь мал болон махны тээврийн урсгал төвлөрсөн *аймгуудад* чиглэнэ. Арга хэмжээнүүд нь сонгогдсон *аймгуудын* хамгийн сүүлд гаргасан улсын чанартай авто замын сүлжээний Авто замын олон улсын тэгш бус байдлын индекс (IRI) дээрхи үзүүлэлт дээр тулгуурлана.<sup>1</sup> Мөн, махны өртгийн сүлжээн дэх дутуу холболтыг гүйцээх хамгийн сүүлийн бээрийн холболтод анхаарлаа хандуулах болно. Энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь төслөөс гадна урт хугацааны үр ашгийг бий болгох зорилготой засгийн газрын тээврийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, менежментийн үйл ажиллагааны нэг хэсэг болгон хэрэгжүүлэх үндэсний авто замын үндсэн хөрөнгийн менежментийн (АЗҮХМ) хүрээг боловсруулахад дэмжлэг үзүүлнэ. Одоо байгаа 51 км шороон замыг хатуу хучилттай болгон сайжруулах ба сайжруулах ажлын төрөлд далан, ухмал, суурь, хоолой, шуудуу, хучилтын ажлууд орно.

**Бүрэлдэхүүн 2: Тээвэр, ложистикийн үйлчилгээ (тооцоолсон нийт өртөг: 50 сая ам. доллар; ОУСБХБ-ны зээл: 28 сая ам. доллар, дотоодын санхүүжилт 2 сая ам.доллар, арилжааны санхүүжилт 20 сая. ам.доллар )**

Бүрэлдэхүүн хэсэг нь ложистикийн үр ашгийг дээшлүүлэх үйлчилгээний талыг хөгжүүлэх зорилготой. ЗТХЯ нь биет холболт болон ложистикийн үйлчилгээг хоёуланг нь шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд, энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь олон жилийн турш байсаар байгаа ложистикийн зарим нэг хүндрэлийг шийдвэрлэх гарц юм. Бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалт нь бэлэн бус байдал, нөөцийн хязгаарлалт гэх мэт цар хүрээ, хэмжээний хувьд хязгаарлагдмал байна. Гэсэн хэдий ч, эдгээр арга хэмжээ нь ЗТХЯ-с АХБ, Японы Олон улсын Хамтын ажиллагааны Агентлаг, Европын Сэргээн босголт Хөгжлийн Банктай хамтран ажиллаж байгаа ба авто зам, агуулах, ачаа тээвэртэй холбогдох томоохон арга хэмжээнд дэмжлэг болох болно.

**Бүрэлдэхүүн 3: Техникийн тусламж ба чадавхыг бэхжүүлэх (тооцоолсон нийт өртөг: 2 сая ам. доллар; ОУСБХБ зээл: 2 сая ам. доллар)**

Энэ бүрэлдэхүүн нь ерөнхий төлөвлөгөө, техникийн зураг төсөл, зохистой засаглалын үнэлгээ, санхүүжилт/ТХХТ-ийн хувилбарууд, ТЭЗҮ, ложистикийн төвүүдийн тендерийн баримт бичгүүд зэрэг шаардлагатай бэлтгэл ажлуудад анхаараал хандуулах ба техникийн зураг төсөл, холимог тээврийн үйл ажиллагаа, экспортын ложистикийн бизнесийг хөгжүүлэх, институцийг хөгжүүлэх, тээвэр, ложистикийн үйлчилгээ, системийг сайжруулах чадавхыг бэхжүүлэх зэрэг стратегийн болон техник эдийн засгийн судалгаанууд багтана.

**Бүрэлдэхүүн 4: Болзошгүй Онцгой байдлын үед авах Арга Хэмжээний Бүрэлдэхүүн (CERC) (нийт өртөг: 0 ам.доллар)**

Энэ бүрэлдэхүүн нь байгалийн гамшгийн үед үндэсний болон бүсийн хэмжээнд онц байдал зарлах, эсвэл гамшгийн дараа засгийн газраас албан ёсны хүсэлт гаргасны үндсэн дээр үүсэж болох болзошгүй

<sup>1</sup> 2019 онд ЗТХЯ болон Зам Тээврийн Хөгжлийн Төв хамтран, улсын хэмжээнд хатуу хучилттай авто замын сүлжээний IRI үнэлгээг гүйцэтгэсэн. 2021 оны зургадугаар сард, АЗЗАК-с муу, маш муу IRI оноотой хээрийн замын үнэлгээг нэмж гүйцэтгэсэн.

онцгой байдлын эрсдэлийн санг 0 төсөвтэйгөөр байгуулна. Тээвэр, хөдөө аж ахуй/махны салбар дахь бараа, үйлчилгээг шуурхай санхүүжүүлэх шаардлага гарсан үед, бусад бүрэлдэхүүн хэсгүүд дэх төслийн хөрөнгийг дахин хуваарилах боломжтой. Боломжит үйл ажиллагаанд авто замын дэд бүтцийг цэвэрлэх, нөхөн сэргээх, төслөөр тодорхойлогдсон эсвэл дэмжигдсэн бүсийн ложистикийн төвүүдийн дэд бүтэц, шаардлагатай материалыг худалдан авах зэрэг орно. Онцгой байдлын үед авах арга хэмжээний хавсралтыг Төслийн Үйл ажиллагааны Гарын авлагад (ТГА) оруулах бөгөөд хэрэгжүүлэлтийн зохицуулалтыг тусгасан, үүнд, идэвхжүүлэх үйл ажиллагаа, хэрэгжүүлэгч агентлагуудын үүрэг, хариуцлага, санхүүжүүлэх боломжтой арга хэмжээний жагсаалт, БОН-н асуудал ба фидуцийн гэрээ орно. Монгол Улсын Засгийн газраас тодорхойлсон хямрал эсвэл онцгой байдал нь шаардлага хангахаар бол уг төслийн хүрээнд холбогдох арга хэмжээнд хамруулах хүсэлтийг Дэлхийн Банкнд гаргаж болно. Ийм нөхцөлд, нэмэлт үйл ажиллагаанд шаардлагатай бүх БОН-н хэрэгслүүдийг бэлтгэж илгээх шаардлагатай бөгөөд Дэлхийн Банкнаас зөвшөөрөл авна.

Төслийн байршил. Төсөл Монгол Улсын Увс, Төв, Өвөрхангай, Архангай, Булган Хөвсгөл, Хэнтий, Сүхбаатар аймгуудад төсөл хэрэгжинэ.

**Байгаль орчин, нийгмийн болзошгүй нөлөөлөл, эрсдэл:** Төслийн гол эрсдлүүдийг дараах үйл ажиллагаанд үндэслэн тодорхойлсон. Үүнд: (i) одоо байгаа 311 км замын засвар арчлалттай холбоотой эрсдлүүд; (ii) 51 км сүүлийн бээрийн холболтын замын шинэчлэлтэй холбоотой эрсдэл; ба (iii) Өвөрхангай аймагт байгуулах жишиг логистикийн төв байгуулахтай холбоотой эрсдэл. Төсөлд Дэлхийн банкны Байгаль орчин, Нийгмийн Хүрээг хэрэгжүүлэх ба БОНС9-с бусад Байгаль орчин ба Нийгмийн стандартууд (БОНС)-ыг нь энэ шатанд хамааралтайгаар авч үзнэ.

Барилга угсралтын явцад гарч болзошгүй тоосжилт, чимээ шуугиан, бохирдол/барилгын хог хаягдал, хөрсний элэгдэл болон шингэн гоожих, ажилчид болон иргэдэд үзүүлэх ХАБЭА-н нөлөөлөл, замын хөдөлгөөн болон замын аюулгүй байдал, зэрлэг ан амьтдад учирч болзошгүй нөлөөлөл, газарт нэвтрэх болзошгүй хязгаарлалт, , замын болон материалын нөөцийн талбайтай ойролцоо амьдардаг иргэдийн амьжиргаанд үзүүлэх нөлөөлөл, үндэстний цөөнхөд үзүүлэх болзошгүй нөлөөлөл, бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл (БМХ) /бэлгийн дарамт (БД)-тай холбоотой эрсдэл, соёлын өвд үзүүлэх болзошгүй нөлөөлөл, тодорхой бүлгүүдийн оролцоог хангах болон оролцогч талуудын оролцоотой холбоотой эрсдэл зэрэг нь байгаль орчин ба нийгмийн эрсдэлүүд (БОНЭ) юм. Эдгээр эрсдэлүүд нь байршлын онцлогоос шалтгаалсан, түр зуурын шинжтэй ба эрсдэлийг үе шатлалтайгаар бууруулах, удирдах боломжтой. Ложистикийн төвийн ашиглалтын явцад байгаль орчин, нийгмийн эрсдэлүүд нь усны бохирдол, агаарын бохирдол, дуу чимээ, хог хаягдал, ХАБЭА-н эрсдэл зэрэг сөрөг нөлөөллийг байгаль орчинд үзүүлэхээр байгаа бөгөөд төслийн хэрэгжилтийн үр нөлөө нь урт хугацаанд байна. Техникийн туслалцаа (ТТ)-ын үйл ажиллагаанууд нь дэд бүтцийн боломжит хөрөнгө оруулалттай холбоотой бөгөөд байгаль орчин, нийгмийн эрсдэлийг эдгээр бүх үйл ажиллагааны Ажлын даалгаварт тусгах шаардлагатай болно.

Одоо байгаа замын засвар арчлалт, сүүлчийн бээрийн холболтын шинэ замын барилгын ажил, жишиг төвийн байгуулалт, техникийн туслалцаа, болзошгүй, онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний бүрэлдэхүүн (БОБҮАХАБХ) хэсгийн үйл ажиллагаанаас гадна дотоодын хууль тогтоомж болон Дэлхийн банкны Байгаль орчин, Нийгмийн хүрээг (БОНХ)-нд нийцсэн хамаарах аливаа байгууламжууд зэрэг төслийн бүх үйл ажиллагаануудыг хамарсан Байгаль орчин ба Нийгмийн Менежментийн арга хэрэгсэл болгон энэхүү Байгаль орчин, Нийгмийн Менежментийн Хүрээг боловсруулав.

**Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ.** Төслийг Дэлхийн банкны БОНХ дагуу боловсруулж Байгаль орчны эрсдэлийн үнэлгээ нь “өндөр”, нийгмийн эрсдэлийн үнэлгээ нь “өндөр” буюу ерөнхий үнэлгээгээр Байгаль орчин, Нийгмийн Эрсдэлийн үнэлгээ нь “өндөр” гэж тодорхойлов.

**Байгаль орчин, нийгмийн эрсдэл болон түүний нөлөөллийг удирдах институцын чадавхи:** Зам, тээврийн хөгжлийн яам (ЗТХЯ) нь энэ БОНМХ-нд БОНМТ, Хөдөлмөрийн харилцааг зохицуулах журам (ХХЗЖ), Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ), Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын хүрээ (НШБХ)

зэрэг баримт бичгийг БОНХ-ний шаардлагуудын дагуу төсөлд зориулан боловсруулсан. Төслийг хэрэгжүүлэгч байгууллага нь ЗТХЯ байна. ЗТХЯ-ны доор байгуулагдах Төслийн удирдлагын алба (ТУА) нь төслийг хэрэгжүүлэх өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангаж ажиллана. ТУА нь төслийн БОНХ-нд тусгагдсан ажлуудыг зохистой хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцөөр хангаж ажиллана.

### 3. УДИРТГАЛ

#### Төслийн суурь мэдээлэл

1,564 сая хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт 3.2 сая гаруйхан хүн амьдардаг Монгол Улсын хүн амын нягтрал нь нэг хавтгай дөрвөлжин километрт 2.1 хүн ногдох юм. Хүн амын тал орчим хувь нь буюу 1.4 сая орчим хүн нийслэл Улаанбаатарт төвлөрөн суудаг. Хүн амын үлдсэн хэсэг нь жижиг хот суурин эсвэл өргөн уудам тал нутагт хонь, ямаа, адуу, үхэр, сарлаг, тэмээ хариулан тархан суурьшсан. Монгол Улсын хэмжээнд 233,000 өрх 70 гаруй сая малтай ба нийт хүн амын бараг 30 гаруй хувь нь уламжлалт нүүдлийн мал аж ахуй эрхэлж эмзэг амьжиргаатай амьдрах ба орлогын цорын ганц эх үүсвэр нь мал аж ахуй юм. Хөдөө орон нутагт өөр ажил хийх боломж хомс. (InfraSAP, 2020)

Ядуурлын түвшин хот суурин газарт 23,2 хувьтай бол хөдөө орон нутагт 35.5 хувьтай байна. Хөдөөгийн ядуу иргэд нь сийрэг, тархан суурьшсан, алслагдмал зайд нүүдэллэдэг эсхүл цөөхөн өрх айлаас бүрдсэн сумын төвд оршин суудаг иргэд байна.

Газар нутгийн байршил, бүтээн байгуулалтын ажлын өндөр өртөг зардал хавсарсан санхүүжилтийн дутагдалтай байдлаас шалтгаалан нийгмийн үйлчилгээ болон зам зэрэг суурь дэд бүтэц маш муу нөхцөлд байна. Энэ нөхцөл байдал нь зах зээлээс алслагдмал, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ хангалтгүй, орлого олох боломж хязгаарлагдмал хөдөөгийн иргэдэд томоохон асуудал үүсгэдэг.

Олон малчин өрх мал маллаж аж төрөхөөс өөр ямар ч боломж байхгүй нөхцөлд бэлчээрт эсхүл багийн хооронд эрсдэлтэй нөхцөлд амьдардаг. КОВИД-19-ийн мал аж ахуйн салбарт үзүүлж буй нөлөөллийг одоогоор тооцох боломжгүй байгаа ба үр нөлөө нь одоо ч үргэлжилсээр байна. Албан ёсоор үнэлгээ хийгдээгүй боловч олон улсын байгууллага, эрдэмтдийн ажиглалтаар малын өртгийн сүлжээнд ноцтой тасалдал үүсэх, малын хөдөлгөөний хязгаарлалт нэмэгдэх, байгалийн нөөц ашиглалттай холбоотой үр дагавар ихтэй зөрчил нэмэгджээ.

Ядуурлыг бууруулах зорилгоор тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг дэмжих, хот, хөдөөгийн хүн амд тэгш боломжийг олгох “Монгол Улсын Зам, тээврийн холболт ба логикийг сайжруулах төсөл” нь Монгол Улсын стратегийн ач холбогдолтой өртгийн сүлжээний зам тээврийн холболт, логикийн үр ашгийг дээшлүүлж, замын дэд бүтцийн үндсэн хөрөнгийг хүргэх, арчлах, удирдах ЗТХЯ-ны институцын чадавхыг бэхжүүлэхэд оршино.

#### БОНМХ-ны зорилго болон цар хүрээ

Энэхүү БОНМХ нь санал болгож буй хөрөнгө оруулалтын дэд төслүүдийн үйл ажиллагаанаас гарч болох байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, эрсдэлийг удирдан зохион байгуулах, хянах үйл явц, зарчим, дүрэм, журмууд удирдамжуудыг багтаан тайлбарласан болно. Дэд төслийн загвар нь төсөл хэрэгжих явцад нарийвчлан тодорхойлогдох ба энэхүү хүрээ нь цаашид дэлгэрэнгүй боловсруулагдах дэд төслүүдийн сөрөг нөлөө ба эрсдэлүүдийг багасгах, арилгах, дүйцүүлэн нийцүүлэх байгаль орчин ба нийгмийн нөлөөллийг бууруулах арга хэмжээ, төлөвлөгөөг боловсруулсан.

Хүрээ нь дэд төслийн болон төслийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх Монгол Улсын хуулиуд, байгаль орчин ба нийгмийн удирдлагын журмууд, Дэлхийн банкны БОНС, БОНХ-ын сайн туршлагуудын тэмдэглэл болон Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа (БОЭМАА)-ны удирдамжуудыг тодорхойлсон. Энэ нь хэрэгжихүйц, тогтвортой, нийгмийн хариуцлагатай төслийн загвар болон хэрэгжилтийг хангахын тулд хуулиуд, стандартууд, удирдамжуудыг зайлшгүй дагаж мөрдөх



шаардлагатай хариуцагч байгууллагуудын институцын арга хэмжээнүүд болон чадавхыг сайжруулах хүрээг тодорхойлж өгсөн.

КОВИД-19-н хязгаарлалтын улмаас БОНМХ-г боловсруулах явцад гол оролцогч талуудтай цахимаар хэлэлцүүлэг өрнүүлсэн ба гол оролцогч талуудтай биечлэн уулзалт зохион байгуулах, олон нийтийн хэлэлцүүлэг хийх боломжгүй байв.

Тайлангийн үндсэн агуулга нь:

- Тайлангийн хураангуй
- Удиртгал
- Бодлого, хууль эрх зүйн орчин
- Байгаль орчин, нийгмийн суурь судалгаа
- Байгаль орчин ба нийгмийн болзошгүй нөлөөлөл, бууруулах арга хэмжээ
- Байгаль орчин ба нийгмийн нөлөөллийг шийдвэрлэх журмууд
- Олон нийтийн хэлэлцүүлэг, мэдээллийг нийтэд ил болгох
- Талуудын оролцоо, өргөдөл гомдлыг барагдуулах
- Төслийн хэрэгжилтийн зохион байгуулалт, үүрэг хариуцлага ба чадавхыг бэхжүүлэх төлөвлөгөө

Энэхүү тайланд төслийн тухайлсан нөлөөллийг бууруулах болон төлөвлөлтийн баримт бичгүүд нэмэлтээр багтсан болно. Үүнд:

- Болзошгүй байгаль орчин, нийгмийн асуудлыг шалгах маягт
- Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын хүрээ
- Хөдөлмөрийн харилцааг зохицуулах журам
- Талуудын оролцоог хангах төлөвлөгөө
- Байгаль орчин, нийгмийн чадавхыг бэхжүүлэх төлөвлөгөө
- Тухайлсан талбайн Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөний (ESMP) маягт
- Зам засварын ажлын туршлыгын Байгаль орчин, нийгмийн дүрэм
- Замын хөдөлгөөний удирдлагын төлөвлөгөө

### **Төслийн хөгжлийн зорилгын тодорхойлолт**

Төсөл хөгжүүлэлтийн зорилго нь Монгол Улсын махны өртгийн сүлжээн дэх тээврийн холболтын уур амьсгалд тэсвэртэй байдал, ложистикийн үр ашгийг сайжруулах юм.

### **Төслийн хөгжлийн зорилгын түвшний шалгуур үзүүлэлтүүд**

Төслөл хөгжүүлэлтийн зорилгын биелэлтийг дараах үзүүлэлтүүдээр хэмжинэ (дэлгэрэнгүйг Үр дүнгийн хүрээнд тусгав).

### **Сайжруулсан холболт**

- 1) Төслийн коридороор зорчих хугацаа, дэд-үзүүлэлт нь улсын чанартай авто зам дагуух коридороор болон орон нутгийн авто замаар зорчих хугацааг хэмжинэ.

### **Сайжруулсан ложистик**

- 2) Тодорхойлогдсон коридоруудын ложистикийн зардал

### **Сайжруулсан уур амьсгалд тэсвэртэй авто замын холболт**

- 3) Төслийн коридор дагуух уур амьсгалд тэсвэртэй авто замыг ашиглах боломжтой зорчигчид (%)

## Байгууллагын амлалтын үзүүлэлт: иргэдийн оролцоо ба жендэр

- 1) Сонгогдсон тээврийн коридор дагуух зам тээвэр, ложистикийн дэд бүтэц болон холбогдох үйлчилгээний судалгаанд хамрагдсан авто замын хөдөлгөөнд оролцогчдын сэтгэл ханамж
- 2) Тээвэр, ложистикийн платформоор дамжуулан шилжүүлэг, захиалга өгсөн малчин эмэгтэйчүүд.

Санал болгож буй Монгол Улсын Тээврийн холболт, ложистикийг сайжруулах төсөл нь махны өртгийн сүлжээн дэх ложистикийн зардлыг үүсгэгч гурван гол хүчин зүйл болох биет холболт, стратегийн байршил, үр ашигтай ложистикийн төвүүдийн дутагдалтай байдал, нийлүүлэлтийн сүлжээнд оролцдог төрөл бүрийн оролцогчдын хоорондох мэдээллийн тэгш бус байдлыг шидвэрлэх багц арга хэмжээнээс бүрдэнэ.

### Төсөл дөрвөн бүрэлдэхүүнтэй:

**Бүрэлдэхүүн 1: Дэд бүтцийн хөрөнгө оруулалт (тооцоолсон нийт өртөг: 80 сая ам. доллар; ОУСБХБ-ны зээл 70 сая ам. доллар; Олон Улсын хөгжлийн ассоциацийн зээл 10 сая ам доллар)**

Махны өртгийн сүлжээнд хамаарах дэд бүтцийн хязгаарлалтад анхаарсан, энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь илүү үр ашигтай махны нийлүүлэлтийн сүлжээг бий болгох тээврийн холболтыг сайжруулна. Хөрөнгө оруулалт болон арга хэмжээ нь мал болон махны тээврийн урсгал төвлөрсөн *аймгуудад* чиглэнэ. Арга хэмжээнүүд нь сонгогдсон *аймгуудын* хамгийн сүүлд гаргасан улсын чанартай авто замын сүлжээний Олон улсын Авто замын тэгш бус байдлын индекс (IRI) дээрхи үзүүлэлт дээр тулгуурлана.<sup>2</sup> Мөн, махны өртгийн сүлжээн дэх дутуу холболтыг гүйцээх хамгийн сүүлийн-бээрийн холболтод анхаарлаа хандуулах болно. Энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь төслөөс гадна урт хугацааны үр ашгийг бий болгох зорилготой засгийн газрын тээврийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, менежментийн үйл ажиллагааны нэг хэсэг болгон хэрэгжүүлэх үндэсний авто замын үндсэн хөрөнгийн менежментийн (АЗҮХМ) хүрээг боловсруулахад дэмжлэг үзүүлнэ.

Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд санхүүжүүлэх үйл ажиллагааг дор жагсаав:

**Дэд-бүрэлдэхүүн 1.1: Стратегийн сүлжээний гол хэсгүүдэд үр дүнд-суурилсан засвар арчлалт хийх.** Энэхүү дэд-бүрэлдэхүүн нь муу буюу маш муу нөхцөлтэй 311 км авто замын засвар, арчлалтын ажлыг санхүүжүүлнэ.

Авто зам	Чиглэлийн Код	Ээлжит засвар хийх авто замын хэсэг (км)	Шинэчлэлт хийх авто замын хэсэг (км)
Улаанбаатар-Авайхээр	A0301	46	37
Улаанбаатар-Өдөрхаан	A0501	77	27
Хархорин-Цэцэрлэг	A0602	13	19
Булган-Мөрөн	A0902	0	25
Тосонцэнгэл-Цэцэрлэг /Архангай/	A0603	40	10
Арвайхээр-Баянхонгор /Өвөрхангай/	A0302	0	35
<b>Нийт</b>			<b>311 км</b>

<sup>2</sup> 2019 онд ЗТХЯ болон Зам Тээврийн Хөгжлийн Төв хамтран, улсын хэмжээнд хатуу хүчилттай авто замын сүлжээний IRI үнэлгээг гүйцэтгэсэн. 2021 оны зургадугаар сард, АЗЗАК-с муу, маш муу IRI оноотой хээрийн замын үнэлгээг нэмж гүйцэтгэсэн.

Үр дүнг хэмжихдээ нотолгоонд-суурилсан засвар үйлчилгээний төлөвлөлт ба төсвийн хуваарилалт, шийдвэр гаргахад туслах хөрөнгө оруулалтын стратеги төлөвлөгөө, авто замын хөдөлгөөнд оролцогчдын хариу үйлдэл үзүүлэх хэмжигдэхүүнтэй уялдуулна. Санал болгож буй үйл ажиллагаа нь сонгогдсон *аймгуудыг* холбосон стратеги сүлжээний холбоосыг жилийн турш холбоотой байлгахын тулд муу болон маш муу нөхцөлтэй авто замын холбоосыг засварлах буюу нөхөн сэргээх юм. Үйл ажиллагааны зорилго нь сүлжээний хүртээмж ба аюулгүй байдлыг сайжруулах, улсын чанартай авто замын хөрөнгийг хадгалан хамгаалахад оршино. Эдгээр авто замуудыг маш анхааралтайгаар сонгосон бөгөөд махны төвлөрөлтэй *аймгуудыг* холбох үндэсний сүлжээний гол хэсэг юм. Арга хэмжээ нь дараах түвшний үйл ажиллагаануудтай:

- *Өвлийн болон цаг агаарын хүнд нөхцөл зориулсан засвар арчлалт* - хэт хүйтэнд бэлдэх, хүчтэй салхи, шавар болон үертэй тэмцэх үйл ажиллагаа.
- *Онцгой байдалд авах хариу хэмжээ* – нүх бөглөх, нөхөөс хийх, зөрчлийг арилгах, замын хөдөлгөөний менежмент.
- (iii) *Авто замын арчлалт* – жижиг засвар, ус зайлуулах суваг цэвэрлэх, бараа материалын менежмент, замын тэмдэг, тэмдэглэгээ арчлах зэргийг багтаасан мөчлөг бүхий авто замын арчлалт.
- *Төлөвлөсөн шинэчлэлтүүд* - ус орохоос урьдчилан сэргийлэх, ус зайлуулах сүвгийг сайжруулах, дахин битүүмжлэх, ослоос хамгаалах саадыг арчилж хамгаалах арга хэмжээ.

**Дэд-бүрэлдэхүүн 1.2: Орон нутгийн малчдад зориулсан хамгийн сүүлийн-бээрийн холболт.** Энэхүү дэд-бүрэлдэхүүн хэсэг нь хамгийн сүүлийн бээрийн холболтыг сайжруулахад авах арга хэмжээний нэг бөгөөд нэн тэргүүний ач холбогдол бүхий орон нутгийн 51 км орчим авто замыг шинэчлэх ажлыг санхүүжүүлнэ.

Авто зам	Нарийвчилсан Зураг төслийн Бэлэн байдал	Урт (км)
Архангай аймгийн Булган сум	Үгүй	35.0
Өвөрхангай аймгийн Есөнзүйл сум	Үгүй	16.0
<b>Нийт</b>		51.0

Энэ ажил нь одоо байгаа 51 км байгалтын хөрсөн замыг хатуу хучилттай болгон сайжруулах ба сайжруулах ажлын төрөлд далан, ухмал, суурь, хоолой, шуудуу, хучилтын ажлууд орно. Энэ нь малчдыг улсын чанартай авто замын сүлжээтэй холбодог орон нутгийн авто замыг сайжруулах үйл ажиллагаа юм. Монгол Улсын мах нийлүүлэх сүлжээний хүрээнд, энэхүү эцсийн шат нь малчдын амьжиргааг хязгаарлах гол хүчин зүйл болохоос гадна бүх сүлжээний хувьд буюу оператор, боловсруулагч, тээвэрлэгч, жижиглэн худалдаалагч, экспортлогчдын хувьд ч мөн маш чухал юм. Дэлхийн Банк нь зохих арга хэмжээг сонгоход хэрэглэгдэх, бага ачаалалтай орон нутгийн авто замд олон шалгуураар шийдвэр гаргах хүрээг<sup>3</sup> боловсруулсан. Зарим арга хэмжээнд хэвтээ ба босоо шугамыг сайжруулах, аюулгүй байдлыг сайжруулах, ус зайлуулах хоолой байрлуулах ажил, хучилтыг

<sup>3</sup> Дэлхийн банк Хатуу хучилттай байх уу эсвэл Үгүй юу: Хатуу хучилт тавих Сонголтод Системтэй Шийдвэр Гаргах Хүрээг Хөгжүүлэх нь, Хөдөөгийн авто зам, Хөдөлгөөн, Тээврийн Холболтын Цуврал (Вашингтон хот, ДС: Дэлхийн банк, 2021 он).

бэхжүүлэх эсвэл дахин битүүмжлэх зэрэг орно.

**Дэд-бүрэлдэхүүн 1.3: Авто замын хөрөнгийн менежмент.** Энэхүү дэд бүрэлдэхүүн хэсэг нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүссэн шинэ сорилтуудад нийцэх авто замын дэд бүтцийн хөрөнгийн менежментийн төлөвлөгөө болон шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх тогтолцоог боловсруулах, замын барилга, засварын хөрөнгийн үндэсний стандарт, норм зэрэг техникийн стандартуудыг шинэчлэх ажлыг санхүүжүүлнэ. Үүнд одоогоор хөгжүүлэлтийн шатанд явж байгаа хязгаарлагдмал ажиллагаатай авто замын тооллогын систем<sup>4</sup> болон мэдээллийн санг ашиглана. Уг системийг Дэд-бүрэлдэхүүн 1.1 ба 1.2 -т хамаарах авто замын хөрөнгийг хүргэх, арчлан хамгаалах ажиллагааг хэрэгжүүлэхэд ашиглана. Энэ нь төслийн дараа ч гэсэн тогтвортой байдалд хувь нэмэрээ оруулах болно.

**Бүрэлдэхүүн 2: Тээвэр, ложистикийн үйлчилгээ (тооцоолсон нийт өртөг: 50 сая ам. доллар; ОУСБХБ-ны зээл 28 сая ам. доллар, дотоодын санхүүжилт 2 сая ам.доллар, арилжааны санхүүжилт 20 сая ам.доллар)**

Бүрэлдэхүүн хэсэг нь ложистикийн үр ашгийг дээшлүүлэх үйлчилгээний талыг хөгжүүлэх зорилготой. ЗТХЯ нь биет холболт болон ложистикийн үйлчилгээг хоёуланг нь шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд, энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь олон жилийн турш байсаар байгаа ложистикийн зарим нэг хүндрэлийг шийдвэрлэх гарц юм. Бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалт нь бэлэн бус байдал, нөөцийн хязгаарлалт гэх мэт цар хүрээ, хэмжээний хувьд хязгаарлагдмал байна. Гэсэн хэдий ч, эдгээр арга хэмжээ нь ЗТХЯ-с АХБ, Японы Олон улсын Хамтын ажиллагааны Агентлаг, Европын Сэргээн босголт Хөгжлийн Банктай хамтран ажиллаж байгаа бусад арга хэмжээнд дэмжлэг болох болно, үүнд: авто зам, агуулах, ачаа тээвэртэй холбогдох нийтийн тээврийн томоохон хөрөнгө оруулалт хийх.


Бүрэлдэхүүнд дараах үйл ажиллагаа орно:

**Дэд-бүрэлдэхүүн 2.1: Бүсийн жишиг ложистикийн төв.** Дэд-бүрэлдэхүүн нь бүсийн жишиг ложистикийн төвийг байгуулах үйл ажиллагааг санхүүжүүлнэ. Ложистикийн үйл ажиллагаанд зориулан зохих ёсоор загварчилсан “hub-and-spoke” тохиргоотой байгууламж дутагдалтай байгаа хязгаарлалтыг шийдвэрлэх болно. Бүсийн төв нь махны өртгийн сүлжээний нөөц боллоцоог хязгаарлаж буй хуваагдмал байдлыг арилгах хадгалах агуулахтай, нэгдсэн байгууламжаар хангаж, жилийн турш өндөр чанартай махыг Улаанбаатар хотын зах зээлд нийлүүлэх боломжийг олгоно. Арга хэмжээ нь одоогоор бүтээгдэхүүний чанарыг ихээхэн алдагдахад хүргэж буй температурын хяналтын механизмгүй, бага оврын, хэсэгчлэн ачсан ачааны машинуудын хэрэгцээг багасгах юм.

Эцсийн дүнд, Монгол Улс бүтээгдэхүүний чанар, тоо хэмжээ, найдвартай байдлыг тогтвортой байлгах асуудлыг шийдвэрлэсний дараа, дотоодын болон экспортын зах зээлийг хөнгөвчлөх зорилгоор, нийт hub-and-spoke сүлжээг дэмжих стратеги ач холбогдол бүхий байршилтай төвүүдтэй байх шаардлагатай. Найман стратеги байршил нь энэхүү холбогдсон зам болон төвүүдийн сүлжээний нэг хэсэг юм. Хэрхэн ажиллахыг харуулах зорилгоор, Өвөрхангай аймаг дахь бүсийн төвийг энэ төслийн хүрээнд санхүүжүүлж, Улаанбаатар хотын дотоодын зах зээлтэй шууд холбох юм. Байршил, ачаалал, холболт зэрэг Монгол Улсын Засгийн газрын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан олон шалгуурыг харгалзан сонгосон болно.

---

<sup>4</sup> АХБ-ны Техникийн Туслалцаа-9544, ЗТХЯ болон Авто тээврийн хөгжлийн төв дэх улсын чанартай авто замын хөрөнгийн засвар арчлалтын төлөвлөлт, хэрэгжилт, эрэмбэлэлтийг сайжруулах зорилгоор авто замын хөрөнгийн менежментийн системийг сэргээн байгуулж байгаа бөгөөд Колорадо мужийн Их сургуулиас боловсруулсан Paver™ нэртэй хучилтын үйлчилгээний менежментийн системийг нэвтрүүлэх туршилтын шатандаа явж байна (АХБ, “Монгол Улс ба Азийн Хөгжлийн Банк хоорондын Зээлийн Гэрээ: Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл”, 2018 оны 7-р сарын 23, <https://www.adb.org/sites/default/files/project-documents/48186/48186-005-lna-en.pdf>).



Зураг 1. Монгол Улсын Зам тээврийн холболт ба ложистикийг сайжруулах төсөл

Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд санхүүжүүлэх үйл ажиллагааг дор жагсаав. Үүнд:

- Төв доторх 4–5 км орчим зам
- Ачааны машины зогсоол
- Оффис, нийтийн байр зэрэг туслах үйлчилгээний зориулалттай байгууламж
- Үндсэн эрчим хүч, хатуу хог хаягдлыг хаях, усан хангамж
- МХХТ-ийн хүртээмж
- Монгол Улсын Засгийн газрын нэгэнт эзэмшиж буй газрыг ашиглах. (28 га орчим талбайг үе шаттайгаар хөгжүүлэх)

Жишиг бүсийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ) схемийн дагуу ажиллуулах буюу, Монгол Улсын Засгийн газар дээр дурдсан үндсэн дэд бүтцээр хангах, харин агуулах, хөлдөөх байгууламжийг хувийн хэвшил барьж, жилийн турш хөлдөөсөн бүтээгдэхүүнийг эрэлт хэрэгцээний дагуу зах зээлд тээвэрлэх орчин үеийн ачаа тээврийн үйл ажиллагааг эрхлэх юм. Хувийн хэвшлийг төслийн үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийг бий болгох гүйцэтгэлд суурилсан гэрээнд үндэслэн сонгох бөгөөд өрсөлдөөнийг дэмжих хүрээнд төвийг нээлттэй зарчмаар ажиллуулах шаардлагатай юм.

Бэлтгэл ажлыг гүйцэтгэх, төслийн барилгын ажлын талбайн авах болон бэлтгэх, дотоодын хэрэглээнд ашиглах зам, инженерийн шугам сүлжээ зэрэг суурь үндсэн дэд бүтцийг хөгжүүлэх, байгууламжийн хийц бүтээцүүдийг барьж байгуулах, ложистикийн төвийг удирдан ажиллуулахад хяналт тавих, төвийг тодорхойлсон стандарт, гүйцэтгэлийн гол шалгууруудын дагуу үйл ажиллагааг удирдан чиглүүлэхэд гэрээлэгч байгууллага нь ЗТХЯ байна. Бэлтгэл ажил нь төслийн Бүрэлдэхүүн 3-аар дамжуулан хэрэгжих тул Дэлхийн банк нь худалдан авалт, хэрэгжилтын явцад байгаль орчин, нийгмийн зохих стандартуудыг мөрдөж ажиллахыг баталгаажуулах ба эдгээр стандартуудыг дагаж мөрдөх нь хувийн хэвшлийн концесс эзэмшигчийн концессын гэрээ, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийн нэг хэсэг байна. Эрсдэл, хариуцлагын хуваарилалтын хураангуйг дараах хүснэгтэд нэгтгэв.

#### ТХХТ-ийн эрсдэл ба хариуцлагын хуваарилалт

	Төр	Хувийн хэвшил
--	-----	---------------

<b>Төслийн бэлтгэл</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Арилжааны гүйлгээг бэлтгэх, үүнд зах зээлийн үнэлгээ хийх, ТХХТ-ийн түншийг тодорхойлох</li> <li>2. Мал нядалгааны газруудаас урьдчилан маркетинг хийх, сонирхлоо илэрхийлэх</li> <li>3. ТХХТ-ын тендерийн баримт бичиг, гэрээг боловсруулах.</li> <li>4. Өрсөлдөөнт тендерийн зохион байгуулах.</li> </ol>	
<b>Газар</b>	Газрын болон замын зурвас газрын эзэмшигчийн эрхийг баталгаажуулах.	
<b>Туслах зам</b>	Туслах замыг санжүүжилтээр хангах, барих.	
<b>Ашиглалтын байгууламжууд</b>	Мэдээлэл, харилцаа холбооны технологи, цахилгаан эрчим хүч, бохир усны байгууламжийг санхүүжүүлэх, барих	
<b>Мах боловсруулах, агуулахын тоног төхөөрөмжүүд</b>		Мах боловсруулах, агуулахын байгууламжийн зураг төсөл боловсруулах, санхүүжүүлэх, барих
<b>Үйл ажиллагаа, засвар арчлалт (O&amp;M)</b>	Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүдэд хүрэхийг баталгаажуулахын тулд O&M гүйцэтгэлийг хянах	Ложистикийн O&M гүйцэтгэх Conducting O&M гүйцэтгэх, үүнд мал нядалгааны газар, худалдаачидийн нийлүүлэлт, гэрээг удирдах.

Жишиг бүсийн ложистикийн төв нь Дэлхийн Банкнаас хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслүүдэд хувь нэмэр оруулна. Тодруулбал, Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх Төсөл (хэрэгжиж байгаа) болон Хөдөө аж ахуйн Кластер Төсөлд (2023 оны санхүүгийн жилд хэрэгжүүлэхээр бэлтгэж байгаа) малын эрүүл мэндийг сайжруулах арга хэмжээ авснаар бүсийн төвүүдийн хангамжийн эх үүсвэрийг сайжруулна.

**Дэд-бүрэлдэхүүн 2.2: Ложистик ба нийлүүлэлтийн сүлжээний платформ.** Энэхүү дэд-бүрэлдэхүүн хэсэг нь махны нийлүүлэлтийн сүлжээн дэх мэдээллийн тулгуур болох дижитал нийлүүлэлтийн сүлжээний платформыг хөгжүүлэх, нэвтрүүлэх ажлыг санхүүжүүлнэ.

Төсөл нь дижитал платформын бизнесийн болон үйл ажиллагааны төсөөлөл, загвар зэргийг харгалзан үзэж, тохирох платформыг худалдан авах болно. Суурь түвшинд, платформ нь нийлүүлэлтийн сүлжээний гол оролцогчид болох малчид, агуулахын операторууд, тээвэрлэгчид, засгийн газрын гол нэгжүүд, дуудлага худалдаачид, жижиглэнгийн худалдаачид, бөөний худалдаачид, экспортлогчдод хүртээмжтэй байх ёстой.<sup>5</sup> Энэхүү платформ нь ЗТХЯ-с хариуцах олон нийтэд нээлттэй ложистикийн мэдээллийн платформын үүрэг гүйцэтгэх боловч, үйл ажиллагааны хэлтэс, судалгааны хүрээлэнгүүд, программ хангамж хөгжүүлэгчид, ложистикийн компаниуд болон бусад талуудтай хамтран хөгжүүлсэн.

**Дэд-бүрэлдэхүүн 2.3: Нийлүүлэлтийн сүлжээнд инновацийг нэвтрүүлэх туршилтын төслүүд.** Дижитал ложистикийн интеграцчилал нь, гараар хийх ажлыг эрс багасгахын зэрэгцээ, ложистикийн үйл явц, тээврийн маршрутыг оновчтой болгох шинэ арга замыг нээж өгдөг. Мөн нийлүүлэлтийн сүлжээгээр дамжин өнгөрөх барааны урсгалыг бодитоор хянах боломжийг олгодог. Үүний үр дүнд, дижитал технологийн интеграцлал нь ложистикийн зардлын үр ашигтай байдлыг дээшлүүлэх асар их боломжийг олгож, эдийн засгийн бодит цаг хугацаанд тулгуурласан бизнесийн шинэ загваруудыг бий болгох боломжийг олгох юм. Дэд-бүрэлдэхүүн нь зарим нэг үр ашиггүй байдлыг арилгах шинэ

<sup>5</sup> Дэлхийн банкны дэмжлэгтэй Хятад дахь Logink платформтой адил, нийлүүлэлтийн сүлжээний үр ашгийг дээшлүүлэхийн тулд өөр өөр оролцогчдод мэдээлэл авах боломжийг олгодог.

технологийн боломжийг ашиглах шинэлэг хэрэглээтэй холбоотой үйл ажиллагааг санхүүжүүлэх бөгөөд дараах ажлуудыг хийхээр төлөвлөж байна:

- *Хүргэлтийг бодит цагаар хянах (үүнд: радио давтамжийг таних [RFID] шошго, хурдан хариу үйлдэл үзүүлэх [QR] код, байршил хянагч ба блокчейн хяналт).* RFID шошго нь цахилгаан соронзон орны тусламжтайгаар объектуудад байршуулсан шошгыг автоматаар таньж, байршлыг хянах боломжтой. RFID технологийг QR код болон блокчейнтэй хослуулах нь бүтээгдэхүүний гарал үүсэл, баталгаа зэргийг харах, хянах боломжийг олгоно. Цар хүрээгээ тэлэхээс өмнө, хувийн хэвшлийн түншүүдээс тодорхой маршрутын шийдлүүдийг боловсруулан хөгжүүлэхийг хүснэ.
- *Хадгалалт ба ухаалаг ачааны машин/чингэлэг.* Machine learning, хиймэл оюун ухаан, робот гэх мэт энгийн технологиудыг ашиглан Монголын махны ложистикийн үйлчилгээнд өргөн тархсан бохирдолын тохиолдлыг бууруулах үндсэн процесс, автоматжуулалтыг зохицуулах шийдлийг боловсруулна.

**Дэд-бүрэлдэхүүн 2.4: Гэрээт ложистикийн үйлчилгээний дүрэм, стандарт.** Бүрэлдэхүүн нь гэрээт ложистикийн салбарын хөгжлийг дэмжих, дүрмийг хянах, шинэчлэх ажлыг багтаасан болно. Комплаенсын стандарт ба дүрмүүд нь Дэд-бүрэлдэхүүн 2.1-н төвтэй холбоотой өртгийн сүлжээн дэх гэрээт ложистикийн үйлчилгээг амжилттай нэвтрүүлэх, ашиг олоход чухал ач холбогдолтой юм.

**Бүрэлдэхүүн 3: Техникийн тусламж ба чадавхыг бэхжүүлэх (тооцоолсон нийт өртөг: 2 сая ам. доллар; ОУСБХБ зээл: 2 сая ам. доллар)**

Энэхүү бүрэлдэхүүн нь шаардлагатай бэлтгэл ажил, техник эдийн засгийн үндэслэл, техникийн зураг төсөл, санхүүжилтийн төлөвлөгөө зэрэг бүсийн ложистикийн төвүүдийг нэвтрүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаанд чиглэнэ. Түүнчлэн мах экспортлох таатай орчинг бий болгох, авто замаас гадна, тээврийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх, институцийг хөгжүүлэх, тээвэр, ложистикийн үйлчилгээ болон системийг сайжруулах чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Бүрэлдэхүүний хүрээнд гүйцэтгэх үйл ажиллагаанд дараах орно:

- **Дэд-бүрэлдэхүүн 3.1: Ложистикийн төвүүдийн бэлтгэл ажил.** Жишиг төвийг бүсийн төвийн нэгдмэл сүлжээний нэгэн хэсэг болж, улмаар, дотоодын болон экспортын зах зээлд тасралтгүйгээр мах нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх нэгдсэн төв болно гэж үзэж байна. Эхний ээлжинд төслийн хүрээнд бэлтгэсэн урьдчилсан ТЭЗҮ болон хувийн хэвшлийн саналаас үзэхэд, тэд бүх төвүүдийн зураг төсөл ба ерөнхий төлөвлөгөөг хэт том эсвэл хэт жижиг биш "тохирсон зөв хэмжээтэй" байхад анхаарах хэрэгтэй гэж зөвлөсөн. Энэ нь хэмжээ, төвүүдийн үйл ажиллагаа, одоогийн үйлдвэрлэл, аймаг тус бүрийн гол оролцогчид, тэдгээрийн зах зээлийн эрэлт зэрэг хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаална. Төвүүдийн сүлжээг байгуулахдаа хэмжээ болон зах зээлд нь нийцүүлэх, мөн төвүүдийн нэгдмэл байдлыг хангахын тулд, төслийн зүгээс үлдсэн төвүүдийн бэлтгэл ажлыг гүйцэтгэх болно. Үйл ажиллагааны хүрээнд мастер төлөвлөгөө, техникийн зураг төсөл, зохистой засаглалын үнэлгээ, санхүүжилт/ТХХТ-ийн хувилбарууд, ТЭЗҮ, ложистикийн төвүүдийн тендерийн баримт бичиг зэрэг багтана.
- **Дэд-бүрэлдэхүүн 3.2: Махны экспортын тээвэр ба ложистикийн стратеги судалгаа.** Дэд-бүрэлдэхүүн нь дотоодын зах зээлээс гадна ложистикийг хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжих юм. Монгол Улсаас мах экспортлох боломж нээгдэх үед төмөр зам болон агаарын тээврийн ложистикийн чиглэлээр тодорхой судалгаа хийх шаардлагатай. Эдгээр стратегийн судалгаанууд нь экспортын ложистикийн үндсийг тавих бөгөөд терминалын зохицуулалт, intermodal-н үйл ажиллагаа, экспортын ложистикийн бизнесийг хөгжүүлэх техникийн зураг төслүүдийг багтаана.
- **Дэд-бүрэлдэхүүн 3.3: Чадавхыг бэхжүүлэх ба сургалт.** Монгол Улсын төрийн байгууллагууд нь ложистикийн салбарыг дэмжих, одоо байгаа биет хөрөнгийг арчилж хадгалах чадавхыг хөгжүүлэх

эхлэлтийн шатандаа байсаар байна. Энэхүү дэд бүрэлдэхүүн нь төслийн менежмент болон хэрэгжүүлэлтийг дэмжих бөгөөд үүнд, Төслийн Удирдлагын Багын (ТУГ) дэмжлэг, техникийн зураг төсөл, байгаль орчин ба нийгмийн (БОН) судалгаа, олон нийтийн хэлэлцүүлэг болон оролцоо, бусад бүрэлдэхүүн хэсгүүдийн хүрээнд хийгдэх мониторинг ба үнэлгээ (М ба Ү) зэрэг орно. Түүнчлэн, авто замын хөрөнгийн менежмент, гэрээт ложистикийн үйлчилгээ, ТХХТ-ийг зохицуулах чадавхыг хөгжүүлнэ. Хэрэгжүүлэлтийг дэмжих, чадавхыг бэхжүүлэх арга хэмжээнд төрийн байгууллагууд болон техникийн ажилтнуудад зориулсан семинар, сургалт, хурал, суралцах аялал зэрэг багтана.

#### **Бүрэлдэхүүн 4: Болзошгүй Онцгой байдлын үед авах Арга Хэмжээний Бүрэлдэхүүн (CERC) (нийт өртөг: 0 ам.доллар)**

Бүрэлдэхүүн нь байгалийн гамшгийн үед үндэсний болон бүсийн хэмжээнд онц байдал зарлах, эсвэл гамшгийн дараа засгийн газраас албан ёсны хүсэлт гаргасны үндсэн дээр үүсэж болох болзошгүй онцгой байдлын эрсдэлийн санг 0 төсөвтэйгөөр байгуулна. Тээвэр, хөдөө аж ахуй/махны салбар<sup>6</sup> дахь бараа, үйлчилгээг шуурхай санхүүжүүлэх шаардлага гарсан үед, бусад бүрэлдэхүүн хэсгүүд дэх төслийн хөрөнгийг дахин хуваарилах боломжтой. Боломжит үйл ажиллагаанд авто замын дэд бүтцийг цэвэрлэх, нөхөн сэргээх, төслөөр тодорхойлогдсон эсвэл дэмжигдсэн бүсийн ложистикийн төвүүдийн дэд бүтэц, шаардлагатай материалыг худалдан авах зэрэг орно. Онцгой байдлын үед авах арга хэмжээний хавсралтыг Төслийн Үйл ажиллагааны Гарын авлагад (ТҮГА) оруулах бөгөөд хэрэгжүүлэлтийн зохицуулалтыг тусгасан, үүнд, идэвхжүүлэх үйл ажиллагаа, хэрэгжүүлэгч агентлагуудын үүрэг, хариуцлага, санхүүжүүлэх боломжтой арга хэмжээний жагсаалт, БОН-н асуудал ба фидуцийн гэрээ орно. Монгол Улсын Засгийн газраас тодорхойлсон хямрал эсвэл онцгой байдал нь шаардлага хангахаар бол уг төслийн хүрээнд холбогдох арга хэмжээнд хамруулах хүсэлтийг Дэлхийн Банкнд гаргаж болно. Ийм нөхцөлд, нэмэлт үйл ажиллагаанд шаардлагатай бүх БОН-н хэрэгслүүдийг бэлтгэж илгээх шаардлагатай бөгөөд Дэлхийн Банкнаас зөвшөөрөл авна.

**Төслийн өртөг ба санхүүжилт.** Санал болгож буй төслийн нийт өртөг нь санхүүжилтийн зардлыг оролцуулаад 132 сая ам.доллар бөгөөд үүнээс 100 сая ам.долларын санхүүжилтыг ОУСБХБ-ны зээлийн санхүүжилт, 10 сая ам.долларыг Олон улсын хөгжлийн ассоциаци (ОУХА)-ийн санхүүжилтээр тус тус хэрэгжүүлнэ. Монгол Улсын Засгийн газар болон ЗТХЯ-наас хамтран 2 сая ам.долларын санхүүжилт олгох юм. Бүсийн төв дэх хувийн концесс эзэмшигчээс ойролцоогоор 20 сая ам.доллар хүлээгдэж байна.

Бүрэлдэхүүн	Нийт Өртөг	ОУСБХБ	ОУХА	Хамтрагч	Хувийн Хэвшлийн Санхүүжилт
		Ам.доллар (саяар)			%
1 Дэд бүтцийн Хөрөнгө оруулалт	80	70	10	0	0
2 Зам тээвэр ба ложистикийн үйлчилгээ	50	28	0	2	20
3 Техникийн тусламж, чадавхыг бэхжүүлэх	2	2	0	0	0
4 Болзошгүй онцгой байдлын үед авах арга хэмжээний бүрэлдэхүүн	0	0	0	0	0
<b>Нийт төслийн өртөг</b>	<b>132</b>	<b>100</b>	<b>10</b>	<b>2</b>	<b>20</b>

<sup>6</sup> Шаардлагатай бол, хөрөнгө шилжүүлсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн санхүүжилтийг сэргээх нэмэлт санхүүжилтийг хайх болно.



Төслийн бүрэлдэхүүн, зардал, үйл ажиллагааг доорх хүснэгтэд нэгтгэн харуулав.

<b>Бүрэлдэхүүн</b>		<b>Үйл ажиллагаа</b>			
<b>Бүрэлдэхүүн 1: Дэд бүтцийн хөрөнгө оруулалт (тооцоолсон нийт өртөг: 80 сая ам. доллар)</b>		<b>Дэд-бүрэлдэхүүн 1.1: Стратегийн сүлжээний гол хэсгүүдэд үр дүнд-суурилсан засвар арчлалт хийх.</b> Энэхүү дэд-бүрэлдэхүүн нь муу буюу маш муу нөхцөлтэй 311 км авто замын засвар, арчлалтын ажлыг санхүүжүүлнэ.			
<b>Авто зам</b>	<b>Чигл элий н Код</b>	<b>Ээлжит засвар хийх авто замын хэсэг (км)</b>	<b>Шинэчлэлт хийх авто замын хэсэг (км)</b>	<b>Дэд-бүрэлдэхүүн 1.2: Орон нутгийн малчдад зориулсан хамгийн сүүлийн-бээрийн холболт.</b>	
Улаанбаатар-Авайхээр	A030 1	46	37	Энэхүү дэд-бүрэлдэхүүн хэсэг нь хамгийн сүүлийн бээрийн холболтыг сайжруулахад авах арга хэмжээний нэг бөгөөд нэн тэргүүний ач холбогдол бүхий орон нутгийн 51 км орчим авто замыг шинэчлэх	
Улаанбаатар-Өдөрхаан	A050 1	77	27		
Хархорин-Цэцэрлэг	A060 2	13	19		
Булган-Мөрөн	A090 2	0	25		
Архангай	A060 3	40	10		
Өвөрхангай	A030 2	0	35		
<b>Нийт</b>		311 км			
		ажлыг санхүүжүүлнэ.			
<b>Авто зам</b>	<b>Нарийвчилсан зураг төслийн бэлэн байдал</b>		<b>Урт (км)</b>		
Архангай аймгийн Булган	Үгүй		35.0		
Өвөрхангай аймгийн Есөнзүйл	Үгүй		16.0		
<b>Нийт</b>			51.0		
		<b>Дэд-бүрэлдэхүүн 1.3: Авто замын хөрөнгийн менежмент.</b> Энэхүү дэд бүрэлдэхүүн хэсэг нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүссэн шинэ сорилтуудад нийцэх авто замын дэд бүтцийн хөрөнгийн менежментийн төлөвлөгөө болон шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх тогтолцоог боловсруулах, замын барилга, засварын хөрөнгийн үндэсний стандарт, норм зэрэг техникийн стандартуудыг шинэчлэх ажлыг санхүүжүүлнэ.			
<b>Бүрэлдэхүүн Тээвэр, 2:</b>	<b>Дэд-бүрэлдэхүүн 2.1: Бүсийн жишиг</b>				

<p><b>ЛОЖИСТИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ (ТООЦООЛСОН НИЙТ ӨРТӨГ: 50 сая ам. доллар)</b></p>	<p><b>ЛОЖИСТИКИЙН ТӨВ.</b> Дэд-бүрэлдэхүүн нь бүсийн жишиг ложистикийн төвийг байгуулах үйл ажиллагааг санхүүжүүлнэ. Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд санхүүжүүлэх үйл ажиллагаанууд:</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Төв доторх 4-5 км орчим зам</li> <li>▪ Ачааны машины зогсоолын зай талбай</li> <li>▪ Оффис, нийтийн байр зэрэг туслах үйлчилгээний зориулалттай байгууламж</li> <li>▪ Цахилгаан, ус хангамжийн суурь бүтэц</li> <li>▪ Монгол Улсын Засгийн газрын нэгэнт эзэмшиж буй газрын ашиглалт.</li> </ul> <p><b>Дэд-бүрэлдэхүүн 2.2: Ложистик ба нийлүүлэлтийн сүлжээний платформ.</b> Энэхүү дэд-бүрэлдэхүүн хэсэг нь махны нийлүүлэлтийн сүлжээн дэх мэдээллийн тулгуур болох дижитал нийлүүлэлтийн сүлжээний платформыг хөгжүүлэх, нэвтрүүлэх ажлыг санхүүжүүлнэ.</p> <p><b>Дэд-бүрэлдэхүүн 2.3: Нийлүүлэлтийн сүлжээнд инновацийг нэвтрүүлэх туршилтын төслүүд.</b> Дэд-бүрэлдэхүүн нь зарим нэг үр ашиггүй байдлыг арилгах шинэ технологийн боломжийг ашиглах шинэлэг хэрэглээтэй холбоотой үйл ажиллагааг санхүүжүүлэх бөгөөд дараах ажлуудыг хийнэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Хүргэлтийг бодит цагаар хянах (үүнд: радио давтамжийг таних [RFID] шошго, хурдан хариу үйлдэл үзүүлэх [QR] код, байршил хянагч ба блокчейн хяналт)</li> <li>▪ Хадгалалт ба ухаалаг ачааны машин/чингэлэг.</li> </ul> <p><b>Дэд-бүрэлдэхүүн 2.4: Гэрээт ложистикийн үйлчилгээний дүрэм, стандарт.</b> Бүрэлдэхүүн нь гэрээт ложистикийн салбарын хөгжлийг дэмжих, дүрмийг хянах, шинэчлэх ажлыг багтаасан болно.</p>
<p><b>Бүрэлдэхүүн 3: Техникийн тусламж ба чадавхыг бэхжүүлэх (тооцоолсон нийт өртөг: 2 сая ам. доллар)</b></p>	<p><b>Дэд-бүрэлдэхүүн 3.1: Ложистикийн төвүүдийн бэлтгэл ажил.</b> Үйл ажиллагааны хүрээнд мастер төлөвлөгөө, техникийн зураг төсөл, зохистой засаглалын үнэлгээ, санхүүжилт/ТХХТ-ийн хувилбарууд, ТЭЗҮ, ложистикийн төвүүдийн тендерийн баримт бичиг зэрэг багтана.</p> <p><b>Дэд-бүрэлдэхүүн 3.2: Махны экспортын тээвэр ба ложистикийн стратеги судалгаа.</b> Дэд-бүрэлдэхүүн нь дотоодын зах зээлээс гадна ложистикийг хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжинэ.</p> <p><b>Дэд бүрэлдэхүүн 3.3: Чадавхыг бэхжүүлэх ба сургалт.</b></p>
<p><b>Бүрэлдэхүүн 4: Болзошгүй онцгой байдлын үед авах арга хэмжээний бүрэлдэхүүн (CERC) (нийт өртөг: 0)</b></p>	<p>Бүрэлдэхүүн нь байгалийн гамшгийн үед үндэсний болон бүсийн хэмжээнд онц байдал зарлах, эсвэл гамшгийн дараа засгийн газраас албан ёсны хүсэлт гаргасны үндсэн дээр үүсэж болох болзошгүй онцгой байдлын эрсдэлийн санг 0 төсөвтэйгөөр байгуулна.</p>

## Төсөл хэрэгжүүлэх зохион байгуулалт

Зам, тээврийн хөгжлийн яам (ЗТХЯ) нь төслийг хэрэгжүүлэгч байгууллага ба төслийн үйл ажиллагааг ссадгүй, цаг хугацаанд нь хэрэгжүүлэх болон бүрэн дуусгахын тулд төслийн хэрэгжилт, удирдлагын үйл ажиллагаанд ерөнхий хяналтыг тавьж ажиллана.

- Төслийн удирдах хороо (ТУХ):
  - Төслийн удирдах хороог салбар хоорондын үйл ажиллагаа, уялдааг хангах зорилгоор ЗГХЭГ-ын дэргэд байгуулах ба бүрэлдэхүүнд ЗТХЯ, холбогдох орон нутгийн удирдлага, Замын тээврийн хөгжлийн төв, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ), Үндэсний хөгжлийн газар, Сангийн яамны төлөөллийг оруулна.
- Төслийн удирдлагын алба (ТУА):
  - Тус албыг ЗТХЯ-ны дэргэд байгуулах ба Төслийн захирлыг Зам, тээврийн хөгжлийн сайд томилно. Төслийн ажилтнуудыг Сангийн яамны журмаар сонгон шалгаруулж ажиллуулна. ТУА нь төслийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлж Дэлхийн банк болон Монгол Улсын Засгийн газрын хоорондын зээлээр батлагдсан төслийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.
  - ТУА-нд Төслийн зохицуулагч, Санхүүгийн ажилтан, Худалдан авалтын мэргэжилтэн, Талбайн инженерүүд, Байгаль орчны мэргэжилтэн, болон Нийгмийн мэргэжилтэн ажиллана.
  - ТУА нь ЗТХЯ-тай гэрээтэй гүйцэтгэгчидтэй нягт хамтран ажиллах ба төслийн зөвлөхүүд нь тус БОНМХ болон хамгаалалтын баримт бичгүүдийг хэрэгжүүлж ажиллана.
- Төслийн удирдлагын албаны инженерүүд:
  - Байгаль орчны болон нийгмийн мэргэжилтнүүдтэй хамтран Байгаль орчны болон нийгмийн хамгааллын баримт бичгийн дагуу байгаль орчны болон нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг нарийвчилсан зураг төсөл, гэрээнд тусгах;
  - Байгаль орчны болон нийгмийн мэргэжилтэнүүд нь ТУА-тай нягт уялдаатай ажиллаж, Байгаль орчин, нийгмийн шаардлагуудыг дагаж мөрдөхөд нь хяналт тавихад туслалцаа үзүүлж ажиллах.
- Гүйцэтгэгчийн инженерүүд
  - Барилгын ажлын талбай дээр ХАБЭА-н менежертэй хамтран Байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийг хангах;
  - Байгаль орчин, нийгмийн бүх баримт бичгийг хэрэгжүүлэх үүднээс холбогдох бүх оролцогч талуудтай холбоо тогтоох, ТУА-нд тайлагнах.

Замын барилгын ажил эсвэл засвар шинэчлэлийн ажлын оролцогч талууд болон тэдгээрийн үүрэг, хариуцлагыг дараах байдлаар тодорхойлов:

1. Төслийн эзэмшигч нь Зам, тээврийн хөгжлийн яам ба замын зураг төсөл, барилга угсралтын ажил, барилгын хяналт, санхүүжилт, ашиглалтын ажлыг ЗТХЯ ерөнхийлөн хариуцна. ЗТХЯ нь i) Зураг төслийн зөвлөх, ii) Хяналтын зөвлөх, iii) Барилгын ажлын гүйцэтгэгч шалгаруулах худалдан авалтыг удирдан явуулна.
2. ЗТХЯ-ны тендер зарлаж сонгон шалгаруулж, гүйцэтгэлийг санхүүжүүлэх зураг төслийн зөвлөх нь материалын зөвшөөрсөн ору найрлага зэргийг багтаасан инженерийн нарийвчилсан зураг төслийг боловсруулна. Зураг төслийн зөвлөх нь барилгын ажлыг эхлүүлэх (улаан шугам хүлээлцэх) болон замын ажлыг хүлээн авах үед байлцана.

3. Замын барилгын ажилд хяналт тавих хоёр төрлийн хяналтын зөвлөх байх ба эдгээр нь: i) төслийн гүйцэтгэгчийн хяналт, ii) төслийн эзэмшигчийн хяналт. Төслийн эзэмшигчийн хяналтыг ЗТХЯ-ны харьяа Зам, тээврийн хөгжлийн төв (ЗТХТ) төрийн өмчит үйлдвэрийн газар хариуцдаг ба ойролцоогоор барилгын ажлын зардлын 2% байдаг. Төслийн гүйцэтгэгчдийн хяналтыг ЗТХЯ-наас тендер зарлаж сонгон шалгаруулсан хувийн хэвшлийн аж ахуйн нэгж гүйцэтгэх ба энэ төрлийн ажил үйлчилгээний зардал барилгын төсөвт өртгийн 4-5% орчим байдаг нь ЗТХТ-ын зардлаас өндөр юм. ЗТХТ эсвэл хувийн хяналтын компанитай хамтран ажиллах шийдвэрийг ЗТХЯ гаргадаг ба энэ нь ихэвчлэн зам барилгын ажилд хуваарилагдсан нийт төсөв, мөн хувийн хяналтын зөвлөх төлөвлөсөн төсөвт өртөгт багтаан гүйцэтгэх боломжтой эсэхээс хамаардаг. Төсөвт өртгийн тооцоог зураг төслийн зөвлөх бэлтгэдэг. Хяналтын зөвлөх/инженер нь зам барилгын ажилд өдөр тутмын хяналт тавих ба нарийвчилсан зураг төсөл, норм, стандарт, техникийн баримт бичиг, технологи, байгаль орчин, эрүүл мэнд, замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавина. (2017 онд шинэчлэн найруулсан Авто замын тухай хуулийн 20.5-ын заалт.
4. Төслийн гүйцэтгэгч буюу зам барилгын ажлын компани нь хяналтын зөвлөх/аж ахуйн нэгжийн хяналтан дор нарийвчилсан зураг төслийн дагуу барилгын ажлыг гүйцэтгэнэ. Зам барилгын компани зураг төслийн зөвлөхүүдийн хяналтанд замын барилгын ажлыг эхлүүлдэг.
5. Замын барилгын ажил дууссаны дараа төслийн бүх талууд – Төслийн эзэмшигч (ЗТХЯ), Барилгын ажлын гүйцэтгэгч компани, хяналтын зөвлөх, зураг төслийн зөвлөх –ыг байлцуулан “ажил хүлээн авсан акт”-ыг үйлдэнэ.

## 4. БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭ

### Монгол Улсын холбогдох хууль тогтоомжууд

Монгол Улсад байгаль орчны үнэлгээ болон менежментийн цогц бодлого, хууль эрх зүйн орчин бүрдсэн. Хамгаалалтай газрыг удирдан зохион байгуулах, ОУ-ын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, иргэдийнхээ эрүүл мэнд, сайн сайхан амьдрахад чиглэсэн байгаль орчны чанарыг хадгалан хамгаалах бодлого, хууль тогтоомж, стратеги Монгол Улсад бий болсон. Эдийн засгийн хөгжлийг байгалийн баялгийг олборлолт, ашиглалтай зөв уялдуулах, агаар, ус, хөрсийн бохирдлыг хянах замаар бий болгох нь Монгол Улсын төрийн бодлогын суурь зарчим юм. Улс орны тогтвортой хөгжилтэй холбоотой үйл ажиллагааг удирдан зохион байгуулах зорилгоор 1996 оны 4-р сард Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үндэсний Зөвлөлийг байгуулсан. Монгол Улсын стратегийг байгаль орчны хувьд ээлтэй байх, эдийн засгийн тогтвортой байдал, нийгмийн баялгийн хөгжилд чиглэн боловсруулсан бөгөөд урт хугацааны тогтвортой хөгжлийн гол чухал хүчин зүйл бол хүн гэдгийг тодотгосон байдаг. Үүнтэй холбоотой Монгол Улсын холбогдох чухал хуулиудыг доорхи хүснэгтэнд жагсаасан болно.

Но.	Хуулийн нэр	Тавигдах шаардлагууд	Төсөлтэй хамаарах эсэх
1	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай (2012)	Замын барилга, засвар, дэд бүтцийн төслүүдэд байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийх шаардлагатай байж болзошгүй.	Хамааралтай
2	Байгаль орчныг хамгаалах тухай (1995)	Нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны хамгаалалттай уялдуулан тэнцвэржүүлэх шаардлагатай байж болзошгүй.	Хамааралтай
3	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай (1994)	Тусгай хамгаалалттай газар нутагт болон ойр орчмын бүсүүдэд зөвхөн тодорхой төрлийн үйл ажиллагааг зөвшөөрсөн.	Хамааралтай
4	Соёлын өвийг хамгаалах тухай (2014)	Дэд бүтэц эсвэл бүтээн байгуулалтын төслийн хүрээнд их хэмжээний газар шорооны ажил эхлэхээс өмнө биет болон биет бус соёлын өв байгаа эсэхийг шалгаж, хамгаалах шаардлагатай.	Хамааралтай
5	Хог хаягдлын тухай (2017)	Болзошгүй хог хаягдлаас үүсэх нөлөөлөл, эрсдлийг тодорхойлж, бууруулж, багасгаж, зохион байгуулах шаардлагатай.	Хамааралтай
6	Усны тухай (2012)	Усны нөөцийг үр ашигтайгаар ашиглаж, зохион байгуулах шаардлагатай.	Хамааралтай
7	Хөдөлмөрийн тухай (1999)	Ажиллагсадын эрх, үүргийг хүндэтгэж, аюулгүй, эрүүл ажиллах орчинг бүрдүүлэх шаардлагатай.	Хамааралтай
8	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай (2008)	Энэхүү хууль болон түүний шаардлагуудыг ажлын бүх орчинд чанд даган мөрдөх шаардлагатай.	Хамааралтай
9	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай (2011)	Эрэгтэй, эмэгтэй хүнийг ижил тэгш боломжоор хангах ёстой.	Хамааралтай
10	Авто замын тухай (2017)	Замын барилга, завсарын үйл ажиллагаа нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх ёсгүй.	Хамааралтай
11	Монгол Улсын Үндсэн хууль (Зүйл 14.2-т 2019 онд нэмэлт өөрчлөлт оруулсан )	Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна	Хамааралтай
12	Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай (2002)	Зам, шугам сүлжээ зэрэг улсын хэмжээний томоохон объект зэрэг улсын тусгай хэрэгцээний газрыг буцаан авахдаа нөхөн олговортойгоор эргүүлэн авна.	Хамааралтай
13	Газрын тухай		
14	Монгол Улсын Иргэний хууль нь замын зурвас газрыг нөлөөлөлд өртсөн этгээдээс төрд шилжүүлэх тухай гэрээний эрх зүйн үндэс юм (15-р бүлэг, 1, 6, 7, 8, 109, 112-р зүйл, бусад).	Хэлэлцэж тохирох зохицуулалтууд	Хамааралтай
15	Соёлын тухай (Зүйл 1.3, 19.2)	Соёлын өвийг хамгаалах, угсаатны соёлыг ялгаварлан гадуурхах, дарамтлахыг хориглох.	Хамааралтай
16	Хөдөлмөрийн тухай (Зүйл 7.1)	Үндэстэн хооронд тэгш байдлыг хангах	
17	Монгол Улсын Эрүүгийн хууль (Зүйл 10.1.2.14, 14.1)	10.1.2.14 Үзэл бодол, арьсны өнгө, үндэс, угсаа, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж алсан бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнэ. 14.1 Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг,	Хамааралтай

		үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.	
--	--	---	--

Малчдын амьжиргааг хамгаалахтай холбоотой бэлчээрийн газар нутгийг ашиглах талаар хатуу дүрэм, журам байдаг. Бэлчээрийн зориулалтаар ашиглахаас өөр зориулалтаар ашиглахын тулд тухайн аймаг, сумын хөгжлийн төлөвлөгөөг дагаж мөрдөх шаардлагатай. Бэлчээрийн газрын ашиглалтыг үйлдвэрлэлийн зориулалтаар өөрчлөхөд хүсэлт гаргаж, зөвшөөрөл өгөх замаар явагдана. Зөвхөн бэлчээрийн газрыг малчид хамтран ашиглаж болох ба малчдад бэлчээрийн талбайг гэрээний үндсэн дээр олгодог. Энэ газрыг зөвхөн бэлчээрийн зориулалтаар ашиглах боломжтой ба тухайн газрын бэлчээрийн даацыг ашиглагч нь зөвшөөрсөн байдаг. Ерөнхийдөө гэрээ нь 15 жилийн хугацаатай, хүсэлт гаргаснаар сунгалт хийгдэж болно. Оршуулгын гараас бусад газрыг аж ахуйн нэгжүүд, иргэд тохиролцсон зориулалтаар гэрээний үндсэн дээр ашиглаж болно. Газар ашиглалтын гэрээний хугацаа, хэмжээ нь газрын шинж чанар, ашиглалтын төрлөөс хамаарч өөр өөр байдаг. Ихэнх тохиолдолд газар ашиглах гэрээний хугацаа 15-60 жил байх ба нэг удаа 40 жилээс илүүгүй хугацаагаар сунгаж болно. Газар ашиглалтын төрлөөс хамаарч газрын төлбөрийг төлдөг. Малчид бэлчээр, хадлангийн талбайн төлбөрөөс чөлөөлөгддөг.

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний шаардлагыг 2012 оны Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай (БОНБУ) Монгол Улсын хуулинд тусгасан. Хуулийн зорилго нь байгаль орчныг хамгаалах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар байгалийн нөөц ашиглалт явуулах, бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулахад оршино.

БОНБУ-ний тухай хуулинд байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хоёр төрлийг тодорхойлсон болно:

- (i) Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ (нягтлан шалгах) – Ерөнхий үнэлгээг эхлүүлэхийн тулд төслийг хэрэгжүүлэгч нь Байгаль Орчин, Аялал жуулчлалын яам (эсвэл аймгийн захиргаа) руу ТЭЗҮ, зураг төсөл, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хүргүүлнэ. Ерөнхий үнэлгээг хүлээн авагч байгууллага судалж үзсэний үндсэн дээр дараах дөрвөн дүгнэлтийн аль нэгийг гаргана. Үүнд: I. БОНБ-ын Нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагагүй, II. Төслийг нэмэлт тодорхой нөхцөл хангуулах, III. БОН-ийн Нарийвчилсан үнэлгээ шаардлагатай, IV. Төслийг хэрэгжүүлэхээс татгалзах эсвэл буцаах. Ерөнхий үнэлгээ үнэ төлбөргүй бөгөөд шийдвэрлэхэд ажлын 14 хүртэлх хоног орно.
- (ii) Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ. Уг үнэлгээний цар хүрээг ерөнхий үнэлгээгээр тодорхойлдог. Нарийвчилсан үнэлгээг БОАЖЯ-аас тусгай журмын дагуу эрх олгосон Монгол Улсын компани боловсруулах шаардлагатай. Нарийвчилсан үнэлгээг боловсруулагч компани нь БОАЖЯ (эсвэл Аймгийн захиргаа) руу уг үнэлгээг илгээх ёстой. Ерөнхий үнэлгээнд өмнө нь оролцож байсан байгууллагын мэргэжилтэн нарийвчилсан судалгааг 18 хоногийн дотор хянаж, БОАЖЯ-нд (эсвэл Аймгийн захиргаанд) танилцуулна. БОАЖЯ (эсвэл Аймгийн захиргаа) мэргэжилтний дүгнэлтийг үндэслэн төслийг батлах эсвэл түдгэлзүүлэх шийдвэрийг гаргана.

- (iii) Нарийвчилсан судалгаа дараах бүлэгтэй байна: I. Байгаль орчны төлөв байдал, II. Төслийн хувилбарууд, III. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, IV. Сөрөг нөлөө, тэдгээрийн эрчим, тархалт, үр дагаварыг тогтоосон тооцоо, дүн шинжилгээ, V. Эрсдэлийн үнэлгээ, VI. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, VII. Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр, VIII. Тухайн төсөл хэрэгжүүлэх шаардлагатай эсэх талаарх оршин суугчдын санал бодол.

Төлөвлөж буй үйл ажиллагааны байршил, төрөл, хэмжээ нь Байгаль орчин, нөлөөллийн үнэлгээний хийхэд Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОНХЯ) эсвэл аймгийн захиргааны үүрэг хариуцлагыг тогтоодог. Монгол Улсын тээврийн холболт, ложистикийг сайжруулах төслийн хүрээнд хийхээр төлөвлөж буй үйл ажиллагаа нь дотоодын хуулийн эдгээр шаардлагыг дэмжих боломжтой гэж үзэж байна. Дэд бүрэлдэхүүн 1.2 – Орон нутгийн малчдад чиглэсэн сүүлийн бээрийн холболтын замын хүрээнд хийгдэх шинэ замын барилгын ажил, Дэд бүрэлдэхүүн 2.1 Бүсийн жишиг ложистикийн төвийн барилгын ажил нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийхийг шаардана. Дэд бүрэлдэхүүн 1.1 - Замын хэсгийн засвар арчлалтыг ажилд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх шаардлага гарахгүй байх магадлалтай.

Байгаль орчны хяналт-шинжилгээний суурь үзүүлэлтийг бий болгох нь орчны агаар, ус, орчны дуу чимээ, хөрсний чанарын чиг хандлага, бохирдуулагч бодис ялгарах, хүний үйл ажиллагааны бусад үйл ажиллагаа болон/эсвэл хог хаягдлыг боловсруулах үйл ажиллагаа (нөлөөлөл) энэ чанарт хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлоход оршино. Төслийн болон ойролцоох нутаг дэвсгэр эсвэл агаар мандал, гүний ус, нуур эсвэл илэрсэн шим тэжээл, бохирдуулагчийн хэмжээг тооцоолох зорилгоор байгаль орчны хяналт-шинжилгээг хийх шаардлагатай. Төсөлтэй холбоотой аливаа үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнө хүрээлэн буй байгаль орчны чанарыг тодорхойлох хяналтыг хийх шаардлагатай ба чанарыг тодорхойлсноор нөлөөллийн хяналттай харьцуулах боломж олгодог юм. Түүнчлэн цэвэр нөхцөлд гэнэтийн өөрчлөлт гарч байгаа эсэхийг шалгахад чанарын мэдээллийг ашиглаж болно. Цаг уур, орчны шинжилгээний газар нь байгаль орчны чанарыг хянах зорилгоор ус, агаар, хүчлийн хуримтлал, хөрс, орчны цацрагийн идэвхижил, тоосжилтын хуримтлал, хүхрийн хийн орчны үнэлгээг хийх үүрэгтэй. Хот болон томоохон суурин газруудын лабораториуд агаар, ус, хөрсний чанар болон цацрагийн идэвхжилийн түвшний хэмжээг тогтмол хэмжих, эрчим хүчний станц, тээврийн хэрэгслээс үүсэлтэй бохирдлын хог хаягдлын эх үүсвэрийг хянах, байгаль орчны үнэлгээний шаардлагатай хяналт-шинжилгээний үйл ажиллагаа явуулах, байгаль орчны хяналт хариуцсан бусад байгууллагуудтай хамтран ахуйн хаягдлыг хянах зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

## Дэлхийн банкны байгаль орчин ба нийгмийн стандартууд

Төслийг хэрэгжүүлэхэд Дэлхийн банкны БОНХ-г ашиглах бөгөөд байгаль орчин, нийгмийн стандартууд энэхүү төсөлд хэрхэн хамааралтай болохыг Хүснэгт 1-т -д үзүүлэв.

*Хүснэгт 2.Төслийн холбогдох Байгаль орчин, нийгмийн стандартууд*

№	Байгаль орчин, нийгмийн стандарт	Хамааралтай эсэх	Дүн шинжилгээ
1	БОНС 1. Байгаль орчин, Нийгмийн Эрсдэл, Нөлөөллийн Үнэлгээ ба Менежмент	Хамааралтай	Энэхүү стандартын дагуу Зам, тээврийн хөгжлийн яам (ЗТХЯ) уг төсөлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэлүүдийг үнэлэх, удирдах, хянах үүрэгтэй.
2	БОНС2. Хөдөлмөр ба Ажиллах Нөхцөл	Хамааралтай	Төсөлд төрөл бүрийн ажилчдын оролцоо байх тул БОНС 2-г хамааралтайд тооцогдоно.
3	БОНС3. Нөөцийн Үр ашигтай хэрэглээ ба Бохирдлоос Урьдчилан сэргийлэх ба Удирдах	Хамааралтай	Зам барих, шинэчлэлтийн ажлын байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл нь их боловч хянаж болохуйц. Ложистикийн төв болон хамаарах байгууламжуудын ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой ус, цахилгаан зэрэг нөөцүүдийн хэрэглээ, хатуу болон

			шингэн хог хаягдал, төрөл бүрийн хийн ялгаралаас үүдсэн байгаль орчны дарамт, нөлөөлөл бий болно. Барилгын ажлын шатны нөөцүүдийн болон хог хаягдал, хийн ялгарал нь шууд нөлөөлөл болох ба энэ шатны амьтаны аймгийн нөлөөлөл харьцангуй зөөлөн байна.
4	БОНС4. Олон нийтийн Эрүүл мэнд ба Аюулгүй байдал	Хамааралтай	Энэхүү стандарт нь төслийг хэрэгжүүлэх хугацаанд иргэдийн эрүүл мэнд болон аюулгүй байдалд үзүүлж болох сөрөг нөлөөллийг урьдчилан тооцоолох, урьдчилан сэргийлэх зорилготой. Газар шорооны болон замын ажлын цар хүрээ, мөн чанарыг харгалзан үзэхэд энэхүү төсөл нь ойр орчмын иргэдэд барилгатай холбоотой нэлээдгүй төвөг учруулах ба экосистемийн аливаа үйлчилгээнд нөлөөлнө. Барилгын ажлын менежментийн сайн туршлагыг хэрэгжүүлэх замаар шинэ замын болон засвар шинэчлэлтийн ажлын үеийн дуу чимээ, тоос шороо, хаягдал бий болох болон замын хөдөлгөөний саад зэрэг тухайн хэсгийг хамарсан түр зуурын нөлөөллийг бууруулж болно. Ковид-19 цар тахлын үед төслийн хэрэгжилтийн явцад шинэ зам барих, шинэчлэлтийн ажилд оролцож буй ажилчдаас орон нутгийн иргэдэд халдвар тараахгүй байхад чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авах шаардлагатай.
5	БОНС5. Газар Чөлөөлөх, Газар Ашиглахыг Хязгаарлах, Албадан Нүүлгэн шилжүүлэлт	Хамааралтай	МУЗГ-аас төслийг дэмжих зорилгоор аливаа асуудалгүй газрыг олгоно. Ерөнхий дүрэмд зааснаар газар чөлөөлөлтөөс зайлсхийх болно. Орон нутгийн иргэдэд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, бууруулах зорилгоор газрыг түр ашиглах зохицуулалтыг хийнэ. ТОХТ нь ложистикийн төвийн барилгын болон засвар, шинэчлэлтийн ажил, сүүлийн бээрийн холболтын ажил болон материалыг бэлтгэхтэй холбоотой ажилд өртөж болзошгүй хүмүүсийг тогтоох нарийвчилсан алхмуудыг тусгасан болно. ТОХТ нь мөн газар ашиглалтаас үүсэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, багасгах зорилгоор газартай холбоотой бүх асуудлыг ойр орчмын иргэдэд ил тод болгох үүднээс олон нийтийн хэлэлцүүлгийг хийх алхмуудыг тусгасан. Байнгын болон түр хугацаагаар газар ашиглахад нөхөн олговор олгох шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хэрэглэх RPF-г бэлтгэсэн.
6	БОНС 6. Биологийн олон янз байдлыг Хадгалах, Амьд Байгалийн Нөөцийн Тогтвортой Удирдлага	Хамааралтай	Энэхүү стандарт нь биологийн төрөл зүйл болон амьдрах орчныг хамгаалах, унаган төрхөөр нь хадгалах, амьд байгалийн нөөцийн тогтвортой менежментийг дэмжих зорилготой юм. Энэхүү стандартын дагуу төслийн үйл ажиллагаа нь биологийн олон янз байдалд ноцтой хор хөнөөл учруулахгүй байх, нутгийн иргэд экосистемийн үйлчилгээнд нэвтрэх, ашиглахад саад учруулахгүй байхыг ЗТХЯ-ны зүгээс хангах шаардлагатай.
7	БОНС 7. Уугуул Иргэд/ Сахар Африкийн Түүхэнд Хадгалагдан Үлдсэн Уламжлалт Орон Нутгийн Нийгэмлэг	Хамааралтай	Увс, Хөвсгөл, Төв зэрэг аймгуудад үндэстний цөөнхүүд амьдран суудаг тул төслийн үнэлгээг хийхээс өмнө тэдний соёл заншлыг хүндэтгэх хүрээнд төслийн тухай ярилцаж зөвшилцөх шаардлагатай тул энэхүү стандартыг ач холбогдолтой гэж үзэж байна.



8	БОНС 8. Соёлын өв	Хамааралтай	Бэлтгэл ажлын явцад байгаа мэдээлэл, төслийн загварт үндэслэн энэхүү стандартыг ач холбогдолтой гэж үзэж байна. Төсөл нь зам барих, шинэлэх явцад соёлын өвийг сүйтгэхгүй байхыг хангах аливаа дүрэм журмыг мөрдөж ажиллана.
9	БОНС 9. Санхүүгийн зуучлагчид	Хамааралгүй	ЗТХЯ нь төслийг хэрэгжүүлэх тул энэ стандарт нь санал болгож буй төсөлд хамааралгүй юм. Санхүүгийн ямар нэг зуучлагч оролцохгүй.
10	БОНС 10. Оролцогч талуудын Оролцоо, Мэдээллийн Ил тод байдал	Хамааралтай	Оролцогч талуудтай ил тод, утга учиртай хамтын ажиллагаатай байх нь төслийн байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлыг сайжруулж, хүлээн зөвшөөрлийг нь нэмэгдүүлэх боломжтой тул ЗТХЯ үүнийг чухалчлан авч үзнэ. Энэхүү стандартын дагуу ЗТХЯ нь оролцогч талуудын хувьд системчилсэн оролцооны арга барилыг бий болгох үүднээс ТОХТ-г боловсруулж хэрэгжүүлэх ба энэ нь оролцогч талууд болон төслийн нөлөөлөлд өртсөн иргэдийг тодорхойлох, төслийн хэрэгжилтийн туршид бүтээлч харилцааг бий болгох, хадгалахад чиглүүлэх зорилготой.

Түүнчлэн Дэлхийн Банкны БОЭМАА-ны удирдамжийг төсөлд ашиглана. Эдгээр:

- БОЭМАА-ны ерөнхий удирдамж
- Төлбөртэй замын БОЭМАА-ны удирдамж
- Замын аюулгүй байдлын талаарх Дэлхийн Банкны БОНХ-ын сайн туршлагын талаарх тэмдэглэл
- Дэлхийн банкны Аж үйлдвэрийн салбарын БОЭМАА-ны холбогдох удирдамж
- Банкны БОНХ/Хамгааллын дунд хугацааны тэмдэглэл болон ДЭМБ-ын Ковид-19-ийн талаарх эрүүл мэндийн удирдамж.

## Монгол Улсын хууль тогтоомж болон Дэлхийн банкны байгаль орчин, нийгмийн стандарт хоорондын зөрүүтэй байдалд хийсэн дүн шинжилгээ

Монгол Улсын болон Дэлхийн банкны байгаль орчин, нийгмийн шаардлагуудын хооронд зарим нэгэн зөрүү байгаа ба эдгээр зөрүүтэй байдалд хийсэн дүн шинжилгээний гол дүгнэлтийг Хүснэгт 3-т харуулав. Дараах хүснэгтэд эдгээр зөрүүг БОНМХ-гээр дамжуулан хэрхэн арилгах талын арга хэмжээг тусгасан болно.

Хүснэгт 3. Байгаль орчин ба нийгмийн бодлогын зөрүүтэй байдалд хийсэн дүн шинжилгээ

Сэдэв	Тогтоосон зөрүү (Дэлхийн банкны БОНХ-ний дагуу)	Зөрүүг нөхөх арга хэмжээнүүд
Байгаль орчны үнэлгээний цар хүрээ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний (БОНБУ) тухай хуулиар зөвхөн хүний эрүүл мэнд, байгаль орчны асуудлыг авч үзсэн. (ДБ БОНХ БОНС1)	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд Байгаль орчин, нийгмийн стандартад тусгасан бүх асуудлууд -байгаль орчин, хөдөлмөрийн нөхцөл, хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, нөөцийн үр ашиг ба тогтвортой байдлын менежмент, албадан нүүлгэн шилжүүлэлт, уугуул иргэд, соёлын өв, хил дамнасан болон дэлхийн байгаль орчны аливаа асуудал багтана.
	Тусгай хамгаалалттай газар нутгийн бүсэд зөвхөн тодорхой төрлийн үйл ажиллагааг БОНБУ-ний хуулиар авч үзсэн. (ДБ БОНХ БОНС1)	Бүх дэд төслүдийг магадлан шалгаж үнэлэх шаардлагатай.
Хөдөлмөр ба Ажиллах Нөхцөл	Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль (1999), Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2008) нь ОУХБ-ын хөдөлмөрийн үндсэн хэм хэмжээг хэрэгжүүлж, ажлын байран дахь эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах эрх, үүргийг тогтоосон. Үндэсний хууль тогтоомжоор бүх ажил олгогчид хуулийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн боловч туслан гүйцэтгэгчид хөдөлмөр, ХАБЭА-н шаардлагыг	БОНМХ-д туслан гүйцэтгэгчид хөдөлмөр болон ХАБЭА-н ижил шаардлагыг хэрэгжүүлэх, мөн дэд төслийн Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах хувилбарууд тусгасан байхаар боловсруулсан.  Мөн хүүхдийн хөдөлмөр, албадан

Сэдэв	Тогтоосон зөрүү (Дэлхийн банкны БОНХ-ний дагуу)	Зөрүүг нөхөх арга хэмжээнүүд
	хангасан байх хуулийн үүрэг байхгүй. ХАБЭА-тай холбоотой эрсдлийг бууруулах тусгай арга хэмжээг үндэсний хууль тогтоомжид заагаагүй ч зармыг нь үндэсний стандарт, дүрэм журмаар тогтоосон байдаг. (ДБ БОНХ БОНС2)	хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төсөл нь БОНС2-д нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах Хөдөлмөрийн харилцааг зохицуулах журмыг (ХХЗЖ) боловсруулсан.
Нөөцийн Үр ашигтай хэрэглээ ба Бохирдлоос Урьдчилан сэргийлэх ба Удирдах	Монгол Улсын Агаар, Ус, Хог хаягдлын тухай хуулиудад эдгээр нөөцтэй холбоотой ерөнхий шаардлагыг зааж өгсөн байдаг. Гэсэн хэдий ч аливаа эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой бохирдлын хяналт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхой зааж өгөөгүй. (ДБ БОНХ БОНС3)	Дэд төслийн байгаль орчны шалгалтын үйл явц нь БОНС-тай холбоотой гол асуудлуудыг тодорхойлох бөгөөд БОНМХ нь Дэлхийн Банкны холбогдох БОЭМАА-нуудыг багтаасан Олон улсын аж үйлдвэрийн сайн туршлагыг эх сурвалж болгон нөөцийн үр ашиг, бохирдлын менежментийн удирдамжийг боловсруулсан болно.
Олон нийтийн Эрүүл мэнд ба Аюулгүй байдал	Иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын талаар тусгай хууль байхгүй (ДБ БОНХ БОНС4)	БОНМХ нь төслөөс иргэдэд үзүүлэх эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл, нөлөөллийг багасгах, КОВИД-19-ийг ажлын байр болон иргэдийн дунд тархахаас сэргийлсэн зааварчилгааг өгсөн. Хортон шавж, замын хөдөлгөөний болон замын аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдал зэрэг нийгмийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээг энэхүү БОНМХ-д тодорхойлсон.
Албадан нүүлгэн шилжүүлэлт	<p>Монгол Улсад газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх тухай хууль байхгүй. Монгол Улсын Газрын тухай хуульд тодорхой ангиллын газар өмчлөх, эзэмших эрхийг тодорхойлж, сумын Засаг дарга малчдын бүлгүүдтэй газар ашиглах гэрээ байгуулах эрхийг олгосон байдаг. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь сумын Засаг даргаас өргөн мэдүүлсэн, орон нутгийн газрыг өөр зориулалтаар ашиглах тухай төрөл бүрийн хүсэлтийг тусгасан сумын жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлах, татгалзах эрхтэй бөгөөд төслийг хэрэгжүүлэх явцад энэхүү процессыг (зохицуулалтыг) мөрдөж ажиллана. Тусгай хамгаалалттай газар нутаг, орчны бүсэд бэлчээр ашиглаж буй малчдын дийлэнх нь албан ёсоор газар өмчлөх эрхгүй ч зарим нь өвөлжөө хаваржааны зориулалтаар хязгаарлагдмал хугацаагаар ашиглах гэрээтэй байж болно.</p> <p>Газрын удирдлагын төлөвлөлтөд хэрэглээний зориулалтаар газар эзэмших талаар тусгах ёстой гэж үздэг боловч хэрэглээний зориулалтаар ашиглах эрхийг үндэсний хууль тогтоомжид тусгаагүй. Монгол Улсад төрөөс хэрэглээний зориулалтаар газрыг чөлөөлөх тухай хуулийн зохицуулалт байхгүй. Дэлхийн банкны стандартын дагуу Олон нийтийн зайлшгүй хэрэгцээнд газрыг чөлөөлөх тухай хуулийн төсөл боловсруулагдсан боловч хараахан батлагдаагүй байна. Энэ хууль батлагдсан тохиолдолд БОНМХ-г шинэчлэх шаардлагатай. (ДБ БОНХ БОНС5)</p>	ЭТХЯ газар чөлөөлөхөөс зайлсхийх болно гэж мэдэгдсэн. Логистикийн төв байгуулахад төрөөс хоосон газар олгоно. Сүүлийн бээрийн холболтын замд тухайн газраас амьжиргаанд үзүүлэх нөлөөллийг арилгах эсвэл багасгахын тулд оролцогч талуудын оролцоог хангана. Материалын нөөцийн талбайн иргэдэд үзүүлэх нөлөөллийг үнэлнэ. ТОХТ нь газар ашиглалтын нөлөөлөлд өртөж болзошгүй хүмүүстэй холбоотой оролцогч талуудыг тодорхойлох, зөвлөлдөх алхмуудын талаар удирдамжийг агуулсан. Хэрэгжилтийн шатанд орлогын эх үүсвэрт хязгаарлалт үүссэн тохиолдолд зааварчилгаа өгөх зорилгоор RPF бэлтгэсэн.
Биологийн олон янз байдлыг Хадгалах, Амьд Байгалийн Нөөцийн Тогтвортой Удирдлага	Монгол Улсад амьтдын эрхийг хамгаалах, тогтвортой мал аж ахуйн салбарын талаар хууль байхгүй. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль байгаа боловч байгалийн болон биологийн төрөл зүйлийн амьдрах орчны талаар зааж өгөөгүй. (ДБ БОНХ БОНС6)	БОНМХ нь Дэлхийн банкны холбогдох БОЭМАА-ны удирдамжийг багтаасан Олон улсын аж үйлдвэрийн сайн туршлагад тулгуурлан удирдамж боловсруулсан. Үүнээс гадна чухал/ноцтой болон байгалийн амьдрах орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийхийн тулд хасагдах шалгуурыг БОНМХ-нд оруулсан болно.
Уугуул иргэд	Монгол Улсын Үндсэн хуульд "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор	Төсөл хэрэгжих аймгуудад үндэсний цөөнхүүд байгааг урьдчилсан БОННУ-нд оруулсан. Төсөл хэрэгжих газрууд тодорхой болсны дараа төслийн хэрэгжилтийн явцад үндэсний

Сэдэв	Тогтоосон зөрүү (Дэлхийн банкны БОНХ-ний дагуу)	Зөрүүг нөхөх арга хэмжээнүүд
	нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэж заасан байдаг. Үндэсний цөөнхийн талаар тусгайлсан хууль байдаггүй. Боловсрол, хэлний бодлогууд нь монгол хэлийг сурталчилсан байдаг ба халх монгол хэл нь албан ёсны төрийн хэл юм. (ДБ БОНХ БОНС7)	цөөнхийн байршлын талаар үргэлжлүүлэн үнэлнэ. Үндэсний цөөнх байгаа нь батлагдсан тохиолдолд тэдэнд хамгийн тохиромжтой хэлээр зөвлөлдөх хэлэлцүүлгийг зохион байгуулна.
Соёлын өв	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон Соёлын өвийн тухай хуулиудаар зохицуулсан. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөр өөр статустай улсын тусгай хамгаалалттай газар нутагт өөр өөр бүсэд зөвшөөрөгдсөн болон хориглосон үйл ажиллагаа явуулах, газар ашиглах зөвшөөрөл олгоход төрийн янз бүрийн шатны байгууллагын үүрэг, хариуцлагыг тодорхойлсон. Соёлын өвийн тухай хуулиар биет өвийг бүртгэх ажлыг эхлүүлж, биет өвийг хамгаалах үүрэг, хариуцлагыг тодорхой зааж өгсөн. (ДБ БОНХ БОНС9)	Төсөл нь соёлын өвийг тодорхойлох, бүртгэх, хамгаалахад оролцогч талуудын оролцоог дэмжинэ. Соёлын өвд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй аливаа үйл ажиллагаа төслийн санхүүжилтэд хамрагдах боломжгүй болно. Мөн БОНМХ-д боломж-олдох (chance-find) журмыг оруулна.
БОННУ-ний олон нийтийн оролцоо	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар олон нийтийн оролцоог хангаагүй. (ДБ БОНХ БОНС10)	Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний тайланг явуулахаас өмнө БОНМХ-д оролцогч талуудтай үр дүнтэйгээр зөвлөлдөн, тэдний саналыг тусгахаар оруулсан.
	БОН Нарийвчилсан үнэлгээнд тусгасан олон нийтийн оролцооны тухай журам нь зөвхөн олон нийтийн оролцооны талаарх ерөнхий удирдамжийг өгдөг. (ДБ БОНХ БОНС10)	БОНМХ-д оролцогч талуудтай үр дүнтэйгээр зөвлөлдөн, тэдний саналыг тусгахаар оруулсан.
Олон нийтэд мэдээлэх, мэдээллийг хуваалцах	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн олон нийтэд мэдээлэх, мэдээллийг хуваалцах заалтууд бүрэн бус. (ДБ БОНХ БОНС10)	БОНМХ болон дэд төслүүдийн БОНМТ нь олон улсын стандартад нийцүүлэн төслийн төлөвлөгөө, БОННУ-г нийтэд мэдээлэх, ил тод болгох журмыг тодорхойлсон байна.
Тайлагналт	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар нарийвчилсан байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд зөвхөн байгаль орчны удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнахаар заасан. (ДБ БОНХ БОНС10)	Байгаль орчин, нийгмийн баримт бичгүүдийн төлөв байдал болон мониторингийн үр дүнг оролцогч талуудад тайлагнаж мэдээлэх шаардлагатай.

## 5. БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН СУУРЬ СУДАЛГАА

### Байгаль орчны суурь судалгаа

Монгол Улс нь Хойд Азийн далайд гарцгүй, 1.56 сая хавтгай дөрвөлжин км газар нутагтай, гурван сая орчим хүн амтай, үүний 2.2 сая нь хот суурин газарт амьдардаг. Хөдөө орон нутгийн хүн амын нягтрал нэг километр квадрат талбайд дунджаар 0.5 хүн байгаа нь хөдөөгийн гол амьжиргааны эх үүсвэр болох бэлчээрийн нүүдлийн мал аж ахуй давамгайлж байгааг харуулж байна. Монгол Улс засаг захиргааны хувьд нийслэл Улаанбаатар хот болон 21 аймгаас бүрдэнэ. Аймгууд нь сум болон багт хуваагддаг. Төслийн хүрээнд хэрэгжиж буй эдгээр үйл ажиллагаанууд нь Хөвсгөл, Увс, Архангай, Өвөрхангай, Булган, Төв, Хэнтий, Сүхбаатар зэрэг 8 аймагт явагдана.

**Хөвсгөл аймаг:** Хөвсгөл аймаг нь Монгол орны хамгийн хойд талын аймаг ба хойд талаараа ОХУ-тай, баруун, зүүн, урд талаараа Завхан, Булган, Архангай аймагтай хиллэдэг. Аймгийн төв Мөрөн хот нь Дэлгэрмөрөн голын хөндийд орших ба далайн түвшнээс 1,283 метр өндөрт оршдог. Хөрсний хувьд голын хөндийн хөрс зонхилох ба хар хүрэн шавранцар, шаварлаг хөрстэй.

Хөвсгөл аймаг нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, өвөл нь урт хүйтэн, зун нь чийглэг богино байдаг. Жилийн дундаж температур  $-1.3^{\circ}\text{C}$ , хамгийн хүйтэн сар нь 1-р сар бөгөөд дундаж температур  $-22.7^{\circ}\text{C}$ , хамгийн хүйтэн температур  $-50.3^{\circ}\text{C}$  гэж тэмдэглэгдсэн. Хамгийн халуун сар нь 6-р сар бөгөөд дундаж температур нь  $22.9^{\circ}\text{C}$ , хамгийн халуун температур нь  $35.4^{\circ}\text{C}$  гэж тэмдэглэгдсэн. Монгол орны цэвдгийн тархалтын хамгийн сүүлийн үеийн зураглалаар тус аймаг нь цэвдэгтэй бүсэд оршдог байна.

Жилийн дундаж харьцангуй чийгшил 63% буюу харьцангуй хуурай, хур тунадасны жилийн дундаж хэмжээ 208 мм ба ихэнх хур тунадас нь (60-70%) зуны саруудад унадаг. 24 цагийн хамгийн их хур тунадас 6, 7, 8-р сард 32-46 мм орчим байдаг. Минутанд унах хамгийн их хур тунадасны хэмжээ 0.75 мм тэмдэглэгддэг. Сарын дундаж нартай байх цагийн хугацаан 6-р сард 291.5 цагаас 12-р сард 154.5 цаг хүртэл буурдаг байна. Салхины зонхилох чиглэл баруунаас ба салхины дундаж хурд 1-р сард 1-2.0 м/с, 4-р сард 2.5-3.3 м/с, намар, 10-р сард 1.8-2.0 м/с байна. Сарын хамгийн их салхины хурд 14-25 м/с, 7-9-р саруудад хамгийн их салхитай байдаг.

Хөвсгөл аймаг нь Дэлгэрмөрөн, Эгийн голын сав газарт орших ба Дэлгэрмөрөн гол нь 445 км урт үргэлжилсэн 26,640 км<sup>2</sup> сав газартай ба Сэлэнгэ мөрөн эх авдаг голуудын нэг юм. Монгол орны хамгийн том цэнгэг усны эх үүсвэр болох Хөвсгөл нуур нь тус аймагт орших ба жуулчдын зорих гол газруудын нэг юм. Монгол орны хамгийн их талбайг хамарсан ой тус аймгийн хойд хэсэгт байх ба энэ ой өмнөд Сибирийн тайга хүртэл үргэлжилдэг.

Ургамлын бүрхэвч нь шивээ өвс (*Stipa Krylovii*), ерхөг (*Agrohyron cristatum*) гэх мэт тачирхан багваахайн овгийн болон өвс ногоо хосолмол ургадаг.

Хөвсгөл аймаг нь 39,449 өрх, 134,371 хүн амтай, аймгийн төвд 40, 510 хүн амьдардах ба зургаан жилд (2013-2018 он) хүн ам 6.7 хувиар өссөн.

Хөвсгөл аймгийн эдийн засгийн гол салбар нь хөдөө аж ахуй ба хүн амын тал орчим хувь нь мал аж ахуй эрхэлдэг. Улсын тооллогын мэдээгээр тус аймаг нь 6 сая гаруй мал тоолуулсан байна. Хөдөө аж ахуйн бусад чухал үйл ажиллагаанд үр тариа, хүнсний ногоо, царгас тариалах үйл ажиллагаанууд ордог. Сүүлийн жилүүдэд аялал жуулчлал эрчимтэй хөгжиж байгаа ба Хөвсгөл нуур нь тус аймгийн эдийн засагт нөлөөлөх томоохон газруудын нэг юм.

**Увс аймаг:** Увс аймаг нь нийслэл Улаанбаатар хотоос 1,336 км зайд, улсын баруун хойд хэсэгт оршдог. Аймгийн төв Улаангом хот нь далайн түвшнээс дээш 936 метрт оршдог. Увс аймагт Монгол Улсын хамгийн том нуур Увс нуур орших ба энэ нуурын нэрээр аймгийг нэрлэдэг. Газар нутгийн хувьд улсын нутаг дэвсгэрийн 4.45 хувийг эзлэх ба 69,585 км<sup>2</sup> талбайтай. Эдийн засгийн гол салбар нь хөдөө аж ахуй, өөрөөр хэлбэл газар тариалан, мал аж ахуй юм. Аймгийн нийт нутаг дэвсгэрийн 60 гаруй хувь нь

уулархаг бүсэд, 40 хувь нь говь хээрий бүст хамаарна. Засаг захиргааны нэгжийн хувьд тус аймаг нь 19 сумтай.

Хамгийн их температур 7-р сард +40-50°C, хамгийн бага температур 1-р сард -40-50°C байна. Зонхилох хөрс нь хагас цөлийн чулуурхаг саарал, элсэрхэг хүрэн шавранцар хөрс. Хөрсний дээд давхаргад ялзмагийн агууламж 1.089% хэмжээтэй бага байх ба үе гүнзгийрэх тутам огцом буурдаг. Хөрсний бүх давхаргад 61.3-64.2% элс зонхилдог.

Увс аймаг нь эх газрын хойд хэсгийн уур амьсгалтай, урт хүйтэн өвөл, чийглэг богино зунтай. Жилийн дундаж харьцангуй чийгшил 63%, жилийн дундаж хур тунадас 135 мм. Жилийн хур тунадасны 75 орчим хувь нь зуны саруудад унах ба нартай байх цаг жилд дунджаар 2,925 цаг байдаг. Өдөрт дунджаар нарны тусгал нь өвлийн улиралд 4.7-5.4 цаг, зуны улиралд 9.4-9.8 цаг байдаг. Салхины зонхилох чиглэл баруунаас байна.

Ургамлын бүрхэвч нь өд өвс (*stipa gobica*), хиэг өвс (*Agropyron repens*), харгана (*Caragana pugnata*) зэрэг бүт сөөгөрхөг ургамал.

Хонь, ямаа, үхэр, тэмээ, адуу зэрэг уламжлалт мал аж ахуй, газар тариалан нь Увс аймгийн зэрэг эдийн засгийн гол салбар ба хонь, тэмээний ноос, ямааны ноолуур, арьс шир, гүүний айраг, цагаан идээ, махан бүтээгдэхүүн нь хөдөө аж ахуйн салбарын гол үйл ажиллагаа юм. Сүүлийн жилүүдэд газар тариалангийн аж ахуй, тэр дундаа төмс болон бусад хүнсний ногоо тариалалт нэлээдгүй нэмэгдсэн.

**Arkhangai aimag:** The Arkhangai aimag is located in the center of the country and borders Bulgan, Ovorkhangai, Bayankhongor, Zavkhan, and Khovsgol.

**Архангай аймаг:** Архангай аймаг нь Монгол орны төв хэсэгт орших ба Булган, Өвөрхангай, Баянхонгор, Завхан, Хөвсгөл аймгуудтай хиллэдэг. Архангай аймгийн хамгийн өндөр цэг Харлагтайн оргил нь 3,529 м өндөр бол 1,290 м өндөрт орших Орхон, Тамир голын бэлчир хамгийн нам цэг юм. Түгээмэл мэддэг уул нь Хорго сөнөсөн галт уул бөгөөд Тэрхийн цагаан нуурын байгалийн цогцолборт оршдог.

Архангай аймгийн газар зүйн төрх байдал нь нуга хээр, ойт хээр зонхилох ба Орхон голын сав газар, Туул голын сав газар, Хануйн голын сав газруудтай. Чулуут, Хануй, Тамир голууд нь хангайн нуруунаас эх авсан голууд юм.

Өвлийн улиралд дундаж температур нь -30 °C-аас -38 °C (-22 °F-аас -36 °F), зуны улиралд хамгийн өндөр температур нь 25 °C-аас 36 °C (77 °F ба 97 °F) хооронд байна. 5-р сарын эхээр харьцангуй чийгшил 19-59%, салхины хурд 4м/с байдаг. Аймгийн төвийн агаарын чанар сумдыг бодвол харьцангуй бохирдол ихтэй.

**Өвөрхангай аймаг:** Өвөрхангай аймаг нь Монгол орны төв хэсэгт орших ба Хангайн нурууны үргэлжлэл аймгийн нийт нутаг дэвсгэрийн 23 хувийг эзэлдэг ба баруун өмнөд хэсгээрээ Алтайн уулсын оргилуудтай. Аймгийн газар нутгийн төв хэсгээр тал хээр үргэлжлэх ба нийт нутаг дэвсгэрийн 28.2 хувийг эзэлдэг. Өмнө талаараа нийт нутаг дэвсгэрийн 48.8 хувийг эзэлсэн говь цөл үргэлжилдэг.

Аймгийн 1-р сарын агаарын дундаж температур -18.1°C, хамгийн хүйтэн температур нь -44°C хүрч тэмдэглэгдсэн. Өвлийн улиралд 36 хоногийн түрш температур -30 хэм хүртэл буурах ба жилийн 180 орчим өдөр хүйтэн цаг агаар үргэлжилдэг бол үлдсэн хагас нь дулаан өдрүүд байна. Жилийн дундаж температур 0°C байна. Жилийн дундаж хур тунадас 354,5 мм ба хур тунадастай байх нь элбэг бөгөөд заримдаа хур тунадас өдөрт 46 мм хүрдэг.

Ургамлын бүрхэвчийг тал хээрийн бүлгэмийн ургамал болох *Stipa baicalienensis*, *Stipa krilo*, *Leymus chinensis*, *Vupleurum scorzonifolium*, *Galium Verum*, *Astragalus melilotoides* зонхилно. Ой, тайга,

говийн бүсийн нэн ховордсон амьтад болох буга, гөрөөс, хээрийн үнэг, чоно, зэрлэг муур, хулан, шилүүс, ирвэс, аргаль, янгир ямаа, цагаан зээр, хар сүүлт зээр, хойлог зэрэг амьтадын өлгий нутаг юм.

Өвөрхангай нь Туул, Орхон, Онги, Таац, Умард говийн гүвээт-Халхын дундад тал, Алтайнөвөр говь зэрэг гол мөрний 6 сав газартай.

**Bulgan aimag:** Bulgan aimag is located in the same Northern part of Mongolia, at elevations of 1260-1500 m above sea level, which belongs to semi-high mountainous region of the Orkhon and Selenge rivers' basin in the KhangaiKhentii mountainous region. The lowest point in this region is 750 m above sea level at the Selenge-murun river meadow. Bulgan aimag has a subarctic climate with long, dry, very cold winters and short, cool summers. The average precipitation in January is 1.5 mm and 71.3 mm in July. Bulgan aimag has scattered distribution of permafrost.

**Булган аймаг:** Булган аймаг нь Монгол орны хойд хэсэгт, далайн түвшнээс дээш 1,260-1,500 м өндөрт орших ба Хангай, Хэнтийн уулархаг бүсийн Орхон, Сэлэнгэ мөрний сав газрын хагас өндөрлөг уулархаг бүсэд багтдаг. Энэ бүсийн хамгийн нам цэг нь далайн түвшнээс дээш 750 м өндөрт Сэлэнгэ мөрний нуга юм. Булган аймаг нь урт, хуурай, маш хүйтэн өвөл, богино сэрүүн зунтай туйлын өмнөх бүсийн уур амьсгалтай. 1-р сард дунджаар 1.5 мм, 7-р сард 71.3 мм хур тунадас ордог. Булган аймаг мөнх цэвдгийн алаг цоог тархалттай.

Орхон гол гол нь Булган хотын зүүн талаар 20 км-т урсах ба Хангайн нуруунаас - дээд урсгал нь Хангайн нурууны байгалийн цогцолборт газраас - эх авч 1,124 км урсаж аймгийн төвийн хажуугаар урсдаг. Энэ гол нь Сэлэнгэ мөрний хамгийн том цутгал бөгөөд 132,835 км<sup>2</sup> ус цуглуулах талбайтай, Сэлэнгэ мөрний ус цуглуулах талбайн 47 хувийг эзэлдэг. Орхон гол 11-р сард хөлдөж жилд 130 орчим хоног хөлдүү байдаг. Голын дундаж гүн нь 3.5 м, урсгалын хурд нь 2.5 м/с хүрдэг.

**Төв аймаг:** Төв аймаг нь уулсын дундах хөндийн намхан уулс, даваа, тэгш тал, хотгор гүдгэр бүхий газар зүйн тогтоцтой бөгөөд тархсан зонхилох хөрс нь бор хөрс юм. Төв аймагт хур тунадас, чийг харьцангуй бага, хур тунадасны дийлэнх нь зуны саруудад ордог. Өвлийн улиралд орох хур тунадас нь жилийн нийт хур тунадасны дөнгөж 5-7 хувийг эзэлдэг ба 4-10-р саруудын хооронд дунджаар 50-60 хоног бороо орно. Сүүлийн 15 жилийн уур амьсгалын мэдээллээс үзэхэд жилийн 10-24 хоногт шороон болон цасан шуурга ажиглагдсан ба салхины зонхилох чиглэл нь баруун хойноос зүүн урд зүгт байна. Шороон шуурга ихэвчлэн 4, 5-р сард болдог. Төв аймгийн нутаг дэвсгэр нь Хойд мөсөн далайн усны хагалбарт хамаарах Монгол орны хойд хэсэгт орших Орхон, Сэлэнгийн сав газрын бүс нутагт хамаардаг.

**Хэнтий, Сүхбаатар аймаг:** Хэнтий аймаг, Сүхбаатар аймаг нь Монгол орны зүүн хэсгээр далайн түвшнээс дээш 1,000-1,500 м өндөрт орших ба Хэнтий аймгийн нутаг дэвсгэр нь Хэнтийн нурууны бүсийн дунд болон зүүн алсын уулархаг бүсэд, Сүхбаатар аймаг нь Дорнод Монголын тэгш талын өмнөд хэсгийн үргэлжлэл бөгөөд тал хээрийн бүсэд багтдаг.

Хэрлэн гол нь 1,254 км урт үргэлжлэх ба 116,400 км.кв талбайг хамардаг. Хэрлэн гол нь Улаанбаатар хотоос зүүн хойш 180 орчим км-т байрлах Хан Хэнтийн дархан цаазат газар, Бурхан Халдун уулын орчмоос Хэнтийн нурууны урд энгэрээс эх авдаг. Энэ газар нь хойд туйлын (Туул гол) болон Номхон далайн (Хэрлэн, Онон голууд) сав газрын хоорондын усны хагалбар газар ба энэ нь Гурван голын сав газар юм. Хэрлэн гол Хэнтий аймгийн нутгаар дамжин ихэвчлэн зүүн тийш чиглэж урсах ба Дорнод Монголын тал нутгийг дайран Улаан эрэг, Чойбалсанг өнгөрч, 480 3' N 1150 36' E-ээр БНХАУ-ын нутгаар 164 км урсаж Хөлөн нуурт цутгадаг.

Хэнтий, Сүхбаатар аймгууд нь урт, маш хуурай, маш хүйтэн өвөл, богино, маш дулаан зунтай, хүйтэн хагас хуурай уур амьсгалтай. Хэнтий аймагт тохиолдлын чанартай мөнх цэвдэг үзэгддэг. Сүхбаатар аймаг улирлын хүйтэн жавартай бүсэд оршдог.

**Экологийн эмзэг газрууд:** Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ болон экологийн чухал бүсүүд экологийн эмзэг газарт багтдаг. Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ нь тус улсын нийт нутаг дэвсгэрийн 21% (3.27 сая га)-ыг хамарсан 120 тусгай хамгаалалттай газраас бүрддэг. УИХ-аас "ТХГН-ийн үндэсний хөтөлбөр"-ийг (1998) баталж, улсын нутаг дэвсгэрийн 30 хувийг хамарсан тусгай хамгаалалттай газрыг бий болгох зорилт дэвшүүлснээс хойш тус улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тоо нэмэгдсэн. 2021 онд Монгол Улсын нутаг дэвсгэрийн тусгай хамгаалалттай газарт 21 дархан цаазат газар (13.8 сая га), 37 байгалийн цогцолбор газар (13.5 сая га), 48 байгалийн нөөц газар (5.3 сая га), үндэсний соёл, түүхийн дурсгалт газар 14 (0.13 сая га) орсон байна.

Түүнчлэн Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 10,4 хувийг буюу 16,3 сая га талбайг хамарсан 911 орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг бий. Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн нийт талбайн хэмжээ 44.3 сая га-д<sup>7</sup> хүрч, нийт нутаг дэвсгэрийн 28.3 хувийг эзэлж байна (Монгол Улсын Засгийн газар 2015 он). Гэсэн хэдий ч тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн чадавх, нөөц нь ТХГН-ийн өргөжилтийг гүйцэхгүй байгаа бөгөөд ихэнх тусгай хамгаалалттай газрууд чухал төрөл зүйл, амьдрах орчныг хамгаалах нөөц хангалтгүйгээс болж ихээхэн бэрхшээлтэй тулгарч байна.<sup>8</sup>

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасны дагуу бүх Тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН), байгалийн цогцолбор газарт (БЦГ) нутгийн орчны бүс (НОБ) байж болно. Тусгай хамгаалалттай газрын нутгийн орчны бүсийн тухай хуулиар НОБ байгуулах, удирдах асуудлыг зохицуулдаг. Энэ нь (i) тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, (ii) орон нутгийн иргэдийг амьжиргааны эх үүсвэрээр хангах, (iii) байгалийн нөөцийн зохистой ашиглалтыг хангах замаар ТХГН-т учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилготой юм. Одоогийн байдлаар Засгийн газар ТХГН болон БЦГ-ын эргэн тойронд нутгийн орчны бүс байгуулахыг идэвхтэй дэмжиж байна. Зохих ёсоор удирдаж чадвал орон нутгийн тусгай хамгаалалтын газар нь сайн хамгаалалтыг бий болгож, тусгай хамгаалалттай газар нутгийг тэлэх бүсийг бий болгоно.

**Биет соёлын нөөцүүд/ Соёлын дурсгалт газрууд:** Монгол Улс биет соёлын баялгаар арвин. Монгол Улсын болон аймгуудын чухал өв, соёл, шашны дурсгалт газрын жагсаалтыг 1994, 1998, 2008 онд шинэчлэн баталсан бөгөөд энэ жагсаалтад нийт 460 объект бүртгэгдсэнээс 175 нь улсын хамгаалалтад, 285 нь аймгийн хамгаалалтад байна.

*Хүснэгт 4. Соёлын үнэт өв, соёлын болон шашны дурсгалт газрын жагсаалт<sup>9</sup>*

#	Аймгууд	Соёлын үнэт өв, соёлын болон шашны дурсгалт газрын тоо	
		Улсын хамгаалалттай	Орон нутгийн хамгаалалттай
1	Архангай*	14	24
2	Булган*	10	25
3	Өвөрхангай*	9	26
4	Сүхбаатар*	8	4
5	Төв*	15	6
6	Увс*	5	8
7	Хөвсгөл*	9	26
8	Хэнтий*	13	23

<sup>7</sup> <https://www.cbd.int/doc/world/mn/mn-nbsap-v2-en.pdf>; [http://www.eic.mn/spalocal/localspa\\_stat\\_en.php?ltype=1](http://www.eic.mn/spalocal/localspa_stat_en.php?ltype=1)

<sup>8</sup> [http://www.mn.undp.org/content/mongolia/en/home/operations/projects/environment\\_and\\_energy/SPAN.html](http://www.mn.undp.org/content/mongolia/en/home/operations/projects/environment_and_energy/SPAN.html)

<sup>9</sup> Эх сурвалж: БСШУСЯ, Соёлын өвийн төв “Соёлын өвийг бүртгэх заавар”, 2014 он.

Сүүлийн бээрийн холболтын замын барилгын ажлын тендер зарлахын өмнө биологийн олон янз байдлын болон соёлын өвийн хээрийн судалгааг газар дээр нь явуулна. Биологийн олон янз байдлын судалгааны явцад тогтоогдсон биологийн төрөл зүйлд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс хамааран Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөөг (BMP) бэлтгэх шаардлага гарч болох ба сүүлийн бээрийн холболтын замын БОНМТ(нүүд)-д нэгтгэж оруулна.

Судалгаагаар Дэлхийн банкны санжүүжүүлж буй сүүлийн бээрийн холболтын зам дээр соёлын өвийн дурсгалт газрууд, тэдгээрийн хамгаалалтын бүс, биологийн олон янз байдлын өндөр үнэ цэнэ бүхий хэсэг тогтоогдвол биологийн олон янз байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор шаардлагатай тохиолдолд сүүлчийн бээрийн холболтын замын трассыг өөрчлөх зэрэг нөлөөллийг бууруулах арга хэмжээг сүүлийн бээрийн холболтын замуудын БОНМТ(нүүд)-д санал болгож оруулна.

## Байгаль орчны одоогийн нөхцөл байдал, томоохон асуудлууд

### Цаг уурын нөхцөл байдал

**Озон:** Монгол Улс 1996 онд Озоны давхаргыг хамгаалах Венийн конвенцид, 1996 онд Монреалын протоколд (озоны давхаргыг задалдаг бодисыг зохицуулах) тус тус гарын үсэг зурж, 1999 онд Засгийн газрын 129 дүгээр тогтоолоор Озоны давхаргыг хамгаалах үндэсний хөтөлбөрийг баталж хэрэгжүүлсэн. Өнөөдөр хэрэглэж буй зарим химийн бодисууд нь хүчтэй хүлэмжийн хийг ялгаруулж дэлхийн дулаарлыг бууруулж, уур амьсгалын өөрчлөлтийн хүчин чармайлтыг сааруулах нөлөөтэй байна. Иймд 2030 он гэхэд озоны болон дэлхийн дулаарлын нөлөөгөөр гидрохлорфтор нүүрстөрөгчийн (ГСФУ) хэрэглээг бүрмөсөн зогсоож, 2045 он гэхэд фторфтор нүүрстөрөгчийн (ГФУ) хэрэглээг суурь үзүүлэлтээс 80 хувиар бууруулахаар үндэсний төлөвлөгөөнд тусгагдсан.

2030 он гэхэд озоны давхарга болон дэлхийн дулаарлын GHFN/HCFC (гидрохлорфтор нүүрстөрөгч) импорт болон хэрэглээг бууруулах Монгол Улсын амлалт, хэрэгжилт, озоны цооролт (ODP), уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх нөлөө буюу нийт CO<sub>2</sub> eq-tn (GWP) тооцоолж Хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт 5. Озоныг задлагч бодисын гидрохлорфтор нүүрстөрөгчийн импорт, 2015-2020<sup>10</sup>

Бодис	Бодис, тонноор						Нийт Дэлхийн дулаарлын магадлал, ( GWP, тн)	Нийт HCFCs (CO <sub>2</sub> eq-tn)
	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он		
HCFC-22	11.43	8.18	10.71	12.61	13.38	0.44	3.12	102,717.5
Нийт	56.75							


### Уур амьсгалын өөрчлөлт

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын нутагт байрлах хүлэмжийн хийн ялгарлын мониторингийн мэдээллээр Монгол дахь хүлэмжийн хийн дундаж нягтрал тасралтгүй өсч байна.

Нүүрстөрөгчийн давхар ислийн агууламж 28 жилийн хугацаанд (1992-2020 он) 354.6 ppm-ээс 413.3 ppm болж, олон жилийн дундажтай харьцуулахад 58.8 ppm буюу 16.5%-иар өссөн байна (Зураг 16). 2020 онд дундаж агууламж 413.3 ppm байсан бол 2019 онд 412.3 ppm байна. Агаар дахь метаны жилийн дундаж агууламж (CH<sub>4</sub>) 1992-2020 оны хооронд 1808 ppbv-ээс 8.8%-иар нэмэгдэж, 1968 ppbv болж нэмэгджээ.


<sup>10</sup> Эх сурвалж: 2015-2020 оны Гаалийн статистик мэдээ





Зураг 2. Агаар дахь нүүрсхүчлийн хийн агууламж (CO<sub>2</sub>)

Монгол орны хэмжээнд 44 цаг уурын станцын 1940-2020 оны ажиглалтаар 1988 оноос хойш гадаргын агаарын жилийн дундаж температур дулаарч 2.4°C/80 жил ( $p < 0.05$  буюу статистикийн ач холбогдолтой) болжээ. (Зураг 17).




Зураг 3. Агаарын жилийн дундаж температурын өөрчлөлт ААТ (1981-2010 дундаж ААТ)

Өвлийн улиралд Улаанбаатар хотын гурван том дизель цахилгаан станцаас цаг тутамд 4.5 сая шоо метр хий бохирдуулагч бодис, 4.14 тонн тоосонцор, 6.76 килограмм нүүрстөрөгчийн дутуу исэл ялгардаг. Монгол Улсын хүлэмжийн хийн 64 орчим хувийг эрчим хүчний салбар гаргадаг. 250 гаруй уурын зуух жил бүр 400,000 гаруй тонн нүүрс шатаадаг. Гэр, модон байшин (хотын хүн амын 48 хувь нь амьдардаг) жил бүр 200,000 гаруй тонн нүүрс, 160,000 гаруй шоо метр түлшний мод хэрэглэдэг. Хүйтэн улирлын хувьд агаар мандалд нүүрстөрөгчийн дутуу ислийн агууламж зөвшөөрөгдөх хэмжээнээс 2-4 дахин их байдаг.

Монгол Улсын томоохон хот, аймгийн төвүүдэд агаарын чанарын асуудал нь байгаль орчны томоохон асуудал юм. Агаарын бохирдлын анхдагч эх үүсвэр нь дулааны цахилгаан станц, жижиг дунд оврын халаалтын зуух, уламжлалт гэр, модон байшин, 40 гаруй мянган автомашин юм. Тус улсын, ялангуяа Улаанбаатар хотын агаарын чанарын нөхцөл байдал газарзүйн байрлал, цаг уурын нөлөөгөөр улам дордож байна. Үүний үр дүнд агаар дахь орчны бохирдуулагчийн агууламж нь Монгол Улсын болон бусад олон улсын агаарын чанарын стандартаас давж, хэдэн долоо хоногоор үргэлжилдэг. Хот суурин газрын айл өрхүүд нүүрс, мод түлэх нь орчны агаарын чанар, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй агаарын бохирдлын гол эх үүсвэр болж байна.

### Цаг агаар, байгалийн гамшиг

Дэлхийн цаг уурын хурдацтай өөрчлөгдөж буй нөхцөлд цаг агаараас үүдэлтэй гамшиг, сүйрлийн давтамж нэмэгдэж, хохирлын хэмжээ нэмэгдэх хандлагатай байна. Арав гаруй төрлийн цаг агаарын гамшиг улс орны нийгэм, эдийн засагт ихээхэн хохирол учруулдаг бөгөөд нийгэм эдийн засгийн эрсдэлд ган, зуд, ой хээрийн түймэр, цасан шуурга, шар усны үер, хэт хүйтний гамшиг зэрэг нь томоохон гамшигт багтжээ. Зураг 20-д 1989-2019 онд Монгол Улсад цаг агаарын нөхцөл байдалтай холбоотой гамшгийн давталтыг харуулав.



Зураг 4. Цаг агаарын гамшгийн давтамж

2019 онд улсын хэмжээнд цаг агаарын аюултай үзэгдэл 78, гамшгийн 21 тохиолдол гарч, 22 хүн амь насаа алдаж, хоёр хүн гэмтэж бэртэн, 23847 толгой мал хорогдож, таван зам, гүүр эвдэрч, 233 гэр, 226 хашаа нурж, 31 барилгын дээвэр эвдэрсэн байна. 27 цахилгаан дамжуулах агаарын шугам унаж, 1052 га тариалангийн талбай өртөж, улс, нийгэмд 15 тэрбум 139 сая 945 мянган төгрөгийн шууд хохирол учирчээ. (ЦУОШГ, 2021)

2020 онд улсын хэмжээнд 90 удаагийн цаг агаарын аюулт үзэгдэл, 11 удаагийн аюулт үзэгдэл бүртгэгдэж, 15 хүн нас барж, 14 хүн гэмтэж бэртэн, 11955 толгой мал хорогдсон, долоон зам, гүүр эвдэрч, 976 гэр, хашаа нурж, 17 барилгын дээвэр нурсан байна. Цахилгааны долоон шон унаж, 11339 га газар тариалангийн талбай сүйдэж, улс, нийгэмд долоон тэрбум 625 сая 187 мянга 426 төгрөгийн шууд хохирол учирчээ. Замыг эвдэлсэн байгалийн томоохон гамшгийн заримыг доор жагсаав.


2019 оны 6-р сарын 15-16-ны өдрүүдэд нутгийн төв хэсгээр усархаг бороо оржээ. 14-нд төвийн аймгуудын нутгийн баруун хэсгээр, 15-16-нд ихэнх нутгаар усархаг бороо орсон. Станцад 40,3-48,0 мм, бусад нутгаар 0,1-39,8 мм бороо орсон байна. Аадар борооны улмаас зургаан хүн амиа алдаж, 30 гаруй айл усанд автжээ. Мөн Төв аймгийн Баянхангай сумаас Лүн сум хүртэлх 110-113 км автозам усанд автаж, засмал зам эвдэрч, олон машин техник эвдэрчээ.

2020 оны 7-р сарын 13-15-ны өдрүүдэд Увсад 16.0-36.0 мм, Хөвсгөл аймгийн Мөрөн хотод 40.0 мм дуу цахилгаантай бороо орсон. 7-р сарын 13-ны 18:00 цагаас эхлэн орсон усархаг бороо гурав хоног, гурван шөнө үргэлжилсний улмаас Увс аймгийн томоохон голууд үерлэж, зам, гүүр эвдэрсэн.


2020 оны 06 дугаар сарын 21-ний өдөр Улаанбаатар-Мандалговь /A0201/, Өндөрдов-Зуунмод ба Зуунмод-Налайх /A25/ улсын чанартай авто замуудад үер ус буусны улмаас замын хажуугийн суваг шуудуу эвдэрчээ.

### Цас болон зудын эрсдэл

2019 оны 1-р сарын 31-ний байдлаар нийт нутгийн 40 орчим хувь цастай байна. Ялангуяа хойд аймгуудын нутгаар их хэмжээний цас орсон боловч нутгийн зүүн өмнөд хэсгээр цас ороогүй байна.



Зураг 5. Цасны зузаан, 2019 оны 1-р сарын 31-ний байдлаар




3 дугаар зураг. Цасны зузаан, см  
(2020 оны 1 дүгээр сарын 31-ний байдлаар)

Зураг 6. Цасны зузаан, 2020 оны 1-р сарын 31-ний байдлаар


Жил бүрийн 11-р сарын 20-ны өдөр ЦУОШГ-аас Зудын эрсдэлийн газрын зургийг гаргадаг бөгөөд цас зудын нөхцөл байдлыг харгалзан шинэчилдэг.

2019 оны 11 дүгээр сарын 20-ны байдлаар зудын эрсдэлийн зураглалаас харахад нийт нутгийн 30 гаруй хувь нь өндөр эрсдэлтэй (хамгийн их эрсдэлтэй 7%, өндөр эрсдэлтэй 27%), 30-с дээш хувь нь (34%) дунд зэргийн эрсдэлтэй байна (Зураг 4).

Ховд, Говь-Алтай, Архангай, Өвөрхангай, Булган, Хэнтий, Сүхбаатар, Дундговь, Увс, Завхан, Баянхонгор, Хөвсгөл, Сэлэнгэ, Төв, Дорнод, Өмнөговийн ихэнх нутаг, Дорноговийн зарим хэсгээр өвөл, хаврын улиралд эрсдэл өндөр байлаа.



Зураг 7. Зудын эрсдэлийн зураг 2019 оны 11-р сарын 20-ны өдрийн байдлаар



Зураг 8. Зудын эрсдэлийн зураг 2020 оны 11-р сарын 20-ны өдрийн байдлаар

2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар, зудын эрсдэлийн зургаар Монгол Улсын газар нутгийн 40 хувь нь зудын өндөр эрсдэлтэй (хамгийн бага 6.0%, хамгийн их 30.4%), ойролцоогоор 30 хувь нь эрсдэлийн дунд түвшинд (28.2%) байна гэж тогтоогдсон (Зураг 9).

Баянхонгор, Говь-Алтай аймгийн өмнөд хэсэг, Өвөрхангай, Дундговь аймгийн нутаг дэвсгэр бүхлээрээ, Өмнөговь, Дорноговь, Төв, Сүхбаатар аймгийн зарим хэсэгт зудын эрсдэл байна. Өөрөөр хэлбэл, эдгээр нутаг дэвсгэрт өвөлжөө, хаваржаа хүндрэх эрсдэлтэй байдаг.


### Газар нутгийн ашиглалт

Бэлчээрийн доройтол нь Монгол Улсад тулгараад байгаа чухал сорилтуудын нэг бөгөөд бэлчээрийн доройтлын нэг шалтгаан нь бэлчээрийн даац хэтэрсэн явдал бөгөөд сүүлийн таван жилийн хугацаанд Монгол Улсын малын тоо жил бүр 13 орчим хувиар өссөн байна.

2019 оны байдлаар Монгол Улсын малын тоо толгой 70.9 саяд хүрч түүхэн дээд хэмжээнд хүрсэн нь 2014 оноос 22 хувиар, 1990 оныхоос гурав дахин өссөн үзүүлэлт юм. Одоогийн малын тоо толгой бэлчээрийн даацаас 2.4 дахин их байна. Энэ өсөлтийн 35 орчим хувь нь төл малын дөнгөж 22 орчим хувийг махны зориулалтаар борлуулж байгаатай холбоотой. Сүргийн тоо нэмэгдснээр бэлчээрийн төлөөх өрсөлдөөн нэмэгдэж улмаас бэлчээрийн даац хэтэрч, бэлчээрийн чанар доройтож, эко системийг нөхөн сэргээхэд удааширдаг. Хэт олон мал нэг бэлчээрийн талбайд эргэлдэж, бэлчээрийн ашиг шимийг хүртэж, сэлгэх хугацаа олгодоггүй улмаас системийн нөхөн сэргэх процесс удааширч бэлчээрийн даац хэтэрдэг. (Байгаль хамгааллын нийгэмлэг, 2021)

## Нийт малын тоо 1970 – 2020

Эх сурвалж : Үндэсний статистикийн хороо




Зураг 9. Монгол Улсын малын тоо 1970-2020 онуудад. Статистикийн ерөнхий хороо

### Тусгай хамгаалалттай газар нутаг


Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 2000 онд 21.7 сая га буюу нийт газар нутгийн 13.8 хувь, 2014 онд 27.2 сая га буюу газар нутгийн 17.4 хувь байсан бол 2020 онд 32.8 сая га буюу газар нутгийн 21 хувь болж нэмэгджээ.

Тусгай хамгаалалттай газар нутагт монгол орны ойн сангийн 39.2 хувь, гадаргын ус, гол горхи, булаг шанд, нуур, томоохон гол мөрөн, горхины 50.0 хувь, Соёлын өв газрын 80 хувь хамаардаг ба нэн ховордсон болон ховордсон 300 гаруй амьтад тусгай хамгаалалттай газар нутаг, байгалийн нөөц газар, үндэсний түүх газруудад тархан байдаг байна.

2020-2021 оны өвөл, хаврын бэлчээрийн даац, %  
(багийн нутгаар)



Зураг 10. 2020-2021 оны өвөл, хаврын бэлчээрийн даац



Хүний нөөцийн чадавхын хомсдол, менежментийн чадвар дутмаг, хүрэлцэн ирэх зочдыг хүлээн авах хөтөлбөр байхгүй зэрэг нь тусгай хамгаалалттай газрын менежментийн томоохон асуудлууд юм. Тусгай хамгаалалттай газар нутагт бичил уурхайн үйл ажиллагаа, хууль бус ан агнуур, буруу зохион байгуулалттай аялал жуулчлал зэргийг хянахад маш хүндрэлтэй байдаг. Уул уурхайн салбар, тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент нэгдмэл бус байдлыг ашиглан тусгай хамгаалалттай газар нутагт ялангуяа орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгодог.

## Усны хэрэглээ

Монгол орны нийт усны нөөц жилд дунджаар 608,300.0 сая м<sup>3</sup> (Мөсөн гол, Потанины мөсөн гол хайлсантай холбоотойгоор хэмжээ багасаж 564,800.0 сая м<sup>3</sup>) байгаагийн 34,600,0 сая м<sup>3</sup> гол мөрөн, 500,000.0 сая м<sup>3</sup> нуур, 62,900.0 сая м<sup>3</sup> (мөсөн голын хэмжээ багасч 19,400.0 сая м<sup>3</sup> болсон) мөсөн гол, 10,800 сая м<sup>3</sup> гүний ус эзэлж байна.

Гүний усны түвшингийн бүрэн мэдээллийг [www.groundwater.mn](http://www.groundwater.mn) сайтад бүртгэж, эндээс бүрэн хянах боломжтой байдаг.

График 1 болон 2-т 2019, 2020 онуудад аймаг тус бүрийн гадаргын усны эх үүсвэр алдагдсан байдал, сэргэсэн байдлыг харуулсан болно. 2019 онд 1266 гадаргын усны эх үүсвэр ширгэж, 457 эх үүсвэр сэргэсэн бол 2020 онд 684 гадаргын усны эх үүсвэр ширгэж, 476 эх үүсвэр сэргэсэн.




График 1. 2019 онд Монгол Улсын хэмжээнд ширгэсэн болон сэргэсэн усны эх үүсвэрийн тоо (Улбар шар өнгөөр ширгэсэн болон хатсан усны эх үүсвэр, хөх өнгөөр сэргэсэн усны эх үүсвэрийг тэмдэглэсэн болно)




График 2. 2020 онд Монгол Улсын хэмжээнд ширгэсэн болон сэргэсэн усны эх үүсвэрийн тоо. (Улбар шар өнгөөр ширгэсэн болон хатсан эх үүсвэр, хөх өнгөөр сэргэсэн усны эх үүсвэрийг тэмдэглэсэн болно)

№	Салбар	Ус ашиглалтын төлбөр	Ус ашигласан хэмжээ сая.м <sup>3</sup>	
			2019	2020
1.	Зөөврийн ус		83.2	83.2
2.	Ашиглах салбар	ХАА	351.7	353.0
		Уул уурхай	98.8	95.4
		Хүнд үйлдвэрлэл	0.067	0.059
		Эрчим хүч	31.4	40.8
		Хүнсний үйлдвэрлэл	2.7	2.8
		Хөнгөн үйлдвэрлэл	1.23	1.29
3.	Барилга	Барилга, барилгын материал үйлдвэрлэл	1.3	2.2
		Зам, зам засвар	0.051	2.645
4.	Ногоон дэд бүтэц, зам болон талбайн усалгаа		0.153	1.787
5.	Үйлчилгээний салбар		7.8	8.243
Нийт			<b>578.5</b>	<b>591.4</b>

Хүснэгт 6. 2019, 2020 онуудын нийт усны хэрэглээ

Мал аж ахуйн хэрэгцээнд хамгийн их хэмжээгээр Архангай 17.9 сая м<sup>3</sup>, Хөвсгөл 16.1 сая м<sup>3</sup>, Өвөрхангай 14.8 сая м<sup>3</sup> ус ашигладаг байна.

### Усны нөөц ба горим

Монгол орны М1:100000 газар зүйн байрлалд 0.0027 км<sup>2</sup>-аас дээш талбай бүхий 4355 нуур байдаг ба тэдгээрийн нийт талбай 15502.5 км<sup>2</sup> байдаг байна. 2000 оны LANDSAT ETM хиймэл дагуулын мэдээллээр, Монгол Улсад нийт 15,233.97 км<sup>2</sup> талбай бүхий 3,943 нуур байдгаас 412 нуур ширгэж, эзлэх талбайн хэмжээ 268 км<sup>2</sup> буюу 6.1 хувиар багассан байна. 2006 оны LANDSAT TM хиймэл дагуулын мэдээллээр, Монгол Улсад нийт 14,696.6 км<sup>2</sup> талбай бүхий 3,825 нуур байсан бол 2006 оны байдлаар 471 нуур ширгэж, эзлэх талбайн хэмжээ нь 818.1 км<sup>2</sup> буюу 5.3 хувиар багассан байна. 2010 оны LANDSAT TM хиймэл дагуулын мэдээллээр, Монгол Улсын хэмжээнд нийт 14,393.2 км<sup>2</sup> талбайтай 3,699 нуур байсан бол 2010 оны байдлаар 597 нуур ширгэж, эзлэх талбайн хэмжээ нь 1,121.49 км<sup>2</sup> буюу 7.2 хувиар багассан. 2014 оны LANDSAT L8 хиймэл дагуулын мэдээгээр, нийт 3,671 нуур тоологдсон ба тэдгээрийн нийт талбай 14,231.2 км<sup>2</sup>, нийт 684 нуур ширгэж, талбайн хэмжээ 1,271.3 км<sup>2</sup> буюу 8.2 хувиар багассан байна. 2015 онд 1330.7 км<sup>2</sup> буюу 8.58 хувиар буурсан үзүүлэлттэй байна (Г.Даваа болон бусад, 2015). (Зураг 28, 29)




График 3. Монгол улсын газар нутаг дахь нуурийн эзлэх хэмжээ, тоон динамик



LANDSAT L8 хиймэл дагуулын 2017 оны мэдээллээр, Монгол Улсын хэмжээнд 14,179.9 км<sup>2</sup> талбай бүхий 3,508 нуур байсан ба 2017 онд ширгэсэн нуурын тоо 788 болж, эзлэх талбай нь 1,334.6 км<sup>2</sup> буюу 8.6 хувиар багассан байна.

### **Гадаргын болон гүний усны бохирдол**

Голын ус харьцангуй богино хугацаа урсан өөрчлөгддөг боловч нитрат зэрэг бохирдуулагч бодис голын усанд удаан хугацаагаар хадгалагдан үлддэг. Тухайн гол, горхины уртын хэмжээнээс шалтгаалан гол, горхи, гуу жалгын усыг янз бүрийн бохирдлоос хамгаалахын тулд малын сэгийг голын эргээс 50-300м ба түүнээс дээш зайд булшлах хэрэгтэй. Үүнээс гадна шүлхий, адууны томуу болон бусад малын гоц халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. Хэрэв ийм арга хэмжээ аваагүй тохиолдолд хавар болон зуны улиралд айл өрх ундны ус, мал аж ахуйд бохирдсон ус хэрэглэж, цаашлаад зуд болох, халдварт өвчин тархан гол шалтгаан болдог.

Сүүлийн жилүүдэд цианид, мөнгөн ус, хүхрийн хүчил зэрэг хорт бодисууд байгаль орчинд, ялангуяа гол мөрөн, гүний ус, хөрсөнд ихээхэн хор хөнөөл учруулж байна.

2020 онд Архангай аймгийн Цэнхэр сум, Баянхонгор аймгийн Баян-Овоо сум, Сэлэнгэ аймгийн Гурванбулаг, Бууцагаан, Бөмбөгөр, Ерөө, Бугант сумууд, Төв аймгийн Заамар сум, Дархан хотын Шарын гол сум, Ховд аймгийн Булган сумын Байтаг баг, Увс аймгийн Өмнөговь сумын Орлогын гол, Түргэн сумын Улаанначин сумуудад хууль бусаар алт олборлох буюу бичил уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа нь батлагдсан. 2020 онд Ерөө-Бугант, Туул-Заамар, Туул-Алтанбулаг ус судлалын станцуудын ойр орчимд их хэмжээний бохирдол үүссэн байсан.

### **Мөсөн гол хайлах**

M1:100,000 байр зүйн зургаар Монгол орны мөсөн гол, мөстлөгийн нийт талбай 667.77 км<sup>2</sup> байдаг боловч нийт мөсөн голыг хамардаггүй байна. 2000-2002 оны LANDSAT хиймэл дагуулын мэдээгээр, 42 ууланд тархсан мөсөн уулын нийт талбай 451.0 км<sup>2</sup> байна. 1940-өөд оны үед Монгол орны нийт мөстлөгийн талбай 535.0 км<sup>2</sup> орчим байсан байна. Эдгээрээс үзэхэд M1: 100,000 топазура дахь мөсөн голын талбайн алдаа 20 орчим хувь байх магадлалтай.

Судалгаагаар Монгол орны мөсөн гол, мөстлөгийн талбай 1940 онд 535 орчим км<sup>2</sup>, 1990 онд 470 орчим км<sup>2</sup>, 2000 онд 451 км<sup>2</sup>, 2011 онд 389 км<sup>2</sup> байсан гэж дүгнэж байна. 1940-1990 онуудыг харьцуулахад нийт мөсөн гол, мөстлөгийн талбай 12.1 хувиар, 1990-2000 онуудыг харьцуулахад 4.0 хувиар, 2000-2011 онуудыг харьцуулахад 13.7 хувиар, сүүлийн 70 жилд нийтдээ 29.9 хувиар буурсан байна.

Мөсөн голын хайлах түвшин 1990 он хүртэл харьцангуй бага байсан ба түүнээс хойш эрчимжиж сүүлийн 10 жилд хамгийн өндөр хэмжээнд хүрсэн байна (Г.Даваа нар, 2016). Тэгш оройтой мөсөн голууд зонхилдог учир Цамбагаравын нуруунд мөстлөгийн хайлах түвшин хамгийн өндөр байна. Таванбогд, Хархираа, Түргэний нуруунд хөндийн мөстэй газар, унжсан мөстлөг, хөндлөн мөстлөг байдаг тул мөстлөгийн хайлах түвшин дунджаас их байна. Харин Мөнххайрхан ууланд үзүүртэй мөсөн гол байрладаг учир мөсний хайлах түвшин харьцангуй бага байна.

Их Британийн Газарзүйн Нийгэмлэгийн нэрт судлаач Дуглас Каррутерс (Douglas Carruthers) 1910 онд мөсөн голын зургийг авч байсан. 2010 оны наймдугаар сард Монгол-Америкийн хамтарсан хайгуулын экспедици мөн мөсөн голын хэмжилтийг хийж, эдгээр үр дүнг хиймэл дагуулын зурагтай харьцуулсан байна.

### **Ой мод**

Монгол орны ойн нөөц 1,248,642,118 шоо метр байдаг ба үүний 79.28% шинс, 8.91% хуш, 5.96% хус, 4.95% нарс, 0.23% шилмүүст мод, 0.01% гацуур, 0.18% улиангар, 0.05% хайлаас, 0.28% бургас, 0.14% заг эзэлдэг байна.

Шилмүүст ойн дундаж насжилт 131 жил, га тутмын талбайн нөөц 142.8 м<sup>3</sup>, өсөлт 1.1 м<sup>3</sup> байдаг байна. Навчит ойн дундаж насжилт 43 жил, га тутмын талбайн нөөц 44.4 м<sup>3</sup>, өсөлт 1.02 м<sup>3</sup>, ба жилийн дундаж өсөлт 10,251.5 м<sup>3</sup> байдаг.

**Ой модны сийрэгжилт:** Манай улсын хойд бүсэд 10.4 сая га талбай ой мод эзэлдэг ба үүний 2.0 сая га заган ой, тээврийн коридорын ойролцоо 3.6 сая га талбай бүхий сийрэгжсэн ой байдаг байна. Хууль ёсны, хууль бусаар мод бэлтгэх, ой хээрийн түймэр, хортон шавьжны тархалт, малын бэлчээр болгох, уур амьсгалын өөрчлөлт зэрэг нь ой мод сийрэгжих гол шалтгаан болдог боловч ой мод сийрэгжилт, сүйтгэлийн талаар үнэн зөв статистик тоон мэдээлэл боловсруулахад хүндрэлтэй байдаг.

1960-1990 онуудад жилд дунджаар 1,500-2,000 сая шоо метр албан мод бэлтгэсний 50 хувийг мод, модон эдлэл бэлтгэл, 50% хувийг түлш бэлтгэлд ашигладаг байв. 2002 оны албан мэдээллээр 620 сая м<sup>3</sup> мод бэлтгэсэн ба үүний бараг бүх хувийг түлшний мод бэлтгэхэд ашигласан байна. Ойн менежментийн бусад томоохон асуудлууд нь ой, хээрийн түймэр мөн хортон шавьжтай тэмцэх зэрэг байдаг. Шилмүүст ойн хортон шавьжны халдварт өвчлөл нь тухайн орон нутагт ноцтой хор хөнөөлт байгалийн гамшигт үзэгдэл юм.

Мөн таван хошуу малын бэлчээрлэлт Монгол орны ойн сийрэгжилт, доройтолд шууд болон шууд бусаар нөлөөлж байна. Өмнө зүгийн заган ой, хойд нутгийн ой модыг малын бэлчээр хэлбэрээр (заримдаа улирлын чанартай) ашигладаг бөгөөд Монгол улсын нийт малын 35-40 орчим хувь ойн бүс, түүний ойр орчимд бэлчээрлэдэг.

Доктор Эмертон болон Энхцэцэг (2013) нарын судалгаанд жилд дунджаар 34.5 тэрбум төгрөг (24.70 сая ам. доллар)-ээс их хэмжээний өртөг бүхий ой модыг малын бэлчээрлэлтэд ашиглаж байгаа нь тухайн сумын малын бүтээгдэхүүний 5 хувьтай тэнцэж байгаа үр дүн гаргасан байна.

Малын бэлчээр ойд олон сөрөг нөлөө үзүүлдэг. Тухайлбал, бэлчээрийн даац хэтэрсэн үед мал залуу мод, суулгацыг ихээр идэж гэмтээснээр ойн нөхөн сэргэлтэд саад учруулдаг. Олон талт улсын ойн тооллогоор (2014-2016) Алтай, Хангайн бүсийн ой мод 14.7%, 32% буюу дунд зэргийн бэлчээрийн нөлөөтэй, тухайн бүс нутгийн 20.4%, 2.3% нь эрчимтэй бэлчээрийн дарамтанд орсон байна (Зураг 5.8).




Зураг 11. Хангайн бүсийн ой модонд малын бэлчээрийн үзүүлж буй нөлөөлөл (НҮБ-ын REDD хөтөлбөр 2017)

Зураг 12. Малын бэлчээрээс үүдэн ойн гүнд үзүүлэх дарамт (UN-REDD 2017 хөтөлбөр)

### Хог хаягдал, химийн болон аюултай материал

Монгол Улсын хэмжээнд хатуу хог хаягдлыг хот, суурин, сумын төвийн ойролцоох задгай газарт булж байна. Ингэснээр хог энд тэндгүй хийсэн тархаж хөрсний бохирдол үүсгэхэд гол нөлөөлж байна. Улаанбаатар, Эрдэнэт, Дархан зэрэг томоохон хотуудын хот төлөвлөлт, хотыг тэлэх төслүүдийн хооронд асар их зөрүү байгаа ба одоогоор хот төлөвлөлтийн жишиг төсөл байхгүй байна. Зуны улиралд хог хаягдлыг ахуйн хог хаягдал (33.8%), цаас (18.9%), хуванцар (15.2%) эзэлж байдаг. Өвлийн улиралд хог хаягдлын 60.2% -иас багагүй хувийг үнс эзэлдэг.

Монгол Улсад хог боловсруулах тохирсон байгууламж байхгүй улмаас хог хаягдлыг хаа сайгүй хаях хандлагатай. Ялангуяа Улаанбаатар хотын хог хаягдлын асуудал ноцтой байна. Одоо хотын захиргаанаас төрийн болон хувийн хэвшлийн, жижиг дунд аж ахуйн нэгжүүдтэй хог хаягдлыг тээвэрлэхэд хамтран ажиллаж байна.



Үйлдвэр, худалдааны байгууллага, барилгын талбайгаас үүссэн хатуу хог хаягдлыг гуравдагч этгээдийн байгууллагууд цуглуулдаг. Гэсэн хэдий ч ийм их хэмжээний хатуу хог хаягдал төвлөрснөөр хог хаягдал цуглуулах аж ахуйн нэгжийн хүчин чадлаас хэтэрдэг.

### Хөрсний бохирдол

Монгол орны хувьд автомашины хаягдал тос, уул уурхайн олборлолтын явцад үүсэж буй химийн бодисыг ялгаруулах, хөдөө аж ахуйн химийн бодис ашиглалт нэмэгдэх зэрэг нь хөрсний бохирдол нэмэгдэхэд нөлөөлж байна. Агаарын бохирдлын гол шалтгаан нь нүүрс түлэх, ашиглах юм. Нүүрсний үнс нурам газарт цацагдсанаас хөрс мөн бохирдож байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад автомашины тоо эрс нэмэгдэж байна. Хот доторх болон төв замуудын ойролцоох шатахуун түгээх станцын тоо 800 орчим болж нэмэгдсэн. Цаашилбал, нүүрсний тос гаргаж авдаг төхөөрөмж, гражууд хэдэн зуугаараа тоологдож байна. Тэдгээрийн ихэнх нь ус зайлуулах дэд бүтцийн байгууламжгүй, ашигласан тосоо ус зайлуулах суваг руу шууд хаяснаар хөрсийг бохирдуулдаг байна. Мөн түүнчлэн ариутгалын бодис, шавьж устгах бодис, хөдөө аж ахуйн химийн

бодис зэрэг химийн бодисууд, эмнэлгийн хог хаягдал, архитектурын хаягдал мод зэргийг боловсруулах үйлдвэрлэлд ашиглан эдийн засгийн өсөлтийг дэмжихийг хичээж байна.

Монгол улсын хэмжээнд 120 гаруй аж ахуйн нэгжүүд алт, нүүрс, зэс, төмөр болон бусад ашигт малтмалын олборлолт хийж байна. Алтны олборлолт нь мөнгөн усны бохирдол их хэмжээгээр үүсгэдэг ба улмаар хөрсийг бохирдуулдаг. Стандартад нийцээгүй хог хаягдал хадгалах сав, бохирын ус зайлуулах байгууламжууд хүчтэй борооны үеэр эвдэрч их хэмжээний химийн бодис ялгардаг.

2007-2013 оны хооронд Монгол Улсын Засгийн газрын нийт зээл тусламжийн 4.7 орчим хувийг хөдөө аж ахуйн салбарт (үр тариа, мах боловсруулах) олгосон статистик тоо мэдээлэл харуулж байгаа ба үр тарианы тариалалтыг дэмжихийн тулд асар их хэмжээний зээл, санхүүгийн дэмжлэг олгодог. Засгийн газраас баримталж буй энэхүү бодлогын үр дүнд газар тариалангийн салбарт оруулсан хөрөнгө оруулалт тасралтгүй нэмэгдэж, үүнээс азотын бордооны импорт сүүлийн 3 жилийн хугацаанд жилд 10 мянган тонноор нэмэгдэж байна (ҮБСХ 2015). Төрөөс химийн бодисын ашиглалтын зохицуулалт сул байгаагаас хүрээлэн буй орчин, бүтээгдэхүүнд химийн бордоо, хортон шавьжны уусмал их хэмжээгээр үлдэж байгааг зарим судлаачид онцолж байна. 2000 оноос хойш хэрэгжиж буй газар тариалангийн хөтөлбөр, бодлогын баримт бичгүүдэд төрөөс газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарч байгаа боловч экологийн тэнцвэрт байдал, хөрсний үржил шим, усны нөөцийг хэмнэлттэй ашиглах асуудлыг шийдвэрлэх санхүүгийн дэмжлэгийг үл тоомсорлон хөрс, усны нөөцөд аюул учруулж буй байдлыг анхаарахгүй байна.

### **Амьтны аймаг**

Хүн амын өсөлт, хотжилт, эдийн засгийн хөгжил, нэг хүнд ногдох байгалийн нөөцийн эрэлт нэмэгдэж байгаа нь газар, байгалийн нөөцөд асар их дарамт учруулж биологийн олон хэв шинжит байдлыг алдагдуулж байна. Үүний зэрэгцээ төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт зах зээлд шилжсэн нь манай улсын байгалийн баялгийг аж ахуйн нэгж эзэмшиж чөлөөт зах зээлийн харилцаанд оруулдаг болсон.

Уул уурхай, газар тариалан, үр тарианы ургуулах үйл ажиллагаа нэмэгдсэнээр зэрлэг болон тэжээвэр амьтдын түүхий эдийг дотоодын хэрэгцээнд зориулан үржүүлэх, экспортлох зэрэг нь өнөөг хүртэл хөндөгдөөгүй байсан байгалийг сүйтгэж, ан амьтдын амьдрах орчинг алдагдуулж байна. Зохисгүй хяналттай буюу хууль бус агнуур, махчин амьтдыг устгах зэрэг нь зэрлэг ан амьтад болон байгалийн тэнцвэрт байдалд дарамт учруулж байна.

## **Нийгмийн суурь мэдээлэл**

### **Хүн ам, хөдөөгийн хөгжил**

Монгол Улс нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд 21 аймаг, нийслэл хот Улаанбаатараас бүрдэнэ. Нийт 329 сум<sup>11</sup>, 1568 багтай<sup>12</sup>. Аймгийн төвүүдэд амьдардаг иргэдийн дийлэнх хувь нь хөнгөн үйлдвэр, үйлчилгээ, жижиг бизнесийн салбарт ажилладаг. Багийн иргэдийн хувьд газар тариалан, мал аж ахуй эрхлэлдэг ба нүүдлийн амьдралтай. Малчид цаг улирлын байдал, цаг агаараас хамааран нүүдэллэдэг. Малчдын нүүдэллэн суурьших газар нь ердийн үед сум, багийн нутгийн хил дотроо байдаг бол зуд, ган болон бусад байгалийн гамшигт үзэгдлийн үед бусад газарт нүүдэллэх шаардлага гардаг. Үндэсний Статистикийн Хорооны (ҮСХ) мэдээллээр, 2020 оны сүүлээр нийт малчин өрхийн тоо 181,5 мянга байв. Малчин өрхийн жилийн дундаж орлого нь 10,5 сая байгаа нь нийт өрхийн дундаж орлогоос 6,9%-р бага байна. ҮСХ-ний судалгаагаар үндэсний хэмжээнд өрхийн орлого 2016-2020 онд 3.0-9.8%-р буурсан үзүүлэлттэй байна.

<sup>11</sup> Сум нь аймгийн доорх засаг захиргааны нэгж юм.

<sup>12</sup> Баг нь сумын доорх засаг захиргааны хамгийн анхан шатны нэгж юм.

	Хүн ам	Өрх	Малчдын тоо	Малтай өрхийн тоо	Өрх толгойлсон нийт өрхийн тоо	Өсөлтийн хувь	Дундаж наслалт, Эр	Дундаж наслалт, Эм
<b>Үндэсний нийт</b>	<b>3,357,542</b>	<b>908,712</b>	<b>298,789</b>	<b>242,024</b>	<b>86,525</b>	<b>4.2</b>	<b>66.71</b>	<b>76.22</b>
Архангай	94,088	27,373	25,907	19,497	3,560	3.4	69.49	73.67
Булган	<b>61,955</b>	<b>18,698</b>	14,186	11,031	<b>2,068</b>	2.6	69.08	76.35
Өвөрхангай	115,732	33,700	28,334	19,813	4,420	3.5	68.98	74.08
Сүхбаатар	63,822	18,231	15,006	<b>10,782</b>	2,873	<b>4.3</b>	68.04	78.5
Төв	93,162	27,669	19,170	16,393	3,409	<b>2.3</b>	<b>70.37</b>	75.13
Увс	83,524	21,874	16,577	13,248	2,390	4.2	65.46	74.21
Хөвсгөл	<b>135,705</b>	<b>38,599</b>	<b>31,290</b>	<b>21,384</b>	<b>5,379</b>	3.6	<b>64.48</b>	<b>72.45</b>
Хэнтий	78,172	24,372	<b>12,818</b>	11,546	2,864	3.7	70.03	<b>76.78</b>
Улаанбаатар	1,597,290	414,292	3,781	5,006	19,737	4.5	67.39	75.36

**Үндэсний цөөнх.** Монгол Улс нь харьцангуй нэг төрлийн үндэстнээс бүрддэг ба хүн амын 90 хувь нь монгол, дийлэнх нь халх (83,8) үндэстэн ба өвөрмөц аялга, соёл бүхий бусад Монгол үндэстнүүд байна. Казах хэлээр ярьдаг цөөнх хүн амын 3,8 хувийг эзлэх ба баруун хязгаарын Баян-Өлгий аймагт төвлөрөн амьдардаг. Бусад үндэстний цөөнх болох буриад, тува, урианхай, хотон үндэстнүүд хүн амын 0.4-1.4 хувийг эзэлдэг. Казах хэлээр ярьдаг цөөнх болох нутаг дэвсгэрийн баруун хязгаарын Баян-Өлгий аймагт дийлэнх нь төвлөрөн амьдрахаас гадна Ховд аймгийн зарим нутаг дэвсгэрт, Улаанбаатар хотын Налайх дүүргийн хүн амын 30 хувийг эзэлдэг. Бусад үндэстнүүдийн хувьд туваа хэлээр ярьдаг цаатан (мөн духа гэдэг), турк хэлээр ярьдаг уйгур, урианхай, хотон үндэстнүүд байдаг. Төслийн нөлөөллийн бүс нь нийт нутаг дэвсгэрийг хамрах тул үндэстний цөөнхүүд нь төслийн үр шимийг хүртэгчдийн нэг байна.

**Малчдын амьжиргаа, хөдөлмөр эрхлэлт, жендэрийн үзүүлэлтүүд.** Малчдын орлого<sup>13</sup> нь ноолуур, мал, махны худалдааны орлогоос бүрдэх ба малын бүтээгдэхүүний үнэ малчин өрхийн амьжиргааны түвшинд хүчтэй нөлөө үзүүлдэг. Малчин өрхийн амьжиргаанд нөлөөлдөг олон гол хүчин зүйлийн нэг нь малын бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл юм. Малын бүтээгдэхүүний худалдаанд дундын зуучлагч худалдаачид болон жижиглэн худалдаачид голлох үүрэг гүйцэтгэдэг. Малчид дийлэнхдээ мал, махаа жижиглэнгийн худалдаачдад худалддаг. Малчид малын бүтээгдэхүүний үнийн уналтын үед өрхийн орлогыг дээшлүүлэхийн тулд малын тоо толгойг өсгөхөд онцгойлон анхаарч малын эрүүл мэнд болон малын бүтээгдэхүүний чанарт анхаарал хандуулдаггүй. Малчид нь жижиглэнгийн худалдаачдаар дамжуулахгүйгээр мал, махаа боловсруулагчдад шууд борлуулах сонирхол өндөр байдаг боловч энэ нөхцөл бүрдээгүй байна. Малчдын 89,4% нь боловсруулагчидтай мал болон малын мах худалдах гэрээ хийх сонирхолтой байгаа боловч боловсруулагчид мал, махыг ангилахаас гадна зах зээлийн үнээс доогуур үнийг санал болгодог байна.

Нийгэм эдийн засгийн 2017 оны судалгаагаар харилцаа холбооны үйлчилгээний хүртээмж, хангалтын хувьд нийт малчин өрхийн 16,2 хувь нь интернэт хэрэглэдэг 15+ насны малчдын 85.0% нь гар утастай байв. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хэрэглээг нэмэгдүүлэх нь малчдад мэдээлэл түгээх, малчидтай мэдээлэл солилцоход чухал ба малчин өрхүүд нэмэгдүүлнэ. Малчин өрхийн нийгэм эдийн засгийн судалгаагаар нийт малчдын 85,1% нь 2016-2017 оны өвөлд бэлтгэн малын өвс, тэжээл бэлдсэн байв.

<sup>13</sup> Малчин өрхийн орлогын гол эх үүсвэрүүд: Мал аж ахуйн орлого; Тэтгэвэр болон нийгмийн тэтгэмжүүд; Ургац хураалтын үйл ажиллагааны орлого; Бусад нэмэлт орлого/цалин болон жижиг бизнесүүд. Мал аж ахуйн орлогод: сүүн болон сүүн бүтээгдэхүүнийг зарж борлуулснаас олох орлого, ноолуур, бусад төрлийн ноос, мах, малын арьс болон мал зарсны орлого орно. Малчдын авдаг нийгмийн халамжийн төрлүүд нь: Хүүхдийн мөнгө, Оюутны сургалтын төлбөрийн дэмжлэг, тэтгэвэр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэмж болон хүнсний талон.

Малчин өрхийн ажлын ачаалал улирлаас хамааран өөрчлөгддөг. Хамгийн өндөр ачаалал нь мал төллөх хаврын үеэр (3 сар, 4 сар) болон зуны сүү цагаан идээний (7-8 сар) цаг байдаг. Өвлийн цагаар (11-1-р сард) хамгийн бага ачаалалтай байдаг байна. Эмэгтэй малчдын ажлын ачаалал эрчүүдийнхээс 3 болон 12-р сарыг тооцохгүйгээр жилийн бүх саруудад илүү байдаг. Эмэгтэйчүүдийн жилийн турш дахь өдрийн дундаж ажлын цаг 11,1 байхад эрчүүдийнх 9,2 цаг байна. Хэдий ийм боловч эмэгтэйчүүдийн үүрэг, оролцоо өрхийн бусад асуудалд жишээ нь малчин өрхийн шийдвэр гаргалт, өрхийн төсвийн зарцуулалт, худалдан авалт, орон нутгийн нийгмийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, манлайлал хангалттай бус байна. Өрхийн өмч хөрөнгийн удирдлагын хувьд хөрөнгө нь эрчүүдийн нэр дээр бүртгэлтэй байдаг байна. Энэ алдагдсан харьцаа нь өрхийн болон иргэдтэй үнэ хаялцах, хэлэлцэх эрх мэдэл болон эмзэг байдалд нөлөөлөх боломжтой. (Жендэрийн дүн шинжилгээ, 2015).

Багийн түвшний олон нийтийг хамарсан үйл ажиллагаанууд болон малчдын байгууллага болох бэлчээр ашиглагчдын бүлэг (БАБ), нөхөрлөлийн үйл ажиллагаанд оролцох оролцооны хувьд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс тооны хувьд илүү оролцдог байна. Эмэгтэйчүүдийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцоход тулгардаг үндсэн асуудал нь гэрийн өдөр тутмын ажлууд болон хүүхэд, өндөр настныг асрах ажил юм. Малчид нөхөрлөл, хамтын ажиллагаа, БАБ-үүдэд зөвхөн түүхий эд, материалаа худалдах, урамшуулал авах зорилгоор нэгдэж ордог байна. Ялангуяа, малчдын 39,3% нь БАБ/нөхөрлөлийн гишүүд боловч тэдний тэн хагас нь түүхий эд материалтай холбоотой урамшуулал авах зорилготой байжээ.

Хүүхдүүд өрхийн ачааллыг хуваалцахад чухал дэмжлэг болдог. Сургууль завсардалтын хувьд хүйсийн ялгаатай хандлага байх ба охидын 9 хувь нь сургууль завсардсан бол хөвгүүдийн 16 хувь сургуулиас завсарддаг байна. Охид, хөвгүүдийн ирээдүйн талаарх мөрөөдөл нь эцэг, эхийнхээс зөрүүтэй байдаг байна. 65 охид хөвгүүдээс авсан ярилцлагаас үзэхэд тэдний 85 хувь нь малчин болохыг хүсэхгүй, дээд шатны боловсрол эзэмших хүсэлтэй байв. Нөгөө талаас ярилцлагад оролцсон эцэг эхчүүдийн 53,5 хувь нь хүүхдүүдээ, ялангуяа хөвгүүдээ малчин болгох хүсэлтэй байжээ.

**Газрын доройтол.** Газрын доройтолд 2 хүчин зүйл нөлөөлж байна: байгалийн болон хүний хүчин зүйлс. Байгалийн хүчин зүйлсэд усны хомсдол, салхины доройтол, цөлжилт багтана. Хүний үйл ажиллагааны хүчин зүйлс нь уул уурхай болон бусад ижил төстэй үйл ажиллагаанаас үүдэлтэй олон салаа хөрсөн гаргах, бэлчээрийн даацын хэтрэлт, газрын доройтол юм. Малчид бие биетэйгээ жилийн турш бэлчээр, усны нөөцийн төлөө тэмцэлдэхээс аргагүй байдалд ордог. Хэдэн сая малаас болж бэлчээрийн даац хэтрэхийн хэрээр ургамлын төрлүүдийн тоо, тэдгээрийн өгөөжийн чанар ихээхэн хэмжээгээр багассаар байна. Хөдөө Аж Ахуйн Их Сургууль, Цаг уур, орчны шинжилгээний газраас гаргасан Монгол орны Бэлчээрийн төлөв байдлын тайланд дүрдсанаар “Ойролцоогоор бэлчээрийн ургамлын 65-70 хувь нөхөн сэргэх чадвараа алдсанаас гадна, ургамлын үндэс суларснаас үүдэн ургамлын төрөл ховордож, тооны хувьд багассан. Нөхөн сэргэх чадавхын хувьд хээр болон ойт хээрийн бүс нутаг хамгийн муу байна.” гэжээ.

#### Эмзэг байдал ба жендэрийн асуудал

Төслийн нөлөө үзүүлэх газар нутгийн хүрээнд дараах эмзэг бүлгүүд (зөвхөн эдгээр бүлгүүдээр хязгаарлагдахгүйгээр): малчид, малтай өрхүүд, туслах малчин өрхүүд, бага орлоготой болон 200-с бага малтай өрхүүд, ганц бие өрх толгойлсон өрхүүд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдгээрийг асран хамгаалагчид, хүүхдүүд, залуучууд, сургуулиас завсардагсад, ажилгүйчүүд, хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд, хөгшид, туршилтын ложистикийн төвийн болон замын ойролцоох нутгийн иргэд, мах үйлдвэрлэгчид болон махны худалдаачид, жижиг худалдаа эрхлэгчид, албан бус бизнес эрхлэгчид багтаж болно. Угсаатны цөөнх нь төслийн үр шимийг хүртэгч аймгуудад багтах ба тухайлсан газар нутаг/суманд тусдаа бие даасан өрх болон хот айлаараа амьдардаг. БОНМХ-ний нийгмийн үнэлгээг Ядуу болон Эмзэг Иргэд, Бүлгүүдэд үзүүлэх болзошгүй эрсдэл, нөлөөллийг шийдвэрлэх Дэлхийн Банкны удирдамжийн дагуу бэлтгэлээ. Төслийн нөлөөлөл үзүүлэх газар нутгийн хүрээнд дараах эмзэг бүлгүүд (зөвхөн уг жагсаалтаар хязгаарлахгүй) байж болно:

Хүснэгт 8. 2020 оны байдлаарх өрхийн мэдээлэл

Гол эмзэг бүлгүүд	Эмзэг байдалд хүргэж буй хүчин зүйлс	Боломжит нөлөөлөл
Малчид болон малтай өрхүүд	Нас, хүйс, нийгмийн байдал, мал аж ахуйн орлогоос өндөр хамааралтай байдал, логистикийн үйлчилгээ, тээврийн холбогдох байдал, байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлт, шийдвэр гаргалт болон төлөвлөлт/төсөллөлтийн үйл явцын оролцоонд хамрагдахгүй байх.	Ерөнхийдөө эерэг, гэвч түр зуурын бүтээн байгуулалтын явцад сөрөг нөлөөтэй байж болно.
Бага орлоготой болон 200-с бага малтай өрхүүд	Нас, хүйс, нийгмийн байдал, (яс үндэс, боловсрол, гэр бүлийн гишүүдийн тоо, хамаарал болон хүйсийн харьцаа), нийгэм эдийн засгийн сул талууд, жендэрт суурилсан хүчирхийлэл, мал аж ахуйн орлогоос өндөр хамааралтай байдал, нийгмийн халамжийн дэмжлэг, сургуулийн дотуур байр, анхан шатны эрүүл мэндийн тусламж зэрэг төрийн үйлчилгээнүүд, логистикийн үйлчилгээ, зам тээврийн, байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлт, шийдвэр гаргалт болон төслийн төлөвлөлт/төсөллөлтийн үйл явцын оролцоонд хамрагдахгүй байх.	Ерөнхийдөө эерэг, гэвч түр зуурын бүтээн байгуулалтын явцад сөрөг нөлөөтэй байж болно.
Туслах малчин өрхүүд		
Ганц бие өрх толгойлсон өрхүүд		
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдгээрийг асран хамгаалагчид	Бие мах бодь, сэтгэц болон бусад төрлийн хөгжлийн бэрхшээлүүд, нас, хүйс, аюулгүй байдал, хөдөлгөөний хязгаарлалт, нийгмийн байдал, боловсрол, ажил эрхлэлтийг дэмжих болон бусад нийгмийн үйлчилгээний хязгаарлагдмал хүртээмж, жендэрт суурилсан хүчирхийлэл, нийгэм эдийн засгийн сул талууд, нийгмийн халамжийн дэмжлэгээс өндөр хамааралтай байдал, тээврийн үйлчилгээ, шийдвэр гаргалт болон төлөвлөлт/төсөллөлтийн үйл явцад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүлгийг үл оролцуулах, тэдний хэрэгцээ шаардлагыг үл харгалзах.	Ерөнхийдөө эерэг, гэвч түр зуурын бүтээн байгуулалтын явцад сөрөг нөлөөтэй байж болно.
Хүүхдүүд, залуучууд болон сургууль завсардагсад	Нас, хүйс, нийгмийн байдал, ажил эрхлэлтийг дэмжих болон бусад нийгмийн үйлчилгээний хязгаарлагдмал болон хүртээмжгүй байдал, жендэрт суурилсан хүчирхийлэл, шийдвэр гаргалт болон төслийн төлөвлөлт/дизайныг гаргах үйл явцад оролцоог үл хангах.	Ерөнхийдөө эерэг, гэвч түр зуурын бүтээн байгуулалтын явцад сөрөг нөлөөтэй байж болно.
Эмэгтэйчүүд, залуу охидууд болон өрх толгойлсон эмэгтэйчүүд	Нас, хүйс, нийгмийн байдал, нийгэм эдийн засгийн сул талууд, аюулгүй байдал, жендэрт суурилсан хүчирхийлэл, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний хязгаарлагдмал, хүртээмжгүй байдал, тээврийн үйлчилгээнээс хамааралтай байдал, хөдөлгөөний хязгаарлалт.	Ерөнхийдөө эерэг, гэвч түр зуурын бүтээн байгуулалтын явцад сөрөг нөлөөтэй байж болно.
Ажилгүйчүүд болон шилжин ажиллагсад	Нас, хүйс, нийгмийн байдал, нийгэм эдийн засгийн сул талууд, ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдал, жендэрт суурилсан хүчирхийлэл, төрийн үйлчилгээний хязгаарлагдмал, хүртээмжгүй байдал, тээврийн үйлчилгээнээс хамааралтай байдал, хөдөлгөөний хязгаарлалт.	Ерөнхийдөө эерэг, гэвч түр зуурын сөрөг нөлөөлөл байж болно.
Хөгшид	Нас, хүйс, нийгмийн байдал, хөдөлгөөний хязгаарлалт, тээврийн үйлчилгээнээс өндөр хамааралтай байдал.	Ерөнхийдөө эерэг, гэвч түр зуурын бүтээн байгуулалтын явцад сөрөг нөлөөтэй байж болно.
Замын ойролцоох нутгийн иргэд	Нас, хүйс, нийгмийн байдал, газар болон төсөл хэрэгжиж буй газрын байршилтай холбоотой орлогын болон амьжиргааны хамаарал, бизнесийн боломжууд, тээврийн холбогдох байдал, логистикийн үйлчилгээнүүд, шийдвэр гаргалт болон төслийн төлөвлөлт/төсөллөлтийн үйл явцын оролцоонд хамрагдахгүй байх.	Ерөнхийдөө эерэг, гэвч түр зуурын сөрөг нөлөөлөл байж болно.
Мах үйлдвэрлэгчид, дундын зуучлагч худалдаачид болон жижиглэнгийн худалдаачид	Орлого олох болон алдах, амьжиргаа, нийгэм эдийн засгийн статус, төслийн төлөвлөлт/дизайныг гаргах үйл явцад оролцоог үл хангах.	Эерэг ба /эсвэл сөрөг
Жижиглэнгийн худалдаачид болон албан бус бизнес эрхлэгчид	Орлого олох болон алдах, амьжиргаа, нийгэм эдийн засгийн сул талууд, төслийн төлөвлөлт/дизайныг гаргах үйл явцад оролцоог үл хангах.	Эерэг ба /эсвэл сөрөг

2016 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд саадгүй орчныг бий болгох, ирээдүйн алсын харааг тодорхойлсон тусгай зүйл заалтыг оруулсан. Хэдийгээр гадаад орчин, тээвэр, мэдээлэл, хүртээмжийг дэмжих төхөөрөмж, хэрэгслийг хуульчилж өгсөн ч хэрэгжилт системтэй бус, сул байна. Үндэсний Статистикийн Хорооны мэдээллээр 2018 онд 21 аймагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 70,141 байсан ба үүнээс 39,963 нь эрэгтэй, 30,178 нь эмэгтэй байв. Дэд бүтцийн хөрөнгө оруулалт, тээврийн үйлчилгээнд сонголт, хараа, хөдөлгөөний гэх мэт хөгжлийн бэрхшээлийн онцлог ялгаатай хэрэгцээг тусган оролцоог хангасан төсөллөлт, төлөвлөлтийн үйл явц дутагдалтай хэвээр байна. Хөдөлгөөний бэрхшээл, тээврийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй байдал нь төрөөс хүртэх үндсэн үйлчилгээ болох боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэх боломжийг хязгаарлаж улмаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олонх нь нийгмийн халамжаас хамааралтай, бие даан амьдарч чадахгүй хэвээр байна.

**Дундаж наслалт.** Монгол Улсын эрэгтэйчүүдийн дундаж наслалт нь эмэгтэйчүүдийнхээс 9.6 жилээр бага байна. (Эмэгтэйчүүдийн дундаж наслалт 76.0; эрэгтэйчүүдийнх 66.4) (ҮСХ 2018). Энэ зөрүүгээр дэлхийд 12-р байрт, Зүүн Өмнөд Ази болон Номхон далайн бүс нутагт 2-т орж байна. (ДЭМБ 2020). Монгол Улсын үндэсний баялгийн хуримтлал саяхнаас нэмэгдсэн боловч 1992-2018 оны хооронд эрэгтэйчүүдийн дундаж наслалт 5,4-хөн жилээр уртассан ба ижил хугацаанд эмэгтэйчүүдийн дундаж наслалт 10.9 жилээр нэмэгджээ (АХБ 2017).

**Хөдөлмөрийн оролцоо.** Монгол Улсын статистикийн мэдээнээс харахад эмэгтэй ажиллах хүчний оролцоо 2006 оноос хойш буурч 2018 он гэхэд 64.8% -иас 53.4% болсон байна. Энэ нь эдийн засгийн хямрал эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд илүү их нөлөөлсөн болохыг харуулж байгаа бөгөөд ялангуяа эмэгтэй ажиллах хүчний оролцоо 2018 оны байдлаар хот суурин газарт, тухайлбал нийслэлд (44.8%) хөдөөгийн эмэгтэйчүүдтэй (60.5%) харьцуулахад илүү нөлөөлөгдсөн байна. (АХБ 2018) Одоогоор энэ талаарх хүйсээр нь ангилсан тоо баримт, судалгааны үр дүн хязгаарлагдмал байна. ҮСХ-ны судалгаагаар 2019 оны байдлаар эмэгтэйчүүд ижил ажлын байран дээр эрэгтэйчүүдээс 19,6%-р бага орлого олж байсан байна. Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр, Монгол эмэгтэйчүүд 2019 оны байдлаар ижил албан тушаал эрхэлж буй эрэгтэйчүүдээс 19.6 хувиар бага цалин авдаг байна. Түүнчлэн, эмэгтэйчүүд ихэвчлэн цалин багатай мэргэжил эзэмшдэг бөгөөд тэдний хувийн чадвараас үл хамааран эмэгтэйчүүд төрийн болон хувийн хэвшлийн ажлын шатлалд эрэгтэйчүүдээс доогуур зэрэглэлтэй байх чиг хандлагатай байдаг. Жендэрийн тэгш эрх, боломжийн талаарх хууль эрх зүйн хүрээний хэрэгжилт хангалтгүй хэрэгжиж буй талаарх мэдээлэл байна. Нэмж хэлэхэд, эмэгтэйчүүд гэрийн ажил, асран халамжлах үүргээ эрэгтэйчүүдээс хоёр дахин илүү хийдэг ба үүний дүнд тэднээс эдийн засгийн байдлаараа улам дорддог байна.

#### Жендэрт суурилсан хүчирхийлэл

Үндэсний Статистикийн Хороо, НҮБ-ын Хүн амын сангаас 2017 онд явуулсан судалгаагаар Монгол Улсын эмэгтэйчүүдийн 58 хувь нь бие бялдар, бэлгийн, сэтгэл санааны, эдийн засгийн болон дотно харилцагчийн зан авирыг хянах (ихэнхдээ тэдний нөхөр байдаг) зэрэг хүчирхийлэлд өртөж байсан байдаг. Судалгааны өмнөх жил эмэгтэйчүүдийн 35 хувь нь эдгээр хүчирхийллийн дор хаяж нэг хэлбэрийг амсаж байжээ. Тээврийн үйлчилгээтэй холбоотойгоор бэлгийн дарамт, хүчирхийлэл үйлдэх, бие махбодын болон хэл амаар доромжлох явдал ихэвчлэн эмэгтэй зорчигчдод тохиолддог бөгөөд харамсалтай нь ийм хүчирхийллийн хэргийг ховор мэдээлдэг, хангалттай хэмжээнд шийдвэрлэгддэггүй ба статистикийн мэдээлэлд ордоггүй байна. Үүнтэй төстэйгөөр жендэрт суурилсан олон төрлийн хүчирхийллийн хэргүүд ажлын байран дээр гардаг боловч эдгээрийг мэдээлдэггүй, урьдчилан сэргийлэх байдал хангалтгүй, шийдвэрлэгддэггүй хэвээр байна.

Ковид 19-ийн нөлөөллөөс болоод эмэгтэйчүүд, охид эрүүл мэндийн үйлчилгээ авах, нэг цэгийн үйлчилгээний төвүүдээс тусламж авах явдал хязгаарлагдан хүндрэлтэй болсон. 2020 оны эхний



улиралд Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газарт ирүүлсэн гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийг 2019 оны мөн үетэй харьцуулан үзэхэд бараг 50 хувиар өссөн байна<sup>14</sup>. Харамсалтай нь нэг цэгийн үйлчилгээгээр үйлчлүүлсэн хүмүүсийн дундаж тоо нь 2019 үеийн мөн үетэй харьцуулахад 90 хувиар нэмэгдсэн байна. Хүчирхийлэлд өртсөн, хохирогчдод зориулсан үйлчилгээ хаагдаагүй ч зөвлөгөө өгөх, зөвлөлдөх үйл ажиллагааг утсаар болон онлайнаар явуулжээ. Орон нутгийн нэг цонхны үйлчилгээ хүчирхийллийн хохирогчдод хязгаарлалтын энэ үед үргэлжлүүлэн нэн чухал үйлчилгээнүүдийг үзүүлсээр байна.

### Төрийн үйлчилгээний хүртээмж

Хөдөө орон нутаг, аймаг, сумдад иргэдэд хүргэх төрийн үйлчилгээнүүд харилцан адилгүй байдаг. Төрийн үйлчилгээг алслагдмал болон хөдөө орон нутагт хүргэхэд өндөр зардалтай байдаг бөгөөд малчид төрийн үйлчилгээг авахын тулд өөрт хамгийн ойр байрлах засаг захиргааны нэгж дээр очих шаардлагатай болдог. Монгол Улсын боловсролын тогтолцоо нь ясли, цэцэрлэг, бага сургууль, дунд сургууль болон их дээд сургуулиас тогтоно. Хөдөөгийн малчдын боловсролын үйлчилгээний хүртээмжтэй холбоотой тулгардаг асуудал нь сургуулийн байршил байдаг. Сум/багийн сургуулиуд дотуур байртай байдаг ба хичээлийн жилийн хугацаанд хүүхдүүд 9 сар хүртэлх хугацаагаар байрлан амьдарч болдог. Сургуульд орох хүүхдийн нас 8 наснаас 6 нас болж өөрчлөгдсөнтэй холбоотойгоор олон гэр бүлүүд тусдаа амьдрах шаардлагатай болсон ба ялангуяа ээж нар хүүхдүүдтэйгээ сумын төвд нүүж ирж хамт амьдардаг. Энэ нь бусад олон нийгмийн асуудлуудыг дагуулж байна. Эрүүл мэндийн үйлчилгээний хувьд тусгай үйлчилгээнүүд төв суурин газар, аймгийн төвүүдэд төвлөрсөн байдаг ба орон нутгийн иргэд зорчих шаардлага тулгардаг.

**Боловсрол.** 2010 оны хүн ам, орон сууцны тооллогоос үзэхэд 15 болон түүнээс дээш насны хүн амын бичиг үсгийн тайлагдалт 98.3 хувьтай байсан ба эрэгтэйчүүдийн хувь (98%) эмэгтэйчүүдээс (97,5%) бага зэрэг илүү байжээ. Бүх төрлийн сургалтын байгууллагад суралцагч оюутан, сурагчдын тоо (сургуулийн өмнөх боловсролд хамрагдагчдыг оруулахгүйгээр 736.8 мянгад хүрсэн ба 2008-2009 оны хичээлийн жилтэй харьцуулахад энэ нь 4.2 хувиар өссөн үзүүлэлт юм. 2009-2010 оны хичээлийн жилийн эхээр дунд сургуульд суралцагчдын тоо 522.1 мянгад (гадаадад сурч буй болон оройгоор суралцагчдын тоог оруулахгүйгээр) хүрчээ. Их дээд сургууль, дээд түвшний боловсролын институт, коллеж, техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын төвүүдэд суралцагч нийт суралцагчдын тоо сүүлийн жилүүдэд байнга өсөж байгаа бөгөөд 2009-2010 оны хичээлийн жилд нийт суралцагчдын тоо 210.2 мянгад хүрчээ. Эдгээрээс 63.8 хувь нь төрийн боловсролын байгууллагуудад суралцаж байсан бол 36.2 хувь нь хувийн хэвшлийн боловсролын байгууллагад суралцаж байжээ.

Аймгийн төвүүд дэх сургуулиудын төвлөрөл нь Монгол Улсын хотжилтын өсөлтийн хурдыг илтгэнэ. (2008 оны байдлаар хотжилтын дундаж хувь 1,2 хувьтай байсан (2005-2010 оны хооронд тооцоход) ба нийт хүн амын 57 хувь нь төв суурин газар амьдарч байв. Хүн ам тархай суурьшсан газруудад, дэлхийн бусад улстай адил, сургуулиуд тархан байрласан байдаг ба өргөн хүрээний сургуулийн байгууламж, үйлчилгээнүүд дутагдалтай байдаг.

**Эрүүл мэнд.** Монгол Улсын хүн амын эрүүл мэндийн байдал сүүлийн жилүүдэд ихээхэн сайжирсан. Нялхсын эндэгдэл маш ихээр буурсан, эхчүүдийн эндэгдэл 100 дахин буурсан, халдварт өвчнүүд - гэдэсний хижиг, бэлэг эрхтний лимфийн гаралтай цусны хорт хавдар, салхин цэцэг, халдварт саа өвчин зэргийг устгаснаар хүн амын өсөлт 4 дахин нэмэгдэж эрүүл мэндийн байдал ерөнхийдөө сайжирчээ. Эдгээр томоохон өөрчлөлтүүдэд нийгэм эдийн засгийн олон хүчин зүйлс нөлөөлсөн боловч энэ нь орчин үеийн шинжлэх ухаанд суурилсан эрүүл мэндийн салбарын хөгжлийн үр дүнтэй хамааралтай

<sup>14</sup> <https://www.unfpa.org/news/mongolian-women-get-help-escape-violence-even-amid-pandemic> (хамгийн сүүлд 2021 оны 1-р сарын 15-нд нэвтэрсэн)

юм. Эдгээр хөгжил дэвшлийг тооцохгүйгээр эрүүл мэндийн салбар дотоодын шилжин ирэгсэд, олон тооны орон гэргүй хүмүүс, амьдралын ядуу нөхцөл зэргээс үүдэлтэй сүрьеэ болон бэлгийн замын халдварт өвчин ихсэх буюу хүн амын зарим гадуурхагдсан бүлгүүдээс үүдэлтэй сорилтуудтай тулгарч байна. Үүнээс гадна хөдөө болон хотын хүн ам, орлогын ялгаатай бүлгүүдийн эрүүл мэндийн байдал, эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмж тэгш бус байх байх зэрэг асуудлууд байна.

### Тээврийн үйлчилгээ

Сүүлийн жилүүдэд бий болсон хүн ам, нийгэм эдийн засгийн хурдтай өсөлтөөс шалтгаалан үндэсний тээврийн системд хэрэгцээ шаардлага, дарамт ихэссэн. Гэсэн хэдийч нийт хүн амын олонх нь тээврээр зорчихдоо их цаг зарцуулж, замын чанар болон замын хүчилт бүсээс хамааран харилцан адилгүй байна. Хүн амын нягтаршил багатай газруудад иргэд төрийн үйлчилгээ авах, эдийн засгийн үйл ажиллагаанд оролцохдоо өөрсдөө асуудлаа зохицуулах шаардлагатай болдог. Эмэгтэйчүүд, залуучууд ажил хөдөлмөр эрхлэх болон бусад нийгэм эдийн засгийн үйл ажиллагаанд оролцоход аюулгүй байдлын эрсдэл болон бусад сэтгэл зовоосон асуудлууд бэршээл болдог. Албан бусаар үйлчилгээ үзүүлдэг микро автобуснууд эсвэл энгийн машинууд, тээврийн хэрэгсэл хязгаарлагдмал газруудыг хамардаг бөгөөд зорчигчдын аюулгүй байдалд баталгаа өгөх боломжгүйгээс гадна харьцангуй өндөр үнээр үйлчилдэг. Тээврийн хэрэгсэл өмчлөгчдийн тоо, замын түгжрэл ихээхэн нэмэгдэх хандлагатай. Орон нутагт голдуу жип төрлийн тээврийн хэрэгсэл зорчих ба энэ нь ашиглалтын зардал өндөртэй байдаг.

### Замын аюулгүй байдлын асуудлууд

Хөдөөгийн замын хурдны тогтоосон хязгаар хөдөөд 80 км/цаг, дээд хязгаар нь 100 км/цаг байдаг. Хурд хэмжигч камер, гараар хурд хэмжигч хэрэгслүүд байдаг боловч эдгээрээс цөөхөн нь ажилладаг. Тээврийн хэрэгслийн хурд хэтрүүлсэн тохиолдолд 50,000 (19 ам.доллар) төгрөгөөр торгодог ба тээврийн хэрэгслийн хурдыг тогтоосон хязгаараас 50 хувиар хэтрүүлсэн бол 2 оноо хасах, зургаан сар жолоодох эрхийг хасдаг. Зам хэрэглэгчийн аюулгүй байдлын үндсэн 3 асуудал нь: 1) согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох, 2) хамгаалах бүс, хүүхдийн хамгаалалтын хэрэгсэл ашиглалт, 3) явган зорчигчид ба нийтийн тээврийн хэрэгслээр зорчигчдын аюулгүй байдлын асуудлууд юм. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил нь буурч байгаа хэдий ч зам тээврийн ослын шалтгааны 2.2 хувийг эзэлж байна. Суудлын бүс, хүүхдийн хамгаалалтын хэрэгслийн ашиглалт, мотоцикл дээр хамгаалалтын малгай өмсөх талаар хийсэн НҮБ-ын хүүхдийн сангийн судалгаанд<sup>15</sup> зам тээврийн осол гарах үед зам тээврийн осол гаргасан жолоочийн маш өндөр хувь нь хүүхдийн хамгаалалтын хэрэгсэл ашиглаагүй байсан, мотоцикл дээр хамгаалалтын малгай өмсөөгүйгээсээ болж тархины гэмтэл авч нас барсан хүний тоо өндөр байсныг харуулжээ. Эдгээр зөрчилд 20,000 төгрөгийн (7.50 ам.доллар) торгууль ноогддог. Нийтийн тээвэр болон зорчигчийн аюулгүй байдлын хувьд автобусны үйлчилгээ харьцангуй аюулгүй, найдвартайд тооцогддог. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгшин настай хүмүүст зориулсан төхөөрөмжүүд дутмаг байдаг. Зорчигчдын хувьд сэтгэл зовоосон асуудлууд нь согтууруулах ундаанаас үүдэлтэй зөрчлүүд, бэлгийн дарамтад өртөх, хулгай, дээрмийн хэргүүд байдаг. Монгол Улс баруун гарын хөдөлгөөний дүрэмтэй боловч баруун гарын жолоодлоготой тээврийн хэрэгслүүд маш ихээр ашиглагддаг ба үзэгдэлтийг хязгаарлаж хүлээн зөвшөөрч боломгүй эрсдэлийг бий болгодог.

*Хүснэгт 9. Монгол Улсын аюулгүй байдлын хийт үзүүлэлтүүд*

<sup>15</sup> НҮБ-ын Хүүхдийн сан (2018), Монгол дахь хүүхдийн замын аюулгүй байдал, зам тээврийн ослын нөхцөл байдал% Үнэлгээний тайлан, Улаанбаатар хот.

INSTITUTIONAL FRAMEWORK	
Lead agency	Ministry of Road and Transport Development, The National Committee
Funded in national budget	Yes
National road safety strategy	Yes
Funding to implement strategy	Partially funded
Fatality reduction target	50% (2012-2020)
SAFER ROADS AND MOBILITY	
Audits or star rating required for new road infrastructure	Yes
Design standards for the safety of pedestrians / cyclists	Partial
Inspections / star rating of existing roads	No
Investments to upgrade high risk locations	No
Policies & investment in urban public transport	Yes
SAFER VEHICLES	
Total registered vehicles for 2016	841 537
Cars and 4-wheeled light vehicles	547 299
Motorized 2- and 3-wheelers	42 751
Heavy trucks	175 648
Buses	6 823
Other	69 016
Vehicle standards applied (UNECE WP.29)	
Frontal impact standard	No
Electronic stability control	No
Pedestrian protection	No
Motorcycle anti-lock braking system	No
POST-CRASH CARE	
National emergency care access number	National, single number
Trauma registry	National
Formal certification for prehospital providers	No
National assessment of emergency care systems	No
DATA	
Reported road traffic fatalities (2016)	484* (75% M, 25% F)
WHO estimated road traffic fatalities (2016)	499 (95% CI 471 - 527)
WHO estimated rate per 100 000 population (2016)	16.5

\* Health indicators 2016, Center for Health Development. Died within 30 days of crash

SAFER ROAD USERS	
National speed limit law	Yes
Max urban speed limit	60 km/h
Max rural speed limit	80 km/h
Max motorway speed limit	100 km/h
Local authorities can modify limits	No
Enforcement	0 1 2 3 4 5 6 7 8 9 10
Predominant type of enforcement	Manual and automated
National drink-driving law	
BAC limit – general population	< 0.04 g/dl <sup>b</sup>
BAC limit – young or novice drivers	< 0.04 g/dl <sup>b</sup>
Random breath testing carried out	Yes <sup>c</sup>
Testing carried out in case of fatal crash	All drivers tested
Enforcement	0 1 2 3 4 5 6 7 8 9 10
% road traffic deaths involving alcohol	25% <sup>d</sup>
National motorcycle helmet law	
Applies to drivers and passengers	Yes
Helmet fastening required	No
Helmet standard referred to and/or specified	No
Children passengers on motorcycles	Not restricted <sup>e</sup>
Enforcement	0 1 2 3 4 5 6 7 8 9 10
Helmet wearing rate	–
National seat-belt law	
Applies to front and rear seat occupants	Yes
Enforcement	0 1 2 3 4 5 6 7 8 9 10
Seat-belt wearing rate	–
National child restraint law	
Children seated in front seat	Not restricted
Child restraint required	–
Child restraint standard referred to and/or specified	–
Enforcement	–
% children using child restraints	–
National law on mobile phone use while driving	
Ban on hand-held mobile phone use	Yes
Ban on hands-free mobile phone use	No
National drug-driving law	
	Yes

<sup>b</sup> Law based on breath alcohol concentration, values converted to BAC


<sup>c</sup> Legislation requires probable cause to test drivers or commission of a traffic offence

<sup>d</sup> 2016, General Police Department, "Statistics on road traffic injury and violation"

<sup>e</sup> Children under 12 years can be transported on a motorcycle provided that there is a special support installed in the rear seat

Зам тээврийн ослоос шалтгаалсан гэнэтийн нас баралтын тоо нь нийт нас баралтын гурав дахь том шалтгаан болдог. 2019 онд Дэлхийн банкны дундаж наслалтад жендэрийн зөрүүг тооцоолох судалгаагаар амиа хорлолт, хүн амины хэрэг, санамсаргүй бэртэл гэмтэл, зам тээврийн осол, халдварт бус өвчлөлөөс (ХБӨ) шалтгаалсан эрчүүдийн нас баралт нь эмэгтэйчүүдийнхээс илүү өндөр байсан. 2018 оны байдлаар эрчүүдийн амиа хорлолт эмэгтэйчүүдийнхээс 5,8 дахин, хүн амины хэргээс үүдэлтэй эрчүүдийн нас баралт эмэгтэйчүүдээс 4,1 дахин, гэмтэл бэртлээс шалтгаалсан эрчүүдийн нас баралт эмэгтэйчүүдийнхээс 3,8 дахин, зам тээврийн ослоос шалтгаалсан эрчүүдийн нас баралт эмэгтэйчүүдээс 2,8 дахин, ХБӨ-р нас барсан эрчүүдийн тоо эмэгтэйчүүдээс 1,5 дахин их байв (Дэлхийн банк 2019). Согтууруулах ундаанаас үүдэлтэй зам тээврийн осолд эмэгтэйчүүдээс илүү эрчүүд өртдөг. 2020 оны байдлаар Авто Тээврийн Үндэсний Төвийн мэдээллийн баазад нийт 1,137,208 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа ба үүний 6 хувь буюу 67,796-г мотоцикл эзэлж байна. Эдгээр мотоциклын 57,962 нь буюу 85.5 хувь нь орон нутагт бүртгэлтэй байна. Нийт мотоциклоос шалтгаалсан үхлийн 81 хувь нь орон нутагт бүртгэгддэг байна. Маш олон залуу малчид мотоциклын ослоор амиа алддаг байна. Мотоциклын үхлийн шалтгаан нь хурд хэтрүүлэх, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ мотоцикл унах, даацаа хэтрүүлэх, зам дээрх объектой мөргөлдөх, малгай өмсөөгүйгээс толгой, нуруу, гар хөлдөө бэртэл авах зэргээс үүдэлтэй байдаг байна. Зарим аймгуудад 10-р сарын 1-нээс 4-р сарын 1-ний хооронд мотоцикл унахыг хориглосон Засаг даргын захирамж гарсан байна. Аймаг, орон нутгийн иргэд бүртгэлтэй болон бүртгэлгүй мотоциклыг өргөнөөр хэрэглэдэг гэж үздэг.

График 4. Монгол Улс дахь авто замаас шалтгаалсан үхэл



Source: 2016, General Police Department, "Statistics on road traffic injury and violation"



Source: Center for Health Development, Health Indicators 2016

195

## Ковид-19

2020 оны 3-р сард бүртгэгдсэн анхны тохиолдлоос хойш 2021 оны 6-р сарын 5-ны байдлаар ковидын нийт 63,978<sup>16</sup> тохиолдол, үүнээс 21 аймагт 7499 бүртгэгдсэн. Маск зүүх, гар угаах, зай барих, бүх нийтийн хөл хорио, бүх нийтийг хамруулсан вакцинжуулалт, тандалт судалгаа, шинжилгээ, тусгаарлалт зэрэг Засгийн газар болон орон нутгийн захиргаанаас авч хэрэгжүүлсэн түргэн шуурхай арга хэмжээний үр дүнд аймгуудад үүссэн кластер өвчлөлүүдийг арилгахад нөлөөлсөн. 2021 оны эхээр Монгол Улсын Засгийн газар болон орон нутгийн захиргаанаас гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бэлэн байдлын төрөл бүрийн арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан. Төслийн үйл ажиллагаанууд болох олон нийттэй уулзаж хэлэлцүүлэг хийх эсвэл бүтээн байгуулалтыг хийх ажил удаашрах, цуцлагдах, эсвэл магадлашгүй зардлууд гарах зэрэг Ковид 19-ийн нөлөөллийг бууруулахтай холбоотой үүсч болно.

## 6. БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ БА БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

### Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ

#### Уур амьсгалын өөрчлөлт

Монгол улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2019 оны 11 дүгээр сарын 407 дугаар тогтоолоор "Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт"-ыг боловсруулан баталсан. Энэхүү баримт бичгийн хүрээнд Монгол Улс үндэсний зорилтоо шинэчилж, хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг бууруулахаар өмнө нь дэвшүүлсэн зорилтоо ахиулан тодорхойлж, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас учрах сөрөг нөлөө, эрсдэлийг багасгах, түүнд дасан зохицоход чиглэсэн арга хэмжээг тодорхойлов. Энэхүү зорилтод Монгол Улсын Үндэсний хувь нэмрийн зорилтод 2010 оны суурь хувилбартай харьцуулахад 2030 онд хүлэмжийн хийн нийт ялгарлыг 22.7 хувиар бууруулах багтсан. Монгол Улс үндэсний хүлэмжийн хийн ялгарлаар нийт ялгаруулах суурь түвшинтэй харьцуулахад 2030 он гэхэд хүлэмжийн хийг 22.7 хувиар бууруулах боломжтой юм.<sup>17</sup>

<sup>16</sup> <https://www1.e-mongolia.mn/covid-19> (хамгийн сүүлд нэвтэрсэн: 2021 оны 6-р сарын 5)

<sup>17</sup> Үндэсний тодорхойлсон хувь нэмэр: <https://www4.unfccc.int/sites/ndcstaging/PublishedDocuments/Mongolia%20First/First%20Submission%20of%20Mongolia%27s%20NDC.pdf>




График 5. Хүлэмжийн хийн ялгарлын суурь болон зорилтот хувилбарын харьцуулсан үзүүлэлт

Ерөнхийдөө Бүрэлдэхүүн 1.2 ба 2-ын төлөвлөсөн ажлын хүрээнд А0301 - Улаанбаатар-Арвайхээр, А0501 - Улаанбаатар-Өндөрхаан, А0602 - Харинхорин-Цэцэрлэг, 0603 - Цэцэрлэг-Тосонцэнгэл (Архангай), А0302 Арвайхээр-Баянхонгор (Өвөрхангай) чиглэлийн авто замын засвар, шинэчлэлтийн ажлын үр дүнд замын нөхцөл сайжирч хурд нэмэгдсэний үр дүнд хүлэмжийн хийн ялгарлыг нэмэгдүүлнэ. Бензин түлшний хувьд 2.32 кг/л<sup>18</sup>, дизель түлшний хувьд 2.70кг/л<sup>19</sup> утгатайгаар CO<sub>2</sub> ялгарлыг HDM-4 загвар<sup>20</sup>-ыг хүлэмжийн хийн шинжилгээнд ашигласан. Суурь болон төслийн хувилбаруудын хүрээнд 20 жилийн үнэлгээний хугацаа нь төслийн эдийн засгийн ашиглалтын хугацаанд хүлэмжийн хийн ялгаруулалтыг 60,75365,881 тонн нүүрстөрөгчийн давхар исэл (CO<sub>2</sub>)-аар цэвэр нэмэгдүүлэхээр тооцоолсон. Харин логистикийн сүлжээг байгуулж тээвэрлэлтийн бөөгнөрлийг бууруулснаар махны нийлүүлэлтийн цэгээс борлуулалтын цэг хоорондох тээвэрлэлтийн давтамж 30 хувиар буурах төлөвтэй байна. Зорилтын 3.1 дэд хэсэгт хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний механизмыг багтаасан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын байгаль орчин, нийгмийн хамгааллын бодлогод эерэгээр нөлөөлнө. Зорилтын 3.2 дэд хэсэгт логистикийн төвүүдийг барих, удирдах, ажиллуулах зааварчилгаа, ногоон хөгжлийн үзүүлэлтийг хөгжүүлснээр хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулахад цаашид хэрхэн хувь нэмэр оруулах талаар тусгасан. Зорилтын 3-р бүрэлдэхүүн хэсэг нь цаг уурын өөрчлөлтийн тэсвэрлэх чадварыг бий болгох хүрээнд дэд бүтцийн менежментийн чадавхыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай тусгасан байдаг.

<sup>18</sup> Бензины ялгарлын утга: Хүснэгт 2; [https://www.epa.gov/sites/production/files/2015-07/documents/emission-factors\\_2014.pdf](https://www.epa.gov/sites/production/files/2015-07/documents/emission-factors_2014.pdf)

<sup>19</sup> Дизель түлшний ялгарлын утга: [https://www.epa.gov/sites/production/files/2015-07/documents/emission-factors\\_2014.pdf](https://www.epa.gov/sites/production/files/2015-07/documents/emission-factors_2014.pdf)

<sup>20</sup> Highway Development and Management Model - HDM-4 нь зам тээврийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын хувилбаруудад үнэлгээ хийх програм хангамж бөгөөд энэ үнэлгээнд мөн хүлэмжийн хийн хэмжээг тооцдог.

## Байгаль орчинд үзүүлэх нөлөө

Төслийн санал болгож буй зам засвар, барилга угсралтын ажил, бүсийн жишиг төвийн үйл ажиллагаанууд нь байгаль орчин, орон нутгийн иргэдэд сөрөг нөлөө үзүүлэхүйц газар шороо, барилгын ажил шаардагдах ч эдгээр сөрөг нөлөөллийг бууруулах зохих арга хэмжээг боловсруулж, цаг тухайд нь хэрэгжүүлж чадвал тэдгээр нь түр зуурынх бөгөөд нөхөн сэргээх боломжтой.

Зам барих, засвар арчлалт, жишиг бүсийн төвийн бүтээн байгуулалтын байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл нь үржил шимт хөрс алдагдах, элэгдэх, хөрс бохирдох, газар хөндөх, барилгын машин механизм, материалыг ачих, буулгах зэргээс үүдсэн тоосжилт, гадаргын усны бохирдол, орон нутагт дуу чимээ, чичиргээ их хэмжээгээр нэмэгдэх зэргээс гадна өөр бусад нөлөөллүүд байж болно. Үүнээс гадна барилгын ажил нь орон нутагт их хэмжээний хатуу болон шингэн хог хаягдал үүсгэж болзошгүй. Мөн тухайн орон нутагт ирэх барилгын ажилчдын шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор шинэ өвчлөлүүд гарч ирэх боломжтой. Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй тохиолдолд шинээр төлөвлөж буй зам талбайгаас хамааран амьдрах орчны хуваагдал үүсч болзошгүй. Хэдийгээр эдгээр болзошгүй сөрөг нөлөөнүүд байгаа ч шинэ замуудыг барьж, орон нутгийн замыг шинэчлэх, ложистикийн төвийг байгуулах нь эдийн засагт ихээхэн эерэг нөлөө үзүүлнэ. Тухайлбал, хөдөө орон нутагт мах цуглуулах ажлыг хөгжүүлэн дэмжснээр малчин өрх, нутгийн иргэдэд нэмэлт орлого бий болгох боломжтой ч сайн төлөвлөөгүй тохиолдолд амьдрах орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй. Замын шинэчлэлтийн ажилтай холбоотойгоор байгаль орчинд нөлөөлөх үр дагавар нь шинэ зам барихтай адил байна. Төвийн ашиглалтын явцын БОН-ын эрсдэлүүд нь тухайлбал бохир ус, агаарын бохирдол, дуу чимээ, хог хаягдал, ХАБЭА-н эрсдэлүүд нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Сүүлийн бээрийн холболтын замыг сайжруулах, одоо байгаа авто замыг шинэчлэх, бүсийн жишиг төв барих ажлууд нь Монгол Улсын барилгын стандарт, байгаль орчны стандарт, ДБ-ын БОЭМАА-ны удирдамжид тус тус заасан дагаж мөрдөх журам, арга хэмжээнүүдэд нийцсэн байна. Тэдгээр зохицуулалтуудын шаардлагыг хангаснаар төслийн орчин түүнчлэн хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл, нөлөөллийг ихээхэн бууруулна.

Төслийн байгаль орчны болон ХАБЭА-н болзошгүй нөлөөлөл, тэдгээрийг бууруулах арга хэмжээний дүн шинжилгээг доор оруулав.

### **Барилгын ажлын өмнөх шатанд гарч болох нөлөөлөл, бууруулах арга хэмжээ**

#### Газар чөлөөлөлт

Барилгын ажлын өмнөх шатны сөрөг нөлөөлөл нь аливаа түр зуурын бүс шинжтэй газар чөлөөлөлт, түүнтэй холбоотой газар болон/эсвэл объектын хохиролтой холбогдож үүснэ. Дэд төслийн бүх ажил, бүсийн жишиг төвийг байгуулах, сүүлийн бээрийн холболтын зам, одоо байгаа автозамын засвар, шинэчлэлтийн ажлыг нэн чухал амьдрах орчин, соёлын өвийн дурсгалт газар болон бусад эмзэг бүсэд ороогүй, төрийн өмчийн эзэнгүй газарт хийх болно. Аль ч дэд төслийн хувьд газар чөлөөлөлт байхгүй.

#### Түр талбайн шаардлага

Гүйцэтгэгчид нь хүрээлэн буй орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөл хамгийн бага хэмжээнд байх эсвэл зайлсхийх боломжтой бол албадан нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх, сүүлийн сонгосон газрыг эцсийн үнэлж, шаардлагатай тохиолдолд сөрөг нөлөөллийг бууруулах нэмэлт арга хэмжээг авч үзэхийг шаардана. Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ ажилчдын кэмп болон тоног төхөөрөмж хадгалах байршил дээр нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлно. Түр талбайг орон нутгийн засаг захиргаа болон ТУА-наас зөвшөөрөл авна.

Нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Байгаль орчны менежментийн арга хэмжээг мөн барилгын ажлын өмнөх шатанд нарийвчилсан зураг төсөл боловсруулах, БОН-ийн баримт бичгүүдийг шинэчлэх, байгаль орчны нөлөөллийг бууруулах арга хэмжээг гүйцэтгэгчийн тендерийн баримт бичиг, техникийн шаардлага, барилгын ажлын болон тоног төхөөрөмж суурилуулах гэрээнд тусгаж оруулах ба ГБМ-ыг хэрэгжүүлэх болон сургалт, чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаанд мөн хамруулна.

Сүүлийн бээрийн замын болон урьдчилсан БОННУ-нд зориулж БОНМХ, БОНМТ-г шинэчлэх

Урьдчилсан БОННУ-г аливаа төсөллөлтийн өөрчлөлт эсвэл шинэ мэдээлэлтэй холбогдуулан шинэчлэх шаардлагатай. Сүүлийн бээрийн холболтын замын барилгын ажлын тендер зарлахын өмнө биологийн олон янз байдлын болон соёлын өвийн хээрийн судалгааг газар дээр нь явуулна. Биологийн олон янз байдлын судалгааны явцад тогтоогдсон биологийн төрөл зүйлд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс хамааран Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөөг (BMP) бэлтгэх шаардлага гарч болох ба сүүлийн бээрийн холболтын замын БОНМТ(нүүд)-д нэгтгэж оруулна. Судалгаагаар Дэлхийн банкны санжүүжүүлж буй сүүлийн бээрийн холболтын зам дээр соёлын өвийн дурсгалт газрууд, тэдгээрийн хамгаалалтын бүс, биологийн олон янз байдлын өндөр үнэ цэнэ бүхий хэсэг тогтоогдвол биологийн олон янз байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор шаардлагатай тохиолдолд сүүлчийн бээрийн холболтын замын трассыг өөрчлөх зэрэг нөлөөллийг бууруулах арга хэмжээг сүүлийн бээрийн холболтын замуудын БОНМТ(нүүд)-д санал болгож оруулна.

Байгаль орчин, нийгмийн баримт бичгүүдэд заасан байгаль орчны нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг нарийвчилсан зураг төсөлд тусгах ба БОННУ, БОНМТ зэрэг байгаль орчин, нийгмийн бүх баримт бичгүүдийг баталж, хэрэгжүүлэхээс өмнө ДБ-наас зөвшөөрөл авна.

Тендерийн баримт бичиг ба гэрээ

Байгаль орчин, нийгмийн баримт бичгүүдэд заасан байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг дэд төслийн гүйцэтгэгчийн тендерийн баримт бичиг, техникийн шаардлага, гэрээнд тусгана.

### **Барилгын ажлын шатанд байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, бууруулах арга хэмжээ**

Элэгдэл, шороо ашиглах, хохирол учруулах

Дэд бүрэлдэхүүн 1.1 - 311 км авто замын засвар, Дэд бүрэлдэхүүн 1.2 – Сүүлийн бээрийн холболтын 51 км шинэ замын сайжруулалт, Дэд бүрэлдэхүүн 2.1 – Бүсийн жишиг төвийн барилгын ажлийн төлөвлөсөн үйл ажиллагааны хүрээнд газар тэгшлэх, ухах, дүүргэх зэрэг бүтээн байгуулалтын ажлууд нь тухайн хэсгийг хамарсан хөрсний элэгдэл, сул шороо, бохирдолд хүргэж болзошгүй. Хөрсний элэгдэл нь налуу болон усан гадаргуутай ойр орчин, барилгын ажил дууссаны дараа талбайн нөхөн сэргээлт хангалтгүй хийсэн тохиолдолд илүү ноцтой байж болно. Хэрэв дэд төслийн талбай нь ерөнхийдөө тэгшэн ба усан гадаргуу, чухал амьдрах орчин, эсвэл орон сууц, сургууль, эмнэлэг зэрэг мэдрэмтгий хүлээн авагчтай ойр биш бол нөлөөлөл нь цар хүрээний хувьд бага, богино хугацааны үргэлжлэх, тухайн хэсэг газрын шинжтэй байна.

## Нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Төсөл хэрэгжүүлэгч (гүйцэтгэгч) нь өнгөн хөрсийг хуулах, хадгалах, гэмтсэн газар болон хөрсний өнгөн давхаргыг нөхөн сэргээхэд Монгол Улсын болон олон улсын удирдамжийг дагаж мөрдөнө. Шимт хөрсийг нөхөн сэргээхэд өнгөн давхаргаыг дахин ашиглах. Инженерийн арга хэмжээг хэрэгжүүлэх, барилгын талбайн сайн менежментээр дамжуулан нөлөөллийг удирддаг. Хуулах, зайлуулах хөрсний хэмжээ, талбайг тогтоох. Дотоодын БОНБУ-нд (эсвэл холбогдох олон улсын стандарт) замын засвар, барилгын стандарт, зааварчилгаа болон мөн бохирдсон хөрстэй харьцах стандарт (гидравлик тос, түүнтэй адилтгах тос, боловсруулсан хөрсийг дахин боловсруулах талаарх үндэсний болон олон улсын туршлага, удирдамж)-ыг оруулна. Талбай дээр шатахуун хадгалах сайн туршлагыг багтаасан Асгах, гоожих асуудалд менежмент хийх төлөвлөгөөг гүйцэтгэгч боловсруулж ТУА батална. Төслийн загварын нэг хэсэг болгон хэрэгжүүлэх Хөрсний элэгдлийн менежментийн төлөвлөгөөг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэг хэсэг болгон гүйцэтгэгч боловсруулна.

Барилга угсралтын ажилд шаардлагатай бүх үйл ажиллагаануудын хувьд бүх материалыг нөхөн сэргээх шаардлагууд нь баталгаажсан орон нутгийн захиргаанаас зөвшөөрөгдсөн тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээс авна.

## Материалын хэрэглээ

Нөхөн сэргээгдэх болон сэргээгдэхгүй нөөцийн хэрэглээ нь материалын нөөцөд сөргөөр нөлөөлнө. Болзошгүй нөлөөллийн хэмжээ нь шаардагдах хэмжээнээс хамаарах ба материалын гарал үүсэл, эх үүсвэр, түүний дотор ерөнхий олдоц, тэдгээрт агуулагдах материалын эзлэх хувь зэргээс хамаарна. Барилга угсралтын болон засварын ажлын хүрээний төлөвлөсөн үйл ажиллагаанд шаардагдах үндсэн нөөцөд суурийн доод үеийн дүүргэгч материал, цементбетон, элс, ус, битум зэрэг болно. Бүсийн жишиг төвийн хөгжүүлэлтийн ажилд ихээхэн хэмжээний барилгын материал мөн шаардагдана.

## Нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Боломжтой бол ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах явцад дахин ашиглах материалын үнэлгээг хийж хувилбарт тогтвортой материалын хэрэглээг дэмжих хэрэгтэй.

## Агаарын бохирдол, тоосжилт

Дэд бүрэлдэхүүн 1.1 - 311 км авто замын засвар, Дэд бүрэлдэхүүн 1.2 – сүүлийн бээрийн холболтын 51 км шинэ авто зам барих, Дэд бүрэлдэхүүн - 2.1 Бүсийн жишиг төвийн барилгын ажлын хүрээнд (i) ухмал, далангийн ажил, материал ачиж буулгах, зөөхтэй холбоотой үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт; (ii) эвдэрсэн, хучаагүй барилгын талбайгаас үүссэн тоосжилт, ялангуяа салхитай өдрүүдэд; (iii) барилгын материалын агуулах хавиас үүсэх тоосжилт, ялангуяа салхитай өдрүүдэд; (iv) шороон зам, эсвэл материалын тээврийн үед хүнд машин механизм болон бусад тээврийн хэрэгслээс үүсэх тоосжилт; (v) дүүргэгч материал бэлтгэх, бетон зуурах явцад үүссэн тоосжилт ба бусад; (vi) тоног төхөөрөмжөөс ялгарах хийн ялгарал (тээврийн хэрэгсэл, хүнд даацын дизель хөдөлгүүртэй машин, тоног төхөөрөмжөөс ялгарах CO ба NO2).

Дэд төслийн талбай дээрх нөлөөллүүд нь тухайн хэсгийг хамарсан орон нутгийн шинж чанартай, богино хугацааных байх ба ойр орчмын оршин суугчид, ан амьтанд нөлөөлөх магадлалтай. Туслах замын дагуух тээврийн хэрэгслийн хийн ялгарлын нөлөөлөл нь агаарын чанарын стандартыг давах хэмжээний нөлөөлөл үзүүлэхгүй ба тээврийн хэрэгслийн бусад төрлийн хийн ялгарал бага байна.

## Нөлөөллийг бууруулах арга хэмжээ



Дээрх болзошгүй нөлөөллийг талбайн болон тоног төхөөрөмжийн менежментийн сайн туршлагуудаар тухайлбал, тээвэрлэгдэж буй ачааг хучих, нөлөөллийг бууруулахын тулд барилгын ажлын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах замаар үр дүнтэйгээр бууруулах боломжтой. Талбайг услах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Зам барилгын ажлын явцад үзүүлэх нөлөөллийг бууруулах зарим арга хэмжээнд: асфальт болон халуун хольцын заводыг ойр орчмын мэдрэмтгий хүлээн авагчидаас дор хаяж 500 м зайд байрлуулах, тоос үүсгэдэг ачааг хучиж тээвэрлэх, гадаргууг чийглэх, шороо, элс, чулуун барилгын материалыг асгарахаас сэргийлж брезент эсвэл тохирох материалаар хучих, машин, тоног төхөөрөмжийн бохирдол хянах төхөөрөмжийг зохих ёсоор тохируулж бохирдолыг хянах, ил галаар шатаахыг хориглох, уусгагч, дэгдэмхий бодисыг зохих ёсоор ашиглах гэрээ, баримт бичигт тусгах зэрэг зарим нэгэн бууруулах арга хэмжээнүүдийг оруулна.

Барилгын ажлын өмнөх шатанд агаарын чанарын одоогийн суурь үзүүлэлтийн хяналт-шинжилгээг бий болгохын тулд барилгын ажлын багц бүртэй уялдуулсан барилгын ажлын өмнөх шатны агаарын чанарын хяналт-шинжилгээг

Усны чанар

шинээр зам барих, одоо байгаа замуудыг шинэчлэх, бүсийн жишиг төвийг хөгжүүлэх барилгын бүх үйл ажиллагаанд хэрэглэсэн химийн бодисоор гадаргын болон урсгал усыг бохирдуулах эрсдэлтэй. Барилгын ажлын үе шатанд хүнд металл, тос, тосолгооны материалыг замын хажууд төвлөрүүлж болох ба усан гадаргуу болон амьтны аймагт сөргөөр нөлөөлж болзошгүй. Ширүүн, аадар бороо нь голын урсгалыг өдөөдөг.

Нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Ажилчдыг ариун цэврийн байгууламжаар хангах, барилгын бохир усыг зохицуулах, барилгын тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн зориулалтын засвар үйлчилгээ, барилгын цохир усны зохицуулалтын менежментийн сайн туршлагаар дамжуулан эдгээр болзошгүй нөлөөллийг бууруулна.

барилгын ажлын болон тээвэрлэлтийн үед барилгын материал, химийн бодис асгарч бохирдуулахаас зайлсхийх зорилгоор гэр хорооллын ойролцоо байрлах гар насостой эсвэл энгийн худагуудын байршлыг тодорхойлж үнэлгээ хийнэ.

Дуу чимээ ба чичиргээ

Барилга ажлын шатанд экскаватор зэрэг хүнд даацын тоног төхөөрөмж ашиглах, барилгын материал тээвэрлэх үйл ажиллагаанаас үүсэлтэй дуу чимээ, чичиргээ бий болно. Ойр орчмын оршин суугчдад үзүүлэх нөлөөлөл, болзошгүй дуу чимээ, чичиргээний нөлөөллийг урьдчилан тооцно. хүнд даацын тээврийн хэрэгслээр барилгын материал тээвэрлэхтэй холбоотой замаас болон одоо байгаа бусад дэд бүтцүүдээс үүсэх чичиргээ, дуу чимээ нэмэгдэж болзошгүй.

Нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Барилга угсралтын ажил эхлэхийн өмнөх хяналт-шинжилгээний суурь үзүүлэлтүүд, ажлын цагийг хязгаарлах, шаардлагатай бол дуу чимээ тусгаарлагч ашиглах, дуу чимээ багатай төхөөрөмж ашиглах, засгийн газрын холбогдох шаардлагын дагуу машин механизмыг дуу намсгагчаар тоноглох зэрэг барилгын дуу чимээний менежментийн сайн арга хэмжээнүүдийг авах замаар болзошгүй нөлөөллийг үр дүнтэй бууруулж болно. Барилга угсралтын өмнө дуу чимээ, чичиргээний үнэлгээг хийнэ.

Хатуу хог хаягдал

Барилгын ажлын шатанд үүссэн хатуу хог хаягдал нь барилгын болон орон суухтай холбоотой хог хаягдал байх ба барилгын хог хаягдал нь төрөл бүрийн замын материал, барилгын хог хаягдал байна. Ахуйн хог хаягдал нь органик болон органик бус хог хаягдал байх ба нэг ажилчин өдөрт 0.4 кг ахуйн хог хаягдал үүсгэнэ гэж тооцдог. Хог хаягдлыг зүй бусаар төвлөрүүлэх, зайлуулах нь хөрс, гүний ус, гадаргын усны нөөц, улмаар хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Хог хаягдлын шатлалыг батлах, барилгын бүх талбайн хогийн сав болон ангилан ялгах боломжийг бүрдүүлэх, боломжтой бүх материалыг дахин боловсруулах, үлдсэн хог хаягдлыг зохих хог хаягдлын цэгт төвлөрүүлж, устгах зэрэг хог хаягдлын менежментийн сайн туршлагаадаар дамжуулан эдгээр болзошгүй нөлөөллийг үр дүнтэй бууруулж болно. Хог хаягдлыг зайлуулах гэрээг орон нутгийн засаг захиргаатай хийх бөгөөд хэрэв боломжгүй бол гүйцэтгэгчтэй материалын илүүдэл, хог хаягдал устгах гэрээг нийнэ. Дэд төслийн талбайд хог хаягдлыг шатаахыг зөвшөөрөхгүй ба байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөнд хатуу хог хаягдалтай харьцах, асгарахаас урьдчилан сэргийлэх, барилгын хог хаягдлыг өдөр бүр цуглуулах, зайлуулах, барилгын талбайг хаших, замын тэмдэг тэмдэглэгээг үр дүнтэй ашиглах зэрэг зөвлөмж, үр нөлөөг бууруулах төлөвлөгөөг тусгасан болно.

Байгаль орчинд халтай хог хаягдлыг хортой хог хаягдлыг зайлуулах журмын дагуу хогийн цэг эсвэл шатаах зуух руу тээвэрлэж устгалд оруулна. Хэрэв албан ёсны хогийн цэг байхгүй бол хотын захиргаатай түр болон сүүлийн шатны устгал хийх гэрээ байгуулна.

Аюултай ба бохирдуулагч бодис

Шатах, тослох материал, аюултай материалын зориулалтын бус тээвэрлэлт, хадгалалт, ашиглалт, устгал, асгаруулах зэрэг нь барилгын ажилтай холбоотой бодит эрсдэл юм. Аюултай хог хаягдал нь хөрс, гадаргын болон гүний усыг бохирдуулдаг.

Нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Ялгаж цуглуулах, асгарахгүй битүү, ус үл нэвтрэх гадаргуу зэрэг аюултай материалын менежментийн сайн туршлагаар дамжуулан эдгээр болзошгүй нөлөөллийг ДБ-ны БОНС-ын болон дотоодын дүрэм, журмын дагуу тусгай зөвшөөрөлтэй компаниудтай гэрээ байгуулах замаар үр дүнтэйгээр бууруулж болно. БОННУ/БОНМТ-д тээвэрлэлтийн явцад аюултай хог хаягдал асгарахаас сэргийлэх, голын ойролцоо хууль бусаар асгахгүй байх аюулуудыг зохицуулах иж бүрэн журмыг багтаана.

Ургамал, амьтан

Төслийн бүх талбайнууд нь төслийн хөрөнгө оруулалтын байршилд эсвэл зэрэгцэн орших чухал амьдрах орчин, ховор буюу ховордсон ургамал, амьтан, байгалийн ойн бүсэд байрлахыг хориглоно. Нарийвчилсан БОННУ-гээр бууруулах тохирсон арга хэмжээг тодорхойлж санал болгоно.

Амьтны аймагт үзүүлэх нөлөөллүүд нь түр замын шийдэл, газар ашиглалтаас үүдэлтэйгээр гарч болох ба энэ нь мал, амьтан ухах аюул, барилгын ажлын машин механизмын нэмэгдэл хөдөлгөөн амьтаны аймагт нөлөөлөх, эрсдэл үүсгэх, барилгын ажилчид, түр кэмпийн менежмент нь хуурай болон усан гадаргуугийн ховордсон, устгах аюулд орсон амьтныг хууль бусаар агнах зэрэг байж болно.

Ургамлын аймагт үзүүлэх нөлөөллүүд нь түр болон байнга ашиглах газраас үүдэлтэйгээр гарч болох байгалийн амьдрах орчин, ургамлын доройтол, карьер, хажуугийн бэлтгэлээс материал бэлтгэхтэй холбоотой үйл ажиллагаанууд байна.

Нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Дэд бүрэлдэхүүн 1.2 - Сүүлийн бээрийн холболтын 51 км замын барилгын ажлын тендер зарлахын өмнө биологийн олон янз байдлын болон соёлын өвийн хээрийн судалгааг газар дээр нь явуулна. Биологийн олон янз байдлын судалгааны явцад тогтоогдсон биологийн төрөл зүйлд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс хамааран Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөөг (BMP) бэлтгэх шаардлага гарч болох ба сүүлийн бээрийн холболтын замын БОНМТ(нүүд)-д нэгтгэж оруулна. Судалгаагаар Дэлхийн банкны санжүүжүүлж буй сүүлийн бээрийн холболтын зам дээр соёлын өвийн дурсгалт газрууд, тэдгээрийн хамгаалалтын бүс, биологийн олон янз байдлын өндөр үнэ цэнэ бүхий хэсэг тогтоогдвол биологийн олон янз байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор шаардлагатай тохиолдолд сүүлчийн бээрийн холболтын замын трассыг өөрчлөх зэрэг нөлөөллийг бууруулах арга хэмжээг сүүлийн бээрийн холболтын замуудын БОНМТ(нүүд)-д санал болгож оруулна.

Замын зураг төсөл нь үерт өртөмтгий газруудад (ус их шингээдэг ургамал гэх мэт) биомимикри, үнэ цэнтэй орон нутгийн төрөл зүйл зэрэг төсөллөлтийн тогтвортой схемүүдийг тусгахад чиглэнэ. Зайлуулсан модыг гүйцэтгэгч зохих газарт нь шилжүүлэн суулгана.

Дэд бүрэлдэхүүн 2.1 – бүсийн жишиг төвийн урьдчилсан БОННУ-г ДБ-ны БОНС болон GIP-д нийцүүлэн иж бүрэн БОННУ-г шинэчилнэ.

Соёлын биет нөөц

Барилгыг ажил эхлэхээс өмнө соёлын өвийн бүх дурсгалт газруудад үнэлгээ хийнэ. Гэсэн хэдий ч илрээгүй соёлын биет нөөц барилгын ажлын явцад гарч ирэх боломжтой.

Нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Хэрэв Соёлын биет нөөц илэрвэл боломж-олдох журмыг бий болгож идэвхүүлнэ.

- Соёлын биет нөөц илэрсэн тохиолдолд барилгын ажлыг нэн даруй зогсооно;
- Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу соёлын биет өвийг устгах, гэмтээх, эвдлэх, нуун дарагдуулахыг хатуу хориглоно;
- Орон нутгийн Соёлын өвийн товчоонд цаг алдалгүй мэдээлж, зөвлөлдөх ба бусад.
- Сайтар шалгаж, орон нутгийн Соёлын өвийн товчооноос зөвшөөрөл авсны барилгын ажлыг дахиу эхлүүлнэ;

### **Ашиглалтын шатанд байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, бууруулах арга хэмжээ**

Хог хаягдлын менежмент

Бүх замын ашиглалтын болон засвар үйлчилгээ түүнчлэн замын дагуух амрах талбайгаас хог хаягдал үүснэ.

Бүсийн жишиг төвийн төрөл бүрийн үйл ажиллагаанаас их хэмжээний хог хаягдал үүснэ. Агуулах, зоорь, оффис, амьдрах байр, сав баглаа боодол зэргээс их хэмжээний хатуу, шингэн хог хаягдлыг бий боно.

Нөлөөллийг бууруулах арга хэмжээ

БОНБНУ-нүүд болон БОНМТ-нд Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг оруулсан.

Замын төсөллөлт

Тэмдэг, хаалт хашилт, замын хөдөлгөөний аюулгүй байдлын арга хэмжээ байхгүйгээс зэрлэг ан амьтадын хөдөлгөөнийг хязгаарлах, мөргүүлэх аюул нэмэгдэнэ.

Нөлөөллийг бууруулах арга хэмжээ

БОНБНУ болон БОНМТ-нд үндэслэн бүх замд зохих тэмдэг, хаалт, замын хөдөлгөөний аюулгүй байдлын арга хэмжээ, тухайлбал, замын хөдөлгөөний аюулгүй байдлын арга хэмжээнүүдтэй нийцүүлэн зэрлэг ан амьтад, малын гарцын тэмдэгийн оруулна.

#### **ХАБЭА-ын эрсдэл, бууруулах арга хэмжээ**

Төслийн байгаль орчны болон ХАБЭА-н болзошгүй нөлөөлөл, тэдгээрийг бууруулах арга хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 10. ХАБЭА-ны болзошгүй нөлөөлөл, тэдгээрийг бууруулах арга хэмжээ*

ХАБЭА-д учирч болзошгүй хор хохирол	Бууруулах арга хэмжээ
<ul style="list-style-type: none"> <li>• Үйлдвэрлэлийн ослын тохиолдол/осол</li> <li>• Зам тээврийн ослын тохиолдол/осол</li> <li>• Дээрээс хүнд зүйл унах</li> <li>• Дуу чимээ, чичиргээний өндөр түвшин</li> <li>• Юм нурж унах</li> <li>• Гулсамтгай гадаргуу дээр ажиллах</li> <li>• Галын аюул</li> <li>• Хорт утаа, уур зэрэг химийн аюул</li> <li>• Гэрэлтүүлэг</li> <li>• Шар усны үер болон бусад байгалийн гамшиг</li> <li>• Халдварт өвчин; COVID-19</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• ХАБЭА-н удирдамжийн дагуу барилгын ажлын ХАБЭА-н сайн туршлагыг хэрэгжүүлэх</li> <li>• Монгол Улсын холбогдох бүх аюулгүй ажиллагааны дүрэм журмыг чанд мөрдөж ажиллах</li> <li>• Бүх ажилчид хатуу малгай, тусгаарлагч болон/эсвэл галд тэсвэртэй хувцас, зохих газардуулга, халуун шугам, тусгаарлагчгүй багаж хэрэгсэл, хамгаалалтын бээлий, хамгаалалтын нүдний шил, хамгаалалтын бүс, уналтаас хамгаалах систем зэрэг зохих хувийн хамгаалалтын хэрэгслээр хангагдсан байх. Авирах бусад хэрэгсэл (өндөрт ажиллах зориулалттай), чихний хамгаалалт гэх мэт. Хамгаалалтын хувцас хэрэгслийг шаардлагатай үед засварлах, шинэчлэх</li> <li>• Бүх төрлийн өндөрт хийх ажлыг өдрийн бус цагаар, манантай үед, хүчтэй салхитай үед хийхийг хориглох</li> <li>• Барилгын талбайг хангалттай ундны ус, түр ариун цэврийн байгууламжаар хангах</li> <li>• Ажилчдад ХАБЭА-н бүхий л чиглэлээр, түүний дотор халдварт өвчнөөс (ХДХВ/ДОХ гэх мэт) урьдчилан сэргийлэх сургалтыг барилгын ажил эхлэхээс өмнө болон тогтмол хугацаанд, тухайлбал сар бүр танилцуулах ажлыг зохион байгуулах</li> <li>• Онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах төлөвлөгөө (ERP): Орон нутгийн болон бүс нутгийн яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлэгчтэй харилцах харилцааны протокол, цахилгааныг унтраах протокол, гал түймэртэй тэмцэх арга хэмжээ, зохих гал унтраах хэрэгслээр хангах, гал түймрийн хариу арга хэмжээний талаар ажилчдыг сургах зэрэг яаралтай хариу арга хэмжээний журмыг боловсруулж бүртгэл хөтлөх</li> <li>• Орон нутгийн болон бүс нутгийн яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлэгчидтэй харилцах харилцааны протокол, газар дээрх анхны тусламжийн хэрэгсэл, хамгийн ойрын түргэн тусламжийн болон эмнэлгийн тусламжийн холбоо барих мэдээлэл зэрэг ажилчид болон олон нийтийн гишүүдийг (төсөлтэй холбоотой ажлын үед өртсөн бол) хамарсан эмнэлгийн яаралтай хариу арга хэмжээний журмыг боловсруулна. барилга байгууламж, ажилчдыг газар дээр нь гарсан анхны тусламжийн талаар сургах, гэмтэж бэртсэн ажилчдыг орон нутаг, аймгийн эрүүл мэндийн төвүүдэд мэдээлэх, шилжүүлэх протокол, бүртгэл хөтлөх. Барилгын талбайд дор хаяж нэг сургагдсан анхны тусламжийн ажилтан ажиллуулах</li> <li>• Ажилчдад ERP-ийн бүх талаар сургалт явуулах.</li> </ul>

Санал болгож буй төслүүдийн үр ашиг нь богино, дунд, урт хугацаатай байх ба амжилттай хэрэгжсэн тохиолдолд шинэ болон засвархийсэн зам, ложистикийн сайжруулалтаар хязгаарлагдахгүй, цаашлаад тогтвортой хөгжил, нийт иргэдийн амьжиргаа, сайн сайхан амьдрахад хувь нэмэр оруулна. Тухайлбал:

- Замуудыг шинээр барьж, шинэчлэх нь сонгосон авто замын сүлжээний хоорондын холболтыг сайжруулж, бүх зам ашиглагч аюулгүй, хүртээмжтэй, үр ашигтай зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.
- Аюулгүй, найдвартай, тогтвортой холболт, ложистикийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлснээр оршин суугчид, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй болон бага насны хүүхдүүд зэрэг эмзэг бүлгийн хүмүүсийн хөдөлгөөнийг сайжруулж, тээврийн зардлыг бууруулна.
- Сонгогдсон байршлын ойр орчимд нийгэм эдийн засгийн өсөлт, хөдөөгийн хөгжил, төрийн үйлчилгээг нэгдмэл байдлаар хүргэхэд хувь нэмэр оруулах бизнес, хөрөнгө оруулалтыг илүү ихээр татах болно. Замын бүтээн байгуулалт, шинэчлэлт хийснээр мал, амьтны гоц халдварт өвчин, өвлийн улиралд үер, зуд зэрэг байгалийн гамшигт нэрвэгдэгсдэд түргэн шуурхай хариу арга хэмжээ авах, хөдөөгийн иргэд эмнэлэг, эрүүл мэндийн төв, нийгмийн бусад үйлчилгээг түргэн шуурхай авах боломжтой болно.
- Шинэ болон шинэчлэлт хийгдсэн замууд нь аялал жуулчлалыг хөнгөвчлөх, илүү найдвартай болгох, импорт, экспортын тээврийн зардлыг бууруулах замаар хөгжил, эдийн засгийн өсөлтийг шууд дэмжинэ. Орон нутгийн аялал жуулчлал өргөжих хандлагатай болно. Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, байгалийн нөөцөт газар, шувуудын бүс нутаг, археологийн дурсгалт газрууд нь тогтвортой, нөлөөлөл багатай эко аялал жуулчлалын үндэс суурийг бий болгоно. Хамгийн чухал нь, шинэ болон шинэчилсэн замууд нь ажлын байр нэмэгдэхийн хэрээр дотоод шилжилт хөдөлгөөний нөлөөллийг бууруулах магадлалтай.
- Мэдээлэл, зах зээлийн хүртээмж сайжирснаар үйлдвэрлэлийн бүтээмж, үнэ цэнэ нэмэгдэнэ.
- Орон нутгийн эрх баригчид, бодлого хэрэгжүүлэгч байгууллагууд техникийн чадавхи, ур чадвараа сайжруулж, хүртээмжтэй дэд бүтцийн менежмент, түүнийг хэрэгжүүлэх туршлагыг нэвтрүүлж ажиллана.

### **Нийгэмд учирч болзошгүй сөрөг нөлөө, түүнийг бууруулах арга хэмжээ**

#### **Замын хөдөлгөөний удирдлага**

Сонгогдсон замуудыг засварлах, шинэчлэх, шинээр зам тавих зэрэг нь төсөл хэрэгжиж буй бүс нутгуудыг дайран өнгөрөх тээврийн хэрэгслийн хөдөлгөөн эрс нэмэгдэж, барилгын материал, тоног төхөөрөмж тээвэрлэх хүнд даацын автомашины хөдөлгөөний урсгалд саад учруулж болзошгүй юм. Хөдөлгөөний зохицуулалт, голдирол өөрчлөх шаардлагатай замын хэсгийг түр зуур эзлэх шаардлага гарна. Сүүлийн милийн холболтын замын зураг төслийн хурд нь цагт 50км-ээс 80км байна. Хөдөлгөөний аюулгүй байдлыг үнэлнэ.

Барилга угсралтын ажлын явцад замыг түр ашиглах нь орон нутгийн малчид, замын хөдөлгөөнд оролцогчид, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, эмэгтэйчүүд зэрэгт ихээхэн хүндрэл учруулж, замын хөдөлгөөний аюулгүй байдлын асуудалд хүргэж болзошгүй. Барилгын бүсээр тээврийн хэрэгслийг аюулгүй зорчих, саатал багатай байлгах үүднээс гэрээт гүйцэтгэгч замыг нэг эгнээтэй болгож, замын хөдөлгөөнд саад учруулсан тохиолдолд замын хөдөлгөөний зохицуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Түүнчлэн замын хөдөлгөөнд саад учруулах эсвэл хүнд даацын машинууд замын хөдөлгөөнд оролцох нь орон нутгийн замд хөдөлгөөний аюулгүй байдлын эрсдэлийг нэмэгдүүлж, орон нутгийн зорчигчдын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй. Барилгын материалыг хүнд даацын тээврийн хэрэгслээр тээвэрлэсний улмаас одоо байгаа зам мөн/эсвэл бусад

дэд бүтцэд гэмтэл учирч болзошгүй. Иймд эдгээр болзошгүй нөлөөллөөс өөр тээврийн зам ашиглах эсвэл зөвхөн зөвшөөрөгдсөн хэмжээтэй ачааны машин ашиглах зэрэг арга хэмжээ авч зайлсхийх ёстой.

Сүүлийн милийн замын хэсэг тосгоноор дайран өнгөрөхөд замын хөдөлгөөний аюулгүй байдлын арга хэмжээг замын барилгын ажлын нэг хэсэг болгон авч үзэх ёстой.

Зөрчлийг бууруулах арга хэмжээ

Хөдөлгөөний аюулгүй байдлын эрсдэлээс зайлсхийх, багасгах, бууруулахын тулд Хавсралт 7-д заасан загварын дагуу талбайн тусгай БОНУТ-г боловсруулж, холбогдох заавар, арга хэмжээг ЕСОР, Хавсралт 8, Замын хөдөлгөөний удирдлагын төлөвлөгөө хавсралт 9-д тус тус оруулна.

### **Хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөн ба хөдөлмөрийн нөхцөл (Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал)**

Ажилчдын шилжилт хөдөлгөөн нь орон нутгийн иргэдэд, ялангуяа хөдөө орон нутаг, алслагдсан, жижиг орон нутгийн нийгмийн амьдралд сөрөгөөр нөлөөлж болзошгүй. Эдгээр сөрөг нөлөөнд нь ус, цахилгаан, орон сууц, бусад орон нутгийн үйлчилгээний эрэлт, эдгээрийн төлөөх өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, тухайлбал, нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ, экосистем, байгалийн нөөцийн ачаалал нэмэгдэнэ. Хүн амын мэдэгдэхүйц өсөлт нь инфляцийн түвшинг нэмэгдүүлж, улмаар орон нутгийн хэрэглэгчдийг шахаж, замын хөдөлгөөн, ослын эрсдэл нэмэгдэх зэрэг сөрөг нөлөөг бий болгож болно. Нийгэм доторх иргэдийн хоорондын зөрчилдөөн, халдварт өвчний тархалт, архины хэрэглээ нэмэгдэх, орон нутгийн ёс заншлыг үл хүндэтгэх, хүчирхийлэл, хууль бус зан үйл, гэмт хэргийн гаралт нэмэгдэх магадлалтай.

Бүрэлдэхүүн 1-ийн дагуу гэрээт ажилчид хөрс ухах, нураах, машин механизмын ажлаас үүсэх тоосжилт, хорт бодисын хэмжээ ихэссэн орчинд ажиллаж, ажлын явцад ядрах, толгой эргэх зэрэг шинж тэмдэг илэрч болзошгүй. Ажилчид ялангуяа ажилдаа хайхрамжгүй хандсан, хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрмийг мэдэхгүй, мөрдөхгүй байдлаас болж цахилгааны шугам/тоног төхөөрөмж, бие махбодийн бэртэл гэмтэл, барилгын талбайд ажиллаж байгаа янз бүрийн машинуудад өртөж болзошгүй.

Жишиг логистикийн төв нь барилгын талбайд ажиллаж байгаа ажилчдад зориулсан оффисын өрөө, ачааны машины жолооч нарт зориулсан дотуур байрыг зураг төсөлд оруулж төлөвлөсөн. Бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл/бэлгийн дарамт болон бусад холбогдох аюулгүй байдлын асуудлууд ойролцоох орон нутгийн иргэдэд тулгарч болзошгүй эсэхийг үнэлнэ.

Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүч хомс учир цөөн тоогоор ажиллуулах боломжтой. Харин төслийн гүйцэтгэгч буюу өндөр ур чадвартай техникийн инженер, ажилчдыг бусад орноор урьж ажиллуулах нь элбэг. Орон сууц, үйлдвэрлэлийн зориулалттай түр баазууд байгуулах шаардлагатай бөгөөд байнга ирж ажиллах боломжтой нийтийн хоол, цэвэрлэгээ үйлчилгээ, тоног төхөөрөмж, тээвэр, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, материал, хангамжийн хүргэлт зэрэг туслах үйлчилгээ үзүүлэх, мөн уг ажлын хэсгүүдийг гүйцэлдүүлэхээр оруулсан тусгай туслан гүйцэтгэгч нартай харилцах шаардлага байж болно. Мөн мансууруулах бодис хэрэглэх хүчирхийлэл, хууль бус зан үйл, гэмт хэрэг гарч болзошгүй эрсдэлүүд байгаа.

Барилгын ажил нь ажилчдыг ХАБЭА-н осолд хүргэх магадлалтай. Орон нутгийн иргэд, ажилчид халдварт өвчин, COVID-19 халдвар, тахал өвчинд нэрвэгдэх эрсдэлтэй байна. Түүнчлэн, гадны хүмүүс, ялангуяа халдварын өндөр түвшинтэй орноос ирсэн хүмүүс байгаа нь бас нөлөөлж болзошгүй. Гадаад ажилчид, орон нутгийн иргэдийн дунд зөрчил үүсч болзошгүй. Тус улсын COVID-19-ээс урьдчилан

сэргийлэх, тэмцэх туршлагаас харахад эрсдэл дунд зэрэг байх төлөвтэй байна. Төслийн гүйцэтгэгчид Засгийн газар, ДЭМБ-аас COVID-19-ийн хяналт, урьдчилан сэргийлэхээр гаргасан чиглэл, эрсдлийг бууруулах бүх арга хэмжээг дагаж мөрдөх шаардлагатай.

#### *Эрсдлийг бууруулах арга хэмжээ*

Төлөвлөсөн ажлуудад голчлон замын засвар, шинэчлэлт, сүүлийн бээрийн холболтын зам, жишиг ложистикийн төв зэрэг багтана. Оргил ачааллын үед нийт ажилчдын тоо 250-аас доош байх төлөвтэй байна. Нарийвчилсан зураг төслийг боловсруулж дуусмагц шаардлагатай ажилчдын тоо болон төслийн талбайтай ойр байгаа иргэдээс хамаарч нөлөөллийн түвшний үнэлгээг хийх болно. Нийгмийн хөрөнгө оруулалт, ажилчидтай тохиролцсон ёс зүйн дүрэм (CoC), хяналт-шинжилгээний тохирсон хөтөлбөр ялангуяа эмзэг бүлгийн орон нутагт эсвэл ойролцоох болон бусад өндөр эрсдэлтэй нөхцөлд барилгын ажил хийгдэж байгаа тохиолдолд тэдгээрийг зохих арга хэмжээгээр бууруулахгүй л бол ийм сөрөг нөлөөлөл нь орон нутгийн түвшинд ирж буй ажиллах хүчийг удирдах, шингээх чадавхи бага байгаагаас ихэвчлэн нэмэгддэг.

Ашиглалтын үеийн эрсдлүүд нь ачааны машины жолооч нар ложистикийн төвд байрлах байруудыг ашиглах үед байна. Эдгээр болзошгүй сөрөг нөлөөнүүдийн ихэнхийг төслийн эхний үе шатанд БОННУ-ны үед илрүүлж болох ч гүйцэтгэгчийг шалгаруулж шаардлагатай ажиллах хүчний эх үүсвэрийн талаар шийдвэрлэсний дараа л бүрэн танигдах болно. Үүнийг БОНМТ, ТОХТ-нд тусгаж Байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөөнд (БОНХТ) нэмэлтээр бататгаж оруулж болно. Энэ нь гүйцэтгэгч ажил эхлэхээс өмнө тухайн талбайн сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ авах ажлыг тусгайлан хийх, төслийн хөгжилд нийцүүлэн шаардлагатай шинэчлэлтүүдийг тусгах боломжыг олгоно. Түүнчлэн ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнөөс үүдэлтэй сөрөг нөлөө, эрсдэлийн зохистой хяналт, менежмент багтаах ба Жендэрт суурилсан хүчирхийлэл, Бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл/Бэлгийн дарамттай холбоотой эрсдэл, түүнийг бууруулах арга хэмжээ нь төслийн хэрэгжилтийн явцад эрсдэлийн үнэлгээний нэг хэсэг байна.

Энэхүү болзошгүй сөрөг нөлөөг бууруулахын тулд тусгай шаардлагыг ХХЗЖ-д (Хавсралт 4) тодорхойлсон болно. Мөн орон нутгийн иргэдээс тэдний саналыг авах зорилгоор ТОХТ-г боловсруулсан. Тухайн газар нутгийн онцлогт тохирсон орчин, нийгмийн үнэлгээний нэг хэсэг болгон судалгаа хийж болно. Халдварт өвчний эдгээр эрсдэлийг үнэлж, түүнтэй холбоотой урьдчилан сэргийлэх арга хэмжээг нарийвчилсан зураг төсөл боловсруулсны дараа гүйцэтгэгч боловсруулж, ТУА-аар батлуулан ХХЗЖ, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын төлөвлөгөөнд (ХАБТХ) тусгана. Мөн жендэрийн ялгааг мэдрүүлэхээргүй ажилд авах туршлагыг сурталчлах болно. Ялангуяа COVID-19 тахлын үед Дэлхийн Банк, ДЭМБ-ын холбогдох удирдамж, бодлогыг барилгын менежментэд тусгана гэдэгт найдаж байна. Барилгын үйл ажиллагаанд гадаадын боловсон хүчин бага байх тохиолдолд гүйцэтгэгчийн гэрээ, бодлогод хангалттай менежментийн арга хэрэгслүүдийг тусгана. Гүйцэтгэх байгууллагууд ДБ-ны Байгаль орчин, нийгмийн ослыг тайлагнах хэрэгслийн<sup>21</sup> шаардлагад нийцүүлэн БОН тохиолдолуудыг бүртгэх, хариу арга хэмжээ авсан байдлыг хөтөлнө.

#### **Эмзэг бүлгүүд, тэдний оролцоо**

Барилгын ажлын явцад Бүрэлдэхүүн 1-ийн үйл ажиллагаа нь орон нутгийн иргэд, бүх зам хэрэглэгчийн аюулгүй байдалд түр зуурын хүндрэл учруулж болзошгүй. Ойролцоох малчид, орон нутгийн жижиг аж

---

<sup>21</sup> PMO to utilize the ESIRT for project implementation. Refer to: <https://openknowledge.worldbank.org/handle/10986/26033>



ахуйн нэгжүүд болох дэлгүүр, цайны газар, зочид буудал зэрэг газрууд өртөх магадлалтай байна. Зэрлэг амьтан, мал хүрэх зам мөн өртөнө. Төслийн ажилчдад зориулсан хангамж, тээвэрлэлт нь замын хөдөлгөөн ихсэх, осол аваар нэмэгдэхээс гадна тээврийн дэд бүтцэд нэмэлт дарамт учруулж болзошгүй юм. Энэ асуудлын талаархи дэлгэрэнгүйг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын сайн туршлагын тэмдэглэлээс илүү нарийн зааварчилгааг харж болно.

Бүрэлдэхүүн 1-тэй холбоотойгоор хүн амын (малчид, зам хэрэглэгчид) дундах эмзэг байдлын зарим хэсгийг зохих аргаар бууруулах боломжтой. Иймд зам хэрэглэгчид, малчид, амьтдыг аюулгүй зорчиж өнгөрөх боломжийг хангах үүднээс нэвтрэх хязгаарлалтыг гүйцэтгэгчтэй хамтран сайтар зохицуулах шаардлагатай. Орон нутгийн иргэд ирж буй ажилчдад бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээ борлуулах боломж нэмэгдэж байгаа ч эдгээр бараа, үйлчилгээг үйлдвэрлэх, хүргэхийн тулд хүүхдийг хөдөлмөр эрхлэх, улмаар сургууль завсардахад хүргэх боломжтой.

Өөрсдийн өвөрмөц эмзэг байдлаас шалтгаалан эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настануудад хэрхэн өөр өөрөөр нөлөөлөх талаар бүрэн хэмжээний үнэлгээ хийнэ. Хэлний асуудал, соёлын тодорхой зуршил зэргийг эмзэг байдлын үнэлгээнд оруулж үндэстний цөөнх хүмүүсийг хамруулах ёстой.

Бүрэлдэхүүн 1-т ялангуяа сонгогдсон газруудад баригдах шинэ замуудын ойрын оршин суугчдад эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна. Бүрэлдэхүүн 2-ын хүрээнд хөдөө орон нутгийн ажилгүй болон ядуу иргэдэд ашигтай эдийн засгийн үйл ажиллагаанууд байна. Бүрэлдэхүүн 1, 2, 3-тай холбоотойгоор хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад хязгаарлагдмал олон нийтийн оролцоо байх эрсдэлтэй тул олон нийтийн санал зөвлөх уулзалтуудад нийтийн санал бодлыг зураг төсөлд тусгах, ялангуяа төвийг сонгох, холбогдох үйлчилгээ болон шийдвэрлэх шаардлагатай нийгмийн эмзэг бүлгийн гишүүдэд зориулсан нэмэлт арга хэмжээ авах асуудлуудыг тусгахаар төлөвлөж байна.

#### *Сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ*

Төлөвлөлт, төсөллөлтийн шатанд ялангуяа Бүрэлдэхүүн 1, 2, 3-т олон нийтийн оролцоо нь чухал ач холбогдолтой бөгөөд төслийг хэрэгжүүлэх явцад ТОХТ, гомдол барагдуулах механизм (ГБМ) -д тусгана. Зөвхөн иргэд, тэдгээрийн төлөөллийн бүлэг, байгууллагууд төдийгүй тухайн нөлөөнд өртсөн бизнес эрхлэгч махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, малын гаралтай бүтээгдэхүүн нийлүүлэлтийн сүлжээний тоглогчид төлөвлөлтийн үйл явц, ерөнхий үр дүнд дуу хоолойгоо хүргэхийн тулд зохих оролцооны сувгийг бүрдүүлэх ёстой. Олон нийтийн дэмжлэгийг хадгалахын тулд ЗТХЯ төслүүдийн талаарх олон нийтийг мэдээллээр хангахын тулд хүчин чармайлт гарган ажиллах ёстой. Төсөл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц, үйлчилгээний дизайн, аюулгүй байдал жендэрийн асуудлуудыг дэмжих болно. Бүх нийтийн хүртээмж, төлөвлөлтийн арга хэрэгслийг ашиглана.

Нэмж дурдахад, жендэрийн тэмдэглэгээ, жендэрийн дүн шинжилгээ, жендэр эсвэл жендэртэй холбоотой асуудлаар зөвлөлдөх нь эмэгтэйчүүд, охид, эрчүүд, хөвгүүдийн хувийн асуудал, жендэрийн ялгааг бууруулж, төслийн үр дүнгийн хүрээнд жендэрийн нөлөөллийн хяналт, үнэлгээг хөнгөвчлөх боломжтой.

#### **Газарт үзүүлэх нөлөө**

Бүрэлдэхүүн 1-ийн дагуу нэн тэргүүнд шинэчлэх замууд болон сүүлийн бээрийн холболтын замуудын байршлыг урьдчилан тодорхойлсон ба биет болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт шаардагдах томоохон нүүлгэн шилжүүлэлт хийхгүй. Бүрэлдэхүүн 2-ын ложистикийн төв нь ашиглагдаагүй газрын хэрэгцээ, шаардлагыг үнэлэх ёстой. ЗТХЯ-наас төслийн хүрээнд ямарваа газар чөлөөлөлтийг хийхээс зайлсхийнэ гэдгээ тодорхой хэлсэн тул ТОХТ-оор чиглүүлсэн оролцогч талуудын оролцоо нь төслийн

газар ашиглалт орон нутгийн иргэдэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхыг бататгах чухал үйл явц болж байна. Зам засвар, шинэчлэлт, сүүлийн бээрийн холболтын замд шаардлагатай материалын эх үүсвэр нь зарим газарт нэвтрэхийг хязгаарлах төлөвтэй байна. Газар түр ашиглалтын нөлөөллийн түвшинг үнэлэх, шаардлагатай тохиолдолд нөхөн төлбөрийг хэрхэн олгох талаар орон нутгийн иргэдийн саналыг авах зорилгоор олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулна.

Албадан газрыг чөлөөлүүлэх, газар руу нэвтрэх эрхийг хязгаарлахаас зайлсхийх, боломжгүй тохиолдолд Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын хүрээ (НШБХ)-ыг боловсруулсан бөгөөд үүнд (i) барилга байгууламж, үндсэн хөрөнгөд үзүүлэх нөлөөллийг нөхөн төлөх протокол; мөн (ii) нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөллийн талаарх бодлого, журам барилгын ажлыг хэрэгжүүлэхээс өмнө үнэлгээ хийсний дараа нүүлгэн шилжүүлэлтийн ажлын төлөвлөгөөг боловсруулахыг шаарддаг.

Энэхүү Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын хүрээ нь газар чөлөөлөх, газар ашиглах хязгаарлалт, албадан нүүлгэн шилжүүлэх тухай Монгол Улсын хууль, Дэлхийн банкны БОНС5-ын шаардлагыг тусгасан болно. Энэхүү журамд төслийн нөлөөнд өртсөн иргэд илүү сайн байх, төслийн өмнөх үетэй харьцуулахад одоо байгаа амьдрал нь сайжирсан байх ёстой гэж үздэг. Төслийн нөлөөнд өртсөн иргэд төслийн туршид зөвлөлдөж, төлөвлөлтөд оролцох, төслийн үр өгөөжийг хүртэх боломжоор хангах хэрэгтэй. Эдгээр зарчмууд нь оролцогч талууд, ялангуяа төслийн нөлөөнд өртсөн иргэдийг эрт илрүүлэхийг шаарддаг; мэдэгдэж байгаа аливаа нөлөөллийг олон нийтэд үр дүнтэй илчлэх; илэрсэн сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, хэн нэг хүн эсвэл ямар нэг нөлөөллийг үл тоомсорлохгүйн тулд олон нийтийн бүх салбаруудтай зөвлөлдөх, хамтран ажиллах; нүүлгэн шилжүүлэх, амьжиргааг сэргээх явцад төслийн нөлөөнд өртсөн иргэдийг дэмжих зорилгоор шударга, ил тод, цаг алдалгүй хөндлөнгөөс оролцох; ялангуяа ядуурал, үндэс угсаа, хүйс, нас, хөгжлийн бэрхшээл, нийгмийн байдлын улмаас эмзэг байдалд орсон хүмүүсийн хувьд нөхцөл байдлыг сайжруулах төлөө байх хэрэгтэй.

Алдагдсан үндсэн хөрөнгө (жишээлбэл, дэлгүүрийн барилга) байвал ижил хөрөнгөөр солих, боломжгүй бол алдагдсан хөрөнгө, орлогыг нөхөх, нүүлгэн шилжүүлэх, амьжиргаагаа сэргээх зардлыг нөхөн олгох зорилготой. Нөхөн сэргээлтэд зөвхөн биет хөрөнгө төдийгүй нийгэм, соёлын үнэт зүйлс орно. Хэрэв эмэгтэйчүүдийн үнэт зүйлс зөрчигдөх эрсдэлтэй байвал төслийн нөлөөнд өртсөн иргэд нь бодлогын зорилтуудад нийцэх сөрөг нөлөөллийг бууруулах хувилбаруудыг сонгоход өөрийн хувь нэмрээ оруулна.

*Сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ*

Газар чөлөөлөхөөс аль болох зайлсхийнэ. Одоо байгаа орон сууцны газрыг авахаас зайлсхийх, сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээг Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын хүрээ (RPF) Хавсралт 1-с харах боломжтой. Нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөөг Дэлхийн банкны БОНХ, 2017 оны Газар Чөлөөлөх, Газар Ашиглахыг Хязгаарлах, Албадан Нүүлгэн шилжүүлэлт (БОНС5) зохицуулалттай нийцүүлэн боловсруулна. Газар чөлөөлөх тохиолдолд Монгол Улсын хуулийг зайлшгүй мөрдөнө.

ЗТХЯ-ны дэргэдэх ТУА нь энэхүү Нүүлгэн шилжүүлэх бодлогийн хүрээнд тодорхойлсон зарчмын дагуу барилга байгууламж, үндсэн хөрөнгөд үзүүлэх нөлөөллийг шалгах, хариу арга хэмжээ авах үүрэг бүхий хүмүүсийг оролцуулна. Хотын нутаг дэвсгэрт газар төлөвлөлт, зөвшөөрөл авах, улсын болон орон нутгийн чанартай авто замын төлөвлөлт, барилга угсралт, засвар, арчлалт хариуцсан орон нутгийн удирдлагууд, агентлагууд, бусад оролцогч талуудын төлөөлөлтэй нягт уялдаа холбоотой ажиллана

**Мэдрэмтгий хүлээж авах бүлэг**

Бүтээн байгуулалтын явцад орон нутгийн иргэд, аж ахуйн нэгж, тэр дундаа жижиг бизнес, мал маллах зэрэгт хүндрэл гарах нь гарцаагүй бөгөөд энэ нь түр зуурын шинжтэй байх болно. Бүх зам ашиглагчдын хувьд тодорхой дэд бүтцийн хэсэг байхгүй байгаа нь тэднийг гэмтэл бэртэл, эрүүл мэндээ эрсдэлд оруулах нөхцлийг бий болгож болзошгүй. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үзлэг, системийн үнэлгээ, одоо байгаа замуудыг ослын магадлал, ноцтой байдлаас хамаарч одоор зэрэглэх нь тухайн салбарт байгаа доголдлыг тодорхойлж таних механизмыг бий болгоно. Энэ тохиолдолд эрсдэл өндөртэй замуудыг сонгон сайжруулах хэрэгтэй. Замын дизайны түүхэн туршлага, стандартууд нь моторт тээврийн хэрэгслийн хүчин чадал, зорчих цагийн хэрэгцээг хангахад чиглэгдэж байсан бол эмзэг зам хэрэглэгчдийн тусгай хэрэгцээг ихэвчлэн хоёрдогч байдлаар авч үздэг.

Барилга угсралтын ажил нь орон нутгийн айл өрхүүдийн өдөр тутмын ахуйн болон бизнесийн үйл ажиллагаа болон/эсвэл ойролцоох төрөл бүрийн үйлчилгээ, барилгын талбайн ойролцоох амьжиргааны бусад үйл ажиллагаанд саад учруулж болзошгүй. Барилгын дуу чимээ, тоосжилт нь орон сууцны хороолол болон талбайн хажуугийн зам дээрх барилгын эхний эгнээнд дунд зэргийн нөлөө үзүүлж болзошгүй. Барилга баригдаж буй талбайн ойролцоо сумдын эмнэлэг, сургууль, цэцэрлэг, нутгийн захиргааны нэгжүүд байрладаг.

Бүрэлдэхүүн 1-ийн ажил явагдах байршилд/эсвэл ойр орчимд нь мэдэгдэж байгаа биет соёлын өв байхгүй. Соёлын өвд үзүүлэх нөлөөллийг үнэлж, одоо байгаа аливаа соёлын өвд сөрөг нөлөө уруулхаас зайлсхийх хэрэгтэй.

Түүнчлэн тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмын ашиглалт нь Бүрэлдэхүүн 1-ийн барилгын ажлын явцад усны худаг, гүүр, малын гарц, цахилгааны шугам, утасны шугам, ус зайлуулах систем зэрэг одоо байгаа биет дэд бүтцэд нөлөөлж болзошгүй. Барилгын ажлын зураг төслийг батлах, хэрэгжүүлэхээс өмнө ойролцоох иргэд, орон нутгийн засаг захиргаа, холбогдох байгууллагуудтай зөвшилцөх, талбайн үзлэг шалгалт хийх зэрэг арга хэмжээнүүдийг авч сөрөг нөлөөнөөс зайлсхийх эсвэл багасгах боломжтой.

#### *Сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ*

Сургууль, цэцэрлэг, сумын эмнэлэг, усны эх үүсвэр зэрэг нийгмийн мэдрэмтгий цэгүүдийн ойролцоох түр зуурын шороон замыг услах, тэмдэг тэмдэглэгээ, хамгаалалтын хаалт хашалт байрлуулах, замын хөдөлгөөнийг намжаах зэрэг олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлын стандарт арга хэмжээнүүдийг хамарна. Арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ХХЗЖ болон ТОХТ буюу Хавсралт, 4, 5-аас авч болно. Боломж-олдох зохицуулалтыг хамааруулна.

- Соёлын биет нөөц илэрсэн тохиолдолд барилгын ажлыг нэн даруй зогсооно.
- Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу соёлын биет нөөцийг устгах, гэмтээх, эвдрэх, нуун дарагдуулахыг хатуу хориглоно.
- Орон нутгийн Соёлын өвийн товчоонд цаг алдалгүй мэдээлж, зөвлөлдөх ба бусад.
- Барилгын ажлыг орон нутгийн Соёлын өвийн товчооноос зөвшөөрөл авч нарийн үзлэг хийсний дараа үргэлжлүүлнэ.

#### **Жендерт суурилсан хүчирхийллийн эрсдэлүүд**

Жендерт суурилсан хүчирхийллийн эрсдэлийн үнэлгээний хэрэгслийг ашиглан төслийн эрсдэлийг бага гэж үнэлэв.

Орон нутгийн иргэд, эмэгтэйчүүд, хүүхдүүд гэх мэт эмзэг бүлгийг шилжин ирж буй ажилчид, ложистикийн төвд байрлах иргэдээс ирэх жендэрт суурилсан хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд (SEA) өртөж болох бүлэг гэж үздэг. Барилгын ажилчид ихэвчлэн залуу эрэгтэйчүүд байдаг. Барилгын ажлаар гэрээсээ хол байгаа хүмүүс ихэвчлэн гэр бүлээсээ хол байдаг тул нийгмийн хяналтын ердийн хүрээнээс гадуур үйлдэл гаргах боломжтой. Энэ нь охид, эмэгтэйчүүдийг бэлгийн дарамтад оруулах, мөлжлөгийн бэлгийн харьцаанд орох, хууль бус бэлгийн харьцаанд орох зэрэг зохисгүй, гэмт хэргийн шинжтэй үйлдэл гаргахад хүргэдэг. Соёлын зан үйлийн өөр байдал нь барилгын талбайн ажилчдын хуаран дахь орон нутгийн болон цагаач ажилчдын хооронд зөрчилдөөн үүсгэдэг. Түүнчлэн цагаач эрчүүд болон орон нутгийн ажилчид сөрөг нөлөөгөөр барилгын ажлын байранд жендерт суурилсан хүчирхийлэл, бэлгийн дарамт гаргаж болзошгүй.

Төсөл хөдөө орон нутгийн нөхцөлд хийж гүйцэтгэх барилгын ажлын хугацаа богино, орон нутгаас бэлтгэгдсэн ажиллах хүч ашиглах тул хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөр эрхлэлт, бэлгийн мөлжлөг, дарамт, хүүхдийн хүчирхийлэл, ЖСХ-ын болзошгүй эрсдэл бага байхаар байна. Барилгын ажлын явцад ажилчдын хуарангийн ойролцоох эмэгтэйчүүдтэй ажилчид буруу харьцах, ашиглах шинжтэй зан авир гаргах боломж байсаар байна. Үйл ажиллагаа эхэлсэн үед ачааны машины жолооч нар логистикийн төвийн буудлаар үйлчлүүлнэ. Гэсэн хэдий ч эдгээр эрсдлийг тодорхойлж, үнэлэхийн тулд нийгмийн үнэлгээний нэг хэсэг болгон судалгаа явуулж, эрсдлийг үнэлж бууруулах арга хэмжээг боловсруулж болно.

#### *Сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ*

Хавсралт 8-д заасны дагуу зан үйлийн дүрэм, ажилчдын албан тушаалд томилогдох зэрэг сөрөг нөлөөг бууруулах холбогдох арга хэмжээг ХХЗЖ, ТОХТ буюу Хавсралт 4, 5-с харж болно. Эдгээр шаардлагуудыг мөн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгах бөгөөд ингэснээр барилгын компаниуд өөрсдийн ажилчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ зэрэг шаардлагатай арга хэмжээг авна. Мөн БОНМТ нь урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг тодорхойлох замаар төслийн хүрээнд Бэлгийн мөлжлөг, дарамт/бэлгийн хүчирхийллийн эрсдэлийг шийдвэрлэх тодорхой арга замуудыг тодорхойлж Бэлгийн мөлжлөг, дарамт/бэлгийн хүчирхийллийн үед авах арга хэмжээний төлөвлөгөөг гаргаж шаардлагатай бол төсөлд тусгана. БОНУТ-г тендерийн багцын нэг хэсэг болгон оруулах бөгөөд ингэснээр гүйцэтгэгч нь төслийн БОНМТ-г ашиглан гүйцэтгэгчийн дэд төслийн БОНМТ-г боловсруулахын тулд дэд төслийн гэрээний нэг хэсэг болно. ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад чиглэсэн бусад хүчин чармайлтыг илүү өргөн хүрээнд авч үзэхийн тулд БМХ/БД-ийн эрсдлийг шийдвэрлэх ажлыг төслийн түвшинд арга хэмжээ авах шаардлагатай бөгөөд түүний БМХ/БД-ээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь эрүүл мэндийн салбар, ЖСХ-ийн эсрэг үйлчилгээ үзүүлэгч нарын одоо явагдаж байгаа үйл ажиллагаануудтай уялдуулсан байх ёстой. Тухайлбал нэгдсэн нэг цэгийн үйлчилгээний төвүүд, шууд утас, лавлагааны үйлчилгээ, шударга ёс/аюулгүй байдал, сэтгэл зүй, нийгмийн дэмжлэг, эдийн засгийг чадавхижуулах хөтөлбөр.

Төслийн бүх хугацаанд ТОХТ-ны дагуу оролцогч талуудын оролцоог чиглүүлэх ба энэ нь төслийн эрсдэлийг удирдахад чухал ач холбогдолтой. Дэлгэрэнгүй мэдээлэл болон ерөнхий удирдамжийг Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй төслүүдийн БМХ/БД-ын талаарх Гомдол барагдуулах механизмын (ГБМ) тэмдэглэлээс авч болох ба эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх нөөцийн гарын авлага, ялангуяа аюулгүй, ёс зүйн зөвлөгөө өгөх ёс зүйн хэсгээс авч болно. Хөрөнгө оруулалтын төслүүдэд оролцогч талуудтай зөвлөлдөх зааварчилгааны дагуу бүх зөвлөгөөг явуулна.

Холбогдох бүх оролцогч талууд хамгийн багаар бодоход орон нутгийн иргэдэд учирч болзошгүй эрсдэл, нөлөөллийн талаар анхаарч байх хэрэгтэй бөгөөд Байгаль орчин, нийгмийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, БМХ/БД, хүн амын шилжилт хөдөлгөөний үр дагавар, ёс зүйн дүрмийн стандартууд, орон нутгийн жендерт суурилсан хучирхийллийн эсрэг үйлчилгээ үзүүлэгчид, оролцогч талуудын оролцооны үйл явц болон түүний боломжтой сувгууд эсвэл ГБМ байна. Илүү дэлгэрэнгүй холбогдох мэдээллийг томоохон барилгын ажилтай холбоотой хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилт дэх БМХ/БД-ыг шийдвэрлэх сайн туршлагын тэмдэглэлээс харж болно. Түүнчлэн жендэртэй холбоотой эмзэг асуудлууд, жендерт суурилсан хучирхийлэлтэй холбоотой асуудалд чиглэсэн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрүүд байх болно.

### **Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал**

Төслийн нөлөөнд өртсөн ард иргэд, ажилчид, зам ашиглагчидад учирч болзошгүй сөрөг нөлөө нь төслийн хүрээнд хэрэгжиж буй барилгын ажлаас (орон нутгийн зам засвар, нөхөн сэргээлт, шинэчлэлт, жишиг төвийг хөгжүүлэх гэх мэт) гадна замын хөдөлгөөн, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эрсдлүүд, өвчин эмгэг, аюултай материалд өртөх зэрэгээр барилгын талбайн эргэн тойронд амьдардаг нутгийн иргэд, ан амьтдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг эрсдэл оруулах гэх мэтээр илэрч болзошгүй. Материал авах хайрга хураах, тээвэрлэхээс үүдэлтэй сөрөг нөлөөг ойр орчмын ард иргэдэд үзүүлэх магадлалтай. Төслийн машин механизмын ажиллагаа, тээвэрлэлтээс шалтгаалж тоосжилт, дуу чимээ, аюултай хог хаягдал, үнэр, гадаргын усны бохирдол, замын хөдөлгөөний нягтрал ихсэх, хөрсний суулт, барилга байгууламжийн нуралт, таглаагүй нүх зэргийн тохиолдол өсөх магадлалтай. Барилгын хог хаягдлыг зохих ёсоор ачиж, устгаагүй тохиолдолд барилгын талбайн орон зайг эзэлснээр байгалын өнгө үзэмж байдалд сөргөөр нөлөөлж, замаар өнгөрөх явган зорчигч, ан амьтан, аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй юм.

Хүлээгдэж буй ажлын цар хүрээ, хөдөө орон нутгийн нөхцөл байдлыг харгалзан үзэхэд жендэрт суурилсан хучирхийлэл тохиох магадлал бага байна. Төслийн бүсүүдийг аюулгүй байдлыг хувьд бага, аюулгүй байдлын эрсдэл багатай гэж үзэж байна. Төслийн газрууд дахь аюулгүй байдлын эрсдлийг удирдахад шаардлагатай зүйлс нь хашаа, зам заагч, гэрэлтүүлэг, аюулгүй байдлын мэдлэг олгох анхан шатны сургалт, хамгаалалтын ажилтан зэрэг үндсэн хамгаалалтын арга хэрэгслүүд.

Төслийн бүх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд, БОНУХ-ээр тодорхойлсон шаардлагуудыг эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийг бууруулах зохих арга хэмжээнүүдэд тусгана, үүнд: (i) тээврийн хэрэгслийн хурд болон явган хүний хөдөлгөөнийг аюулгүй болгоход түлхэц үзүүлэх замын хэсэг, зохион байгуулалт; (ii) тээврийн хэрэгслийн хурдыг бууруулах эсвэл аюулгүй гарцаар гарах зэрэг замын хөдөлгөөн эрчийг намжаах арга хэмжээнүүд; (iii) явган хүний болон бусад замын хөдөлгөөнд оролцогчдын аюулгүй байдлыг дэмжих байгууламжууд, нийтийн эзэмшлийн талбайруу орох хэсэг; (v) тээврийн коридор, буудал, зогсоол руу аюулгүй нэвтрэх хэсэг. Төслийг хэрэгжүүлэх явцад гол оролцогч талуудтай нягт зөвлөлдсөний үндсэн дээр дээрх ажлыг гүйцэтгэнэ. Учир нь Тээврийн цагдаагийн алба нь замын хөдөлгөөн, аюулгүй байдлын аливаа зөрчилд оролцох үүрэгтэй бөгөөд төслийн үр дүнг өгөөжтэй байлгах чухал оролцогч тал байх болно.

### *Сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ*

Нөлөөг бууруулахад авах тусгай арга хэмжээнүүдийг ХХЗЖ, ТОХТ, БОНМТ, ЕСор-д тодорхойлсон байна. Орон нутаг, барилгын талбайн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, тухайлбал явган зорчигч, ан амьтад, ажилчдыг мөн материал хангамжийн ажилчид, барилгын ажилчид, тээврийн хэрэгслийн жолооч нарыг хамгаалахад чиглэсэн замын хөдөлгөөний аюулгүй байдлын түр арга хэмжээнүүдийг

тухайн газар нутгийн онцлогт тохирсон Замын хөдөлгөөний удирдлагын төлөвлөгөөнд зориулсан замын хөдөлгөөний удирдлагын удирдамж байх болно. Төслийн туршид замын хөдөлгөөний аюулгүй байдлын үнэлгээг хийж, холбогдох аюулгүй байдлын тохирох арга хэмжээг улсын болон орон нутгийн шаардлага болон ДБ-ны БОЭМАА-ны удирдамжууд болон ДБ-ны БОНХ-ний Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх сайн туршлагын тэмдэглэл, БОНХ-ын (i) Барилгын ажлын талбайн ажлын байрны аюулгүй байдал, (ii) Барилгын талбай дээрх аюулгүй тээврийн хэрэгсэл, (iii) Аюулгүй жолооч ба жолоочтой холбоотой дадал зуршил, (iv) Замын хөдөлгөөний аюулгүй байдал, (v) Онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээ зэрэгт нийцүүлэн боловсруулна.

## 7. ТӨСЛИЙН БҮХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ


Төслийн хэрэгжилтийн явцад ЗТХЯ-ны Төслийн удирдлагын алба (ТУА)-наас БОНХ-ний бодлогын шаардлагын дагуу төслийн бүхий л үйл ажиллагаа, түүний дотор техник туслалцаа, болзошгүй, онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний БОН эрсдэлийн тусгайсан үнэлгээ, урьдчилсан үнэлгээг тус тус гүйцэтгэнэ. Дотоодын хууль, тогтоомж болон Дэлхийн Банкны БОНХ-ний бодлогын дагуу урьдчилсан үнэлгээнд үндэслэн холбогдох БОН эрсдэл/нөлөөллийг нэмж бэлтгэн хэрэгжүүлэх, хяналт тавих БОН хэрэгслийн хамт тодорхойлно. Төслийн хүрээнд хийх биет хөрөнгө оруулалт болон техник туслалцааны төрлийн дагуу тэдгээрийн болзошгүй үр дагавар, БОН хэрэгсэл ашиглах саналын хураангуйг доорх хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 11. Биет хөрөнгө оруулалт, техник туслалцааны байгаль орчин, нийгмийн эрсдэлийн урьдчилсан үнэлгээ*

Үйл ажиллагааны төрөл	Төслийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагааны жишээ	Байгаль орчин, нийгмийн хэрэгсэл болон урьдчилсан нягтлан шалгалтын шаардлага	Эрсдэлийн түвшин
Авто замын засвар үйлчилгээ	Бага хэмжээтэй барилгын ажил, талбайн тухайлсан нөлөөлөл, барилгын ажилтай голдуу холбоотой таагүй байдал	Замын засварын ажилд зориулсан байгаль орчны үйл ажиллагааны дүрэм (Хавсралт 8), замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө (Хавсралт 9)-нүүдийг хэрэгжүүлэг агентлаг болон барилгын ажлын гүйцэтгэгч гэрээний үүргийн хэсэг болгож хэрэгжүүлэх.	Дунд
Сүүлийн бээрийн холболтын замын барилгын ажил	Тухайлсан нөлөөлөл, барилгын таагүй асуудал барилгын ажилтай голдуу холбоотой таагүй байдал	Сүүлийн бээрийн холболтын замуудын БОНМТ болон замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө (Хавсралт 9)-г гэрээний үүргийн хүрээнд хэрэгжүүлэгч агентлаг болон гүйцэтгэгчид гэрээний үүргийн хүрээнд хэрэгжүүлэх.	Дундаас өндөр
Жишиг төвийг хөгжүүлэлт	Байгаль орчин, нийгмийн ихээхэн эрсдэл/нөлөөлөл гарч болзошгүй гэж урьдчилан үзэж байгаа ч эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх эрсдэлийг үр дүнтэй бууруулах арга хэмжээ авах боломжтой	Урьдчилсан үнэлгээний дүнд үндэслэн холбогдох гүйцэтгэгч аж ахуйн нэгж боловсруулан бэлтгэх, дэд төсөл эхлэхийн өмнө хянуулан зөвшөөрөл авах байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ) байгаль орчин, нийгмийн менежментийн нэгдсэн төлөвлөгөө (БОНМТ)-ний хамт, нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөө (НШҮАТ), ХХЗЖ (ХХЗЖ) болон бусад.	Өндөр
Төрөл 1 Техникийн туслалцаа: Ирээдүйн хөрөнгө оруулалтын төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлэх	Логистикийн төв байгуулах бэлтгэл ажил, түүний дотор санхүүжилт/Төр-хувийн хэвшлийн түншлэлийн хувилбар, техник эдийн засгийн үндэслэлийн тайлан, логистикийн төвийн тендерийн баримт бичиг Техникийн дизайны стратегийн болон техник эдийн засгийн үндэслэлийн судалгаа, тээврийн олон	Дэмжлэг үзүүлж буй дэд бүтцийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн явцад үйл ажиллагаанд дараах байгаль орчин, нийгмийн нөлөөллийг харгалзах ёстой. Иймд холбогдох техникийн туслалцаа, биет хөрөнгө оруулалтын төслийг боловсруулахдаа доорх зүйлийг тодорхойлох/тогтоох үүднээс тусгайлан үйл ажиллагаа бүрийн байгаль орчин, нийгмийн болзошгүй нөлөөллийн урьдчилсан үнэлгээг хийх ёстой. Үүнд: а) байгаль орчин, нийгмийн эрсдэлийн ангилал; б) инженерийн зураг/дизайн боловсруулан бэлтгэх явцад байгаль орчин, нийгмийн хэрэгсэл (БОННУ, БОНМТ, НШҮАТ, ХХЗЖ, гм. ). Төрөл 1 үйл ажиллагаа нь	Дундаас өндөр

	төрлийн ашиглалт, экспортын логистикийн бизнес хөгжүүлэх	техникийн нарийвчилсан зураг/дизайн бол (Дэлхийн Банк санхүүжүүлсэн эсэхээс үл хамаарч) хөрөнгө оруулалтад шаардлагатай Дэлхийн Банкны бодлогод нийцсэн байгаль орчин ба/эсхүл нийгмийн (БОН) хэрэгсэл бэлтгэхэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөсөн үр дүн байж болно. Хэрэв Төрөл 1 үйл ажиллагаа нь техник эдийн засгийн үндэслэл бол Дэлхийн Банкны БОНХ-тэй нийцсэн байдлаар техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулахдаа холбогдох байгаль орчин болон нийгмийн асуудлыг харгалзан үзэх явдлыг хангахаар техник эдийн засгийн үндэслэлийн Ажлын даалгаврыг эзэлдэгчтэй тохирох нь хангалттай байж болно.	
Төрөл 2 Техникийн туслалцаа: Бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, стратеги эсхүл хуулийн хүрээ г.м боловсруулахад дэмжлэг үзүүлэх	Ложистикийн төвийн ерөнхий төлөвлөгөө, засаглал зэрэг ложистикийн төвийн бэлтгэл ажил.	Төрөл 2 үйл ажиллагаа нь үйл ажиллагааны дараах байгаль орчин, нийгмийн болзошгүй ихээхэн нөлөөлөлтэй бодлого, стратеги эсхүл хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулах замаар зөвлөгөө үзүүлэх бол байгаль орчин, нийгмийн үр дагаврын зохистой үнэлгээ гүйцэтгэх, өгч буй зөвлөгөө нь БОНХ-тэй нийцсэн байхыг ажлын даалгаварт тусгахаар тохиролцсон байх ёстой. Үүнээс гадна бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг дэмжих Төрөл 2-ын үйл ажиллагааг болзошгүй нөлөөллүүдийг тодорхойлох үүднээс хянан шалгах хэрэгтэй ба БОНХ-нд нийцүүлж байгаль орчин, нийгмийн үр дагаваруудыг шийдвэрлэх гарцуудыг ТТ-ын хүрээнд байгаль орчин, нийгмийн эрсдэлийг үнэлж, бууруулах арга хэмжээг санал болгох заалтуудыг Ажлын даалгаварт тусгана.	Өндөр
Төрөл 3 Техник туслалцаа: Зээлдэгчийн чадавх бэхжүүлэх	Засгийн газрын яамд, техникийн мэргэжилтнүүдэд зориулсан семинар, сургалт, хэлэлцүүлэг, танилцах аялал.	Эдгээр үйл ажиллагаа нь нийгмийн эсхүл байгаль орчны хамгийн бага эсхүл нөлөөлөлгүй байж болох ч дэмжлэг авч буй институци байгаль орчин, нийгмийн болзошгүй ихээхэн үр дагавартай үйл ажиллагаа эрхлэдэг эсхүл хяналт тавьдаг байж болох юм. Чадавхыг бэхжүүлэх дэмжлэгийн дизайн бэлтгэх, хэрэгжүүлэхэд эдгээр үр дагаврыг харгалзан үзсэн байх ёстой. Шаардлагатай БОН асуудлыг тусгасан байх үүднээс холбогдох ажлын даалгаврыг хянах үзэх хэрэгтэй.	Доогуур

Төслийн хүрээнд санхүүжүүлэх дэд төслийн үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөөс сэргийлэх эсхүл бууруулах үүднээс дэд төслийн төлөвлөлт, боловсруулалтын явцад байгаль орчин, нийгмийн боломжит нөлөөллийг тодорхойлох, түүнийг бууруулах практик арга хэмжээг бэлтгэх явдлыг хангахад доорх удирдамжийг мөрдлөг болгоно. Биет хөрөнгө оруулалт, техник туслалцааны төслийн хувьд талуудын оролцоо, нийтэд мэдээлэл хэвлэн нийтлэх замаар ил тод байдлыг дэмжих явдал бас чухал ач холбогдолтой юм. Төслийн үйл ажиллагааны бүхий л чухал үе шатанд шаардлагатай гэж үзвэл стратегийн төлөвлөлтийн санаачлагад зорилтот бүлэг, иргэдийн хэлэлцүүлэг, шинжээчдийн зөвлөл, нийтийн сонсгол гэх мэтийг багтаан оруулж болох юм.



Диаграмм 1. Дэд төслийн байгаль орчин, нийгмийн менежментийн журам

### Дэд төслийн урьдчилсан үнэлгээ

Сонгосон дэд төслийн БОН шаардлага хангасан байдал, бэлэн байдлыг хангах үүднээс БОН урьдчилсан үнэлгээ хийнэ. Тухайлбал, энэ үе шатанд ЗТХЯ-ны дэргэдэх төслийн удирдлагын алба, Төслийн удирдах хороо нь байгаль орчин, нийгмийн асуудлаарх гадны мэргэжилтнүүдийн дэмжлэгтэйгээр доорх зорилгоор БОН урьдчилсан үнэлгээний маягт (хавсралт 2 ) бөглөх ёстой. Үүнд:

- Санал болгож буй дэд төсөл БОН шаардлага хангаж буй байдлыг тодорхойлж, шаардлага хангахгүй үйл ажиллагаа ( Хүснэгт 2)-г төслийн санхүүжилтээс хасах;
- Дэлхийн банкны БОНХ-ний шаардлага болон дотоодын холбогдох хууль тогтоомжтой нийцсэн дэд төслийн БОН эрсдэлийн түвшинг ангилж, эрсдэл, нөлөөллийн шинж чанар, далайц, магадлалтай дүйцсэн холбогдох БОН баталгаажуулах.



Дэлхийн банкны БОНХ, БОЭМАА-ны удирдамж, байгаль орчин нийгмийн нөлөөллийн үнэлгээний баримт бичгүүд түүнчлэн дотоодын байгаль орчин, нийгмийн шаардлагуудтай нийцүүлэх зэрэг хувийн хэвшлийн нэр дэвшигчдын байгаль орчин, нийгмийн талаарх асуудлууд/үүрэг хариуцлагуудыг тендерийн баримт бичиг, барилгын ажлын гэрээнд оруулах зорилгоор байгаль орчин, нийгмийн урьдчилсан хяналтын шатны үед хэвшлийг оролцуулах үйл ажиллагааг хийнэ.

Байгаль орчин, нийгмийн (БОН) эрсдэлийн урьдчилсан үнэлгээний маягтыг бөглөн бүртгэл, гэнэтийн шалгалтад хянуулахаар Дэлхийн банкинд хүргүүлэх ёстой. Төслийн удирдлагын алба, түүний байгаль орчин, нийгмийн гадны мэргэжилтэн эрсдэлийн ангилалын дүнг баталгаажуулах хэрэгтэй.

*Хүснэгт 12. Төслийн хасалтын жагсаалт*

<b>Өндөр эрсдэлтэй төсөл бөгөөд Монгол Улсын Зам, тээврийн холболт ба логистик сайжруулах төслөөс санхүүжүүлэхгүй:</b>
a. Монгол Улсын хуулиар хориглосон аливаа үйл ажиллагаа.
b. Тусгай хамгаалалттай газар нутагт заналхийлж (Жишээ нь, ховор ургамал эсхүл амьтан нутагшуулах) эсхүл ховордсон эсхүл нэн ховордсон амьтдад аюул учруулах эсхүл тэдний амьдрах орчинг сөргөөр өөрчлөхүйц үйл ажиллагаа
c. Археологийн эсхүл палеонтологийн дурсгалт газар, тахилгат уулс зэрэг соёлын чухал дурсгалт газар
d. Ойг бэлчээрийн газар болгон хувиргах
e. Элэгдсэн бэлчээр эсхүл ойг үерт автуулах далан болон бусад усны хяналтын байгууламж
f. Элэгдсэн ой модоор дамжин өнгөрдөг авто замын барилга, шинэчлэх, засвар үйлчилгээ
g. Эдийн засгийн эсхүл биет нүүлгэн шилжүүлэхэд хүргэх аливаа дэд бүтцийн эсхүл барилгын бусад үйл ажиллагаа
h. 200 эсхүл түүнээс дээш иргэдийг нүүлгэн шилжүүлэхэд хүргэх аливаа дэд төсөл
i. 1000 дээш иргэдийг эдийн засгийн нүүлгэн шилжүүлэхэд хүргэх аливаа дэд төсөл
j. 100 эсхүл түүнээс дээш га газрыг хувиргахад хүргэх аливаа дэд төсөл
k. Дархан цаазат газар, аялал жуулчлалын бус, үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн үндсэн бүсэд орших аливаа дэд төсөл
l. Өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн аливаа дэд төсөл

### **Дэд төслийн бэлтгэл**

Дээр тайлбарласан БОН урьдчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн нэмэлт арга хэмжээ/хэрэгсэл шаардахгүй дэд төсөл нь байгаль орчин болон нийгмийн менежментийн талаарх дотоодын хууль, тогтоомжийг мөрдөнө. Бусад тохиолдолд байгаль орчин, нийгмийн (БОН ) эрсдэлийн ангилалын удирдамжинд заасны дагуу төслийн удирдлагын алба, зөвлөх нар дэд төслийн санаачлагч төслийг хэрэгжүүлэхээс өмнө Дэлхийн Банкны БОНХ-ний холбогдох БОН стандартын дагуу тухайлсан төслийн БОН нэмэлт хэрэгслийг шаардлагатай байдлаар бэлтгэж, Дэлхийн банкинд хүргүүлэн хянуулна.

### **Дэд төслийг хянан батлах**

- Засгийн газар батлах: Засгийн газраас баталсан БОННУ журмын шаардлагын дагуу холбогдох хариуцсан байгууллага холбогдох бүх баримт бичгийг батална. БОННУ-ний тайлангийн монгол эх хувь болон баталсан нөхцөлийн талаар Дэлхийн Банкинд мэдээлэл болгон хүргүүлнэ. БОННУ-ний тайлан, баталсан нөхцөлийг олон нийтэд хэвлэн нийтэлнэ.
- Төслийн албан ёсны цахим хуудсанд БОН бүх баримт бичгийг байршуулж, төслийн удирдлага алба, дэд төслийн талбайд монгол хэлээрх хэвлэмэл хувийг бэлдсэн байна. Нийтэд ил тод болгосон талаар мэдэгдэл гаргаж, нийтэлсэн өдрөөс хойш сарын хугацаанд санал хүлээн авна. Дэлхийн Банкны цахим хуудсанд БОННУ/БОМТ англи хэлээр байршуулан нийтэд мэдээлнэ.

- Дэлхийн банк хянах, зөвшөөрөх: Бүх дэд төслүүдийн байгаль орчин, нийгмийн баримт бичгүүдийг (БОННУ, БОНМТ, НШУАТ гэх мэт) баталж, хэрэгжүүлэхээс өмнө Дэлхийн банк хянаж, баталгаажуулна.

### **Дэд төслийн хэрэгжилт ба хяналт**

Дэд төсөл батлагдсаны дараа барилгын болон ашиглалтын үе шатанд ТУА, БОН ажилтан, гадны зөвлөхүүд дэд төслийн хяналтын салшгүй бүрэлдэхүүн болгон БОН менежментэд үр дүнгийн хяналт тавина.

Доорх тусгайлсан шаардлага тавина. Үүнд:

- Дэлхийн Банкны дэд төслийн санхүүжилт авахын тулд төслийн удирдлага дэд төслийн БОН үр дүнг хянан үнэлгээ хийх асуудлыг тусгасан байх ёстой. Дэлхийн Банкны БОНХ-ний холбогдох шаардлага болон дотоодын хууль тогтоомжийн дагуу төслийн удирдлагын алба, гадны зөвлөхүүд, дэд төслийн өмчлөгч дэд төслийн үр дүнг үнэлэх ёстой.
- Хэрэгжилтийн явцад БОН өсөн нэмэгдэж буй эрсдэлтэй гэж тодорхойлсон дэд төслийн хувьд төслийн удирдлагын алба болон гадны туршлагатай зөвлөхүүд илрүүлэлтийг баримтжуулж, БОН хяналт-шинжилгээний хагас жилийн болон түүнчлэн бүртгэгдсэн тохиолдол гарсан үед тайлан боловсруулан бэлтгэх замаар Дэлхийн банкинд мэдээлнэ. Дотоодын хууль тогтоомж болон Дэлхийн БОНХ-ний шаардлагын дагуу эрсдэл бууруулах арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэх ёстой. Дэлхийн Банкинд хүргүүлэх хяналтын тайланд энэ тухай мөн тусгасан байх хэрэгтэй.

### **Дэд төслийг дуусгах, үнэлэх**

Төсөл дууссаны үнэлгээний бүрэлдэхүүн болгон дэд төсөл дуусмагц түүний БОН үр дүнг хянан үнэлнэ.

### **Талуудын оролцоо**

Төслийн бүхий л үе шатанд буюу дэд төслийг тодорхойлох, түүний БОН менежментийн үе шатанд Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн стандарт 10 (БОНС 10) удирдамжийн шаардлагыг хангах ёстой. Энэхүү тайлангийн бүлэг 7 болон хавсралт 5 тэмдэглэсэнчлэн төслийн байгаль орчин ба нийгмийн үнэлгээ, төслийн дизайн болон хэрэгжилтийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг бол талуудын оролцоог хангах явдал юм.

2021 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар Улсын онцгой комисс Улаанбаатар хотод КОВИД-19 цар тахлын халдварын өндөр тархалтад хатуу хяналт тавьж байв. Улсын онцгой комиссын КОВИД-19 халдвараас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журмаар КОВИД-19 цар тахлын халдвараас сэргийлэх бэлтгэл ажил, дэгдэлтийн үед авах арга хэмжээг тодорхойлсон доорх 4 ангилалыг тогтоосон байна. Үүнд:

Улаан-Түвшин 4: хэрэв халдварын тохиолдол илэрсэн бол  
Улбар шар- Түвшин 3: хэрэв халдварын тохиолдлын кластер илэрсэн бол  
Шар- Түвшин 2: хэрэв импортлогдсон халдварын тохиолдол илэрсэн бол  
Ногоон- Түвшин 1: хэрэв сүүлийн 28 хоногт халдварын тохиолдол илрээгүй бол.

КОВИД-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, хорио цээрийн нөхцөл байдлыг харгалзан талуудын оролцоог хангах бүх үйл ажиллагааг хэрэгжүүлэх ёстой.

Хүснэгт 13. Нийтийн хэлэлцүүлэгийн бүртгэлийн хүснэгт

Огноо	Байршил	Оролцогчийн овог, нэр	Хэлэлцүүлгийн явцад гол талуудын хэлэлцсэн эсхүл тавьсан санаа зовниж буй асуудал	Хэрхэн шийдвэрлэх	Хүйс

## 8. ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА МЭДЭЭЛЛИЙГ НЭЭЛТТЭЙ БАЙЛГАХ

Хууль эрх зүйн шаардлага

2012 оны Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулийн 5 болон 18-р зүйлүүдэд дараах шаардлагуудыг тусгасан болно:

- Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Байгаль орчны хэрэгжүүлэгч агентлагийн бүрэлдэхүүн хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрийн үнэлгээний дүгнэлтийн талаарх мэдээллийг нийтэд мэдээлж, өөрийн цахим хуудсанд байршуулах;
- Стратегийн үнэлгээнд олон нийтээс санал ирүүлэх хугацаа нь ажлын 30-аас дээшгүй өдөр байх бөгөөд амаар болон бичгээр санал авах бөгөөд Байгаль орчны хэрэгжүүлэгч агентлагийн зөвлөх нь нөлөөлөлд өртөх орон нутгийн төрийн захиргааны байгууллага болон оршин суугчидтай нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулна;
- Байгаль орчны хэрэгжүүлэгч агентлагийн Төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх орон нутгийн төрийн захиргааны байгууллага болон оршин суугчидтай хийх уулзалтуудын тэмдэглэл, санал хүсэлтүүдийг багтаасан байна.

2015 оны Хот байгуулалтын тухай Монгол Улсын хуулийн 17 болон 18-р зүйлүүдэд дараах шаардлагуудыг тусгасан болно:

- Хот төлөвлөлтийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоотой төлөвлөлтийн зарчмыг тусгаж ажиллана.
- Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар, Хотын захирагчийн ажлын алба нь энэ хуулийн хүрээнд гаргасан аливаа шийдвэрийн талаар тухай бүр олон нийтэд мэдээлнэ;
- Хэрэглээний дэд бүтэцтэй холбогдолтой доголдол, тасалдалын тухай уг тасалдал болохоос 24 цагийн өмнө оршин суугч болон байгууллагуудад мэдээлэх.

Дэлхийн банкны БОНХ-д Байгаль орчин, нийгмийн стандарт (БОНС) 10-р бүлэг, Талуудын оролцоог хангах болон Мэдээллийн ил тод байдлын талаарх ойлголтууд багтах бөгөөд уг ойлголтоор "... Зээлдэгч ба төслийн оролцогч талууд хоорондоо нээлттэй, ил тод хамтын ажиллагаатай байх нь олон улсын сайн туршлагын чухал нэг хэсэгт тооцогдоно". Зээлдэгчээс Төслийн мөн чанар, цар хүрээ болон болзошгүй эрсдэл, нөлөөлөлтэй пропорциональ уялдаатай ТОХТөлөвлөгөө боловсруулах шаардлагатай. БОНСтандартын 10-р бүлэгт заасан журмын дагуу Гомдол барагдуулах механизм (ГБМ) боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай.

Энэхүү БОНМХүрээг амьсгалын замын цочмог хам шинж коронавирус 2 (SARS-CoV-2)-с үүдэлтэй халдварт өвчин болох Ковид-2019 өвчний цар тахлын үед (COVID-19) бэлтгэсэн бөгөөд Монгол Улсын ЗГ уг цар тахлын эсрэг арга хэмжээ болгон бүх сургууль, цэцэрлэгийг хаах, гадаад руу чиглэсэн болон гадаадаас ирэх бүх аялал, дотоодын агаарын болон төмөр замын тээврийг зогсоох, олон нийтийн цугларалт, арга хэмжээ, хурал цуглаан, түүний дотор чуулган, спортын арга хэмжээ, концерт хорих зэрэг арга хэмжээнүүдийг авсан болно.

Ковидтой холбоотой хязгаарлалтын улмаас дэд төсөлтэй холбоотой мэдээллийг ил тод болгох болон олон нийтийн хэлэлцүүлэг, уулзалтуудыг ердийн үе шиг зохион байгуулах боломжгүй байсан боловч дараах хэлэлцүүлгүүдийг тодорхой хязгаарлалтуудыг баримтлан хийв.

Оролцогч тал	Тодорхой зорилтот бүлэг: Нэр/s	Уулзалтын арга барил
Засгийн газар	Яамд болон агентлагууд: ЗТХЯ, СЯ, Үндэсний хөгжлийн газар	Онлайн групп уулзалт
	Аймаг, сумдын орон нутгийн төрийн захиргааны байгууллагууд, түүн дотор ЗДТГ, НИТХ, Зам засвар, байгаль орчин (ТХГН), газар болон соёлын өв хариуцсан байгууллагууд.	Онлайн групп уулзалт эсвэл онлайн асуулга
Иргэд болон Иргэний нийгмийн байгууллагууд	Малчид болон орон нутгийн иргэд: <ul style="list-style-type: none"> <li>Зам дагуух суурин газрын оршин суугчид, багийн иргэдийн төлөөлөгчид</li> <li>Малчдын хамтрал, Бэлчээр ашиглагчдын холбоо, орон нутгийн ТББ-ууд</li> </ul>	Онлайн групп уулзалт эсвэл онлайн асуулга
	Эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд: <ul style="list-style-type: none"> <li>Эмэгтэйчүүдээр ахлуулах бизнес холбоод</li> <li>Жендер болон хөгжлийн бэрхшээлийн иргэдийг хамруулах мэргэжилтнүүд болон болон холбогдох ТББ-ууд</li> </ul>	Онлайн групп уулзалт эсвэл онлайн асуулга
Донорууд болон холбогдох төслүүд	ДБ, НҮБ-ын ОУХБ, НҮБ-ын ХХААБ, Швейцарийн хөгжлийн агентлаг (ШХА), АХБ, АНУ-ын Азийн Сан: <ul style="list-style-type: none"> <li>"Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл" (ДБ, ХХААБ)</li> <li>Эмэгтэйчүүдийн бизнесийг дэмжийг төсөл (ТАФ)</li> <li>Амьтны эрүүл ахуй болон бэлчээрийн менежмент (ШХА)</li> </ul>	Ганцаарчилсан онлайн уулзалтууд болон судалгаа, тайлантай танилцах
Хувийн хэвшил	Замын компани, газар дээрх гүйцэтгэгч байгууллагууд	Онлайн групп уулзалт эсвэл онлайн судалгаа
	Жижиг худалдаачид болон албан бус бизнес эрхлэгчид <ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн бизнесийн төлөөлөл</li> </ul>	
Академийн байгууллагууд	Эрдэм шинжилгээний болон судалгааны институтууд	Судалгаа, тайлантай танилцах

ЗТХЯ-ны удирдлагууд болон холбогдох байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр төслийг хэрэгжүүлэх явцад ЗТХЯ болон Төслийн удирдах хорооноос агуулгын төслийг боловсруулж, төлөөлөгч болон оролцогчдыг Оролцогч талуудын олон нийтийн хэлэлцүүлэгт урьж оролцуулна. Оролцогч талуудын олон нийтийн хэлэлцүүлгийн уулзалтын үргэлжлэх хугацааг хагас өдөр байхаар төлөвлөж байгаа бөгөөд энэхүү тайланг илгээх үеийн урьдчилсан товъёог доорхи Хүснэгт 17-т харуулав.

Хүснэгт 14. Оролцогч талуудын олон нийтийн хэлэлцүүлэгийн уулзалтын жишээ товъёог

Заасан хугацаа	Үйл ажиллагаа
5 минут	Нээлтийн үг
15 минут	Төслийн тайлбар
30 минут	Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл болон процедуруудын талаарх тайлбар
40 минут	Асуулт хариулт
5 минут	Хаалтын үг

Нээлттэй хэлэлцүүлгийн үеэр Төслийн талаар болон түүний байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, тэдгээрийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ болон процедуруудыг тайлбарлах бөгөөд түүний дараа оролцогчидтой асуулт, хариултын хэсэг явна. Хэлэлцүүлгийн уулзалтыг явуулах хэлбэрийг Ковид-19-

ийн эсрэг халдвар хамгааллын дэглэмийг харгалзан үзэж, Төслийн удирдах нэгж болон холбогдох байгууллагуудын зөвшилцлөөр тогтооно. БОНМХ, БОНМТ-г бэлдэх үеийн олон нийтийн хэлэлцүүлгийн бүх уулзалтыг онлайнаар явуулна.

ТУХороо нь олон нийтийн хэлэлцүүлгийг холбогдох талуудтай уялдуулж, эдгээр уулзалтуудыг хялбаршуулах зэрэг ажлыг зохион байгуулах, хурлын тэмдэглэл (оролцогчдын нэрсийн жагсаалт, асуулт, хариултын тэмдэглэл, баримтжуулах гэрэл зураг гэх мэтийг) хөтлөх болно.

Дээрх урьдчилсан төлөвлөгөөгөөр ТУХороо болон ЗТХЯ нь монгол хэл дээр Төслийн танилцуулгыг бэлдэж, хэлэлцүүлгийн үеэр тайлбарлахаар төлөвлөж байна.

Нээлттэй ил тод байх

Барилга болон ашиглалтын явц дахь талуудын оролцоог төрийн болон ДБ-ны холбогдох бодлого, журмын дагуу хангана.

Байгаль орчны хяналт шинжилгээний тайланг ДБ-ийн вэбсайт дээр байршуулах бөгөөд байршуулах давтамж нь барилгын ажлын явцад хагас жил тутам, ашиглалтын явцад жилд нэг удаа байх болно.

ТУА нь барилгын ажлын болон ашиглалтын шатанд гомдол барагдуулах механизмыг хэрэгжүүлэх зэрэг олон нийттэй харилцах ажлыг тогтмол явуулна (ГБМ, 8-р бүлгийг үзнэ үү). Хэлэлцүүлгийг байнга явуулах нь олон нийтийн санаа зовоосон асуудлыг цаг тухайд нь ойлгож, шийдвэрлэх боломжийг олгоно. Үндэстний цөөнх байгаа нь батлагдсан тохиолдолд төслийн мэдээллийг монгол хэл болон үндэстний цөөнхийн хэлээр, хүртээмжтэй, соёлын хувьд тохирсон байдлаар нийтэд ил болгоно. Мэдээллийг ил тод болгох ач холбогдолтой арга замыг орон нутгийн нөхцөл байдалд нийцүүлэн төлөвлөх ба тухайлбал, алслагдсан нутагт амьдардаг малчдад харилцаа холбооны технологи, радио зэргээр дамжуулан холбогдоно.

## 9. ТАЛУУДЫН ОРОЛЦОО БА ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ МЕХАНИЗМ

### Олон нийтэд мэдээлэх

Зам, тээврийн хөгжлийн хөгжлийн яам олон нийтэд зориулан БОНМХ-ний дэлгэрэнгүй (монгол хэлээр) болон хураангуй баримт бичгийг өөрийн албан ёсны вэб хуудсаар <https://www.mrtd.gov.mn> мэдээлсэн.

Мэдээлэл, холбогдох материалыг олон нийт саадгүйгээр мэдээллийг авах боломжтой нутгийн иргэд олноор цуглардаг байршлууд, газруудад байршуулан түгээнэ. Яамны байранд олон нийтэд зориулан БОНМХ, ТОХТ, НШБХ зэрэг монгол хэл дээр хэвлэгдсэн материалуудыг байршуулан түгээнэ. Оролцогч талуудын дунд эхний уулзалтыг төслийн бэлтгэл ажлын үед зохион байгуулна. Засаг захиргааны нэгж болон төрийн үйлчилгээгээр дамжуулан иргэдэд барилгын ажлын зарын самбар, иргэдэд хүргэх захидлыг хүргэх ба төлөвлөсний дагуу төслийн хэрэгжүүлэх явцад бий болсон саад бэрхшээлийн талаар сонины зар, вэб хуудсаар дамжуулан мэдээлэл тараана.

### Талуудын оролцоо

ЗТХЯ/ТХН нь төсөл боловсруулах, хэрэгжүүлэх явцад оролцогч талуудын дунд утга учиртай, үр дүнтэй, мэдээлэлтэй оролцоог бий болгоход үйл ажиллагаагаа чиглүүлнэ. Энэхүү үйл явц нь ил тод байдал, хоёр талын харилцаа, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж, төсөл хэрэгжсэнээр сөрөг нөлөөнд өртөж

болзошгүй хүн амын бүлгүүд түүний дотор эмзэг бүлгийн иргэдийг багтаасан шударга, төлөөллийн оролцоог хангахыг зорьж байна.

БОНМХ-ний нэг хэсэг болох Талуудын Оролцоог Хангах Төлөвлөгөөг (ТОХТ)-г оролцогч талуудын оролцоог илүү иж бүрэн хангах стратеги болон төлөвлөгөөг боловсруулах зорилготой давталттай үйл явцын эхлэл болгон боловсруулж нийтэд ил тод болгосон. Төсөл батлагдсаны дараа тус баримт бичгийг илүү нарийвчилсан мэдээллийг оруулан шинэчлэхээр төлөвлөсөн ба шаардлагатай тохиолдолд тодорхой хугацаанд шинэчилнэ. Ковид-19 халдварлах байдал өндөр байгаагаас шалтгаалан халдвараас хамгаалах үүднээс зөвлөлдөх үйл явцад онлайн сүвгийг нэвтрүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Оролцогч талуудыг тодорхойлохдоо тэдний сонирхол, хэрэгцээ, төсөлд гүйцэтгэх үүрэг, чадавх, боломж, хамтран ажиллах хязгаарлалт зэрэг хүчин зүйлсийг авч үзлээ. Төсөлд оролцогч талууд, тэдний гүйцэтгэх үүргийг дараах байдлаар тодорхойлов:

*Хүснэгт 15. Оролцогч талууд ба үүрэг*

<b>Оролцогч тал</b>	<b>Төслийн хэрэгжилтэд гүйцэтгэх үүрэг</b>
Дэлхийн Банк	Төслийг санхүүжүүлнэ. Төслийн зорилго биелж буй эсэхэд хяналт тавина.
Зам, тээврийн хөгжлийн яам	Төслийн Удирдах Хороогоор дамжуулан төслийн хэрэгжилтэд ерөнхий чиглэл өгнө.
Байгаль орчин, аялал жуулчлалын яам/нийслэлийн байгаль орчны газар	БОАЖЯ/Нийслэлийн Байгаль Орчны Газар байгаль орчны зөвшөөрлийг өгөх ба өөрсдийн шийдвэрт тулгуурлан хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хяналт-шалгалт зохион байгуулна.
Сангийн Яам	Сангийн сайдын 4-р тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх” журмын хэрэгжилтэд хяналт тавина. Төслийн Удирдах Хороогоор дамжуулан төслийн хэрэгжилтэд ерөнхий чиглэл өгнө.
Барилга, хот байгуулалтын яам	БХБЯ нь зөвшөөрөл олгох ба өөрсдийн шийдвэрт тулгуурлан хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хяналт-шалгалт зохион байгуулна.
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Төслийн дизайн болон хэрэгжилтэд оролцож зохицуулалтаар хангана.
Тээвэр болон Замын хөгжлийн асуудал хариуцсан үндэсний болон орон нутгийн агентлагууд	Төслийн хэрэгжилтэд хяналт тавина, зохицуулалтаар хангана.
Үндэсний хөгжлийн газар	Төслийн дизайн болон хэрэгжилтэд оролцож зохицуулалтаар хангана.
Аймгийн мэргэжлийн хяналтын газрууд	Гүйцэтгэлийн явцад хугацаат хяналт, шалгалт хийнэ.
Аймаг, сумдын тамгын газрын ажилтнууд	Дэмжлэг үзүүлэх, мэдээлэл өгөх, оролцогч талуудын оролцоог хангах
Төслийн удирдах хороо	Зам, Тээврийн хөгжлийн яам даргалах ба ХХААХҮЯ, СЯ, ҮХГ, орон нутгийн удирдлагын байгууллага, холбогдох агентлагуудын төлөөллөөс бүрдэнэ. Засгийн газрын гадаадын зээлийн хөрөнгийг ашиглах 196 дугаар журмын

	дагуу төслийн хэрэгжилтэд хяналт тавина.
Төслийн удирдлагын алба	Төслийн хэрэгжилтийг бүхэлд нь хариуцна.
Гүйцэтгэгч	Төслийн хамтрагчид
	Төслийн хэрэгжилтэд оролцоно.
Зөвлөхүүд/Зөвлөх	Төслийн хамтрагч
	Төслийн хэрэгжилтэд оролцоно.
Орон нутгийн судалгааны байгууллагууд	Төслийн боломжит хамтрагч
	Төслийн хэрэгжилтэд оролцоно.
ТББ-ууд, сонирхлын бүлгүүд	Төслийн боломжит хамтрагч
	Төслийн хэрэгжилтэд оролцоно.
Төслийн үр нөлөөнд өртөх төрийн байгууллагууд	Төслийн хэрэгжилтэд оролцох; хэрэглэгч талуудтай тогтвортой харилцаа тогтоох
Төслийн үр нөлөөнд өртөх хувийн хэвшлийн байгууллагууд	Төслийн хэрэгжилтэд оролцоно.
Төсөлд өртсөн иргэд	Төслийн хэрэгжилтэд оролцоно.
Үндэстний цөөнх	Төслийн бүсэд амьдардаг үндэстний цөөнхийн хүмүүс төслийн үйл ажиллагаанд онцгой анхаарал хандуулж болно.

Төслийн бүх үе шатуудад төсөл нь зорилтот төслийн оролцогч талууд түүний дотор эмзэг бүлгүүдийн санаа зовоосон асуудлууд/хэрэгцээ шаардлагыг тодорхойлохын тулд тэдний гэртээ, ажлын байрандаа болон нутгийн иргэдийг хамарсан нийтийн үйл ажиллагаанд оролцоход тулгардаг сорилтууд, тэдний авч буй мэдээлэл болон үйлчилгээнд чиглэсэн. Оролцогч талуудыг төслийн хэрэгжилтийн явцад нийгэм, эдийн засгийн гүйцэтгэл, талуудын оролцоог хангах төлөвлөгөө, өргөдөл, гомдол шийдвэрлэх механизмын талаар тогтмол мэдээллээр хангаж ажиллана.

Төслийг хэрэгжүүлэх зохион байгуулалт нь дараах байдалтай байна: Зам, Тээврийн Хөгжлийн Яам нь төслийн хэрэгжилтийг хариуцах ба үүнд ерөнхий зохицуулалтаар хангах, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээг гүйцэтгэх, Дэлхийн банктай санхүүгийн болон хамгааллын талаар холбоо барьж ажиллана. Энэ үйл ажиллагааг төсөл хэрэгжүүлэх нэгж дэмжиж ажиллах ба төсөл хэрэгжүүлэх нэгж нь төслийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Төслийн нэгжийн ажилтнууд ТОХТ, БОНМХ-г хэрэгжилтэд үр дүнтэй хяналт тавихын тулд зохих сургалтад хамрагдсан байна. Төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулахаас өмнө Монгол Улсын хууль, Дэлхийн банкны дүрэм, журмын дагуу Зам, Тээврийн Хөгжлийн Яам нь төсөл батлагдахаас өмнө оролцогч талуудын хэлэлцүүлгийг зохион байгуулах үүрэгтэй. Төслийн хэрэгжилтийн үеэр төсөл хэрэгжүүлэх нэгж нь оролцогч талуудын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Дэлхийн банкны “Байгаль орчин, нийгмийн хүрээний ESS10” стандартын шаардлагыг дагаж мөрдөнө. Төслийн ТОХТ-нд “Талуудын оролцоог хангах төлөвлөгөө/хүрээ” –г оруулсан бөгөөд үүнд оролцогч талуудын зөвлөлдөх уулзалтыг удирдан чиглүүлэх нарийвчилсан журам, тавигдах шаардлагыг тусгасан болно. (Хавсралт 5)

Талуудын оролцоог хангах төлөвлөгөөний зорилго нь төслийн оролцогч талуудыг тодорхойлох, төсөл хэрэгжих хугацаанд зөвлөлдөх, мэдээлэл түгээх хэлбэр, өргөдөл, гомдлыг барагдуулах арга замыг тодорхойлоход оршино. “Оролцогч тал”-д дараах хүмүүс эсвэл бүлгүүд багтана. Үүнд: (а) төслийн үйл ажиллагааны сөрөг нөлөөнд өртөж болзошгүй, эрх ашиг нь хөндөгдөх магадлалтай (төслийн сөрөг



нөлөөлөлд өртөж болзошгүй талууд); (б) төслийн үйл ажиллагааг сонирхогч талууд байж болно (бусад сонирхогч талууд).

Дэлхийн банкны БОНХ нь “Байгаль орчин, нийгмийн стандарт 10”, “Оролцогч талуудын оролцоо ба мэдээллийн ил тод байдал” багтдаг бөгөөд эдгээрт "...зээлдэгч ба төслийн оролцогч талуудын дундах нээлттэй, ил тод хамтын ажиллагаанд ач холбогдол өгөх нь олон улсын сайн туршлагын чухал элемент болохыг" хүлээн зөвшөөрсөн байдаг. БОНМХ-г боловсруулах явцад холбогдох талуудыг оруулан оролцогч талуудын эхний хэлэлцүүлгийг 2021 оны 7-р сард зохион байгуулж тэдний саналыг ТОХТ-нд тусгасан.

### Гомдол шийдвэрлэх механизм

“Байгаль орчин, нийгмийн стандарт 10”-ын дагуу ЗТХЯ нь төслийн хэрэгжилтээс үүдэлтэй байгаль орчин, нийгмийн асуудлаар төслийн нөлөөнд өртөж болзошгүй талуудаас гаргасан өргөдөл, гомдлыг хугацаа алдахгүй шийдвэрлэх ГБМ-г байгуулж хэрэгжүүлнэ.

ГШМ-д дараах мэдээллүүд орж болно: (а) Өргөдөл, гомдол гаргагч/хэрэглэгчид өөрийн биеэр гомдлоо хүргэх, утсаар, текст мессежээр, и-мэйлээр болон вэб хуудсаар гэх мэт бүх төрлийн хэлбэрээр өргөдөл, гомдлоо хүргүүлэх боломжтой байх; (б) Бичгээр хүргүүлсэн өргөдөл гомдол бүртгэгдэж, өгөгдлийн санд хадгалагддаг байх; (в) Хэрэглэгчид өргөдөл, гомдол гаргасны дараа хүлээн авсныг баталгаажуулах, хариу өгөх, хэрхэн шийдвэрлэгдсэн талаарх хугацааг тодорхойлсон олон нийтэд нээлттэй зарласан журам; (г) Гомдол шийдвэрлэхтэй холбоотой журмын ил тод байдал, гомдол шийдвэрлэх бүтэц, шийдвэр гаргагчид; (д) Гомдлын дагуу асуудал шийдэгдээгүй үед сэтгэл ханамжгүй үлдсэн гомдолтой холбоотой давж заалдах үйл явц. Төслийн хүрээнд гомдлыг шийдвэрлэсэн байдалд сэтгэл ханамжгүй байгаа хэрэглэгчдэд зуучлалын сонголтыг санал болгоно. “Байгаль орчин, нийгмийн стандарт 2”-т тавигдах шаардлагын дагуу шууд ажилтан болон гэрээт ажилтнуудыг ажлын байртай холбоотой өргөдөл, гомдол гаргах боломжоор хангана. Эдгээр ажилтнуудыг ажилд авах үед ГШМ-ын талаар болон Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын (ХЭААБ) арга хэмжээг хэрэгжүүлэх, хэрэглэхэд тулгарч буй аливаа эсэргүүцэлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх, ажилтныг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхтэй холбоотой мэдээллээр хангана.

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь ГШМ-г хэрэгжүүлэх журмыг боловсруулах ба төсөл хэрэгжих явцад өргөдөл, гомдол барагдуулах механизмын талаар оролцогч талуудын хэлэлцүүлгүүдээр танилцуулан, Монгол хэлээр оролцогч талуудын дунд мэдээлэл тараана. Өргөдөл, гомдлыг дараах дөрвөн үе шатаар шийдвэрлэнэ:

Нэгдүгээр үе шат: Орон нутгийн түвшинд өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ба өргөдөл гомдол барагдуулах механизмд хандах боломж. Өргөдөл, гомдол барагдуулах механизмын систем нь төслийн сөрөг нөлөөнд өртөж болзошгүй талуудаас (орон нутгийн оршин суугчид, аж ахуйн нэгжийн төлөөлөгчид, гэрээлэгчдийн ажилтнууд гэх мэт) гомдол, саналыг хэд хэдэн хувилбараас хамгийн боломжит арга замыг сонгон гаргах нөхцлийг бүрдүүлнэ. Төслийн сөрөг нөлөөнд өртсөн хүний санал, гомдлыг ЗТХЯ-ны дотоод цахим төв серверт шууд бүртгэх бөгөөд энэ нь хариу өгөх системтэй холбогддог. Өргөдөл, гомдлын бүртгэлд санал/ өргөдөл гомдлын асуудал, төслийн сөрөг нөлөөнд өртсөн хүний нэр, холбоо барих хаяг, өргөдөл, гомдол хүлээн авсан огноо зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг оруулна.

Хоёрдугаар үе шат: ЗТХЯ-аас гаргасан шийдвэр, өргөдөл, гомдлын шаардлагыг хангах боломжтой эсэхийг үнэлэн, шийдвэрлэнэ. Хүлээн авсан өргөдөл, гомдлыг төсөл хэрэгжүүлэх нэгжийн холбогдох


ажилтнуудад эсвэл ЗТХЯ-ны холбогдох хэлтэс /хэлтэс/ нэгжид хуваарилна. Төсөл хэрэгжүүлэх нэгж нь асуудлыг шалгаж, шийдвэрлэх арга хэмжээг авна. Үүнд ажил гүйцэтгэгчийн үйл ажиллагааны алдааг залруулах арга хэмжээ багтана. Гэрээлэгч өргөдөл, гомдол барагдуулсан шийдлийг хэрэгжүүлэн, түүний үр дүнг төсөл хэрэгжүүлэх нэгжид уламжилж, ДБ-д мэдэгдэх ёстой. Өргөдөл, гомдлын төрөл, ярвигтай байдлаас шалтгаалан ТХН/ЗТХЯ нь тухайн өргөдөл, гомдлыг хүлээн авснаас хойш 1-30 өдрийн дотор асуудлыг шийдвэрлэнэ.

Гуравдугаар үе шат: Өргөдөл, гомдлыг төсөл хэрэгжүүлэх нэгж, төслийн удирдах хороо шийдвэрлэнэ. Гуравдугаар үе шатанд ЗТХЯ, төсөл хэрэгжүүлэх нэгж нь асуудлыг судалж 10 хоногийн дотор олон талын оролцогчдын дунд уулзалт зохион байгуулж, түүнээс хойш 10 хоногийн дотор асуудлыг шийдвэрлэн хэрэгжүүлнэ.

Дөрөвдүгээр үе шат: Дээд байгууллагын тогтоол. Хэрэв өргөдөл, гомдлыг барагдуулаагүй бол төслийн нөлөөнд өртсөн тал шүүхэд хууль ёсны дагуу хандах боломжтой.

#### **ЗТХЯ-ны холбогдох хаяг:**

<b>Зам, Тээврийн Хөгжлийн Яам</b>
Хаяг: Засгийн газрын 13 дугаар байр, Чингисийн өргөн чөлөө-11, Улаанбаатар хот, Монгол Улс, Зип:14251 Утас: 976-(51)263179; Fax: (976-11)-312315; И-мэйл: <a href="mailto:info@mrttd.gov.mn">info@mrttd.gov.mn</a> Цахим хуудас: <a href="https://mrttd.gov.mn/feedback/form">https://mrttd.gov.mn/feedback/form</a> Фэйсбүүк хуудас: <a href="https://www.facebook.com/MRTD.GOV.MN">https://www.facebook.com/MRTD.GOV.MN</a> Твиттер хуудас: <a href="http://twitter.com/MrttdGovMn">http://twitter.com/MrttdGovMn</a>



Диаграмм 2. Төслийн санал болгож буй өргөдөл, гомдол барагдуулах механизм

## **Хяналт-шинжилгээ үнэлгээ, тайлагнах**

ТУА талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ)-г хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Орон нутагт ТОХТ хэрэгжүүлэх явдлыг хангахад орон нутгийн байгууллага, засаг захиргаа мөн чухал үүрэг гүйцэтгэнэ. Олон нийтийн өргөдөл, гомдол, асуулга, болон холбогдох тохиолдлын талаар хагас жил тутмын хураангуй мэдээлэл болон дотоод тайланг холбогдох засч залруулах\урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн талаарх мэдээллийг хариуцсан ажилтан цуглуулан нэгтгэж, төслийн удирдлагад танилцууж байна. Өргөдөл, гомдол болон мэдээлэл хүссэн асуулгын шинж чанар, тоо хэмжээг үнэлэх механизм нь [сарын] хураангуй мэдээлэл, тэдгээрийг хугацаанд үр дүнтэй шийдвэрлэх төслийн чадавхи болно. Жилийн туршид төслийн зүгээс авч хэрэгжүүлсэн олон нийтийг оролцоог хангах үйл ажиллагааны тухай мэдээллийг талуудад дараах хоёр боломжит аргаар хүргэж болно. Үүнд: а) төслийн зүгээс талуудтай харилцсан талаарх төслийн үйл ажиллагааны жилийн тайланг хэвлэх; б) төслийн зүгээс үр дүнгийн гол үзүүлэлтэд байнга бас хяналт тавих. ТУА Дэлхийн Банк болон Төслийн Удирдах хорооны гишүүдэд зориулсан байгаль орчин, нийгмийн менежментийн хэрэгжилт, хяналтын тайланд энэ мэдээллийг тусгана.

Өргөдөл, гомдол барагдуулалтыг мөшгих, баримтжуулахаар дараах үйл ажиллагааг гүйцэтгэнэ. Үүнд: i) төслийн ажилтан болон өргөдөл, гомдол мэдүүлэгчийн мэдээлэл цуглуулах маягт, журам; ii) өргөдөл, гомдлын төлөвийг тогтоох үүднээс өргөдөл, гомдлыг тогтмол хянан үзэх, өргөдөл, гомдлын системийн шинжтэй шалтгааныг тодорхойлох, өргөдөл, гомдол барагдуулах механизм бүхэлдээ ажиллаж байгаад тогтмол үнэлгээ хийх; iii) өргөдөл, гомдол барагдуулж буй явц, эмзэг бүлэгт нөлөөлж буй байдлын талаар талуудад мэдээлэх процесс; iv) Дэлхийн Банк, ЗТХЯ, СЯ-д хүргүүлэх тогтмол тайлан зэрэг тайлагналын зориулалтаар мэдээлэл татан авах журам.

# 11. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЛТИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАРИУЦАХ ИНСТИТУЦИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

## Төсөл хэрэгжилтийн зохион байгуулалт: чиг үүрэг, хариуцлага

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага бол Зам, тээврийн хөгжлийн яам (ЗТХЯ) юм. Тус яам төслийн үйл ажиллагааг төлөвлөсөн хугацаанд сааталгүй хэрэгжүүлэн дуусгах үүднээс төслийн нийт хэрэгжилт, удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавина.

ЗТХЯ нь төслийн удирдах хороог байгуулна. Хорооны бүрэлдэхүүнд ЗТХЯ-ны газрын дарга нар, СЯ, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Байгаль орчин, аялал жуулчлалын болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны төлөөлөл орно. ЗТХЯ нь Дэлхийн Банкны зээлийн хөрөнгийн санхүүжилттэй төслийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах Төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулна. Удирдлагын чиг үүрэг, хариуцлагыг Хүснэгт 19-д үзүүлэв.

Хүснэгт 16. Удирдлагын чиг үүрэг, хариуцлага

Төсөл хэрэгжүүлэх байгууллага	Удирдлагын чиг үүрэг, хариуцлага
Гүйцэтгэгч - Зам, тээврийн хөгжлийн яам (ЗТХЯ)	Төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулах Төслийн удирдах хороо байгуулах Төслийн үр дүнтэй, үр ашигтай хэрэгжилтийг хангах систем, журам, механизм бүрдүүлэх Төслийн үйл ажиллагааг төлөвлөсөн хугацаанд сааталгүй хэрэгжүүлэн дуусгах үүднээс төслийн нийт хэрэгжилт, удирдлагын үйл ажиллагаанд ерөнхий хяналт тавих
Төслийн удирдах хороо	Төслийн жилийн төсөв, төлөвлөгөөг батлах Төслийн хэрэгжилтийн явцад хяналт тавих Төслийн хэрэгжилтийн чиглэл удирдамж, дэмжлэг үзүүлэх Төслийн хэрэгжилтэд оролцогч яамд, бусад тал хоорондын зохицуулалтыг хангах
Хэрэгжүүлэгч байгууллагууд: - ЗТХЯ, ХХААХҮЯ болон концесс эзэмшигчид	Төслийн үйл ажиллагааны холбогдох хэсгийг хэрэгжүүлэх
Хөндлөнгийн зөвлөхүүдийг гэрээлэх Төслийн удирдлагын алба	Төслийн өдөр тутмын удирдлагыг хэрэгжүүлэх, Худалдан авалт, хүний нөөц, санхүүжилт, гэрээний удирдлага, хяналт, тайлагнал зэрэг төслийн үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжүүлэх Хэрэгжүүлэгч болон гүйцэтгэгч байгууллагын нэрийн өмнөөс тендерийн баримт бичиг, ажлын даалгавар, тайлан, бусад баримт бичиг боловсруулан бэлтгэж, хянуулан зөвшөөрөл авахаар хүргүүлэх. БОН-ийн баримт бичгүүдийг шалгах боловсруулах, хэрэгжилтийг хянах, тайлагнах. Хэрэгжүүлэгч байгууллагын нэрийн өмнөөс данс хөтлөх, хөрөнгө гаргах хүсэлт, дагалдах баримт бичгийг бэлтгэн хүргүүлэх, улирлын болон жилийн тайлан, аудитын жилийн тайлан, санхүүгийн тайлан
Гүйцэтгэгчид	Гэрээлэгч дэд төсөл бүрээр БОНМХ, БОННУ, БОНМТ, ХХЗЖ, НШҮАТ зэрэг БОН баримт бичгийн дагуу эрсдэл бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй. Тендерийн баримт бичигт тусгасан байгаль орчны шаардлагыг хангах талаар саналд тусгахыг гэрээлэгчээс шаардана. Дэлхийн Банкны Бүлгийн Байгаль орчин, Эрүүл мэнд, Аюулгүй байдлын удирдамж, төслийн БОНМХ-ний дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төлөвлөгөө (ХАБЭМТ) бэлтгэн хэрэгжүүлэх шаардлагыг гэрээлэгчид тавина. ХАБЭМТ-нд осол хэргийн шалгалт, тайлагнал, дүрмийн

	<p>зөрчлийн бүртгэл болон тайлагналын журам, гамшиг, ослын бэлэн байдал, хариу арга хэмжээний журам, ажилчдыг тасралтгүй сургах, мэдээлэл сурталчилгааны талаар мөн тусгана.</p> <p>Гэрээлэгч бүрт байгаль орчинг нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ) боловсруулах шаардлага мөн тавих ба байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал хариуцсан ажилтныг томилно.</p> <p>Төсөл дууссаны дараа байгаль орчны менежментийн чиг үүргийг гүйцэтгэгч байгууллагын ашиглалт, засвар үйлчилгээний нэгжид шилжүүлнэ.</p>
Дэлхийн Банк	<p>Төслийн хэрэгжилтэд техникийн дэмжлэг үзүүлэх</p> <p>Төслийн хэрэгжилтийн явцад Дэлхийн Банкны бодлого, журмыг хэрэгжүүлэгч байгууллага болон агентлаг мөрдөж байгаад хяналт тавих</p>

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь төслийн өдөр тутмын удирдлагыг хэрэгжүүлэх туршлагатай мэргэжилтэн (төслийн зохицуулагч, худалдан авалтын ажилтан, санхүүгийн удирдлагын ажилтан, хяналт, шинжилгээ, үнэлгээний ажилтан, байгаль орчин, нийгмийн аюулгүй байдлын ажилтан)-тэй байна.

ЗТХЯ-ны Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) байгаль орчны үнэлгээ хийх үндсэн үүргийн хамт барилгын компани (газар шорооны ажил гэрээлэгч) эсхүл гуравдагч талын зөвлөхийн дэмжлэгтэй БОНМХ-г хэрэгжүүлэх үүрэгтэй. Байгаль орчны хяналт, БОНМТ-ний арга хэмжээ хариуцсан ТУА-ны байгаль орчин, нийгмийн стандарт (БОНС) төслийн зохицуулагчид дэмжлэг үзүүлнэ.

ТУА-ны байгаль орчин, нийгмийн ажилтнууд дор хаяж дараах үүргийг хүлээнэ. Үүнд: (i) эрсдэл бууруулах арга хэмжээний хяналт, хэрэгжилтэд барилгын компанид хяналт тавих; (ii) орон нутгийн захиргаа, барилгын компани (газар шорооны ажлын гэрээлэгч нар)-тай харилцах, төслийн хэрэгжилтийн байгаль орчны холбоотой асуудал шийдвэрлэхэд тэднээс дэмжлэг хүсэх; (iii) (Дэлхийн Банкнаас шаардсаны дагуу) техникийн явцын тайлангийн хамт байгаль орчны менежментийн тайланг 6 сар тутамд бэлтгэх.

Гэрээний шаардлага болон ТУА-ны дэргэд ажиллуулж буй иргэний байгууламж, механик, цахилгааны инженерийн гүйцэтгэх чиг үүрэгт хяналт тавихад байгаль орчин, нийгмийн ажилтанд ТУА-ны хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан дэмжлэг үзүүлнэ. Шаардлагатай бол ЗТХЯ гуравдагч талын нэмэлт үйлчилгээг авч болно. БОНМХ-ний хэрэгжилтийг хариуцсан хүн/агентлагийн дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 20-Т тусгав.

Хүснэгт 17. БОНМХ-ны хариуцах институцын чиг үүрэг, хариуцлага

Үйл ажиллагаа	Хариуцсан ажилтан/агентлаг
<b>Төсөл эхлүүлэх үе шат</b>	
ТУА байгуулж, гэрээ байгуулах	Төслийн зохицуулагч, худалдан авалтын ажилтан, ТУА, ЗТХЯ
Монгол Улсын Засгийн холбогдох агентлагаас зөвшөөрөл авах/батлуулах	ТУА, ЗТХЯ
ТУА-ны цахим хуудсанд дэд төслийн БОНМТ дэлгэрэнгүй мэдээллийг байршуулан мэдээлэх	ТУА
Төслийн нөлөөлөлд өртсөн иргэд болон бусад талтай хэлэлцүүлэг, уулзалт, семинар зохион байгуулах	ТУА-ны байгаль орчин, нийгмийн ажилтан, бусад ажилтан
Хэлэлцүүлэгт үндэслэн БОНМТ-ний эрсдэл бууруулах арга хэмжээг шинэчлэх	ТУА, байгаль орчин, нийгмийн ажилтан
<b>Хэрэгжилтийн үе шат</b>	
Олон нийтийн/өрхийн түвшинд төслийн нөлөөлөлд өртсөн иргэдтэй хийх уулзалт	Байгаль орчин, нийгмийн ажилтан, барилгын компани
БОНМТ-ний санал болгосон эрсдэл бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх	Байгаль орчин, нийгмийн ажилтан, барилгын компани
БОНМТ-ний эрсдэл бууруулах арга хэмжээг	Байгаль орчин, нийгмийн ажилтан, барилгын

Үйл ажиллагаа	Хариуцсан ажилтан/агентлаг
хэрэгжүүлэх явцад төслийн нөлөөлөлд өртсөн иргэдтэй хийх хэлэлцүүлэг	компани
Өргөдөл, гомдол барагдуулах	ТУА
Дотоод хяналт	ТУА / ЗТХЯ
Гадны буюу хөндлөнгийн хяналт*	Гадны буюу хараат бус мэргэжилтэн

БОНМТ-Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө; Байгаль орчин ба нийгмийн менежментийн төлөвлөгөө; Төслийн удирдлагын алба

\*Тэмдэглэл: Байгаль орчны ихээхэн эсхүл өндөр сөрөг нөлөөлөлтэй гэж ажиглагдсан төслийн хувьд л гадны буюу хараат бус хяналт-шинжилгээ шаардана.

## Чадавхыг бэхжүүлэх

Төслийн хэрэгжилтийн явцад төслийн нэгжид БОН ажилтан 1 доошгүй эсхүл байгаль орчин болон нийгмийн асуудлыг тусад нь хариуцсан аюулгүй байдлын 2 ажилтан, байгаль орчин, нийгмийн гадны буюу хараат бус зөвлөх авч ажиллуулах ёстой. Одоогийн байдлаар Дэлхийн Банкны БОНХ-ийн БОНС-ын дагуу БОН хэрэгслийг боловсруулан бэлтгэх асуудлаар ажилтан сургаж бэлтгээгүй тул шаардлагатай бол ЗТХЯ гуравдагч талын нэмэлт үйлчилгээг ажиллуулж болно. Үр дүнтэй байхын тулд төслийн эхний 12 сард олон улсын болон үндэсний зөвлөх Дэлхийн Банкны аюулгүй байдлын багийн дэмжлэгтэйгээр БОН-ийн сургалт зохион байгуулах шаардлагатай. БОНХ, БОНС нь ажилчид, орон нутгийн нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой зохистой үйлчилгээ үзүүлэх зэрэг гэрээлэгч нарын үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг хангахад анхаарал тавих шаардлага тавьдаг учраас эдгээр асуудлаар тусгайлсан сургалт хэрэгтэй болно.

БОНХ-ний асуудлаар сургалт, чадвар бэхжүүлэхдээ БОНХ-ний үзэл баримтлал болон удирдлага, БОНС, урьдчилсан үнэлгээ, эрсдлийн ангилал, БОНМХ, Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ), хөдөлмөрийн харилцааны зохицуулалтын журам (ХХЗЖ), ялангуяа, гэрээлэгчийн удирдлага, хөдөлмөрийн харилцааны зохицуулалттай холбоотой БОН-ийн асуудлын хяналт, нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал (БОЭМАБ), талуудын оролцоонд тавих шаардлагын талаар ойлголт, мэдлэг авсан байхад хангалттай гэж үзэж байна. Газар эргүүлэх авах, нийтийн үйлчилгээний саатал, бусад асуудлын үр дүнтэй удирдлагыг хангахад чухал ач холбогдолтой агентлаг хоорондын зохицуулалт, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд БОН-ийн эрсдэлийн удирдлагын талаарх сургалтын зорилтот хөтөлбөр дэмжлэг үзүүлж болох юм.

Төслийн эхэн болон хэрэгжилтийн шатанд хэрэгжүүлэгч агентлаг, холбогдох талуудад БОН сургалт, техник туслалцаа үзүүлнэ. Сургалтын тэргүүлэх сэдэвт дараах асуудлыг багтааж болно. Үүнд:

- БОНМТ, ТОХТ, ХХЗЖ, НШТХ- д төвлөрөн БОН хэрэгсэл боловсруулан бэлтгэх, хэрэгжүүлэх, хяналт тавих удирдамж, БОНМХ процесс,
- НШТХ, НШУАТ, БОНМТ, ТОХТ, ХХЗЖ-ын төлөвлөлт, хэрэгжилт, түүний дотор өргөдөл, гомдол барагдуулах хяналтын асуудлаарх тусгайлсан сургалт
- Гэрээлэгчийн үр дүнд/гүйцэтгэлд хяналт тавих, түүний дотор маягт, тайлагналын процесс, эрүүл мэнд, аюулгүй байдал, жендер, хамралтын талаарх суурь мэдлэг, сурталчилгаа, орон нутгийн олон нийт болон байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийг бүүруулах асуудлаар барилгын сайн туршлага\практик, өргөдөл, гомдол барагдуулах менежмент (ӨГБМ)-ийн журам, жендерт

суурилсан хүчирхийлэл (ЖСХ), КОВИД-19, халдварт бусад өвчин зэрэг нийгмийн бусад холбоотой асуудлаар тусгайлсан сургалт.

Төслийн эхний 2 жилд төслийн хэрэгжүүлэгч агентлагуудад зориулан БОНМХ процесс, аюулгүй байдал, аюулгүй байдлын баримт бичиг боловсруулан бэлтгэх шаардлага, ялангуяа, БОНМТ, ТОХТ, ХХЗЖ, БОПД, НШУАТ-тэй холбоотой баримт бичиг боловсруулах шаардлагын талаарх сургалт, семинарыг 2 доошгүй удаа зохион байгуулахыг ТУА-нд зөвлөж байна. Төслийн эхлэлийн хөтөлбөрийн гол сургалтын тусгайлсан зорилтот бүлгийг санал болгон доорх хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 18. Төслийн хэрэгжилтийн эхэнд зохион байгуулах аюулгүй байдлын сургалтын хураангуй*

No	Агуулга	Сургалтын зорилтот бүлэг	Санал болгож буй хугацаа
1	БОНМХ процесс, хэрэгжилт, хяналт, тайлагнал, БОНХ үзэл баримтлал, БОНС, ТОХТ, ХХЗЖ, түүний дотор БОПД, бэлгийн мөлжлөг, хүчирхийллийн ёс зүйн дүрэм (БМХЁСД), жендерт суурилсан хүчирхийлэл (ЖСХ), өргөдөл, гомдол барагдуулах механизм (ӨГБМ)	ТУА, ХА, хувь эсхүл компаний зөвлөхүүд	ТУА байгуулагдсаны эхний сарын дотор
2	НШБХ, түүний дотор НШУАТ боловсруулан бэлтгэх	ТУА, ХА, хувь хүн эсхүл компаний зөвлөх, орон нутгийн захиргаа	Төслийн хэрэгжилтийн эхний 6 сарын дотор
3	БОНМТ, ТОХТ, ХХЗЖ бэлтгэх, хяналт тавих, түүний дотор гэрээний удирдлага болон БМХЁЗД, ЖСХ зэрэг асуудлаар чадавх бэхжүүлэх	ТУА,ХА, хувь хүн эсхүл компаний зөвлөх, гэрээлэгч нар	Төслийн хэрэгжилтийн эхний 6 сарын дотор
4	Байгаль орчин, нийгмийн хяналт тавих чадварыг сайжруулах	ТУА, талбайн инженер, гэрээлэгч нар, байгаль орчин, нийгмийн зөвлөх, орон нутгийн захиргаа	Төслийн хэрэгжилтийн эхний 12 сарын дотор, жил бүр давтан хийх
5	БОПД, БМХЁЗД, ЖСХ мөрдөх, байгаль орчны эрүүл мэнд болон хөдөлмөрийн аюулгүй байдлын арга хэмжээ, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, КОВИД-19 талаарх сургалт	Талбайн инженерүүд, гэрээлэгч, хувь эсхүл компаний зөвлөх, орон нутгийн олон нийт	Төслийн хэрэгжилтийн эхний 12 сарын дотор, жил бүр давтан хийх

БОН сургалтын ялгаатай хэрэгцээ, агентлагын чадавх хязгаарагдмал байдлыг харгалзан ТУА нь БОНМТ хэрэгжүүлэх, БОН баримт бичиг боловсруулан бэлтгэх, хариуцаж буй дэд төслийн эрсдэл бууруулах арга хэмжээ хэрэгжүүлэхэд туслах БОН зөвлөх (хувь хүн эсхүл компани) авч ажиллуулах, дайчлах арга хэмжээ авна. БОНМТ хэрэгжүүлэх, БОНХ үзэл баримтлал, БОНС талаарх сургалт, чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааны төлөвлөж буй зардал 0.4 сая орчим ам.доллар ба ТУА энэхүү төсвийг удирдах үүргийг гүйцэтгэнэ.

Төлөвлөж буй сургалтын сэдвийг дор жагсаав. ТУА нь зөвлөхүүдийн дэмжлэгтэйгээр зарим сургалт боловсруулан бэлтгэж, төслийн бүх байршилд сургалт зохион байгуулна. Бүх аймаг, Улаанбаатар хотыг сургалтад хамруулна гэж төлөвлөж байна.

ТУА-нд зориулан төслийн хэрэгжилтийн бүх үе шатанд зохион байгуулах санал болгож буй Чадавхыг бэхжүүлэх сургалтын төлөвлөгөө Хавсралт 6-гаас үзнэ үү. Сургалтыг сургалт монгол хэлээр явуулна.



## ХАВСРАЛТ 1. ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

<b>МУЗТХЛСТ</b>	Монгол Улсын Зам, тээврийн холболт ба логистик сайжруулах төсөл
<b>БОБХАХТ</b>	Болзошгүй онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөө
<b>БОЭМАБ</b>	Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал
<b>БОМТ</b>	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
<b>БОН</b>	Байгаль орчин, нийгэм
<b>БОНХ</b>	Байгаль орчин, нийгмийн хүрээ
<b>БОНС</b>	Байгаль орчин, нийгмийн стандарт
<b>БОНАТ</b>	Байгаль орчин, нийгмийн амлалтын төлөвлөгөө
<b>БОННУ</b>	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ
<b>БОНМХ</b>	Байгаль орчин, нийгмийн менежментийн хүрээ
<b>БОНМТ</b>	Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө
<b>БОНХХ</b>	Байгаль орчин, нийгмийн урьдчилсан үнэлгээний хураангуй
<b>МУЗГ</b>	Монгол Улсын Засгийн газар
<b>ЗТХЯ</b>	Зам, тээврийн хөгжлийн яам
<b>СЯ</b>	Сангийн яам
<b>ТҮББ</b>	Төслийн үнэлгээний баримт бичиг
<b>ТУА</b>	Төслийн удирдлагын алба
<b>ТҮАГА</b>	Төслийн үйл ажиллагааны гарын авлага
<b>ТХЗ</b>	Төслийн хөгжлийн зорилт
<b>ХХААХҮЯ</b>	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
<b>ХЭМАБ</b>	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал
<b>БОНҮ</b>	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ
<b>БОННУ</b>	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
<b>НШБХ</b>	Нүүлгэн шилжүүлэн бодлогын хүрээ
<b>ХХЗЖ</b>	Хөдөлмөрийн харилцааны зохицуулах журам
<b>ТОХТ</b>	Талуудын оролцоог хангах төлөвлөгөө
<b>КОВИД-19</b>	Коронавирус-2019 халдварт өвчин
<b>БОНМЕТ</b>	Байгаль орчин, нийгмийн менежментийн ерөнхий төлөвлөгөө
<b>ЗХУТ</b>	Замын хөдөлгөөний удирдлагын төлөвлөгөө
<b>АБЁЭЗЖД</b>	Аюулгүй байдлын ёс зүйн жишиг дүрэм

## ХАВСРАЛТ 1. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН БОЛЗОШГҮЙ АСУУДЛЫН УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ МАЯГТ

Энэхүү маягыг хэрэгжүүлэгч байгууллага бөглөж, байгаль орчин нийгмийн мэргэжилтнүүдийн дэмжлэгтэйгээр ЗТХЯ-ны ТУА хянан баталгаажуулна. БОН урьдчилсан үнэлгээний бүх бөглөсөн маягыг бүртгэл, гэнэтийн шалгалт хийлгэхээр бэлтгэсэн байх ёстой.

Дэд төслийн нэр: \_\_\_\_\_

Төрөл<sup>22</sup> (чагтлах): Баригдсан автозамын засвар үйлчилгээ/гол автозамтай хэрэглэгчийг холбох автозамын барилга/ логистикийн төв /техник туслалцаа 1 / техник туслалцаа 2/ техник туслалцаа 3/ бусад.

Бусадыг сонгосон бол тайлбар өгнө үү: \_\_\_\_\_

Хэрэгжүүлэгч байгууллагын нэр: \_\_\_\_\_

Асуулт	Тийм	Үгүй	Тайлбар/санал болгож буй арга хэмжээ
<b>А. БОН үндэслэлээр хассан үйл ажиллагааны жагсаалт (БОН эрсдэл өндөртэй үйл ажиллагааг хассан)</b>			
1. Монгол Улсын хууль тогтоомжоор уг үйл ажиллагааг хориглох үү?			Тийм бол дэмжихгүй
2. Уг үйл ажиллагаа нь тусгай хамгаалалттай газар нутаг (жишээ нь, чамин ургамал, амьтан нутагшуулах)-т заналхийлж, ховордсон эсхүл нэн ховордсон амьтдад аюул учруулах эсвэл тэдний амьдрах орчинд сөргөөр өөрчлөх үү эсвэл амьдрах орчны хуваагдал, замаас болж үхэлд хүрэх эрсдэлтэй юу?			Тийм бол дэмжихгүй
3. Уг үйл ажиллагаа археологийн болон палеонтологийн дурсгалт газар, тахилгат уулс зэрэг соёлын чухал дурсгалт газарт сөрөг нөлөө үзүүлэх үү?			Тийм бол дэмжихгүй
4. Уг үйл ажиллагаа нь ойг бэлчээрийн газар болгон хувиргахад хүргэх үү?			Тийм бол дэмжихгүй

<sup>22</sup> Дэлхийн Банкны техник туслалцааны болон байгаль орчин, нийгмийн хүрээний удирдамжийн дагуу “Төрөл I” – техник эдийн засгийн үндэслэл, зураг, байгаль орчин нийгмийн баримт бичиг эсхүл байгаль орчин, нийгмийн болзошгүй эрсдэлтэй бусад арга хэмжээг бэлтгэн боловсруулах зэрэг ирээдүйн хөрөнгө оруулалтын арга хэмжээ бэлтгэн боловсруулахад дэмжлэг үзүүлэх; ,” II төрөл”- бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр болон хууль зүйн хүрээ боловсруулахад дэмжлэг үзүүлэх; “III төрөл”- зээлдэгчийн чадавч бэхжүүлэх арга хэмжээ.

Асуулт	Тийм	Үгүй	Тайлбар/санал болгож буй арга хэмжээ
5. Уг үйл ажиллагаа нь элэгдсэн бэлчээр эсхүл ойг үерт автуулах далан болон бусад усны хяналтын байгууламж барих уу?			Тийм бол дэмжихгүй
6. Уг үйл ажиллагаа элэгдсэн ой модоор дамжин өнгөрдөг замын барилга, шинэчлэх, засвар үйлчилгээг хамруулах уу?			Тийм бол дэмжихгүй
7. Уг үйл ажиллагаа эдийн засгийн эсхүл биет нүүлгэн шилжүүлэхэд хүргэх үү?			Тийм бол дэмжихгүй
8. Уг үйл ажиллагааны улмаас 200 ба түүнээс дээш иргэдийг нүүлгэн шилжүүлэх үү?			Тийм бол дэмжихгүй
9. Уг үйл ажиллагааны улмаас 1000 дээш иргэдийг эдийн засгийн хувьд нүүлгэн шилжүүлэх үү?			Тийм бол дэмжихгүй
10. Уг үйл ажиллагааны улмаас 100 ба түнээс дээш га газрыг хувиргах уу?			Тийм бол дэмжихгүй
11. Уг үйл ажиллагаа дархан цаазат газар, аялал жуулчлалын бүс болон үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн үндсэн бүст оршдог уу?			Тийм бол дэмжихгүй
<b>В. БОН эрсдэлийн үнэлгээ, ангилал</b>			
12. Уг үйл ажиллагаа аливаа БОН ихээхэн нөлөөлөл (жишээ, байгалийн амьдрах орчинд үзүүлэх болзошгүй нөлөөлөл, хүний эрүүл мэнд ба/эсхүл байгаль орчинд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх магадлал багаас дунд эсхүл бага хэмжээний газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх гм.)-тэй ч эрсдэлийн удирдлагын эрсдэл бууруулах үр дүнтэй арга хэмжээ авах боломжтой юу?			Хэрэв тийм бол энэ дэд төсөл БОН “өндөр” эрсдэлтэй гэж үзнэ. Дэлхийн Банкны БОНХ-ний дагуу шаардлагатай гэж үзсэн БОН холбогдох баримт бичиг (БОННУ, БОНМТ, НШУАТ, ХХЭЖ)-ийг боловсруулан бэлтгэх хэрэгтэй.
13. Төслийн үйл ажиллагаа зөвхөн хүн ам ба\ эсхүл байгаль орчинд хамгийн бага эсхүл ялимгүй эрсдэл эсхүл сөрөг нөлөөлөл үзүүлэх үү?			Хэрэв тийм бол энэхүү дэд төслийн БОН эрсдэлийг “бага” гэж үзнэ. ТОХТ-өөс өөр БОН баримт бичиг шаардлагагүй болно.
14. Төслийн үйл ажиллагааны БОН эрсдэл асуулт 12 болон 13-д дүрсэлсний хооронд байна уу?			Хэрэв тийм бол дэд төслийн БОН эрсдэлийг “дунд ” гэж үзнэ. Дэлхийн Банкны БОНХ дагуу шаардлагатай гэж үзсэн БОН холбогдох баримт бичиг (БОННУ, БОНМТ, НШУАТ, ХХЭЖ, гм)-ийг боловсруулан бэлтгэх хэрэгтэй.
15. Хэрэв төслийн үйл ажиллагаа ТТ1 бол доорх асуултад хариулна уу? Үүнд:			
10.1 Техник туслалцааны үйл ажиллагааны төлөвлөгөө аливаа тусгайлсан хөрөнгө оруулалтын нарийвчилсан дизайн/зураг эсхүл			Тийм бол Дэлхийн Банкны БОНХ нийцсэн БОН баримт бичгийг ТТ-ны үр дүнгийн бүрэлдэхүүн болгон

Асуулт	Тийм	Үгүй	Тайлбар/санал болгож буй арга хэмжээ
дүйцэхүйц бусад техникийн баримт бичиг боловсруулах ажлыг дэмжихээр төлөвлөж байна үү?			боловсруулан бэлтгэх шаардлагатай. ТТ-ний үр дүнгийн бүрэлдэхүүн болсон тусгайлсан БОННУ, БОНМТ, <b>НШҮАТ</b> , ХХЗЖ, гм болно.
10.2 ТТ-ны үйл ажиллагаа техник эдийн засгийн үндэслэл эсхүл тусгайлсан ямарваа биет хөрөнгө оруулалтын техникийн баримт бичиг боловсруулахаар төлөвлөж байна уу?			Хэрэв тийм бол Ажлын даалгавар, улмаар ТТ-ны хүлээлгэн өгөх ажлын бүрэлдэхүүн болгон шаардлагатай БОН асуудлыг тусгах хэрэгтэй. Жишээлбэл, БОНХ-ний шаардлагын дагуу төслийн БОН эрсдэл болон нөлөөлөл, эрсдэл бууруулах арга хэмжээг шинжлэхээр <b>FSR</b> тайланд тусгай бүлэг оруулах шаардлагатай юм.
16. Дэд төсөл “хамааралтай байгууламж”-той холбоотой юу? “Хамааралтай байгууламж” гэдэг нь төслийн бүрэлдэхүүн болгон санхүүжүүлээгүй байгууламж эсхүл үйл ажиллагаа ба Дэлхийн Банкнаас түүнийг дараах байдлаар үздэг. Үүнд: (а) төсөлтэй шууд бөгөөд ихээхэн холбоотой”; (б) төсөлтэй хамт нэгэн зэрэг хэрэгжүүлэх эсхүл төлөвлөсөн; (в) төслийн зориулалтаар барьсан бөгөөд төсөлд шаардлагатай гэж үзсэн.			Хэрэв тийм бол дэд төслийн БОН шаардлагыг “хамааралтай байгууламж”-д тавина.
17. БОН урьдчилсан үнэлгээний өмнө (ерөнхийдөө сүүлийн 2 жилд) төслийн үйл ажиллагаанаас улбаалан газар чөлөөлөх эсхүл газар ашиглалтад хязгаарлалт тавих болсон үү?			Хэрэв тийм бол БОНС 5 дагуу нүүлгэн шилжүүлэлтийн урьдчилсан нягтлан шалгалт хийх шаардлагатай.
18. Төслийн үйл ажиллагаа ТТ2 төрөлд хамаарах уу?			Хэрэв тийм бол холбогдох БОН эрсдэлийг судлахыг ажлын даалгаварт тусгаж, уг судалгааг хийхээс өмнө Дэлхийн Банкинд хянуулахаар хүргүүлэх шаардлагатай. Стратеги, төлөвлөгөө эсхүл журам боловсруулах үйл ажиллагааг бүхий дэд төслийн хувьд ТТ-ны хүлээлгэн өгөх ажилд БОН хуримтлагдсан нөлөөллийн урьдчилсан шинжилгээг санал болгож буй эрсдэл бууруулах стратегийн хамт оруулсан байна.
19. Төслийн үйл ажиллагаа ТТ 3 төрөлд хамаарах уу?			Хэрэв тийм бол БОН нэмэлт баримт бичиг боловсруулан бэлтгэх шаардлагагүй. Гэсэн ч үйл ажиллагаа хэрэгжихийн өмнө холбогдох ажлын даалгавар боловсруулан бэлтгэхэд ТОХТ болон тусгайлсан үйл ажиллагаанд үндэслэн талууд (эмзэг бүлгийг хамруулан)-

Асуулт	Тийм	Үгүй	Тайлбар/санал болгож буй арга хэмжээ
			ын зохистой бөгөөд үр дүнтэй оролцоог хангах асуудлыг авч үзэх шаардлагатай.
<p><b>Ерөнхий дүгнэлт</b> (холбогдох зүйлийг чагтална уу):</p> <ol style="list-style-type: none"> <li><b>БОНХ-ний БОН хассан жагсаалтад үндэслэн санал болгож буй үйл ажиллагаа нь төслийн санхүүжилтийн шаардлагыг (хангаж\хангахгүй) байна.</b></li> <li><b>Санал болгож буй дэд төсөл нь БОН эрсдэл (өндөр/дунд/ багатай) болно.</b></li> <li><b>Санал болгож буй дэд төслийг боловсруулан бэлтгэх явцад БОН доорх баримт бичгийг боловсруулан бэлтгэх шаардлагатай. Үүнд:</b>  Сүүлийн бээрийн холболтын замын БОНМТ, Биологийн олон янз байдлын асуудалтай сүүлийн бээрийн замуудын хувьд Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөө- ВМР, ложистикийн төвийн БОННУ, замын засварын ажлын Байгаль орчин, нийгмийн хариуцлыгын үйл ажиллагааны дүрэм - ESCOP, замын шинэчлэлтийн ажлын БОНМТ.</li> </ol> <hr/> <hr/> <p>Маягтыг бөглөсөн (хэрэгжүүлэгч байгууллагын төлөөлөл ): _____;</p> <p>Хянасан (ТУА төлөөлөл/ БОН ажилтан) _____</p>			

## ХАВСРАЛТ 3. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭ

### 1. Оршил

Энэхүү баримт бичиг бол Монгол Улсын Зам, тээврийн холболт ба логистикийг сайжруулах төсөл, тухайлбал, түүний бүрэлдэхүүн 1 болон 2- дэд бүтцийн хөрөнгө оруулалт, логистикийн үйлчилгээ; хүсэлт гаргасан тохиолдолд бүрэлдэхүүн 4- болзошгүй, онцгой байдлын хариу арга хэмжээ- хүрээнд санал болгох аливаа нэмэлт үйл ажиллагаанд хамаарах нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын хүрээ (НШБХ) юм.

Бүрэлдэхүүн 1 үйл ажиллагаанд сонгосон аймгийн тухайлсан автозам сайжруулах, шинэчлэх ажлаас гадна нийт улс орны хэмжээний арга хэмжээ багтана. Автозамын гол хэсгийн үр дүнд суурилсан засвар үйлчилгээ, орон нутгийн хэрэглэгчтэй холбох орон нутгийн тэргүүлэх зам нь сонгосон аймгийг үндэсний автозамын сүлжээнд холбоход төвлөрөх бол зам, замын байгууламжийн хөрөнгийн менежментийн хүрээ болон систем улсын нийт автозамын сүлжээг хамарна.

Дэд бүрэлдэхүүн 1.1: автозамын гол хэсгийн үр дүнд суурилсан засвар үйлчилгээ. Сонгосон аймгийг жилийн туршид тасралтгүй стратегийн замын сүлжээнд холбох үүднээс муу чанартай замын холболтын хэсгийн засвар, нөхөн сэргээх ажил гүйцэтгэнэ. Автозамын хамгаалалтын зурваст ажил хийгдэнэ. Автозам засвар, нөхөн сэргээх, ус зайлуулах суваг сайжруулах, замын тэмдэг, тэмдэглэгээ, зэрлэг ан амьтдын гарц зэрэг замын хөдөлгөөний аюулгүй байдлын байгууламжийг суурилуулах ажил багтана.

Дэд бүрэлдэхүүн 1.2: улсын автозамын сүлжээнд орон нутгийн малчдыг холбох замын хэсэг. Үндэсний автозамын сүлжээнд орон нутгийн малчид, хэрэглэгчдийг холбох орон нутгийн чанартай 51 км замын шинэчлэлтийн барилгын ажил багтана. КОВИД-19 цар тахлын халдвараас сэргийлэхээр зорчих хөдөлгөөнд тавьсан хоригийн улмаас талуудыг урьдчилан үнэлэх, тодорхойлох ажлыг хориг цуцлагдмагц гүйцэтгэнэ. Газар чөлөөлөх, соёлын өвийн дурсгалт газраас зайлсхийх үүднээс автозамын трассыг сонгоно.

Бүрэлдэхүүн 1 хүрээнд тэргүүлэх автозамын байршлыг урьдчилан тогтоосон ч нэмэлт нарийвчилсан мэдээлэл эцэслэгдээгүй тул төслийн үнэлгээ хийхийн өмнө энэхүү нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын хүрээг боловсруулан бэлтгэсэн. Бүрэлдэхүүн 4- болзошгүй, онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг (**БОБУАХАБХ**) нь хямрал эсхүл онцгой байдал тохиолдоход үйлчлүүлэгч онцгой байдлын хариу арга хэмжээ, дахин сэргээлтийг дэмжих зориулалтаар төслийн санхүүжилтийг дахин хуваарилах хүсэлтийг Дэлхийн Банкнд тавих боломж олгох замаар яаралтай хариу арга хэмжээ авах зорилгоор бэлтгэсэн. Ийм нөхцөлд нэмэлт үйл ажиллагааг авахад шаардлагатай БОН бүх хэрэгслийг боловсруулан бэлтгэх, хэвлэн нийтлэх, Дэлхийн Банкнаас зөвшөөрөл авах шаардлагатай.

Бүрэлдэхүүн 2 хүрээнд Өвөрхангай аймагт логистикийн загвар төв байгуулна. Ингэснээр бараа, бүтээгдэхүүний чанар ихээхэн алдагдахад хүргэдэг хөргүүрийн төхөөрөмжөөр тоноглогдоогүй бага оврын, хагас ачаатай ачааны машины хэрэгцээ багасгана. ЗТХЯ, орон нутаг хоорондын одоогийн гэрээгээр Байдрагийн гол орчимд хоосон газар олгохоор яригдаж байна. Уг газар нь цахилгаан эрчим хүч зэрэг суурь дэд бүтэцгүй, айл өрх байхгүй, амьжиргаанд шууд нөлөөлөх нөлөөлгүй, газар чөлөөлөлттэй холбоотой зардал байхгүй. Доорх үйл ажиллагааг төлөвлөж байна. Үүнд:

- Төвийн хилийн дотор ойролцоогоор 4-5 км дотоод зам
- Ачааны машины зогсоол
- Оффисын байр болон дэн буудал зэрэг туслах үйлчилгээ
- Монгол Улсын Засгийн газар эрчим хүч, усны суурь хангамжийн зориулалтаар газар чөлөөлөх.

Нүүлгэн шилжүүлэх ихээхэн шаардлага гарахгүй гэж төлөвлөж байна. Энэхүү НҮБХ нь биет болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэх тохиолдол гарахад мөрдөх удирдамжаар хангана.

Энэхүү НШБХ-нд дараах асуудлыг тусгасан. Үүнд: а) барилга байгууламж, үндсэн хөрөнгөд үзүүлэх нөлөөллийн нөхөн төлбөрийн протокол; (б) газар шорооны ажил эхлэхийн өмнө төслийн үнэлгээний дараа бэлэн болгох нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө (НШТ) боловсруулахыг шаарддаг нүүлгэн шилжүүлэх нөлөөллийн талаарх бодлого, журам.

Дэлхийн Банкны БОНХ, газар чөлөөлөх, газрын ашиглалтын талаарх хязгаарлалт, албадан нүүлгэн шилжүүлэлт (БОНС 5) болон Монгол Улсын хууль, тогтоомжийн дагуу аливаа НШТ боловсруулна.

Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх Төслийн удирдлагын алба (ТУА) нь энэхүү НШБХ-ний зарчмын дагуу бүтээц болон автозамын хамгаалалтын зурвасын үндсэн хөрөнгөнд үзүүлэх нөлөөлөл, хариу арга хэмжээг урьдчилан үнэлэх үүрэгтэй ажилтныг ажиллуулна.

## **2. Зорилт ба гол зарчим**

Энэхүү НШБХ нь Монгол Улсын хууль тогтоомжийн шаардлага, Дэлхийн Банкны газар чөлөөлөх, газар ашиглалтын хязгаарлалт болон албадан нүүлгэн шилжүүлэлтийн шаардлагыг тусгасан болно. НШБХ-ний чиглүүлэгч зорилт бол нийт төслийн хүрээнд албадан нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх эсхүл багасгахад оршино. Зайлсхийх боломжгүй бол бодлогын зорилт нь нөлөөллийг бууруулахад оршино. Эцсийн эцэст төслийн нөлөөлөлд өртсөн иргэд (ТНӨИ)<sup>23</sup> -ийн амьжиргааны байдал төслийн өмнөх үеийн байдлаас сайжирсан эсхүл наад зах нь муудаагүй байх ёстой. Төслийн бүхий л үе шатанд төслийн нөлөөлөлд өртсөн бүх иргэдтэй зөвлөлдөх, төлөвлөлтөд оролцуулах, төслийн үр шимээс хүртэх боломж олгоно. Энэхүү төсөл тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах ёстой.

Эдгээр зарчим талууд, ялангуяа, төслийн нөлөөлөлд өртөх иргэдийг эртнээс тодорхойлох; мэдэгдэж буй аливаа нөлөөллийг олон нийтэд үр дүнтэй мэдээлэх; тодорхойлсон сөрөг нөлөөллөөс зайлсхийх эсхүл түүнийг багасгах үүднээс олон нийтийн бүх бүлэг/салбартай зөвлөлдөх, хэлэлцэх, хэнийг ч эсхүл аливаа нөлөөллийг орхигдуулахгүй байх явдлыг хангах, төслийн хэрэгжилт, нүүлгэн шилжүүлэлт, амьжиргааг сэргээх явцад төслийн нөлөөлөлд өртсөн иргэдэд шударга, ил тод бөгөөд цаг алдалгүй дэмжлэг үзүүлэх, боломжтой бол ялангуяа ядуурал, яс үндэс, жендер, нас, тахир дутуу эсхүл нийгмийн байдлын шалтгаанаас эмзэг болсон хүн амын бүлгийн өнөөгийн байдлыг сайжруулах үүрэг амлалт авахыг шаарддаг.

Хэрэв үндсэн хөрөнгө (дэлгүүрийн барилгын бүтээц гм) үрэгдэхэд хүрсэн бол ижил эсхүл төстэй хөрөнгөөр солин орлуулах, хэрэв боломжтой бол үрэгдсэн хөрөнгө, алдагдсан орлогыг нөхөх, нүүлгэн шилжүүлэлтийн болон амьжиргааг сэргээх зардлыг төлөхийг зорино. Биет хөрөнгөөс гадна нийгмийн болон соёлын хөрөнгийг сэргээнэ. Хэрэв ихэнхдээ эмэгтэйчүүдэд илүүтэй тулгардаг эдгээр үнэ цэнэд хохирол учрах эрсдэл байвал бодлогын зорилтыг хангах үүднээс төслийн нөлөөлөлд өртсөн иргэдийг эрсдэл бууруулах хувилбарыг сонгоход оролцуулна.

## **3. Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөлтийн гол зарчим**

Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцад доорх зарчмыг мөрдөнө. Үүнд:

---

<sup>23</sup> Төслийн нөлөөлөлд өртсөн иргэний нийгэм ба\эсхүл эдийн засаг болон биет шилжих хөдөлгөөний “нүүлгэн шилжүүлсэн” гэж нэрлэнэ. Төөрөгдөл үүсэхээс сэргийлж энэхүү баримт бичигт “нүүлгэн шилжүүлсэн” гэсэн хэллэг аливаа сөрөг нөлөөлөлд өртсөн хүнийг илэрхийлэх болно. Тэд газар, хөрөнгө эзэмших болон хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн газар, хөрөнгийн талаар нэхэмжлэл гаргах хууль ёсны эрхтэй эсвэл газар, хөрөнгө нэхэмжлэх хууль ёсны эрхгүй.

- НШТ боловсруулан бэлтгэх процессын явцад нөхөн олговрын зохион байгуулалтын асуудлаарх төслийн нөлөөлөлд өртсөн иргэдийн байр суурийг асуух, харгалзан үзэх үүднээс тэдэнтэй зөвлөлдөх ёстой.
- Нөхөн олговор олгох ажлыг тасалбар болгох огноо нь хохирлын судалгаа, тооллогын өдөр бөгөөд Монгол Улсын олон нийтийн хэвлэлд сурталчлан нийтэлсэн өдөр байна.
- Өмчийн байдал, түүний дотор зөвшөөрөлгүй газар ашиглан оршин суугч, үл хөдлөх хөрөнгийн ашиглалтын төрөл (орон сууц, арилжааны, нийтийн эсхүл хамтын)-өөс үл хамааран төслийн нөлөөлөлд өртсөн бүх хүмүүс нөхөн олговор авах, нөхөн сэргээх боломж эдлэх эрхтэй байна. Үрэгдсэн хөрөнгө эзэмших хууль ёсны эрхгүй байх нь нүүлгэн шилжүүлсэн иргэдийг нөхөн олговор эсвэл альтернатив төрлийн дэмжлэгээс авахыг хориглох үндэслэл болохгүй.
- Төслийн нөлөөлөлд өртсөн байгууламж, үндсэн хөрөнгийг дүйцүүлэхүйц төрлийн байгууламжийн зах зээлийн элэгдэл хасаагүй үнэд үндэслэн зардлыг нөхөн олгоно. Төслийн нөлөөлөлд өртсөн иргэд материалыг мөн авч болно.
- Автозамын хамгаалалтын зурвасын гаднах газар хашаа хайс буулгах, газар шорооны ажил хийх зэргээр хэвийн байдлыг түр зур алдагдуулсны нөхөн олговрыг нөлөөлөлд өртсөн аж ахуйн байгууллагатай хэлэлцэн тохирсон гэрээнд суурилан бэлэн мөнгө хэлбэрээр олгоно. Нөлөөлөлд өртсөн аж ахуйн байгууллага газар, орон сууцанд нэвтрэх эрхээ үргэлжлэн эдэлнэ. Газар шорооны ажил дуусмагц гэрээлэгч хашаа хайсыг буулгаж, газар, хашаа хайсыг сэргээнэ.
- НШТ-гөөр тогтоосон нөхөн олговрын хувь хэмжээ нь үрэгдсэн хөрөнгийн эрх бүхий өмчлөгч эсхүл хэрэглэгчид элэгдэл хорогдол эсхүл аливаа зориулалтаар суутгал хийгээгүй бүрэн хэмжээгээр төлөх дүнг хэлнэ.
- Бүтээц болон үндсэн хөрөнгийн нөхөн төлбөрийг нөлөөллийн хугацаанаас өмнө төлнө.
- Засгийн газар нүүлгэн шилжүүлэх, шилжүүлэх, гүйлгээний бүх зардал (төлбөр, хураамж)-ыг чөлөөлөх эсвэл нөлөөлөлд өртсөн үл хөдлөх хөрөнгийн гэрээний үнэд оруулна.
- Бүх төрлийн нөхөн олговор олгогдоогүй, нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагаа дуусаагүй, орлого алдсаны төлөөх богино хугацааны санхүүгийн дэмжлэг төлөгдөөгүй бол газар шорооны ажил эхлэхгүй болно.
- Бэлэн мөнгөний нөхөн олговорт татвар ногдуулахгүй ба үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн бүх төлбөр, гүйлгээний зардлыг төслийн эзэмшигч хариуцна.
- Төслийн автозамын хамгаалалтын зурвасын гаднах бүс рүү нөлөөлөлд өртсөн дэлгүүрүүд нүүх шаардлагыг харгалзан тэдгээрийг дахин байгуулахад үр дүнтэй дэмжлэг үзүүлэхээр тэтгэмж олгож, орлогын алдагдлыг төлнө.
- Талуудын оролцоог хангах төлөвлөгөөнд тусгасны дагуу төслийн талаарх өргөдөл, гомдол барагдуулахаар байгуулсан механизмыг ашиглана.
- Төсөл санаачлагч/Дэлхийн Банкны эзэлдэгч нөхөн олговортой холбоотой зардлыг хариуцна. Аливаа бэлтгэсэн НШТ-нд газар чөлөөлөхтэй холбоотой бүх зардлын төсөв, түүний дотор болзошгүй арга хэмжээний зохион байгуулалтын асуудлыг тусгана.
- 2017 оны БОНХ шаардлагын дагуу аливаа нүүлгэн шилжүүлэлтийн бэлтгэсэн төлөвлөгөөг аливаа боломжтой байршилд хүртээмжтэй хэлбэрээр хэвлэн нийтэлж, хяналт тавина.

#### **4. Хууль эрх зүй, зохицуулалтын хүрээ**

Энэхүү НШБХ -ний бүх заалт нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж (доорх жагсаалтын дагуу) болон Дэлхийн Банкны БОНС5 нийцсэн болно. Энэхүү бүлэгт үндэсний хууль тогтоомж болон Дэлхийн Банкны бодлогын холбогдох заалтыг эдгээрийн шаардлага хоорондын зөрүүг арилгах арга хэмжээний хамт хураангуйлан өгүүлэв.



Энэхүү бүлэгт үндэсний хууль тогтоомжийн холбогдох заалт болон Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн хүрээ (2017 оны БОНХ)-тэй нийцсэн нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын бүх заалтыг хуулийн заалт болон Дэлхийн Банкны шаардлага хоорондын зөрүүг арилгах арга хэмжээний хамт хураангуйлан өгүүлэв. Хүчин төгөлдөр мөрдөж буй хууль эрх зүйн хүрээнд газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой суурь хууль эрх зүйн хүрээ доорх хуулиас бүрдэнэ. Үүнд: Үндсэн хууль (1992 он), Газрын тухай хууль (2006 он), Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2003 он), Иргэний хууль (2002 он), Засгийн газрын аргачлал, үнэлгээ батлах тухай (Засгийн газрын 2003 оны 103 дугаар тогтоол), Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль (2003 он), Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль (2015 он).

Монгол Улсын Үндсэн хуулинд “Төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно”, “Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө” гэж тус тус заасан.

Газрын тухай хуулиар газар эзэмших эрхийн хугацаа дуусмагц түүнийг чөлөөлөх талаар зохицуулсан. Газар эзэмших эрхийн гэрчилгээгүй этгээдийг хууль ёсны бус гэж үзэн хуулийн 27.4 заалт “Хүчин төгөлдөр эрхийн гэрчилгээгүй аливаа этгээд газар эзэмшихийг хориглоно” гэж заасны дагуу хууль бусаар эзэмшсэн газрыг чөлөөлөхийг шаардаж болно. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд хувийн өмчийн газрыг ашиглах эрхийг хүндэтгэн үзэх заалт бий. Уг хуулийн 35 заалтад газар өмчлөгч хуулийн 28 заалтыг зөрчсөн бол түүний газрыг хураан авахаар заасан. Засгийн газрын газрын үнэлгээний тариф (Засгийн газрын 103 дугаар тогтоол)-аар газрын үнэлгээний тариф тогтооно.

*Хүснэгт 19. Монгол Улсын хууль тогтоомж болон Дэлхийн банкны албадан нүүлгэн шилжүүлэлтийн шаардлага хоорондын харьцуулалт*

Сэдэв/ асуудал	Монгол Улсын хууль тогтоомжийн заалт	Дэлхийн Банкны Байгаль орчин, нийгмийн хүрээ
Шаардлага хангасан төслийн нөлөөлөлд өртсөн аж ахуйн нэгж	Газрын тухай хууль (35 болон 38 зүйл), Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (27 зүйл)-ийн дагуу газар эзэмшигч, өмчлөгч, ашиглагч нь хуулийн бусад этгээдэд эрхээ шилжүүлж болно. Газар эзэмших эрхгүй хууль бус эзэмшигч нь эзэмшиж буй газрыг шилжүүлэх эсхүл нөхөн олговор авах эрхгүй. (Газрын тухай хуулийн 27.4 зүйл). Иргэний хуулиар эзэнгүй үл хөдлөх эд хөрөнгийг олж авсан өмчлөгч бус этгээд уг эд хөрөнгийн өмчлөгчөөр улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш 15 жилийн хугацаанд уг эд хөрөнгийг өмчлөгчийн адил эзэмшиж байсан бол дээрх хугацаа дууссанаар уг этгээд өмчлөх эрхийг хүлээн зөвшөөрсөн.	БОНС 5) доорх иргэнийг төслийн нөлөөлөлд өртсөн гэж ангилж болно. Үүнд: (a) газар эсхүл хөрөнгө эзэмших хууль ёсны эрхтэй; (b) газар эсхүл хөрөнгө эзэмших хууль ёсны эрхгүй ч үндэсний хууль тогтоомжийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн буюу хүлээн зөвшөөрөгдөхүйц газар эсхүл хөрөнгийн талаар нэхэмжлэл гаргасан; (c) өөрийн оршиж буй эсхүл ашиглаж буй газар эсхүл хөрөнгийг эзэмших хүлээн зөвшөөрөгдсөн хууль ёсны эрхгүй эсхүл нэхэмжлэлгүй.
Бүтээцийн нөхөн олговор	Гэрээгээр тохирон эргүүлэн авч буй газарт байрлах бүтээцийг шилжүүлэх төлбөр. Бүтээцийн үнийг зах зээлийн нийт үнээс элэгдэл хорогдлыг хасч тогтооно. Газрын тухай хуулийн дагуу газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнээр тооцон нөхөн олговор олгох ёстой. Практикт зах зээлийн үнэд үндэслэн нөхөн олговрыг тооцдоггүй. Автозамын хамгаалалтын зурваст байрлах	Газар эргүүлэн авах эсхүл газар ашиглалтад хязгаарлалт тавьснаас үүссэн зайлсхийх боломжгүй нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг доорх арга замаар бууруулах. Үүнд: (a) хөрөнгө үрэгдсэнийг түүнийг оруулан нөхөх зардалтай <sup>24</sup> тэнцэх нөхөн олговрыг хугацаанд олгох (БОНС5).

	байгууламжийн бүтээцийн нөхөн олговрын талаар хуулийн заалт байхгүй.	
Эмзэг бүлэг	Нүүлгэн шилжүүлсэн эмзэг бүлгийн тухай хууль тогтоомжийн заалт байхгүй	Эдийн засгийн болон биет нүүлгэн шилжүүлэлтийн хувьд НШТ жендерийн асуудал, хүн амын эмзэг бүлгийн хэрэгцээ шаардлагын асуудалд анхаарал хандуулж, тэдгээрийг ил тод, нийцсэн, тэгш шударга байдлаар шийдвэрлэх явдлыг хангана. (БОНС 5)
Өргөдөл, гомдол барагдуулах журам	Газрын тухай хуульд газрын маргааныг засаг дарга, улмаар шүүхээр шийдвэрлүүлэхээр зохицуулсан (60 зүйл). Иргэний хууль, Иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд төрөл бүрийн маргааныг шүүхээр шийдвэрлүүлэхээр зохицуулсан.	Төслийн эрсдэл, нөлөөлөлтэй дүйцүүлэн санаа зовниж буй асуудал, гомдол хүлээн авах, шийдвэрлэх талаарх өргөдөл, гомдол барагдуулах механизмыг санал болгон хэрэгжүүлэх. (БОНС 10)
Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг хэвлэн нийтлэх, олон нийтээр хэлэлцүүлэх	Хот суурин газрын дахин хөгжүүлэх тухай хууль (17, 18 зүйл)-д хот төлөвлөлтөд оролцоот төлөвлөлтийг хэрэглэж, хот төлөвлөлтийн явцад иргэдтэй хэлэлцэн зөвлөлдөх талаар зохицуулсан. Хот суурин газрын хөгжлийн асуудлаар гаргасан шийдвэрийг хугацаанд нийтэд мэдээлж, хэвлэн нийтлэнэ.	Зээлдэгч нь төсөлтэй холбоотой эрсдэл болон нөлөөлөлд дүйцсэн төлөвлөгөө боловсруулан бэлтгэнэ. Бага хэмжээний газар чөлөөлөх эсхүл газар ашиглалт хязгаарлалт тавьсны улмаас орлого эсхүл амьжиргаанд үлэмж бус нөлөөлөл үзүүлэхээр бол төлөвлөгөөнд төслийн нөлөөлөлд өртсөн иргэний тодорхойлолт буюу шаардлагыг тодорхойлох, нөхөн олговор олгох журам, стандартыг тогтоох, хэлэлцүүлэг хийх, хяналт тавих болон өргөдөл гомдол барагдуулах зохион байгуулалтыг тусгана (БОНС5).
Тасалбар болгох огноо	Эзэмшлийн эсхүл ашиглаж буй газрыг эргүүлэн авах тасалбар огнооны талаар заалт байхгүй.	Зээлдэгч тооллогын судалгаатай хамт тасалбар болгох огноог тогтооно. Тасалбар болгох огноотой холбоотой мэдээллийг сайтар баримтжуулж, төслийн бүх байршлаар хэвлэмэл болон бусад хэлбэр (зохимжтой бол)-ээр тогтмол давтамжтайгаар түгээнэ. (БОНС5).
Үл хөдлөх хөрөнгийг чөлөөлөх, газар шорооны ажил эрхлэх мэдэгдэл өгөх хугацаа	Үл хөдлөх хөрөнгийг чөлөөлөх хугацааг гэрээнд зааж өгч болно. Үл хөдлөх хөрөнгийг эргүүлэн авахтай хамт газар шорооны ажлыг эхлэх ч хүлээх хугацааг тогтоогоогүй.	БОНС дагуу нөхөн олговор бэлэн болсны дараа л зөвхөн зээлдэгч чөлөөлсөн газар, холбогдох хөрөнгийг эзэмшилд авна. (БОНС5). Газар шорооны ажил эхлэхийн өмнө энэ ажил явагдана.

<sup>24</sup> Хөрөнгө солин орлуулахад хангалттай нөхөн олговрыг тодорхойлох үнэлгээний арга дээр хөрөнгө солин орлуулахтай холбогдсон гүйлгээний шаардлагатай зардлыг нэмж “солин орлуулах өртөг”-ийг тодорхойлно. Үйл ажиллагаа явуулж буй зах зээлгүй тохиолдолд солин орлуулах өртгийг альтернатив аргаар тодорхойлж болно. Тухайлбал газрын эсхүл хөрөнгийн гарцын өртөг, эсхүл барилга байгууламж, бусад үндсэн хөрөнгийг барихад шаардагдах орлуулах материал, хөдөлмөрийн үнэ цэнэ дээр гүйлгээний зардлыг нэмэх гэх мэт. Биет нүүлгэн шилжүүлэлтийн улмаас орон байраа алдахад хүргэсэн бүх тохиолдолд солин орлуулах зардал нь чанар, аюулгүй байдлын хамгийн доод стандартыг хангасан орон сууц худалдан авах эсвэл барихад хангалттай байх ёстой. Солин орлуулах өртгийг тодорхойлох үнэлгээний аргыг баримтжуулж, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөлтийн холбогдох баримт бичигт тусгасан байна. Гүйлгээний зардалд захиргааны хураамж, бүртгэлийн эсхүл өмчлөх эрхийн хураамж, нүүлгэн шилжүүлэх боломжийн зардал, төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүст ногдуулсан ижил хэмжээний зардал орно. Солин орлуулах өртөгтэй тэнцүү нөхөн олговрыг олгохын тулд инфляц өндөртэй эсхүл нөхөн олговрыг тооцох болон олгох хоорондын хугацаа урттай төслийн бүсүүдэд төлөвлөсөн нөхөн олговрын хэмжээг шинэчлэх шаардлагатай.

Хүснэгт 1-т үзүүлсэнчлэн Монгол Улсын хууль эрх зүйн хүрээ болон Дэлхийн Банкны БОНХ-ний хооронд бодлогын хэд хэдэн зөрүү байна. Монгол Улсын хууль тогтоомж эсхүл практикийн дагуу (i) улсын мэдлийн газар эсхүл автозамын хамгаалалтын зурваст эзэмших эрхгүй оршин суугч нь нөхөн олговор, хөрөнгөө сэргээлгэх эрх эдлэхгүй; (ii) орон нутгийн газар чөлөөлөх практикт орлогын болон амьжиргааг сэргээх асуудлыг ерөнхийдөө авч үздэггүй; (iii) нөхөн олговрын төлбөрт гүйлгээний зардлыг тусгадаггүй; (iv) засаг дарга болон шүүхээр маргаан шийдвэрлүүлэхийн өмнөх төсөл дотооддоо өргөдөл, гомдол барагдуулах журам байхгүй; (v) нийтийн хэлэлцүүлэг, мэдээлэл хэвлэн нийтлэх шаардлагыг практикт хэрэгжүүлдэггүй; (vi) тасалбар болгох огноог зарладаггүй; (vii) газар чөлөөлөх журам хэрэгжиж дууссаны дараа л газар шорооны ажил эхлэх тухай зохицуулалт байхгүй; (viii) НШТ боловсруулан бэлтгэх эсхүл хяналт, үнэлгээний арга хэмжээ авах шаардлага тавигдаагүй.

Эдгээр зөрүүг арилгах үүднээс энэхүү НШБХ нь үндэсний хууль болон Дэлхийн Банкны шаардлагыг нэгтгэсэн бөгөөд зөрүүтэй тохиолдолд Дэлхийн Банкны БОНХ (БОНС 5)-ний шаардлагыг мөрдөхөөр нөхөн олговрын эрхийн заалт (нөхөн олговрын эрхийн матрицыг үзнэ үү) оруулсан. Үүнээс гадна процесстой холбогдолтой зөрүүг арилгахын тулд энэхүү НШБХ-нд тусгасан журам (үнэлгээний аргачлал, НШТ төлөвлөгөө боловсруулан бэлтгэх, хэлэлцүүлэг, өргөдөл, гомдол барагдуулах механизм, хяналт шинжилгээ, үнэлгээ)-ыг мөрдөнө. Түүнчлэн өмнө дурдсан гол зарчмыг төсөл хэрэгжүүлнэ.

#### **5. Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө бэлтгэх, батлах**

Нийгмийн болон нүүлгэн шилжүүлэх асуудлаар санал авах үүднээс ТУА-ны аюулгүй байдлын ажилтны хамт санал болгож буй автозамын урьдчилсан үнэлгээг гүйцэтгэнэ. Урьдчилан үнэлгээ хийсэн байршилд нүүлгэн шилжүүлэлтийн болзошгүй нөлөөллийг харгалзан үзэж, юуны түрүүнд түүнээс зайлсхийх, нөлөөллийг багасгахыг эрэлхийлнэ.

Замын хэсэг болон шинээр барих замын тооцоолол эцэслэн тодорхойлогдсоны дараа ТУА-ны аюулгүй байдлын ажилтан доорх ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Газар шорооны ажлын үр дүнгээс шалтгаалсан нүүлгэн шилжүүлэлтийн түр зуурын болон байнгын нөлөөллийн цар хүрээг тодорхойлох үүднээс нэмэлт нягтлан шалгалтын ажил гүйцэтгэх.

**Хэрэв автозамын хамгаалалтын зурвасын нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөллийг тодорхойлбол нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулан бэлтгэхээр ТУА дараах арга хэмжээг авна. Үүнд:**

- Дэлхийн Банкны ажлын хэсэгтэй хамт нүүлгэн шилжүүлэлтийн хэрэгслийг боловсруулах, бэлтгэх процессийг хэлэлцэх.
- Засгийн газрын оролцогч яамд, байгууллагын холбогдох албан хаагч нартай хэлэлцүүлэг яаралтай өрнүүлэх.
- Төслийн үзүүлэлт, хүлээгдэж буй нөлөөлөл, дэмжлэг үзүүлэх шалгуур үзүүлэлт, дэмжлэгийг тасалбар болгох огноо зэрэг мэдээллийг агуулсан төслийн мэдээллийн бюллетень (ТМБ)-ийг монгол, англи хэлээр (шаардлагатай агуулгыг Хэрэгсэл 3) бэлтгэх.
- Төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдтэй уулзах, төслийн бюллетениэр гаргах замаар төслийн тухай мэдээлэх.
- Төслийн нөлөөлөлд өртсөн иргэд болон алдагдлын тооллого, асуулга судалгаа явуулах (Тооллогын судалгаа, хөрөнгийн тооллогын агуулгыг Хэрэгсэл 1).
- Бүлэгт 9 өгүүлсэнчлэн шаардлагатай хөрөнгийн үнэлгээний асуулга судалгаа явуулах замаар орлуулан нөхөх үнийг хянах.

- Дэлхийн Банкны БОНС5 болон энэхүү НШБХ нийцүүлэн НШТ-ний төсөл бэлтгэх. НШТ-ний агуулгыг Хэрэгсэл 4-т өгүүлсэн. НШТ-нд төслийн нөлөөлөлд өртсөн иргэний профиль, хөрөнгийн тооллого, нөхөн олговор бусад эрхийн матрицын төсөл (Хэрэгсэл 2-д харуулсанчлан энэхүү НШБХ-д тусгасан матрицыг сайжруулсан), албадлагын нөлөөллийг хамруулсан НШТ-ний төсөв оруулна.
- НШТ-ний төслийн мэдээлэл, шинэчилсэн ТМБ хэвлэн нийтлэх.
- НШТ эцэслэх, зээлдэгч болон Дэлхийн Банк түүнийг батлах
- Зээлдэгчийн болон Дэлхийн Банкны цахим хуудсанд НШТ байршуулах
- Төслийн нөлөөлөлд өртөгдсөн иргэн бүрээр нөхөн олговрын хэмжээ, төлбөрийн давтамж болон байршлыг тэмдэглэсэн нөхөн олговор, эрхийн маягтыг бэлтгэх.
- Төслийн нөлөөлөлд өртсөн иргэд эрх шилжүүлэх.
- Хандивлагч, санхүүжүүлэгч нарын бүртгэл, тогтмол тайлагнал
- Төслийн нөлөөлөлд өртсөн иргэд болон олон нийтийн оролцоотойгоор хяналт тавих, үр дүнг хэвлэн нийтлэх

Хэрэв зөвшөөрөл олгосны дараа урьдчилан тооцоогүй нөлөөлөл тодорхойлогдвол НШТ шинэчлэн бэлтгэн хэлэлцэж, хэвлэн нийтэлнэ. Дэлхийн Банк бэлтгэсэн НШТ хянан зөвшөөрөл олгоно.

## **6. Нүүлгэн шилжүүлэх хүн амын тооцоо**

Төслийн бүрэлдэхүүн 1 хүрээний дэд бүтцийн хөрөнгө оруулалт нь замын сүлжээний хүртээмж, аюулгүй байдал, улсын чанартай авто зам, замын байгууламжийн хөрөнгө хамгаалалтыг сайжруулахыг зорьж байна. Энэхүү бүрэлдэхүүн нь сонгосон 8 аймгийг холбосон стратегийн 2700 км автозамын сүлжээний гол хэсгийн үр дүнд суурилсан замын засвар үйлчилгээнд дэмжлэг үзүүлнэ. Төслийн үйл ажиллагаа нь орон нутгийн малчдыг улсын автозамын сүлжээтэй холбох тэргүүлэх чиглэлийн орон нутгийн чанартай зам сайжруулахад бас чиглэнэ. Үүнээс гадна төслийн хугацаа дууссаны дараа ч үйл ажиллагааг үргэлжлүүлэх үүднээс зам, замын байгууламжийн хөрөнгийн удирдлагын хүрээг нэвтрүүлснээр хөрөнгийн удирдлага болон төлөвлөлтийн процесс, түүний дотор холбогдох бодлоготой уялдуулах, техникийн стандарт, үр дүнгийн хэмжүүр, хөрөнгө оруулалтын стратеги, ажлын хөтөлбөрийг зам, замын байгууламжийн хөрөнгийн удирдлагын систем, түүний дотор, авто зам, замын байгууламжийн хөрөнгийн тооллогын програм хангамж, мэдээллийн баазтай нэгтгэх болно. Төслийн үйл ажиллагаа цаг уурын өөрчлөлтөд тэсвэртэй буюу дасан зохицох асуудлыг цаг уурын өөрчлөлтөд тэсвэртэй замын зураг төсөл, практикт ашиглах замаар тусгайлан хангана.

Төслийн бүрэлдэхүүн 2 хүрээнд санхүүжүүлэх логистикийн төвийн загвар нь орон нутгийн захиргааны чөлөөлсөн нийтийн эзэмшлийн газрыг ашиглана. Газар чөлөөлөх процесс, хууль эрх зүйн үүсэх эсэхийг үнэлэх үүднээс нягтлан шалгах ажил гүйцэтгэнэ. Ойр орчмын орон нутгийн иргэдийн өнөөгийн амьжиргаанд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ нь нягтлан шалгах ажлын нэг хэсэг бас болно.

## **7. Шалгуурт нийцэх**

Төсөлтэй холбоотойгоор нүүлгэн шилжүүлэгдсэн хүн гэдэгт дараах ангиллын хүмүүс багтана:

- Байгууламж/үл хөдлөх хөрөнгийн шууд өмчлөгчид эсвэл ашиглаж буй эзэмшигч.
- Зам барилгын ажлын нөлөөлөл эсвэл түүнээс үүдсэн эвдрэл, хохиролд өртсөн замын коридорын ойр орчим дахь барилга, байгууламжийг өмчлөгчид эсвэл аж ахуйн нэгжүүд.

Шалгуур нь нөлөөлөлд өртсөн хүмүүс болон хөрөнгийг аль алиныг хамруулна. Нүүлгэн шилжүүлэгдэх хүмүүс нь дараах гурван бүлгийн аль нэг ангилалд харьяалагдана: (а) тухайн газар нутгийг хуулиар өмчлөх, эзэмших эрх бүхий (үүнд, тухайн улсын хуулиар уг газар нутгийг үе дамжуулан өвлөн эзэмших

эрхийг хүлээн зөвшөөрсөн) хүмүүс; (b) тооллогын үед тухайн газар нутгийг өмчлөх, эзэмших хууль ёсны эрх байхгүй байсан боловч уг газар нутаг эсхүл хөрөнгөд нэхэмжлэл гаргасан бөгөөд уг нэхэмжлэл нь тухайн орны хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн эсхүл шилжүүлэн суурьшуулах төлөвлөгөөнд тодорхойлсон үйл явцын үр дүнд хүлээн зөвшөөрөгдсөн өмчлөгчид/эзэмшигчид; (c) оршин сууж, эзэмшиж буй газартаа хууль ёсны болон хүлээн зөвшөөрөгдсөн эрх байхгүй эсхүл нэхэмжлэл гаргаагүй хүмүүс болно.

Тэмдэглэл: (1) Хохирол нь түр зуурын эсхүл байнгын байж болно; (2) нүүлгэн шилжүүлэх туслалцаанд нүүлгэх зардал, эсхүл шинээр шилжин суурьшиж буй нутаг дэвсгэртээ шинэ амьжиргаа эхлүүлэх зорилгоор газрыг бэлтгэх зэрэг үйл ажиллагааны зардалтай дүйцэх хэмжээний байж болно.

Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө нь нөлөөлөлд өртсөн хүмүүсийн хөрөнгийн хохирлыг орлуулахад хүрэлцэхүйц хэмжээтэй байх бөгөөд тэдний орлого болон амьжиргааны стандартыг сайжруулахуйц эсхүл одоогийн хэм хэмжээг хадгалах түвшинд байх баталгааг хангахуйц байхаар төлөвлөгдсөн байна. Түүнчлэн нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө нь нөлөөлөлд өртсөн хүмүүсийг хүйс, нийгмийн байдал, хэл эсхүл бусад шалгуураар алагчлалгүй, ялгаварлалгүй, гадуурхал байхгүй байх баталгааг хангана. Эдгээр зорилтуудыг ханган биелүүлэхийн тулд ТУА нь нөлөөлөлд өртсөн бүх хүмүүсийг илрүүлэн тогтоосон байх, нөлөөлөлд өртсөн бүх хүмүүс нь НШТ-ний нөлөөллийг бууруулах арга хэмжээнд хамрагдах шалгуурт нийцсэн байхыг баталгаажуулна.

Төслийн дүнд газраас бусад хөрөнгө хохиролд өртсөн тэр нь түр зуурын эсхүл байнгын эсэхээс үл хамааран дараах зүйлсийг хамруулна:

- Хувь хүмүүсийн бизнес эсхүл орлого
- Мэдээллийг нээлттэй байлгах олон нийтийн хэлэлцүүлгийн үеэр илрүүлэн тогтоосон, Монгол Улсын хууль болон БОНС5-д хүлээн зөвшөөрөгдсөн амьжиргаа залгуулах зориулалттай аливаа хөрөнгө эсхүл бүрэлдэхүүн байна.

Албадан нүүлгэн шилжүүлэлтийн эцсийн хугацаанд багтаж эдгээр нөхцөлүүдийн аль нэгэнд харьяалагдан албадлагын дүнд хохирч байгааг танилцуулсан тохиолдолд нүүлгэн шилжүүлэх шалгуурт нийцсэн гэж үзнэ. Тухайн төслөөс заасан эцсийн хугацаанаас хойш үүссэн халдлага эсхүл үйл ажиллагааны хохирлыг шалгуурт нийцээгүйд тооцно.

## **7. Үнэлгээний аргачлал**

“Орлуулах өртөг” гэдэг нь тухайн орлуулах хөрөнгөөс олох орлогыг баталгаажуулахад хүрэлцэхүйц нөхөн төлбөрийг тооцоолох аргачлал бөгөөд үүний дээр орлуулах хөрөнгөтэй холбоотой ажил, гүйлгээнд шаардлагатай зардлыг нэмж тооцно. Зах зээл нь идэвхтэй үйл ажиллагаатай бол орлуулах өртөг нь бие даасан, өрсөлдөх чадвартай үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэлгээ байх ба нэмэх нь ажил гүйлгээний зардлыг оруулан тогтооно. Зах зээл байхгүй эсхүл идэвхтэй үйл ажиллагаа явуулдаггүй бол орлуулах өртгийг хувилбарт аргаар сонгох буюу газрын гарц эсхүл бүтээмж бий болгодог хөрөнгөөр эсхүл орлуулах хөрөнгө болох барилга байгууламжийг барих материал болон ажиллах хүчний зардал эсхүл үл хөдлөх хөрөнгийн элэгдэл хорогдол хуримтлуулаагүй үеийн үнэлгээгээр тооцоолох ба нэмэх нь ажил, гүйлгээний зардлыг оруулан тооцно. Нүүлгэн шилжүүлэлт хийгдэх бүх тохиолдолд амьдрах байраа алдаж байвал орлуулах өртөг нь чанар болон аюулгүй байдлын хувьд тухайн орон нутгийн амьжиргааны зөвшөөрөгдсөн хамгийн бага түвшингээс доошгүй орон байрыг худалдаж авах эсхүл барихад хүрэлцэхүйц байх ёстой.

Нөлөөлөлд өртөж буй хөрөнгө болон үнэ цэнийг олон нийтийн зөвлөлдөх уулзалтын үеэр бүрэн илрүүлэн тогтоох ба НШТ-д тусгана. НШТ-нд ижилтэй ижил байдлаар орлуулах, алдаж буй хөрөнгө болон орлогыг орлуулах өртөг, амьжиргааг бүрэн сэргээх зарчмуудыг хэрэглэнэ.

Үнэлгээний багийн зах зээлийн харьцуулах аргачлалаар хийсэн үнэлгээнд үндэслэн орлуулах өртгийг тогтоож нөлөөлөлд өртсөн бүх хөрөнгөнд нөхөн төлбөр олгоно. Үнэлгээний багт дараах мэргэжилтнүүд багтана: нүүлгэн шилжүүлэлтийн мэргэжилтэн; Хөрөнгийн харилцааг зохицуулах агентлагийн хөрөнгийн үнэлгээний мэргэжилтэн, Газрын харилцаа, Барилга, хот байгуулалтын хэлтсийн (ГХБХБХ) мэргэжилтэн; болон нөлөөлөлд өртсөн аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл ба нөлөөлөлд өртсөн иргэд болно. Үнэлгээний баг бүрдүүлэлтийн асуудлыг ДБ-ны холбогдох багтай зөвшилцөнө. ТУА нь газраас бусад хөрөнгө болон хохирлын орлуулах үнэлгээний тооцооллын үйл явцыг хянах, мөрдүүлэх, чиглүүлэх үүрэг хүлээнэ. Нөхөн төлбөрийн хэмжээг нөлөөлөлд өртсөн хүнтэй тохиролцох явцад маргаан гарвал ТУА нь үнэлгээний хараат бус мэргэжилтэн ажиллуулж нөхөн төлбөрийн хэмжээг дахин тооцоолж нөлөөлөлд өртсөн хүнд санал болгох бөгөөд үр дүнг нөлөөлөлд өртсөн хүнд мэдээлнэ.

**Дэлгүүр, байгууламж, газар ба барилга.** Эдгээрийг ижил төрлийн байгууламжтай харьцуулан элэгдэл хорогдол тооцолгүйгээр зах зээл дээрх давамгайлах ханшаар тооцоолж, ажил гүйлгээний зардал болон нөлөөлөлд өртсөн айл өрхүүд үнэ төлбөргүй хэрэглэх аврах ажиллагааны материалын үнийг нэмсэн дүнгээр орлуулах өртгийн нөхөн төлбөр олгоно. Үнэлгээ хийхээс өмнө төсөлд зориулан бэлтгэж НШТ-нд тусгагдсан ханшийг 12 сарын хугацаа өнгөрөөгүй бол ашиглаж болно.

**Байнгын орлогоо алдах хохирол.** Орлогоо алдсан ажилчдад 2 сарын тэтгэмжийг цалингийн доод түвшингээр тооцоолон нөхөн төлбөр олгоно.

**Орлогоо түр алдах хохирол.** Тасалдлын хугацаанд цэвэр орлогоо алдах хохиролын нөхөн төлбөрийг гэрээнд тусгах бөгөөд татварын баримт/бусад хүчин төгөлдөр баримтад үндэслэн тооцоолох ба хэрэв байхгүй бол төсөлд ажилладаг замын салбарын түгээмэл ажиллагсдын дундаж цэвэр орлогын хэмжээгээр тооцоолно.

## **8. Хэрэгжүүлэх үйл явц**

Газар чөлөөлөх болон нөхөн төлбөр олгохтой холбоотой бүх үйл ажиллагааг цаг хугацаанд нь хэрэгжүүлэх, шударга явагдахыг баталгаажуулахын тулд тэдгээрийг НШТ бүхий л төлөвлөгөөнд тусгана. Нөхөн төлбөрийг барилгын ажил эхлэхээс өмнө өгч дууссан байх нь нөлөөлөлд өртсөн хүмүүс зохицуулах болон шилжүүлэх хугацаатай байх боломж олгоно. Хөрөнгийг үнэлэх, нөхөн төлбөр олгох хугацааны хооронд нэг түүнээс урт хугацаагаар үргэлжилбэл нөхөн төлбөрийн хэмжээнд ханшийн уналт эсхүл үнийн өсөлт зэрэг бусад хүчин зүйлсийг тооцон тохиргоо хийнэ. Ажил гүйлгээг тохирсон боловч төлбөрийг хийхэд үндэслэл бүхий хоцрогдол жишээлбэл, өмчлөгчийг олоход бэрхшээл тохиолдвол төрийн эскроу дансанд төлбөрийг байршуулан хэрэгжүүлэх боломжтой үед шилжүүлнэ. Үнийн дүнд хуримтлагдсан хүүг эсхүл хууль ёсны нэхэмжлэгчдэд ногдох хэмжээг зохих хувийн дагуу олгоно. Эдгээр арга хэмжээнүүд нь өмчлөгчдийг орхигдуулалгүйгээр төслийн үйл ажиллагааг явуулах боломж олгоно.

## **9. Албадан нүүлгэн шилжүүлэх асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэг хийх, мэдээллийн ил тод байдлыг хангах зохицуулалт**

Төслийн бүх асуудлуудаар хэлэлцүүлэгт оролцогч Талуудын оролцоог хангах төлөвлөгөөнд тусгах бөгөөд энэ хэсэг нь зөвхөн нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөлтэй хамааралтай тул хэлэлцүүлэг, мэдээллийн ил тод байдлыг авч үзнэ. Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулах шатанд гол

хэлэлцүүлгийн үйл ажиллагаанд холбогдох гол байгууллагуудын болон арилжааны мэдээлэгчдийг оролцуулна; Төслийн мэдээллийн товхимолыг боловсруулна, түгээнэ; НӨ хүмүүсийг илрүүлэх тогтоох, тооллого явуулна; хэрхэн оролцох болон залруулга хийх тухай мэдээлэл бүхий НШТ-ний нооргийг танилцуулна. Нөлөөлөлд өртсөн аливаа хүн шилжин суурьших нөлөөлөл болон бусад зохицуулалттай холбогдолтой асуудлаар хэлэлцүүлэгт шууд оролцоно.

Төлөвлөлтийн шатны гол үр дүн нь хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд болон хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн дүгнэсэн мөн цаашид хэрэгжүүлэх шаардлагатай аливаа хэлэлцүүлгийн үйл ажиллагаа бүхий НШТ-г хүлээн зөвшөөрөх явдал болно. Хэлэлцүүлэгт оролцож гарын үсэг зурсан бүртгэл болон хэлэлцүүлгийн асуудлууд, хэлэлцүүлгээс гаргасан шийдвэрийг нэгтгэн дүгнэсэн баримтууд нь олон нийтийн хэлэлцүүлгийн бусад үр дүнгүүд юм.

ТУА нь НШТ-ний аливаа хувилбар болон төгсгөлийн шатны тухай мэдээллийг төслийн нутаг дэвсгэр дэх нөлөөлөлд өртсөн хүмүүс болон олон нийтэд ойлгомжтой хэлээр, мэдээлэл авахад хүртээмжтэй байршлуудад веб хуудсаар болон цаасаар ил тод мэдээлнэ. Банктай хамтарч хэрэгжүүлж буй энэхүү болон цаашид хэрэгжүүлэх бусад төслүүдийн НШТ-ний нооргийг Банк хяналт хийхээс нэг сараас доошгүй хугацааны өмнө нээлттэй мэдээлнэ. НШТ-ний эцсийн хувилбарын мэдээллийг Банк хүлээн зөвшөөрсний дараа нийтэд нээлттэй мэдээлнэ.

Энэхүү НШТ-ний Хүрээний хэлэлцүүлэг болон нээлттэй мэдээллийг БОНУХ-тэй хамтран гүйцэтгэсэн бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг БОНУХ-нээс авна уу.

#### **10. Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг шилжүүлэн авахтай холбоотой гомдол барагдуулах журам**

Төслийн Гомдол Барагдуулах Механизм (ГБМ) нь ТОХТ-нд тодорхойлогдсон бөгөөд засгийн газрын хүчин төгөлдөр журмын дагуу (шууд утас, биечлэн, бичгээр) хүлээн авах ба төсөлтэй холбоотой гомдлыг ТУА руу дамжуулна. Түүнчлэн нэрээ нууцалсан гомдлыг хүлээж авдаг. Энэхүү ГБМ нь аливаа НШТ-нд хамааран хэрэглэгдэнэ (доор үзнэ үү). Холбогдох үйл ажиллагаанууд нь аливаа нүүлгэн шилжүүлэлт хийхээс аль болох зайлсхийх эсхүл хамгийн бага түвшинд байлгахаар зохион байгуулагдсан тул томоохон гомдол гарахгүй хэмээн тооцоолж байгаагаас гадна төсөлтэй холбоотой гомдлыг орон нутагт барагдуулах механизмыг бүрдүүлсэн бөгөөд уг механизм нь аливаа нөлөөлөл боломжит бага хэмжээнд байхаар төлөвлөгдсөн. Уг үйл ажиллагаа нь дараах байдлаар явагдана (гомдол бүртгэх тухай дэлгэрэнгүйг ТОХТ-ний дагуу ТОХТ-нөөс харна уу):

1 дэх шат:

Төсөлтэй холбоотой гомдлыг хүлээн авах хоёр утасны дугаар болох ТУА-ны болон 24/7 дуудлагын төвийн дугаарыг зарлан мэдээлнэ (барилгын самбараар, ГБМ товхимолоор, оршин суугчдад/нөлөөлөлд өртсөн хүмүүст захидлаар дамжуулан). Гомдол гаргагч нь ТУА-нд хүчин төгөлдөр үйлчилж буй арга замын дагуу шууд бичгээр болон биечлэн өгч болно. Дуудлагын төвөөр өгсөн гомдлыг ТУХ-нд шууд дамжуулна. Ажлын бус цагаар ирсэн гомдол нь ТУА-нд дараачийн өдөр дамжуулагдана. Энэ тохиолдолд ТУА нь дотоод хэлтсүүдтэй болон/эсхүл барилгын гэрээт байгууллагад дамжуулж асуудлыг шуурхай шийдвэрлэхээр хамтран ажиллах боловч 7-оос доошгүй хоногийн хугацаанд шийдвэрлэнэ, эсхүл гомдлыг ГБМ-ын 2 дахь шатанд дамжуулсан болохыг гомдол гаргагчид мэдэгдэнэ.

2 дахь шат:

Хэрэв ТУА нь гомдлыг 7 хоногийн хугацаанд барагдуулж чадахгүй бол ЗТХЯ-ны гомдол хариуцсан албан тушаалтанд хянуулахаар дамжуулах бөгөөд ийм тохиолдолд уг гомдол нь 15 хоногийн дотор шийдвэрлэгдэнэ. Хэрэв нөхөн төлбөртэй холбоотой маргаантай асуудал гарвал гомдол барагдуулах механизмын хүрээнд хараат бус үнэлгээчин ажиллуулах нөхцлийг харгалзан үзэж шийдвэрлүүлэн дуусгах бөгөөд хэрэв гомдол нь нэлээд томоохон асуудал хөндөж байвал өртсөн талууд Монгол Улсын хууль, журмын дагуу бичгээр эсхүл аман хэлбэрээр Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### **11. Санхүүжилт ба холбогдогдох байгууллагуудын уялдаа**

ТУА нь ЗТХЯ-ны харьяанд байгуулагдах бөгөөд холбогдох агентлагуудтай нягт холбоотой ажиллана. Төслийн зээлдэгч нь нүүлгэн шилжүүлэхтэй холбогдолтой зардлыг төсөвлөсөн хэмжээнд байлгах үүрэгтэй. Аливаа НШТ нь НШХ-тэй нийцтэй байж НШТ-г хэрэгжүүлэх бүхий л асуудлууд нь тооцоолсон төсөвтэй байхаар боловсруулагдах шаардлагатай. Нөлөөлөлд өртсөн газар болон хөрөнгийн тооллого, бүртгэлийг хийх үйл явц нь нөлөөлөлд өртсөн бүх хүмүүсийг тогтоосон байх ёстой бөгөөд тооллого явуулах үед алдаа эсхүл орхигдол гарч нөхөн төлбөр авах нь зүй ёсны боловч нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний дараа нэхэмжлэл гаргавал бууруулах арга хэмжээний анх тусгасан санхүүжилт хүрэлцэхгүй байсан ч нөхөн төлбөр авах эрхтэй. Энэхүү шаардлагыг ханган биелүүлэх болон аливаа тооцоолоогүй зардал гарах тохиолдолд НШТ-ний нийт зардлаас 10%-иар тооцоолсон болзошгүй зардлын ангиллын эх үүсвэрээс гаргана. НШТ-нд тусгасан нөхөн төлбөрийн түвшин нь нөхөн төлбөрийг тооцоолох суурь болно. Нөлөөлөлд өртсөн хүн эсхүл хүмүүсийн газар эсхүл хөрөнгө эсхүл орлогын хохирлыг барилгын ажил эхлэхээс өмнө бүрэн төлж барагдуулна. ТУА нь байгаль орчин, нийгмийн мэргэжилтнүүдийг ажиллуулж нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангана.

Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний төсөвт дараах төрлийн зардлууд багтана:

Захиргааны зардал:

- Захиргааны үйл ажиллагааны зардал, тоног төхөөрөмж болон бараа материалын нөөцийн ашиглалт.
- Томилолт, аялал.
- Зар сурталчилгаа ба хэвлэн нийтлэх.

Нүүлгэн шилжүүлэх зардал:

- НӨ хүмүүст зориулсан хэлэлцүүлэг хийх уулзалтуудын зардал (Томилолт / Зуучлал).
- Нөлөөлөлд өртсөн байгууламж болон хөрөнгийн нөхөн төлбөр
- Нөлөөлөлд өртсөн амьжиргааны нөхөн төлбөр
- Нүүлгэн шилжүүлэх болон амьжиргааг дахин сэргээн суурьшуулах туслалцаа.
- Ажил гүйлгээний зардал (нотариатын төлбөр, кадастрын зураглал гаргах, үйлчилгээний төлбөр үүнд хөрөнгийн бүртгэлийн төлбөр багтана).
- Болзошгүй, гэнэтийн болон урьдчилж тооцоолоогүй зардал буюу дээр дурьдсан нийт зардлын нийлбэрээс 10%-иар тооцоолно.
- Төлбөр хүлээн авагчийн эрхийг хянагчийн зардал.

Ямар ч тохиолдолд нөхөн төлбөрийн хэмжээг бууруулахгүй. НШТ-нд нөхөн төлбөрийн санхүүжилтийн ил тод байдлын журмыг хангах зорилгоор ажил, гүйлгээг гэрчлэх болон баримтжуулах ажилтныг нөлөөлөлд өртсөн хүмүүст зориулан ЗТХЯ-наас байлцуулна. Өрх бүрээс эхнэр, нөхрийн аль алианаар гарын үсэг зуруулахыг хичээх нь зүйтэй.

#### **12. Албадан нүүлгэн шилжүүлэлтийн хяналт шинжилгээ**



Энэхүү хэсэг нь Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд (НШҮАТ) оруулах шаардлагатай хяналт шинжилгээнд хамааралтай. Хяналт шинжилгээ нь зээлдэгчийн хариуцлага болно. Хэрэгжүүлэлтийн явцад НШҮАТ-тэй нийцтэй байдлыг ТУА-наас хянаж шинжлэх бөгөөд үр дүнг төслийн хагас жилийн явцын тайланд оруулан ДБ-нд тайлагнана. НШТ бүр хяналт шинжилгээний индикатор үзүүлэлтүүдтэй байна.

ТУА нь НШТ-г зээлдэгчийн ДБ-тай байгуулсан гэрээнд заасан бүх индикатор үзүүлэлтийн дагуу дараах асуудлаар хяналт хийж явцын тайланг тогтмол бэлтгэн гаргана:

- Бодлогын зорилтуудыг ханган биелүүлэх асуудалтай холбогдолтой аливаа өөрчлөлтийг НШТ-нд оруулах шаардлагатай бэрхшээл үүссэн эсэх.
- Нүүлгэн шилжүүлэх үйл явцыг Төслийн мэдээллийн товхимол (ТМТ) болон бусад хэвлэлийн мэдээгээр дамжуулсан байдал.
- НӨ хүмүүстэй хэлэлцүүлэг хийх хуваарь.
- НШТ-ний хэлэлцүүлгийн уулзалтанд оролцсоныг баталгаажуулах гарын үсэг зуруулсан хуудас, фото зураг болон бусад оролцооны талаар нотолгоожуулах баримтууд.
- НШТ-ний хэлэлцүүлэг, шийдвэрийн дүгнэлт, тэмдэглэл.
- НШТ-ний хүрээнд гарсан гомдлын бүртгэл, үйл явц ба үр дүн.
- Төсөлтэй холбоотойгоор газар ашиглалт эсхүл газрын эрх шилжүүлэхтэй асуудлаарх аливаа өөрчлөлтийн албан ёсны бүртгэлийн хуулбар.
- НШТ-ний хүрээнд эрх шилжүүлэх мариц болон эрх шилжүүлэх төлбөрийн гүйцэтгэлийн бүртгэлийг шинэчлэх.
- Эрх шилжүүлэх төлбөр барагдуулсан санхүүгийн тайлан.

**Арга 1: Тооллогын судалгаа болон хөрөнгийн бүртгэлийн агуулга**

**МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ХОЛБОЛТ БА ЛОГИСТИКИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ  
ӨРХИЙН ТООЛЛОГЫН АСУУЛГА**

Огноо: 

--	--	--	--	--	--	--

Асуулгын дугаар: 

--	--	--	--	--	--	--	--

**1. НӨЛӨӨЛӨЛД ӨРТСӨН ӨРХИЙГ ТОГТООХ.**

*Байгууламж/хөрөнгийн өмчлөгч тус бүрээр нэг асуулга (ө.х. бизнес эрхлэгч бүрээр нэг асуулгын маягт) бөглөнө*

1.1 Өмчлөгийн нэр (банкны дансанд бүртгэлтэй ижил албан ёсны нэр):.....  
.....

1.2 Бусад нэр /Богино нэр: .....

1.3 Сум / Баг: .....

1.4 Байршил (хамгийн ойрхон гудамж /газрын тэмдэглэл):.....  
.....

1.5 Хохиролын # маягтын бүртгэлтэй нийцэх ёстой .....

**ТӨСЛИЙН ТАЛААРХ МЭДЛЭГ, МЭДЭЭЛЭЛ**

2. Та Монгол Улсын авто зам, тээврийн холболт ба логистикийг сайжруулах төсөл дараа жил эхэлж байгаа талаар мэдээлэлтэй юу?  Тийм  Үгүй

*Хэрэв төслийн тухай мэдээлэл байхгүй бол төсөл хэрэгжих тухай товч мэдээлэл өгөх.*

**ӨРХИЙН ХОХИРОЛЫН ТӨРӨЛ**

3. Айл өрхийн хохиролын төрөл:

- Бизнесийн бүтэц,
- Хөрөнгө (хашаа, бусад);
- Барилга (ө.х. хамгаалалтын саравч, хоосон барилга)
- Орлого (ө.х. ажиллагсад)
- Газар (тодорхойлох)

□ Бусад (тодорхойлох)

**ХҮН АМ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ**

Өрхийн байдал					
	Хууль ёсны эрхийн байдал	Хөлслөгч	Аюулгүй бүсийн 10 м дотор хууль бусаар оршин суугч	Түрэмгийлж орсон хүмүүс (байгууламж нь хувийн эдлэн газар бөгөөд 10м-ийн дотор)	Бусад
3.1					

3.2 Хэрэв хөлслөгч, хууль бусаар оршин суугч эсхүл түрээслэгч бол өмчлөгчийн бүтэн нэр, хаягийг оруулна уу.....

.....

3.3 Өрхийн гишүүдийн нийт тоо (нэг сууцанд хамт байдаг бүх хүмүүс орно): .....

	Өрхийн гишүүдийн нэрс	Хүйс	Нас	Боловсролын байдал (6 наснаас дээш бүх хүмүүсийн)	Эдийн засгийн үйл ажиллагаа	Өрхийн тэргүүнтэй ямар хамааралтай болох	Гэрлэлтийн байдал
3.4							
3.5							
3.6							
3.7							
3.8							
3.9							
3.10							

Код: Хүйс: 1=Эр, 2= Эм

Боловсрол: 1= Бичиг үсэг тайлагдсан боловч бага боловсролыг дүүргээгүй

2= Бүрэн бус дунд боловсролтой (1-8 дугаар ангийг дүүргэсэн)

3= Бүрэн дунд боловсролтой (8-10 дугаар ангийг дүүргэсэн)

4= Хоёр дахь шатны боловсролтой (Мэргэжлийн гэрчилгээ эсхүл түүнтэй ижил түвшний)

5= Бакалавр болон түүнээс дээш боловсролтой

6= Бичиг үсэг тайлагдсан Гэрлэлтийн байдал: 1=Гэрлэсэн 2=Гэрлээгүй

Эдийн засгийн байдал: 1=Төрийн байгууллагад ажилладаг, 2=Хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 3=Бизнес эрхэлдэг, 4=Мал аж ахуй эрхэлдэг, 5=Оюутан, 6=Ажилгүй, 7=Эдгээрээс өөр бол түүнийг дурьдах.

## ӨРХИЙН ОРЛОГО

4. Төсөл нь танай орлогод нөлөөлөх үү?

Тийм: .....(яагаад болохыг бичих)

Үгүй: .....(яагаад болохыг бичих)

Өрхийн орлогын эх үүсвэр

4.1	Орлогын гол эх үүсвэр		1 Ажилчин (ө.х. ямар нэгэн газар хөлсөөр ажилладаг)	6 Конторт ажилладаг
4.2	Нэмэлт орлогын эх үүсвэр		2 Төрийн байгууллагад ажилладаг	7 Хөдөө аж ахуйн
			3 Бизнес эрхэлдэг / хувийн бизнесийн эзэн	8 Тэтгэвэр /Тэтгэмжийн
			4 Түрээс	9 Бусад (тодорхойлж бичих)
			5 Биеийн хүчний хөдөлмөр эрхэлдэг	

Өрхийн сарын нийт орлого

	Орлогын эх үүсвэр	Өрхийн сарын орлогын хэмжээ, төгрөгөөр
4.3	Гол эх үүсвэр	

4.5	Нэмэлт эх үүсвэр	
4.6	Нийт эх үүсвэрийн дүн	

Нэг сарын дундаж орлого		
	Өрхийн гишүүн	Өрхийн сарын орлого, төгрөгөөр
4.7	Нөхөр	
4.8	Эхнэр	
4.9	Өөр гишүүн	
4.10	Нийт (өрхийн хэмжээнд)	

#### ӨРХИЙН ЗАРДАЛ

Өрхийн зардал			
	Зардлын төрөл	Жилийн зардлын хэмжээ, төгрөгөөр	Сарын хэмжээ, төгрөгөөр
5.1	Хүнс		
5.2	Хувцас		
5.3	Сургууль, сургалтын төлбөр, ном, бичиг хэргийн г.м		
5.4	Эм /эмч /эрүүл мэндийн үзлэг		
5.6	Тээвэр, утас, харилцаа холбоо г.м.		
5.7	Баяр наадам тэмдэглэлт үйл явдал		
5.8	Бусад		
5.9	Нийт зардал		

Тэмдэглэл: Хэрэв зардал нь орлогоосоо мэдэгдэхүйц өндөр бол шалтгааныг тайлбарлах.

#### ТУСЛАЛЦААНЫ ТОДОРХОЙЛОЛТ

6.1	Байгууламжийг нүүлгэх, зөөвөрлөх өөр байрлал, газар танд бий юу?		1 Байрлал, газар бий 2 Байрлал, газар байхгүй 3 Байрлал, газар олоход туслалцаа шаардлагатай
6.2	Байгууламж/хөрөнгийг өөр байрлал, газар луу нүүлгэхэд танд туслалцаа хэрэгтэй юу?		1 Нүүлгэхэд туслалцаа хэрэгтэй 2 Нүүлгэхэд туслалцаа хэрэггүй
6.3	Барилгын ажил эхлэхээс өмнө төслийн зүгээс ямар туслалцаа авахыг та хүсч байна вэ?		Туслалцаа хэрэггүй Туслалцаа хэрэгтэй (тодорхойлон бичих)

6.4 Төслийн талаар таны санааг зовоож буй бусад асуудлууд бий юу? (жагсаах)

6.5 Тэмдэглэл:

Ярилцлага авсан хүний нэр:

Ярилцлага авагчийн гарын үсэг

Гарын үсэг /Ярилцлага өгсөн хүний тэмдэглэгээ



# МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ХОЛБОЛТ БА ЛОГИСТИКИЙГ САЙЖРУУЛАХ

## ТӨСӨЛ

### ХОХИРОЛ БҮРТГЭХ МАЯГТ

Огноо: 

--	--	--	--	--	--	--

Маягтын дугаар:

--	--	--	--	--	--	--	--

### 1. ӨМЧЛӨГЧИЙГ ТОГТООХ/ӨМЧЛӨГЧИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

\*Өмчлөгчийг тогтоох боломжгүй бол маягтын бусад мэдээллийг бүртгэнэ. Хэрэв төрийн байгууламж бол А6 руу очно.

Байгууламж/хөрөнгө өмчлөгч тус бүрд нэг маягт бөглөнө (ө.х. бизнес тус бүрд нэг маягт)

1.1 Өмчлөгчийн/компаний нэр (банкны дансанд бүртгэгдсэн албан ёсны нэр байна):.....  
.....

1.2 Бусад нэр / Нэрлэгдэж заншсан эсхүл хоч: .....

1.3 Сум /Баг: .....

1.4 Байршил (хамгийн ойр байрлах гудамж /газрын тэмдэглэгээ):.....  
.....

### БҮТЭЭЦ (ОБЪЕКТ)

2. Байгууламж нь зам дагуу бөгөөд төслийн барилгын ажлын нөлөөлөлд өртөх үү? Тийм  Үгүй

Төслийн барилгын ажлын нөлөөлөлд өртөх авто замын хамгаалалтын зурвас дагуу байгууламжуудыг жагсааж бичих

№	Байгууламжийн төрөл	Материалын төрөл	Талбайн хэмжээ мкв	Түүх байхгүй	Баригдсан он	Байгууламжийн нөлөөлөлд өртөх хэмжээ %-иар	Тэмдэглэгээ
2.1							
2.2							
2.3							

2.4							
2.5							
Байгууламжийн төрөл: мухлаг /дэлгүүр, амьдардаг байр, агуулах, олон нийтийн байгууламж; бусад (тодорхойлох.							

### ХӨРӨНГӨ

3. Төслийн барилгын нөлөөлөлд өртөх авто замын хамгаалалтын зурвасын дагуу өмч хөрөнгө бий юу  Тийм  Үгүй

### БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА АЖИЛЛАГААНЫ БҮТЭЭЦ (ОБЪЕКТ)

4. Таны өмчлөлийн цех/мухлаг эсхүл аливаа нэгэн байгууламж, бүтээц бий юу?  Тийм  Үгүй

4.1  Өөрөө өмчилдөг,  Хамтарсан өмч,  Түрээсэлдэг  Компаний өмч

4.2 Танд өмчлөлийн баталгаа бий юу?  Тийм  Үгүй (зөвхөн эзэмшдэг)

4.3 Өмчлөлийн баримт бичгийн төрөл:

4.4 Энэ байрлалд та өөрийн бизнес үйл ажиллагааг хэдэн жил явуулж байна вэ?

4.5 Одоогийн ханш, үнэлгээ, Төгрөгөөр:

4.6 Бизнес/дэлгүүр, цехийн бүтээцийн үнэлгээ, Төгрөгөөр:

### 5. БИЗНЕСИЙН МЭДЭЭЛЭЛ

	Бизнесийн төрөл	Бизнесийн татвар төлөлтийн байдал		Ажиллагсдын тоо		Сарын ашгийн дундаж хэмжээ	Өдрийн ашгийн дундаж хэмжээ	Тэмдэглэл
		Бүртгэлтэй	Бүртгэлгүй боловч татвар төлдөг	Тогтмол ажилладаг	Улирлын чанартай ажилладаг			
5.1								
5.2								
5.3								
5.4								

5.5 Төслийн барилгын ажлын дүнд таны мухлаг/цех өртөх эсэх. Орлогын өөр үүсвэр танд бий юу?

5.6 Орлогын өөр эх үүсвэр нь юу вэ?



5.7 Та гэр бүлийн орлогын ямар хэмжээний орлогыг өөр эх үүсвэрээс олдог вэ (хувиар)?

## 6. БУСАД ДЭД БҮТЭЦ

Төслийн барилгын ажлаас үүдэн нөлөөлөлд өртсөн **УБДС УВНС**-с бусад газарт хамааралтай Авто замын хамгаалалтын аюулгүй байдлын зурвас дагуу бусад дэд бүтэц

	Дэд бүтэц	Дугаар/ Нэгж	Талбай / уртын хэмжээ	Материалын төрөл	Тооцоолсон өртөг	Өмчлөгч төрийн агентлаг
6.1						
6.2						
6.3						
6.4						
6.5						
6.6						

Дэд бүтэц: Сургууль, цахилгааны шон, төрийн байгууллагын контор, төрийн өмчийн хашаа, бусад (тодорхойлох)

Судалгаа авагчийн тэмдэглэл:

Хөрөнгө болон объектыг өмчлөгчийн гарын үсэг:

Судалгаа авагчийн нэр:

Судалгааг авагчийн гарын үсэг

### ФОТО ЗУРГИЙГ ХАВСАРГАВ

(өмчлөгчийг хөрөнгө, объектын өмнө оруулна)

Тийм  Үгүй

## Арга 2: Өмчлөл/Эзэмшлийн эрхийн матриц

Монгол Улсын хууль ба Дэлхийн Банкны бодлого хоёрын хоорондын зөрүүг арилгахын тулд хоёр талын нөхцлийг нэгтгэсэн өмчлөлийн эрхийн нөхцлүүд байдаг бөгөөд энэхүү НШТХ-нд уг нөхцлүүд орох бөгөөд зөрүү гарвал ДБ-ны бодлого давуу эрхтэй байна. Энэхүү төсөлд зориулан бэлтгэсэн аливаа НШТ нь дэд бүрэлдэхүүний нөлөөллийг тодорхой харуулах дараах Өмчлөл/эзэмшлийн эрхийн матрицыг хөтөлж шинэчилж байна.

### НШТХ-ний Өмчлөл/эзэмшлийн матриц

Хохирлын төрөл	Өмчлөгч/эзэмшигчийн аль нь болох	Өмчлөх/эзэмших эрх
Авто замын хамгаалалтын зурвас дагуу дэлгүүр/цехийн байгууламж (байгууламжийг бүхэлд нь алдана)	Байгууламжийг өмчлөгч	<ul style="list-style-type: none"> <li>Байгууламжийг орлуулах зардал</li> <li>Шилжилтийн болон шилжүүлэн байршуулах тэтгэмж</li> <li>Дэлгүүр/цех байрлах хувилбар олох туслалцааг боломжийн хэрээр</li> </ul>
Эрхтэй байгууламж (байгууламжийг бүхэлд нь алдана)	Байгууламжийг өмчлөгч	<ul style="list-style-type: none"> <li>Байгууламжийг Орлуулах өртгөөр тооцсон нөхөн төлбөр</li> <li>Аврах материалын эрх</li> <li>Тээврийн тэтгэмж</li> </ul>
Байгууламжид ээлжилдэг	Өмчлөгч, эзэмшигч, газарт хууль ёсны байрладаг	Байгууламжийг хохиролд өртсөн хэсэг болон үлдсэн хэсгийн бүтээцийг сэргээн засварлах зардлыг зах зээлийн ханшаар, гэрээний дагуу элэгдэл хорогдлыг хасахгүй тооцож бэлэн мөнгөөр нөхөн төлбөр олгоно.
Газар (газраа бүрмөсөн алдаж хохирох)	Газар ашиглагч /өмчлөгч	<ul style="list-style-type: none"> <li>Газрыг орлуулах зардал</li> <li>Шилжилт болон шилжүүлэн байршуулах тэтгэмж үүнд нүүх зардал болон шилжилтийн үеийн (ихэнхдээ 3-6 сар) орлогын дэмжлэг нэмэгдэж болзошгүй.</li> <li>Орлуулах газар олох туслалцааг боломжийн хэрээр үзүүлэх</li> </ul>
Бизнес	Бүх аж ахуйн нэгжүүд нөлөөлөлд түр хугацаагаар өртөнө	Алдаж буй хохиролтой дүйцэх бэлэн мөнгөний нөхөн төлбөр олгох, тухайлбал татварын баримт/бусад хүчин төгөлдөр баримт эсхүл баримт байхгүй бол төслийн орон нутаг дахь ижил төрлийн бизнесүүдийн дундаж цэвэр орлогыг үндэслэл болгох.
	Бүх аж ахуйн нэгжүүд нөлөөлөлд түр хугацаагаар өртөнө.	Алдаж буй хохиролтой дүйцэх бэлэн мөнгөний нөхөн төлбөр олгох, тухайлбал татварын баримт/бусад хүчин төгөлдөр баримт эсхүл баримт байхгүй бол төслийн орон нутаг дахь ижил төрлийн бизнесүүдийн дундаж

Хохирлын төрөл	Өмчлөгч/эзэмшигчийн аль нь болох	Өмчлөх/эзэмших эрх
	Түрээслэгчид түр хугацаагаар нөлөөлөлд өртөх	<p>цэвэр орлогыг үндэслэл болгох.</p> <ul style="list-style-type: none"> <li>Түрээсийн төлбөр болон үлдсэн хугацааны түрээсийн төлбөртэй дүйцэх мөнгөн хөрөнгийг бэлэн мөнгөөр нөхөн төлөх</li> <li>Түрээслэгчид 3 сарын орлоготой тэнцэх шилжилтийн тэтгэмж</li> </ul>
Ажиллагсад	Нөлөөлөлд өртсөн дэлгүүр/цехийн ажиллагсдын ажлаас халагдах	Орлогоо алдсан хохиролыг цалингийн доод хэмжээгээр 2 сарын тэтгэмж
	Нөлөөлөлд өртсөн бүх бизнесийн ажиллагсад түр халагдах	1 жилээс доошгүй хугацаагаар ажилласан ажилчин/ажиллагсдад 2 сарын цалинтай тэнцэх бэлэн мөнгөний нөхөн төлбөр; бусад тохиолдолд 1 сарын цалингийн хэмжээтэй тэнцэх нөхөн төлбөр.
Эмзэг бүлгийн өрх	Ядуу эмзэг бүлгийн өрхүүдийг тоологын явцад тогтооно, эдгээрт, өмчийн эрх байхгүй, өрх толгойлсон эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй өрхийн тэргүүнтэй, ядуурлын түвшингээс доогуур орлоготой.	<ul style="list-style-type: none"> <li>Эмзэг бүлгийн өрхийн тэтгэмж нь орлогын доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү.</li> <li>Шилжин байрлах эсхүл амьжиргаагаа шинээр босгоход зөвлөх үйлчилгээ болон дэмжлэг үзүүлэх.</li> </ul>
Тайван байдлыг түр алдагдуулах	Газар өмчлөгч, эзэмшигч, зөвшөөрөлгүй оршин суугчид	<ul style="list-style-type: none"> <li>Тайван байдлыг түр хугацаагаар алдагдуулах жишээлбэл, хашаагаа хойшлуулан татах, замын коридорын ойролцоох нутаг дэвсгэрт явагдах барилгын ажил зэрэг нөлөөлөлд өртсөн аж ахуйн нэгжүүдтэй зөвшилцөн тохиролцсоны үндсэн дээр бэлэн мөнгөөр нөхөн төлбөр олгоно.</li> <li>Нөлөөлөлд өртсөн аж ахуйн нэгжүүд нутаг дэвсгэр болон оршин суух байр луу нэвтрэх хүртээмжтэй хэвээр байна.</li> <li>Барилгын гэрээт байгууллагууд ажил дууссаны дараа хашааг авч, газар болон хашааг хэвийн байдалд буцаан оруулна.</li> </ul>

### **Арга 3: Төслийн мэдээллийн товхимолын (ТМТ) агуулга**

ТМТ нь төслийн тухай анхан шатны мэдээлэл өгөх бүрэлдэхүүн хэсэг 1.1 дэх нүүлгэн шилжүүлэлт хийгдэх тухай англи монгол хэлээр гарна. Мэдээлэл нь ойлгоход хялбар олон нийтэд зориулсан хэлээр бэлтгэгдэнэ. Товхимол нь наад зах нь (i) НШТ-ний нооргийг нээлттэй мэдээлэх, (ii) НШТ-ний эцсийн хувилбарыг нийтлэх, (iii) төслийн эцсийн хяналт шинжилгээний үр дүнг мэдээлэх зорилгоор шинэчлэгдэн гарна.

Мэдээллийн товхимол нь шаардлагатай бол төслийн ажлын хэрэгжүүлэлтийн явцын тухай замын хэвийн хүртээмж болон замын ажилла

апугаа, мөн нисэх буудлын замыг хязгаарласан тухай олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор өөр хугацааны интервалд гарна.

Нүүлгэн шилжүүлэлт төлөвлөх шатанд ТМТ нь дараах агуулгыг багтаасан байна:

- Нийт төслийн тодорхойлолт, НШТ-д хамаарах бүрэлдэхүүнүүд
- Төслийн үндэслэл, гарах үр дүн, ач холбогдол
- Байгаль орчин, нийгэм болон эдийн засгийн таамагласан эерэг, сөрөг нөлөөллийн тодорхойлолт
- Сөрөг нөлөөлөлд нөхөн төлбөр олгох тухай баталгаа
- Шалгуурт нийцэх үзүүлэлт – нүүлгэн шилжүүлэх шаардлагатай хүмүүс ба нөлөөлөл
- Эрхийг хязгаарлах эцсийн хугацаа
- Нөлөөлөл хэмээн зөвшөөрөх нөхцөл түүний төрлийн тухай тодорхойлолт
- Санал болгож буй хэлэлцүүлгийн үйл явцын тодорхойлолт
- Нөлөөлөлд өртөх хүн гэж бүртгүүлэх тухай мэдээлэл
- Зорилтот бүлгийн төлөвлөсөн уулзалтын тухай мэдээлэл
- Санал болгож буй дараагийн үйл явцын үзүүлэлт
- Санал болгож буй гомдол барагдуулах системийн тодорхойлолт
- Газрын зураг болон бусад үзүүлэн материал боломжийн хэрээр ашиглах

Дараагийн товхимолуудын агуулгад эхний хэлэлцүүлэг, НШТ-ний эцсийн хувилбар, гомдол, хянан магадлагааны үйл явц нөлөөлнө.

### **Арга 4. Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний агуулга**

- Төслийн тодорхойлолт
- Нүүлгэн шилжүүлэх зорилтууд
- Тооллого, судалгаа болон нийгэм эдийн засгийн үзүүлэлтийн суурь судалгаа
- Хууль эрх зүйн хүрээ
- Холбогдох байгууллагуудын хүрээ, шаардлага хангах байдал
- Хохиролыг үнэлэх болон нөхөн төлбөр
- Хэрэгжүүлэх хуваарь
- Зардал ба төсөв
- Гомдол барагдуулах механизм
- Хянан магадлагаа ба үнэлгээ

## ХАВСРАЛТ 4: ХӨДӨЛМӨРИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЖУРАМ

Эдгээр Хөдөлмөрийн менежментийн журамд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, ДБ-ны Байгаль орчин, нийгмийн стандарт 2-ын (БОНС2) нөхцлүүд, МУ-ын Зам, тээврийн сүлжээ ба логистикийг сайжруулах төслийн (P174806) бүрэлдэхүүн хэсгүүдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой эрсдэл, бэрхшээлийг төсөл хэрэгжүүлэх явцад хэрхэн зохицуулах талаар тусгасан болно.

### Төсөлд ажиллах хүчнийг хэрхэн ашиглах тухай тойм

Төсөл нь 4 бүрэлдэхүүнтэй:

Бүрэлдэхүүн 1: Дэд бүтцийн хөрөнгө оруулалт

Бүрэлдэхүүн 2: Тээвэр ба логистикийн үйлчилгээ

Бүрэлдэхүүн 3: Мэргэжлийн туслалцаа ба чадавхыг бэхжүүлэх

Бүрэлдэхүүн 4: Болзошгүй осолд авах хариу арга хэмжээний бүрэлдэхүүн (БОХАХБ)

Төслийн үйл ажиллагаанд дөрвөн төрлийн ажиллах хүчнийг ажиллуулна, тэдгээрт: (i) *шууд ажиллагсад* – зээлдэгчийн ажилтнууд, үүнд Төслийн удирдлагын албаны (ТУА) ажилтнууд буюу ЗТХЯ-ны системд болон удирдлагад ажилладаг хүмүүс болон төслийн зураг төсөл болон эрсдлийн удирдлагад туслалцаа үзүүлэх гэрээгээр ажилладаг зөвлөхүүд; (ii) *гэрээт ажилчид* гуравдагч этгээдийн удирдлагад ажилладаг барилгын компаний удирдлага дор замын тохижилт, засвар үйлчилгээ ба логистикийн зангилаа барих барилгын ажилчид, болон компаниудад ажилладаг олон төрлийн техникийн мэргэжилтнүүд; (iii) төслийн үйл ажиллагаанд оролцдог байж болох орон нутгийн ажилчид болно. Дор төслийн турш ажиллах ажилтнуудын төрөл, тоог дэлгэрэнгүй харуулав.

Бүрэлдэхүүн 1-д, төслийн удирдлагад ажилладаг 10 хүртэлх тооны шууд ажиллагсад болон гуравдагч тал болох барилгын компаниудаас 50-100 гэрээт ажилчид зам тохижилт, засвар үйлчилгээ, сүүлийн бээрийн замын холболтын, хэрэв түүхий эд материалын эх үүсвэрийг тусдаа компани хийж байвал анхан шатны нийлүүлэлтийн 20 ажилчин, сүүлийн бээрийн замын холболтонд 40 хүртэлх орон нутгийн ажилчдын бүрэлдэхүүн дээр тулгуурлан ажиллана.

Бүрэлдэхүүн 2, 3-т үндэсний логистикийн үйлчилгээ, системийг боловсронгуй болгох, тээвэр, логистикийн үйлчилгээг сайжруулах үндэс суурийг тавих зорилготой. Бүрэлдэхүүн 2-т малчид, операторууд, логистикийн компаниудыг зах зээлд илүү сайн холбогдоход туслах нийлүүлэлтийн сүлжээний платформыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх болно. Түүнчлэн мал аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг хөнгөвчлөх гэрээт логистикийн үйлчилгээг хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх шинэлэг, туршилтын төслүүдийг дэмжиж, холбогдох байгууллагуудад зохицуулалтын дэмжлэг үзүүлнэ. Бүрэлдэхүүн 3-ын үйл ажиллагааны хүрээнд нь зах зээлийн үнэлгээ, логистикийн төвүүдийг хөгжүүлэхийн тулд хувийн хэвшилтэй зөвлөлдөх, экспортын логистикийн стратегийн судалгаа зэрэг шаардлагатай бэлтгэл ажлыг хийнэ. Энэхүү бүрэлдэхүүн хэсэгт түүнчлэн, ЗТХЯ-ны төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чадавхыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Эдгээр бүрэлдэхүүн хэсгүүд нь бүс нутагт суурьшдаг олон улсын болон үндэсний техникийн мэргэжилтнүүдэд (бие даасан зөвлөхүүд) (гэрээт ажилчид) голчлон тулгуурлана. Төсөл хэрэгжих хугацааны туршид бүрэлдэхүүн тус бүрд дээр ажиллах Гэрээт ажилчдын тоо одоогоор тодорхойгүй бөгөөд нэг удаа ажиллах техникийн мэргэжилтний тоо 5-20 хүний хооронд хэлбэлзэнэ.

### Төслийн ажилчдын тоо ба шинж чанар.

#### 1. Шууд ажилчид:

Шууд ажилчид – Зээлдэгч ажилд авсан (төсөл санаачлагч болон төсөл хэрэгжүүлэгч агентлагууд багтана) төсөлд тусгайлан ажиллуулахаар ажилд авсан эсхүл ажилд орсон хүмүүсийг хэлнэ.

Энэхүү төсөлд зээлдэгч нь СЯ-ны удирдамжийн дагуу Төслийн Удирдлагын Алба (РМО)-д ажилтнуудыг авна. ТУА-ны шууд ажиллагсад нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсээс бүрдэх бөгөөд ЗТХЯ-наас төсөлд бүтэн цагаар ажиллахаар томилогдоно. Эдгээр ажиллагсад нь төрийн байгууллагуудын холбогдох хэлтсүүдийн удирдлага дор байх ба тэдгээртэй хөдөлмөрийн харилцаатай байна. ТУА-ны захирлыг ЗТХЯ-наас томилно. ТУА нь зөвхөн МУЗТХЛМТ-ийг зохицуулах зорилготой зохицуулагч, мэргэжилтэн, зөвлөхүүдтэй байна. Бүх ажиллагсад 18-аас дээш настай байна. Мэргэжлийн туслалцааны үед зөвлөх, талбайн баталгаажуулагч, хянан шалгагч, сургагч багш болон бусад хүмүүсийг ажилд авах шаардлагатай байж болно. Нөхцөл байдлаас шалтгаалан тэдгээр хүмүүсийг “төслийн ажилчид” гэж үзэж болно.

## **2. Гэрээт ажиллагсад:**

Гэрээт ажиллагсад – гэдэг нь төслийн үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор байршил харгалзахгүй үүрэг гүйцэтгэхээр гуравдагч этгээдээр дамжуулан ажилд орсон болон ажил гүйцэтгэх хүмүүсийг хэлнэ. Гуравдагч талуудад гэрээт, туслан гүйцэтгэх гэрээт, брокер, агент эсхүл зуучлагчид багтана. “Үндсэн үйл ажиллагаа” гэдэг нь тухайн төсөлд зайлшгүй шаардлагатай уг үйл ажиллагаагүйгээр төслийн үйл ажиллагаа явагдах боломжгүй үйлдвэрлэл болон/эсхүл үйлчилгээний процесс болно. Энэхүү төсөлд гэрээт ажилчдыг дараах байдлаар тодорхойлсон:

Ойролцоогоор 50-100 барилгын ажилчид холбогдох бүрэлдэхүүнүүдэд шаардлагатай тооцооллын баримжаа гарсан. Гэрээт ажиллагсдыг уралдаант шалгаруулалтаар сонгон шалгаруулна. Барилгын ажлыг гүйцэтгүүлэхэд олон улсын өрсөлдөөнт шалгаруулалт явуулахаар тооцоолсон бөгөөд орон нутгийн хувийн хэвшлийн чадвар, туршлагыг харгалзах болно. Иймээс барилгын ажил эхлэхээс өмнөх болон барилгын эхэн үед 1 ба 3 дахь бүрэлдэхүүн хэсгүүдэд цөөн тооны олон улсын техникийн мэргэжилтэн, ажилтнууд ажиллах болно. Уралдаант шалгаруулалтын үйл явцад шалгаруулалтанд оролцогсдын хөдөлмөрийн менежментийн системийг нягталж үзэх замаар барилгын ажилчдын менежментийг хангах шаардлагатай байдаг. Барилгын багт ерөнхий инженерээр 2 жил ажилласан туршлагатай, тухайн чиглэлээр мэргэшсэн, тусгай зөвшөөрөлтэй байх, хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтэн нь ХАБЭА-н гэрчилгээтэй, ХАБЭА-н ажилтнаар 2 жил ажилласан байх ёстой. Түүнчлэн тогтвор суурьшилтай ажилладаг, мэргэшсэн болохыг нь нотлох сүүлийн 6 сарын Нийгмийн даатгал төлсөн хуулбарыг өгөх ёстой.

ТУА нь Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-аас зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөл эзэмшдэг байгаль орчны зөвлөх агентлагийн эрэгтэй, эмэгтэй ажиллагсдыг ажиллуулна. Энэхүү бүс нутагт суудаг олон улсын болон үндэсний мэргэшсэн мэргэжилтнүүдэд (бие даасан зөвлөхүүд) ихээхэн тулгуурлах болно. Эдгээрт мэргэжлийн туслалцаа үзүүлэх байгаль орчин, нийгэм, санхүү, худалдан авах ажиллагааны мэргэжилтнүүд орох бөгөөд ажиллах хүмүүсийн тоо тодорхойгүй боловч нэг удаад 5-10 ажилчин/мэргэшсэн мэргэжилтэн байх төлөвтэй. Төслийн хугацаанд тодорхой бүрэлдэхүүн хэсгүүдэд гэрээгээр ажиллах Гэрээт ажиллагсдын тоо одоогоор тодорхой бус байгаа бөгөөд нэг удаа 5-10 ажилтаны хооронд хэлбэлзэх магадлалтай.

## **3. Үндсэн нийлүүлэлтийн ажиллагсад**

Үндсэн нийлүүлэлтийн ажиллагсад – зээлдэгчийн үндсэн нийлүүлэлтийг гүйцэтгэхээр ажилд орсон хүмүүсийг хэлнэ. “Үндсэн нийлүүлэгчид” гэдэг нь төслийн үндсэн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа, материалыг төсөлд шууд, байнга нийлүүлдэг нийлүүлэгчид болно. Үндсэн

нийлүүлэлтийн ажиллагсдын тоо одоогоор тодорхойгүй бөгөөд 10-20 ажилчин/мэргэшсэн мэргэжилтэн байж магадлалтай.

## **Гарч болзошгүй хөдөлмөрийн эрсдэлийн үнэлгээ**

### **Төслийн үйл ажиллагаа**

#### Шууд ажиллагсад

ТУА-ны ажилтнууд төслийн удирдлага, зохицуулалт, бараа, ажил, үйлчилгээний худалдан авалт, гэрээний менежмент, төлбөр гүйцэтгэсэн байдал, төслийн аудит зэрэг санхүүгийн менежмент, олон нийттэй харилцах, Дэлхийн банкны шаардлагад нийцүүлэн байгаль орчин, нийгмийн хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх, тогтмол гардаг тайлан бэлтгэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ (ХШҮ) болон тэдгээрийг Дэлхийн банкинд хүргүүлэх, гомдол барагдуулах механизмыг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Шууд ажилчдад учирч болзошгүй хөдөлмөрийн эрсдэл бага гэж тооцогддог боловч зарим эрсдэл бий, тухайлбал: (i) ажлын цаг баримтлахгүй байх; (ii) ажилд авах, ажилд авахад ялгаварлан гадуурхах, үндэсний хууль тогтоомжийг зөрчиж эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг ижил ажилд авахдаа ижил цалин олгохгүй байх магадлалтай.

#### Гэрээт ажиллагсад

Төслийн мэргэжлийн туслалцааны асуудалд ажиллах ажиллагсад нь техникийн санал, түүнчлэн Төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, эрсдлийн судалгаа, үнэлгээ хийнэ. Мэргэжлийн туслалцаа нь Төслийн хэрэгжилтэд мэргэжлийн заавар өгөх зорилготой бөгөөд хяналт шинжилгээний ажилтнууд Төсөлд хяналт, удирдлагын үйлчилгээ үзүүлнэ.

Барилгын ажилчид барилгын талбай дээр Төслийн барилгын ажлыг гүйцэтгэнэ. Төслийн барилгын мэргэшсэн багууд нь ерөнхий инженер, цахилгааны инженер, ХАБЭА-н мэргэжилтэн, техникч, барилгын ажилчдаас бүрдэх бөгөөд ойролцоогоор 50-100 хүний бүрэлдэхүүнтэй байна. Мансууруулах бодис, согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох, холбогдох хууль, тогтоомжийг чанд мөрдөж ажиллахын чухлыг онцлон тэмдэглэсэн ажлын байрны төвлөрсөн удирдлага, ёс зүйн дүрмийг боловсронгуй болгож хэрэгжүүлэх шаардлагатай.

Барилгын нэгжүүд холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдөж ажиллахгүй, хөдөлмөрийн гэрээ байгуулахгүй бол барилгын ажилчдын эрх ашгийг хамгаалах баталгаа, цалинг цаг тухайд нь олгохгүй байх магадлалтай. Үйл ажиллагаа явагдаж байх үед барилгын ажлын хаалттай талбайд болон тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийх явцад механик гэмтэл, осол гарч болзошгүй.

Тиймээс гэрээт ажиллагсдад дараах эрсдэл гарч болно:

- Албан ёсны гэрээ байхгүй
- Ажлын цаг мөрдөхгүй байх
- Хүүхдийн болон албадан хөдөлмөр эрхлүүлэх тухай үндэсний хөдөлмөрийн хууль зөрчих
- Ижил ажилд эрэгтэй эмэгтэй хүмүүс ажиллуулахдаа ижил цалин олгохгүй байх
- Хөдөлмөр эрхлэх, ажилд авахдаа ялгаварлан гадуурхахгүй байх тухай үндэсний хуулийг зөрчих
- Хөдөлмөрийн ГБМ байхгүй байх
- Хөдөлмөрийн ГБМ-ын тухай ойлголт, мэдлэггүй байх
- Хөдөлмөрийн ГБМ үйлчилдэггүй байх
- ХАБЭА-н арга хэмжээг зохистой авч хэрэгжүүлээгүйгээр ноцтой осол эсвэл гэмтэл гарах.
- Хүйсээр ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх, мэдлэг ойлголт байхгүй байх
- КОВИД 19 холбоотой асуудлууд

- ХАБЭА мэргэшсэн, зөвшөөрөл бүхий ажилтан ажлын талбайд тогтмол ажиллахгүй байх.

### Хөдөлмөрийн хууль тогтоомжийн тойм

2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэслэн Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль (2021 он), Үйлдвэрчний эвлэлийн тухай хууль (1991 он), Жендэрийн тэгш байдлыг дэмжих тухай хууль (2011 он), Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2015 онд шинэчлэн найруулсан), Засгийн газраас баталсан холбогдох журмууд, гурван талт гэрээнүүд Монгол Улсын хөдөлмөр эрхлэгчдийн хууль ёсны эрх ашиг болон сонирхолыг хамгаалах зорилгоор хүчин төгөлдөр үйлчилдэг.

Хөдөлмөрийн тухай хуульд заасан хөдөлмөрийн нөхцөл, эрхийг тоймлон доор харуулав.

<b>Хөдөлмөр эрхлэх насны доод хязгаар</b>	Аюултай бус ажил эрхлэх насны доод хязгаар 15 нас байна. Аюултай ажил эрхлэх насны доод хязгаар 18 нас байна.
<b>Албадан хөдөлмөрөөс хамгаалах</b>	Хэнийг ч хууль бусаар албадан ажиллуулж болохгүй.
<b>Ялгаварлан гадуурхалаас хамгаалж, тэгш харьцах, тэгш боломж олгох эрх</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Үндэс угсаа, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, гэр бүлийн байдал, хэл, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үйлдвэрчний эвлэлийн гишүүнчлэл, эрүүл мэндийн байдал, жирэмслэлт, төрөлт, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, гадаад төрх байдал, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхах, хязгаарлах, давуу эрх олгохыг хориглосон.</li> <li>• Ажил олгогч нь иргэнийг ажилд авахдаа гүйцэтгэх ажил, үүргийн онцлог, хувийн амьдрал, хувийн үзэл бодол, гэр бүлийн байдал, улс төрийн намын гишүүнчлэл, шашны итгэл үнэмшил, эрүүл мэндийн байдал, жирэмслэлт эсхүл ажил үүргийн онцлогтой холбоогүй асуулт асуухыг хориглоно.</li> </ul>
<b>Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, хамтын хэлэлцээр хийх эрх (ҮЭ-ийн тухай хуульд заасан)</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Иргэд хөдөлмөрлөх, үйл ажиллагаа явуулах, дүрмийг батлах, төлөөлөгч сонгох, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах эрхээ ямар ч ялгаварлан гадуурхахгүйгээр зөвхөн сайн дурын үндсэн дээр урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр үйлдвэрчны эвлэлд нэгдэх эрхтэй.</li> <li>• Үйлдвэрчний эвлэл нь удирдлага, ажил олгогчтой зөвшилцөх, хамтын болон бусад гэрээ төрлийн байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, хөдөлмөрийн маргаан таслах байгууллагад гишүүдийнхээ эрх ашгийг төлөөлөх үндсэн эрхтэй.</li> </ul>

Монгол Улсад Хөдөлмөрийн тухай хууль (2021 он)-ийн 142.1-т аюулгүй нөхцөлд ажиллах хөдөлмөрийн насны доод хязгаарыг 15 нас гэж заадаг хэдий ч 18 нас хүртэл эрүүл мэндийн үзлэгт хамрагдах, хүнд ачаа өргөхийг хориглох, насанд хүрээгүй хүнийг шөнийн цагаар ажиллуулах зэргийг хориглодог. Төслийн ажлын онцлогийг харгалзан зөвхөн 18 ба түүнээс дээш насны иргэдийг төсөлд ажиллуулна. Насны баталгаажилтыг ажил олгогч хийх ба хөдөлмөрийн гэрээг байгуулах иргэний үнэмлэхийг шалгаж насыг тогтооно.



## **Цалин, тэтгэмж**

1. Цалингийн хуваарилалт нь гүйцэтгэлд үндэслэсэн ба ижил ажилд ижил хэмжээний цалин олгох зарчмыг баримтална. Цалингийн түвшин нь эдийн засгийн өсөлтийг даган аажим нэмэгдэнэ. Засгийн газар нийт цалинд макро эдийн засгийн зохицуулалтыг хийж хяналт тавина.
2. 2020 оны 1 сараас эхлэн Монгол улсын цалингийн доод хэмжээг сард 420,000 төгрөг байхаар тогтоосон. Ажил олгогчоос ажилагсдад төлөх цалингийн доод хэмжээ нь 420,000 төгрөгөөс доошгүй байна.
3. Ажиллагсдад төлөх цалин нь тухайн хүнд сар бүр мөнгөн хэлбэрээр олгох ба суутгал хийх болон үндэслэлгүй өр төлөх ёсгүй.
4. Ажил олгогч нь хууль ёсны баяр ёслол, гэрлэх ёслол болон оршуулгын чөлөө авсан, хууль ёсны үйл ажиллагаанд оролцсон тохиолдолд хуулийн дагуу ажиллагсдад цалин төлнө.

## **Ажлын амралтын цаг ба баяр ёслол**

1. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 5-р зүйлд дагуу ажлын цаг нь өдөрт 8, долоо хоногт 40-өөс илүүгүй цаг ажиллах ба дараалсан хоёр ажлын өдрийн тасалдалгүй амралтын хугацаа 12 цагаас багагүй байна.
2. Ажил олгогч нь төрөөс тогтоосон ажлын цагийн системийн дагуу хөдөлмөрийн хувь хэмжээ болон төлбөрийн хэмжээг үндэслэлтэй тогтооно.
3. Ажил олгогч нь хуулийн дагуу Наадам (7 дугаар сарын 11, 12, 13-нд) Эх үрсийн баярын өдөр (6 дугаар сарын 1-нд) болон бусад хууль ёсны баярын өдрүүдэд ажиллагсдыг амраана.
4. Ажилтан нь ажлын болон үйлдвэрлэлийн онцлог байдлаас шалтгаалан Бямба, Ням гарагуудад амраагүй бол Монгол Улсын Хөдөлмөрийн хуульд (5 дугаар зүйл, 77 дугаар хэсэг) заасны дагуу дараачийн хоёр өдөр дараалан амарна.

## **Тэгш эрх**

1. Ажилтан нь үндэс угсаа, арьс өнгө, хүйс, эсхүл шүтлэг бишрэлээс болж ялгаварлагдахгүйгээр ажилд орно.
2. Хамтын гэрээ, хэлэлцээрт эрэгтэй, эмэгтэй хүмүүс мэргэжлийн болон гэр бүлийн үүргээ хослуулан гүйцэтгэх, хүүхэд төрүүлэх, асрах, эрүүл мэндийг нь сахих, хөдөлмөрийн аюулгүй байдал, ижил хөдөлмөрт ижил хөлс, урамшуулал авах, хөдөлмөрийн тэгш нөхцөлийг эдлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх зохицуулалтыг тусгана.
3. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд хүйсээр ялгаварлан гадуурхахыг хориглоно. Түүнчлэн Монгол Улс соёрхон баталсан олон улсын гэрээ болон холбогдох бусад хуульд өөрөөр заагаагүй бол ажилтныг хүйс, жирэмслэлт, хүүхэд асран хүмүүжүүлэх үүрэг, гэр бүлийн байдлыг харгалзан давуу эрх олгох, хязгаарлах, ажлаас халахыг хориглоно.
4. Албадлагаар ямар нэгэн хөдөлмөр эрхлүүлэхийг хориглоно.

5. Ажил олгогч нь хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөдөлмөрийн харилцаанд хүйсээр ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх, ажлын байран дахь хүйсийн тэгш байдлыг хангах дараахь үүрэг хүлээнэ:
  - 5.1 Хүйсийн тэгш байдлыг хангахад чиглэгдсэн үйл ажиллагааг төлөвлөгөө болон/эсхүл хөтөлбөрийн үндсэн дээр хэрэгжүүлж, хэрэгжүүлэлт ба үр дүнг ажиллагсаддаа тайлагнана;
  - 5.2 Хүйсийн тэгш байдлыг хангах тухай хуульд (энэ хуулийн 6.5, 7 дугаар зүйл) зааснаас бусад тохиолдолд ажлын байрны зар/сурталчилгаанд аль нэг хүйсийг илүүд үзэх эсхүл шууд заахыг хориглоно;
  - 5.3 Тухайн байгууллага эсхүл хэсгийн хүйсийн тэнцүү байдлыг хангахын тулд дутуу байгаа хүйсийн хүнийг ажилд авна;
  - 5.4 Адил хөдөлмөр эрхэлж, хөдөлмөрийн тэгш нөхцөлтэй байх хуулийн зохицуулалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авна;
  - 5.5 Эрэгтэй, эмэгтэй ажиллагсдын албан тушаал ахих, мэргэжил дээшлүүлэх, давтан сургах, үр чадварыг дээшлүүлэх, цалин хөлсийг нэмэгдүүлэх ажлыг хүний нөөцийн жагсаалтад үндэслэн хэрэгжүүлэх;
  - 5.6 Бүх ажиллагсад ажлын сул орон тоо болон мэргэжил дээшлүүлэх сургалт, давтан сурах боломжийн талаар шуурхай мэдээлэх;
  - 5.7 Бүтцийн өөрчлөлтийн улмаас ажилчдын гуравны нэгээс илүү нь нэг удаа халах шаардлагатай бол үйлчилгээ үзүүлэх ажлын хугацаанаас үл хамааран халагдах бүлгийн хүйсийн харьцаа нийт ажиллах хүчнийхтэй шууд пропорциональ байх нөхцлийг хангах шаардлагатай;
6. Ажил олгогч нь байгууллага татан буугдсан, Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 40.1.4, 40.1.5-д зааснаас бусад тохиолдолд жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх настай хүүхэдтэй эхийг ажлаас халахыг хориглоно.
7. Ажлын байрыг бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, бэлгийн дарамтаас ангид байлгах болон бэлгийн дарамтыг үл тэвчих зорилгоор ажил олгогч дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:
  - 7.1 Ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гомдлыг барагдуулах тодорхой хэм хэмжээг байгууллагын дотоод журамд тусгах;
  - 7.2 Бэлгийн дарамтаас ангид ажиллах орчинг бүрдүүлэхэд чиглэсэн сургалт, давтан сургах хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх, түүний үр дүнг ил тод тайлагнах.
8. Иргэнийг ажилд авахдаа хөдөлмөрийн харилцааны явцад ажил, үүргийн онцлог, шаардлагын улмаас ажил олгогч нь ажилтны эрх, эрх чөлөөг хязгаарласан бол ажилтан нь түүний тийнхүү хязгаарласан үндэслэлийг нотлох үүрэгтэй.
9. Иргэнийг ажилд авахдаа гүйцэтгэх ажил, үүргийн онцлогтой холбоогүй бол хувийн амьдрал, үзэл бодол, гэр бүлийн байдал, улс төрийн намын гишүүнчлэл, шашны итгэл үнэмшил, жирэмсэн эсэхийг асуухыг хориглоно.

### **Хөдөлмөрийн гэрээ**

1. Хөдөлмөрийн гэрээнд дараахь суурь нөхцлүүд байхаар зөвшөөрсөн байна:
  - а. Нэр эсхүл албан тушаал эсхүл эрхлэх ажил;

- b. Хөдөлмөрийн гэрээний нөхцөл;
  - c. Үндсэн цалингийн хэмжээ эсхүл албан тушаалын цалингийн хэмжээ;
  - d. Ажиллах нөхцөл.
2. Талууд өмнөх хэсэгт заасан шаардлагатай заалтаас гадна бусад зүйлийг тохиролцож болно.
  3. Хөдөлмөрийн гэрээ нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
  4. Хөдөлмөрийн гэрээ нь хугацаатай эсхүл хугацаатай байна.
  5. Хөдөлмөрийн гэрээний хугацааг тухайн ажил болон гүйцэтгэх үүргийн онцлогоос хамааран талууд тохирно.
  6. Хөдөлмөрийн гэрээний хугацаа дууссан бөгөөд талууд гэрээг цуцлах тухай санал гаргаагүй, ажилтан ажлаа үргэлжлүүлж байгаа бол уг хөдөлмөрийн гэрээг хөдөлмөрийн гэрээнд анх заасан хугацаагаар сунгасанд тооцно.
  7. Ажил олгогч нь ажилтантай хөдөлмөрийн гэрээг бичгээр үйлдэн байгуулж, гэрээний яг ижил хувийг ажилтанд өгнө.  
Байнгын ажлын байранд ажилд авсан тухай гэрээнээс өөр гэрээ байгуулахыг хориглоно.
  8. Ажил олгогч нь хэрэв нэг ажлын байранд хэд хэдэн ажилтан ажиллуулах бол ажилтан тус бүртэй хөдөлмөрийн гэрээ байгуулна.
  9. Ажил олгогч нь хөдөлмөрийн гэрээг бичгээр үйлдэн байгуулаагүй бол ажилтаныг ажил, үүргээ гүйцэтгэхийг шаардах эрхгүй.
  10. Урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдал үүссэний улмаас гамшгийн эрсдэл, үр дагаврыг бууруулах зайлшгүй шаардлагатай бол ажил олгогч нь ажилтныг хөдөлмөрийн гэрээнд заагаагүй өөр ажлын байранд 45 хүртэл хоногийн хугацаагаар шилжүүлж болно.
  11. Ажилтан нь хөдөлмөрийн үүргээ биелүүлээгүй дараах тохиолдолд ажил, албан тушаалаа хэвээр хадгална:
    - a. Ажилтан нь ажилд томилогдоод үүргээ гүйцэтгэж эхлээд 3 сар болоогүй бол;
    - b. Ажилтан нь хуулийн ёсны амралттай байгаа бол;
    - c. Ажилтан нь эмнэлгийн үзлэг хийлгэж байгаа эсхүл хандивлагчдын ажил үүргийг гүйцэтгэж байгаа, эсхүл захиргаанаас зөвшөөрөлтэй чөлөөтэй, эсхүл эмчийн заалттай бол;
    - d. Ажилтан нь жирэмсний эсхүл хүүхдээ асрах чөлөөтэй бол;
    - e. Ажилтан нь хамтын гэрээнд орхоор ярилцаж, гэрээ хэлэлцээрт нэгдэх эсхүл хуулийн дагуу ажил хаялтанд оролцох явцад байгаа бол;
    - f. Цэрэгт татагдах шийдвэр гарсан ажилтаныг цэргийн албанд татсан тухай цэргийн зарлан дуудах комиссын шийдвэр гарах хүртэл;
    - g. Хууль, хамтын болон хөдөлмөрийн гэрээнд зааснаас бусад нөхцөлд.
    - h. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу хамгаалалтын арга хэмжээнд хамрагдсан.
  12. Дараахь үндэслэлээр хөдөлмөрийн гэрээ цуцлагдана:
    - a. Талууд харилцан зөвшөөрөлцсөн бол;

- b. Ажил олгогч эсхүл ажилтан иргэн нь нас барсан бол;
- c. Хөдөлмөрийн гэрээний хугацаа дууссан болон гэрээг сунгахгүй байхаар шийдвэрлэсэн бол;
- d. Хуулийн дагуу эрх бүхий байгууллага шаардсан бол;
- e. Үндэслэлгүйгээр халагдсан ажилтаныг өмнөх ажил эсхүл үүрэгт нь буцаан оруулсан бол;
- f. Ажилтан нь цэргийн албанд татагдсан бол;
- g. Гэмт хэргийн улмаас ажилтаныг хөдөлмөрийн үүргээ биелүүлэхийг хориглосон шүүхийн шийдвэр гарч хүчин төгөлдөр болсон бол;
- h. Хөдөлмөрийн гэрээг ажил олгогч эсхүл ажилтан дуусгавар болгохоор санаачлага гаргасан бол зэрэг болно.

### 13. Ажлаас халах ба шилжүүлэх

- a. Ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцлахдаа ажил олгогч нь шинэ ажилтанд үүргийг шилжүүлэх хугацааг тогтоож, ажлаас халах тухай шийдвэрт энэ хугацааг тусгана.
- b. Ажилтан ажлаа шилжүүлсэн сүүлийн өдрөөс эхлэн ажлаас халагдсанд тооцно.
- c. Ажил олгогч нь ажлаас халагдсан ажилтанд ажлаас халагдсан тухай шийдвэр, нийгмийн даатгалын дэвтэр, хуульд заасан бол ажлаас халагдсан өдөр ажлаас халагдсаны тэтгэмж олгох үүрэгтэй.
- d. Ажил олгогч нь ажилтны хүсэлтээр ажил, мэргэжил, мэргэшил, албан тушаал, цалин хөлсний тухай тодорхойлолт гаргах үүрэгтэй.

### **Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал**

#### **Хөдөлмөрийн хууль тогтоомжийн тойм**

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2015 оны шинэчилсэн найруулга) нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар төрөөс баримтлах бодлого, зарчмыг тодорхойлж, удирдлага, хяналтын системийн харилцааг зохицуулдаг.

#### **1. Өргөх, хүргэх ба тээвэрлэх машин механизмд тавигдах шаардлага**

- a. Өргөх, хүргэх ба тээвэрлэх машин механизм нь техникийн шаардлагуудыг хангасан байна.
- b. Өргөх, хүргэх ба тээвэрлэх машин механизмууд нь мэргэжлийн байгууллагаас олгосон гэрчилгээ, ашиглах зөвшөөрөлтэй байна.
- c. Өргөх, хүргэх ба тээвэрлэх машин механизмын засвар үйлчилгээ, засварын ажил болон тохиргоог техникийн баримт бичиг эсхүл туршилтанд тусгайлан заасан цаг хугацааны хүрээнд, тийм төрлийн машин, механизмын тохиргоо болон гэрчилгээжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаас баталсан хугацаанд хийнэ.

#### **2. Даралт бүхий сав болон сувагт тавигдах шаардлага**

- a. Даралттай сав, хоолой болон суваг нь холбогдох зохицуулалтын дагуу туршилт, тохиргоо хийгдэн гэрчилгээ олгогдох бөгөөд техникийн шаардлагуудад нийцсэнээр ашиглахыг зөвшөөрөл олгогдоно;
- b. Даралттай сав, хоолой болон суваг нь ашиглалт, удаан хугацаагаар зогсох, засвар үйлчилгээ хийх ажиллуулах журам, зохицуулалттай байна.

с. Даралттай сав, хоолой болон суваг нь ялгагдах тэмдэглэгээ, лого болон ослоос урьдчилан сэргийлэх дуут дохиолол, хамгаалах хэрэгслээр тоноглогдсон байна.

**3. Хортой, аюултай химийн бодис, тэсрэх дэлбэрэх хэрэгсэл, цацраг идэвхт болон биологийн идэвхт бодист тавигдах шаардлага**

- a. Ажил олгогч нь ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах, химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг идэвхт, биологийн идэвхт бодис, тэдгээрийн нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.
- b. Ажил олгогч нь үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг идэвхт, биологийн идэвхт бодисын бүртгэлийг эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу хөдөлмөрийн хяналтын байгууллага болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагуудад мэдээлнэ.
- c. Химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэрч дэлбэрэх төхөөрөмж, цацраг идэвхт, биологийн идэвхт бодистой харьцаж байгаа этгээд эдгээр бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэдлэг, дадлага эзэмшсэн байна.
- d. Химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэрч дэлбэрэх төхөөрөмж, цацраг идэвхт, биологийн идэвхт бодисыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн ашиглах, худалдаалахад тавих бусад шаардлагыг холбогдох хуулиар зохицуулна.
- e. Химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг идэвхт, биологийн идэвхт бодис ашиглахтай холбоотой осол, цочмог хордлогыг үйлдвэрлэлийн осолд тооцож, мөрдөн байцаалт явуулж бүртгэнэ.

**4. Ажиллагсдыг тусгай хувцас болон хамгаалах хэрэгслээр хангах нөхцөл**

- a. Ажил олгогч нь хөдөлмөрийн нөхцөл болон ажлын байрны онцлогт тохирсон тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг ажиллагсаддаа үнэ төлбөргүй олгоно.
- b. Тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг турших, худалдан авах, хадгалах, цэвэрлэх, засварлах, халдваргүйжүүлэхтэй холбогдсон зардлыг ажил олгогч хариуцна.
- c. Тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн нэр, төрөл, ашиглалтын хугацааг ажил олгогч баталж, бүртгэл хөтөлнө.
- d. Ажил олгогч нь тусгай хувцас, хамгаалах хэрэгслийнхээ чанарын талаар мэргэжлийн байгууллагаас дүгнэлт гаргуулж авна. Тусгай хувцас, хамгаалалтын хэрэгслийг олон улсын стандартын дагуу үйлдвэрлэдэг, чанарын баталгаатай байдаг нь энэ заалтад хамаарахгүй.

**5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон мэргэжлийн сургалт**

- a. Хөдөлмөр эрхэлж буй иргэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн богино хугацааны сургалтанд хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу хамрагдаж мэдлэг чадварыг эзэмшсэн байна.
- b. Өөр ажлын байр луу шилжүүлж буй иргэн ажилтныг сургалтад хамруулна;
- c. Үйлдвэрлэлийн хортой, аюултай нөлөөлөл, түүнтэй адилтгах нөхцөлтэй ажлын байранд ажиллаж байгаа иргэн ажилтанд зориулсан сургалтад хамруулна.

- d. Ажил олгогч нь жилд хоёроос доошгүй удаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй сургалт явуулж шалгалт авна.

**6. Иргэн ажиллагсад нь хөдөлмөрийн таатай нөхцлөөр хангагдах эрх ба үүрэг**

- a. Хөдөлмөр эрхэлж буй иргэн нь дараахь түгээмэл эрхийг эдэлнэ:
  - i. Хөдөлмөрийн аюулгүй байдал болон эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд ажиллах;
  - ii. Үйлдвэрлэлийн осол болон ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалах өвчлөлийг хамарсан эрүүл мэндийн даатгалтай байна;
  - iii. Ажлын байрны нөхцөл, эрүүл мэндэд хор учруулж болзошгүй эрсдэл, үйлдвэрлэлийн хортой болон аюултай хүчин зүйлсийн талаар мэдээлэл авах;
  - iv. Ажил үүргээ гүйцэтгэх явцад хөдөлмөрийн аюулгүй байдлын зохицуулалт зөрчигдсөн эсхүл хүний амь нас болон эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй бол ажлыг зогсоож уг асуудлыг ажил олгогчид мэдэгдэнэ;
  - v. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар хэлэлцүүлэгт биечлэн эсхүл төлөөлүүлэн оролцоно.
- b. Хөдөлмөр эрхэлж буй иргэд нь дараахь түгээмэл үүрэг хүлээнэ:
  - i. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт, хууль эрх зүйн зохицуулалт, технологийг дагаж мөрдөх;
  - ii. Хууль болон аюулгүй ажиллагааны зааварчлага дэх нөхцлийн дагуу аюулгүй ажиллагаа болон эрүүл ахуйн сургалтан хамрагдаж шалгалт өгнө;
  - iii. Ажил гүйцэтгэх явцад хүний амь нас, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд аюулгүй ажиллагааны дүрэм, журамд заасан арга хэмжээг шуурхай авах.
  - iv. Эрүүл мэндээ хамгаалах зорилгоор эмнэлгийн үзлэгт хамрагдах.
  - v. Тусгай хувцас болон хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу ашиглах.
  - vi. Ажил үүргээ эрсдэлгүй, осолгүй гүйцэтгэх аргачлал, арга зүй, мэргэжлийн ур чадвар эзэмшиж осол, гэмтэл, хурц хордлого, ослоос урьдчилан сэргийлэх, аюул, ослын үед эмнэлгийн анхны тусламж үзүүлэх ур чадварыг эзэмшинэ.
  - vii. Өөртөө болон бусдад аюул учруулахгүй, тийм эрсдэл үүсгэхгүй байх.
  - viii. Хууль, холбогдох зохицуулалтын дагуу, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаарх ажил олгогчийн тогтоосон шаардлагад нийцэж ажил үүргээ гүйцэтгэнэ.

**Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын арга хэмжээ**

ТУА болон Үнэлгээний хороод нь хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг удирдах, зохицуулах чадвартай гэрээт гүйцэтгэгчийг сонгон авч ажиллуулна. Түүнчлэн ТУА нь хор хөнөөл учруулж болзошгүй аюулыг тодорхойлох, ажилчдад учирч болзошгүй эрсдлийг үнэлэх, хохирол, хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх болон хяналт тавих замаар ажлын байран дахь эрсдэлийг хянах арга хэмжээг авч, холбогдох арга хэмжээг авна.

Монгол Улсын ХАБЭА-н тухай хууль тогтоомжийн дагуу инженер техникийн ажилтнууд 2 жилд нэгээс доошгүй удаа шалгалт өгдөг. Иймээс гэрээт байгууллагын ХАБЭА-н ажилтнууд ХАБЭА-н мэргэжилтнээр 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай байна. Түүнчлэн ТУА нь ажиллагсад болон гэрээт байгууллагуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг тогтмол зохион байгуулна. ХАБЭА-н талаар танилцуулга өглөө бүр хийх шаардлагатай бөгөөд тэнд ажилтан бүр ХАБЭА-н талаар мэдээлэл авсанаа гарын үсэг зурж баталгаажуулна. Хэрэв гарын үсэг зураагүй бол ажлаа эхлэхийг хориглоно. Ажлын бүлгүүд бүгд ижил журмыг баримтлах ба бусад гэрээт гүйцэтгэгчээр ажиллах байгууллага мөн мөрдөж ажиллана.

ТУА нь ослын үед авах арга хэмжээний талаар гаднаас яаралтай тусламж авах төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлнэ. Үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор үйлдвэрийн болон барилгын талбайд ажиллагсдыг хамгаалалтын малгай, ган хошуутай гутал, хамгаалалтын хувцас зэрэг ажлын тусгай хувцасаар хангана. Мөн ариун цэврийн байгууламж, хувцас солих өрөө, сүү, сүүн бүтээгдэхүүн, витаминээр хангана. ТУА нь ажиллагсад, гэрээт ажиллагсад болон бусад холбогдох талуудтай идэвхтэй уулзаж, санал хүсэлтийг нь авах замаар аюулгүй байдлын баталгаатай суурийг байнга бэхжүүлнэ.

Цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй байдлын дүрмийн дагуу бүх цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмжийг суурилуулж, хамгаалалттай байлгана. Кемп байгуулах, зам барилгын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа (ус, ариутгах татуурга, зайлуулах) асуудал

Төсөл хэрэгжиж буй газар нутаг дахь аюултай хэсэг болон хүн амын нягтаршил ихтэй хэсэгт анхааруулах тэмдгийг харагдахуйц газарт байрлуулна. Барилгын ажлын явцад үйл ажиллагаа явагдаж байх үед ажиллагсдын аюулгүй байдлыг хангах холбогдох арга хэмжээг авна. Төслийн үйл ажиллагааны бүхий л явцад анхны тусламж үзүүлэх хэрэгсэл үүнд эм, гал унтраах хэрэгсэл, цэвэр усаар хангана.

### Хөдөлмөрийн хариуцлага ба үүрэг

Зам, тээврийн хөгжлийн яам, ТУА болон хэрэгжүүлэгч агентлагууд нь төсөлд үр дүнтэй оролцох, төслийг удирдах нөхцлийг бүрдүүлэх, төслийн үйл ажиллагааг үр дүнтэй явуулахын тулд дараах үүргийг хэрэгжүүлнэ.

Үүрэг хариуцлага	Шууд ажиллагсад	Гэрээт ажиллагсад
Гэрээт болон туслан гүйцэтгэгчдийн удирдлага	ТУА (Төслийн зохицуулагч)	ТУА
Удирдлагын ажиллагсад	ЗТХЯ	Гэрээт ажиллагсад (талбайн менежер)
ХАБЭА	ТУА	Гэрээт ажиллагсад (үүнд туслан гүйцэтгэгчидтэй зохицуулалт хийх)
Сургалт	ЗТХЯ	ТУА, Гэрээт байгууллагууд
Давж заалдах	ЗТХЯ	ТУА
Хяналт шинжилгээ	ЗТХЯ	ТУА

### Гүйцэтгэгч байгууллагын удирдлага

Гүйцэтгэгч нь эдгээр журмыг мөрдөнө:

1) Барилгын ажлын явцад гүйцэтгэгчийн ХАБЭА-н мэргэжилтэн нь хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын зохицуулалт зэрэг хөдөлмөрийн удирдлагын журмыг хэрэгжүүлнэ. ХАБЭА-н ажилтанд тавигдах шаардлагыг тендерийн баримт бичиг, гэрээний баримт бичигт тусгана.

2) Үйл ажиллагаа эхлэхээс өмнө гүйцэтгэгч нь төслийн хэрэгжилтийн явцыг ТУА-нд тайлагнах үүрэгтэй тусгай ажилтнуудыг томилно.

3) Туслан гүйцэтгэгчийн гэрээ байгуулан ажиллах тохиолдолд ерөнхий гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэгчдийн зохицуулалтыг хариуцаж, аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчныг хамгаалах ажлыг ерөнхий гүйцэтгэгчийн төслийн менежер хариуцах боломжийг хангаж хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ; дотоод хяналтыг тайлагнах, хяналтын механизмыг хөдөлмөрийн харилцааны удирдлагын шаардлагад нийцэхээр бүрдүүлнэ.

4) Төслийн барилга болон үйл ажиллагаа эхлэхээс өмнө зохистой зан үйлийг мөрдөх, мансууруулах бодис, согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох, холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх ёс зүйн дүрмийг боловсруулсан байна. Ажилтан бүр хөдөлмөр эрхлэх бүхий л хугацаандаа Ёс зүйн дүрмийг ойлгож, дагаж мөрдөх ёстой. Ёс зүйн дүрмийг олон нийтийн газар нийтэд хялбар хүртээмжтэй байхуйц газар ил тод байрлуулна. Ёс зүйн дүрэмд дараахь арга хэмжээг багтаасан (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй) байна:

- Бүх ажиллагсад болон гүйцэтгэгчид нь Монгол Улсын хууль, журмыг дагаж мөрдөнө.
- Төслийн талбайд хууль бус эд зүйлс, зэвсэг болон галт зэвсэг, бусад аюултай эд зүйлсийг хадгалах, хэрэглэхийг хориглоно.
- Хэрүүл маргаан эсхүл зодоон хийхийг хориглоно.
- Мөрийтэй тоглоомыг хориглоно.
- Ажлын цагаар хар тамхи эсхүл мансууруулах бодис болон бусад төстэй үйлдэл гаргахыг хориглоно.
- Зэрлэг ан амьтан агнахыг хориглоно.
- Тэжээвэр амьтан байлгахгүй.
- Хөршүүдийн амгалан тайван байдлыг алдагдуулж болохгүй.
- ХАБЭА-н стандартыг мөрдөж хамгаалах малгай болон дүрэмт хувцас өмсөнө.
- Ажлын байран дээрх дотоод болон гадаадын бүх хүмүүст хүндэтгэлтэй харьцаж, ажлын харилцаатай эрэгтэй, эмэгтэй болон бусад албан тушаалын хамт олон, тэр дундаа нутгийн иргэдийг гүтгэсэн, доромжилсонн үг хэллэгээс зайлсхийх.
- Ажлын цаг, чөлөөний мэдэгдэл, халагдахтай холбоотой компаний дүрмийг дагаж мөрдөх.
- Хамтран ажиллагсад болон эргэн тойрон дахь нутгийн иргэд, эрэгтэй, эмэгтэйгээр ялгаварлан гадуурхах, дарамтлахаас татгалзах.
- Компанийн ХАБЭА-н дүрмийг дагаж мөрдөх.

Компаниас "зохисгүй үйлдэл" хэмээн тодорхойлсон болон бодлого журам ба анхааруулга, мэдэгдлийн тайлбарлаж өгсөн байна.

Гүйцэтгэгч нь ажиллагсаддаа Бэлгийн замын халдварт өвчин (БЗХӨ), ажлын байрны бэлгийн дарамт (АББД), бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл (БМХ), жендерт суурилсан хүчирхийлэл (ЖСХ), КОВИД 19 болон төслийн Ажлын байрны Ёс Зүйн талаар зааварчилгаа өгөх үүрэгтэй бөгөөд ГБМ-ын талаар танилцуулга хийлгэнэ.

ТУА болон төслийн гүйцэтгэгч нь төслийн хэрэгжилтийн явцад өдөр тутам хяналт, шалгалт хийж, төслийн явц, хөдөлмөрийн удирдлагын хэрэгжилтийн нөхцөл байдал, сургалтын хэрэгжилт,



хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын мэдээ, дүгнэлтийг бүртгэн төсөл эзэмшигчид болон ТУА-д цаг тухайд нь хүргүүлнэ.

### Шууд ажиллагсад

Шууд ажиллагсад нь төрийн холбогдох байгууллагуудын удирдлагын дор хөдөлмөрийн харилцаатай байх ба төслийн зохицуулалт, хяналтын удирдлагын үйл ажиллагаанд голчлон оролцоно.

### Хөдөлмөрийн гомдол барагдуулах

Төсөлд олон нийтийн гомдлыг барагдуулах журам байдаг ч Дэлхийн банкны БОНС2-ын дагуу хөдөлмөр эрхлэлттэй холбоотой гомдлын ГБМ шаардлагатай. Иймээс бүх шууд ажиллагсад болон гүйцэтгэгчдэд (болон тэдгээрийн байгууллага) ажлын байртай холбоотой санаа зовниж буй асуудлыг илэрхийлэх гомдол барагдуулах механизмтай байна. Иймд ажиллагсдыг ажилд авах үед гомдол гаргах механизм болон түүнийг ашиглах, аливаа хэлмэгдүүлэлтээс хамгаалах арга хэмжээ байдаг талаар мэдээлнэ. Гомдол барагдуулах механизмыг төслийн бүх ажилчдад хялбар хүртээмжтэй болгох арга хэмжээ авна.

Гомдол барагдуулах механизм нь хууль тогтоомж эсвэл хүчин төгөлдөр үйлчилж буй арбитрын журам, бусад шүүх, захиргааны арга хэрэгслийг ашиглахад саад учруулахгүй, эсхүл хамтын гэрээнд заасан гомдол барагдуулах механизмыг орлохгүй.

Төсөлтэй холбоотой хөдөлмөрийн гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэхийн тулд дараах гомдол барагдуулах журам бий болгосон. ГБМ хүчин төгөлдөр болсноос хойш болон барилгын ажил эхлэхээс өмнө үйлчилнэ. Төслийн аливаа ажилтан ГБМ-д имэйл, утсаар эсвэл бичгээр гомдлоо гаргаж болно. Ажиллагсдад зориулсан ГБМ түүний тусгайлсан имэйл хаягийг ажиллагсдыг албан тушаалд томилогдох үед өргөнөөр сурталчилна.

- **Ажиллагсдын гомдлыг барагдуулах хороо (ГБХ):** гишүүдэд: (i) БОАЖЯ, (ii) Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам; (iii) барилгын үндсэн гүйцэтгэгчийн төлөөлөгч, (iv) ТУА-ны гомдол хариуцсан ажилтан; (v) ажиллагсдын төлөөлөл/үйлдвэрчний эвлэл, (vi) ЗТХЯ-ны төлөөлөгч орно. Ажиллагсдын ГБМ-д ирүүлсэн гомдлыг ажлын 7 хоногийн дотор хянана.

Хэрэгжүүлэгч байгууллага нь өргөдөл гомдлын бүртгэх хуудас, гомдлын бүртгэлийг хөтлөх үүрэгтэй. Мөн гомдол гаргагчид маягт бөглөхөд нь тусална. Түүнчлэн хариу гарах боломжтой хугацааны талаар гомдол гаргагчид мэдэгдэх үүрэгтэй.

ГБХ нь ялангуяа барилгын ажлын явцад шаардлагатай үед хуралдаж, шаардлагатай бол гомдол гаргагчийн өргөдөлийг хянах ба шийдвэрлэхэд зуучилна. Дээр дурьдсан ГБХ-ны механизм нь Аоролцогч талууд (ажилтан, ажил олгогч) ажилтай холбоотой гомдлыг эвлэрүүлэн зуучлах замаар шийдвэрлэх зарчим дээр суурилан боловсруулагдсан болно. Гэвч ГБХ амжилттай шийдвэрлэж чадаагүй тохиолдолд талуудыг доорх хүснэгтэд заасны дагуу гомдлоо барагдуулахын тулд эрх зүйн зохицуулалтын хүрээгээр шийдвэрлүүлэх боломжтой.

Ажиллагсдад зориулсан ГБХ нь үндэсний хөдөлмөрийн хууль, дүрэм журам, Дэлхийн банкны БОНХ (БОНС2 болох хөдөлмөр ба хөдөлмөрийн нөхцөл), хөдөлмөрийн менежменттэй холбоотой (тэтгэмж, ажлын байр болон бусад эрхийн) талаарх сургалтад хамрагдсан байна.

*Хүснэгт 20. Хөдөлмөрийн гомдол барагдуулах хүчин төгөлдөр үйлчилж буй зохицуулалт*

Сэдэв	Зохицуулалт	Гомдол барагдуулах
-------	-------------	--------------------

Хүйсээр ялгаварлан гадуурхах	Жендэрийн тэгш байдлыг хангах тухай Монгол Улсын хууль (2011)	Төрийн албаны зөвлөл нь төрийн албаны хүрээнд жендэрийн ялгаварлан гадуурхалтын талаарх гомдлыг шийдвэрлэхэд хяналт тавьдаг (21 дүгээр зүйл)  23 дугаар зүйл, Энэ хуулийн 14 дүгээр зүйлээс бусад заалт зөрчсөн аливаа үйлдэл нь Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисст гомдол гаргах үндэслэл болно
Буруу халах, нөхөн төлбөр, гэрээ, шийтгэл	Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль (1999), Зүйл 128	Хөдөлмөрийн харилцааны маргааныг шүүхээр шийдвэрлэнэ.
Бусад бүх хөдөлмөрийн маргаан	Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль (1999), Зүйл 126	Хөдөлмөрийн маргаан таслах комисс нь 1999 оны Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу шүүхээр шийдвэрлээгүй хуулийн бусад бүх асуудлыг хамардаг (Зүйл 126)

## ХАВСРАЛТ 5: ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

### 1. Танилцуулга

Талуудын оролцоог хангах төлөвлөгөөг Монгол Улсын Зам, тээврийн холболт ба ложистикийг сайжруулах төсөл (цаашид "төсөл" гэх)-д зориулж 2021 оны 7 дугаар сард боловсруулсан баримт бичиг юм. Энэ баримт бичгийг Зам, тээврийн хөгжлийн яам (ЗТХЯ)-ны цахим хуудаснаас үзэх боломжтой.

Дэлхийн банкнаас (цаашид "Банк" гэх) энэхүү төслийг санхүүжүүлэхээр Монгол Улсын Сангийн яаманд Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны 100 сая ам.доллар, Олон Улсын хөгжлийн ассоциацийн 10 сая.ам долларын зээлийн санхүүжилт олгох саналыг тавьсан. Хэрэгжүүлэгч агентлаг нь Зам, тээврийн хөгжлийн яам. Зам, тээврийн хөгжлийн төв, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Үндэсний хөгжлийн газар болон Сангийн яам нь Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын удирдлага дор харилцан уялдаатай ажиллахаар зохицуулна.

Энэхүү ТОХТ-ийг төслийн оролцогч талуудтай<sup>25</sup> харилцан тохиролцож, урьдчилсан судалгаа хийсний үндсэн дээр боловсруулсан ба төсөл хэрэгжих хугацаанд төслийн оролцох талууд, мэдээлэл түгээх болон зөвлөлдөх аргууд, ба гомдол барагдуулах аргыг тодорхойлдог.

Дэлхийн банкны БОНХ-нд заасны дагуу талуудын оролцоог хангах гол зорилго буюу Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн стандарт (БОНС) 10<sup>26</sup> нь:

- Оролцогч талуудыг тодорхойлох, ялангуяа Төслийн нөлөөлөлд өртсөн талуудтай бүтээлч харилцааг хадгалах ба тогтоох, талуудын оролцоонд системтэй хандлагыг бий болгох;
- Төслийн оролцогч талуудын сонирхол, дэмжлэгийн түвшинг үнэлж, Төслийн зураг төсөл, байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлд оролцогч талуудын саналыг тусгах боломжийг олгох;
- Төслийн нөлөөлөлд өртсөн талуудтай төслийн үргэлжлэх мөчлөгийн туршид тэдэнд нөлөөлж болзошгүй асуудлаар үр дүнтэй, хүртээмжтэй хамтын ажиллагааг дэмжих, хангах;
- Байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн талаархи төслийн зохих мэдээллийг оролцогч талуудад цаг тухайд нь ойлгомжтой, хүртээмжтэй, зохих хэлбэрээр ил тод болгох;
- Төслийн нөлөөлөлд өртсөн талуудыг асуудал, гомдол гаргах хүртээмжтэй хэрэгслээр хангах, төсөл хэрэгжүүлэгчид эдгээр гомдолд хариу өгөх, зохицуулах боломжийг олгох.

Дэлхийн Банкнаас төсөлд зориулж санхүүжилтийг олгохыг санал болгож байгаа ба 2018 оны 10-р сарын 1-ээс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн хүрээний (БОНХ) шаардлагуудыг хангахын тулд байгаль орчин, нийгмийн үнэлгээ болон төлөвлөлтийн бусад баримт бичгүүд шаардагддаг. Төслийн үнэлгээнд дараахь зүйлс орно:

- Байгаль орчин, нийгмийн менежментийн хүрээ. (БОНМХ, төслийн бүх бүрэлдэхүүн хэсэг) БОНМХ нь байгаль орчин, нийгмийн үнэлгээний шаардлага, зохицуулалтыг баталгаажуулсны дараа менежмент болон нөлөөллийг бууруулах арга хэмжээг боловсруулахад чиглүүлнэ.
- Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ, төслийн бүх бүрэлдэхүүн хэсэг). Үнэлгээнээс өмнө бэлтгэсэн болон үнэлгээний дараа боловсруулсан бүрэлдэхүүн хэсгүүдийг багтаасан бүх төсөлд бүхэлд нь зориулан бэлтгэсэн энэ баримт бичиг нь дийлэнх оролцогч талуудад ижил төстэй

<sup>25</sup> "Оролцогч тал/Талууд" гэдэг нь: (а) Төслийн нөлөөлөлд өртсөн эсвэл өртөх магадлалтай (төслийн нөлөөлөлд өртсөн талууд); ба (б) Төсөлд сонирхолтой байж болох (бусад сонирхогч талууд).

<sup>26</sup> Хэрэгжилтийг дэмжих, тайлагнах үйл ажиллагааны (ХДТҮА) байгаль орчин, нийгмийн хүрээ. БОНС 10: Талуудын оролцоо ба мэдээллийн ил тод байдал, 2018 он.

байх ба зөвлөлдөх үйл ажиллагаанд чиглэсэн арга барилыг төслийн хэмжээнд бүхэлд нь хангана.

- Замын гол хэсгүүдийн засвар, шинэчлэлт болон орон нутгийн чухал ач холбогдолтой 51 км замыг сйажруулах Байгаль орчин нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ, 1.1 ба 1.2 дэд хэсэг) нь энэхүү бүрэлдэхүүн хэсгийн нөлөөллийг бууруулах, менежментийн арга хэмжээг тусгана.
- Хөдөлмөрийн харилцааг зохицуулах журам (ХХЗЖ, төслийн бүх бүрэлдэхүүн хэсэг) хөдөлмөрийн гомдлыг барагдуулах механизмыг багтаасан энэхүү баримт бичиг нь төсөлд тавигдах хөдөлмөрийн шаардлагыг тодорхойлно.
- Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын хүрээ (НШБХ, 1.1 ба 1.2 дэд хэсэг). НШБХ нь төслийн үнэлгээ, нөхөн олговрын шаардлагуудыг удирдан чиглүүлдэг бөгөөд үүнийг дээр дурдсан БОНМХ-ний хавсралтад оруулно.
- Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө (НШТ, 1.1 ба 1.2 дэд хэсэг). Газар чөлөөлөх эсвэл орлогын эх үүсвэрт нэвтрэх эрхийг хязгаарлах тохиолдолд зайлшгүй Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөө (НШҮАТ)-г бэлтгэдэг. НШҮАТ-нүүд нь төслийн дараа хийгдэх үйл явц, нөхөн олговрыг тоймлон харуулна.

Дэлхийн Банкны БОНХ-нд Байгаль орчин, нийгмийн стандарт (БОНС) 10, "Талуудын оролцоо ба мэдээллийн ил тод байдал" багтсан бөгөөд энэ нь "Зээлдэгч болон төслийн оролцогч талуудын хоорондын нээлттэй, ил тод оролцооны ач холбогдлыг олон улсын сайн туршлагын чухал хэсэг" гэж хүлээн зөвшөөрдөг. Зээлдэгч нь төслийн шинж чанар, цар хүрээ, түүний болзошгүй эрсдэл, нөлөөлөлтэй пропорциональ талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ) боловсруулах шаардлагатай (Зүйл 13). Төслийг Дэлхийн банкнаас үнэлэхээс өмнө оролцогч талуудыг тодорхойлж, ТОХТ-г аль болох эрт олон нийтэд дэлгэж, санал асуулгыг нь авна. БОНС 10 нь гомдол барагдуулах механизм (ГБМ) боловсруулж хэрэгжүүлэхийг шаарддаг. Үндэсний зохицуулалтын шаардлага, түүнчлэн БОНХ-ны дагуу тавигдах шаардлагуудыг энд тусгасан.

Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн стандарт (БОНС) 10-аас гадна талуудын оролцоотой холбоотой зохицуулалтад үндэсний хэмжээнд тавигдах шаардлагууд байдаг. Зөвлөлдөх, нийтэд ил тод болгоход тавигдах Монгол Улсын зохицуулалтын шаардлагыг мөн энд авч үзнэ. Хот байгуулалтын тухай хууль (2015 оны 17, 18 дугаар зүйл)-д хот төлөвлөлтийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоотой төлөвлөлтийн зарчмыг тусгаж, хот төлөвлөлтийг хэрэгжүүлэхдээ иргэд болон холбогдох мэргэжлийн хүмүүсийн оновчтой саналыг авч хот төлөвлөлтөд тусгана гэж заасан. Хот байгуулалттай холбоотой асуудлын хүрээнд гаргасан аливаа шийдвэрийн талаар тухай бүр олон нийтэд мэдээлнэ. Ашиглалтын үйлчилгээний тасалдлыг оршин суугчид болон аж ахуйн нэгжүүдэд таслахаас 24 цагийн өмнө мэдээлэх шаардлагатай. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012 оны 5, 18 дугаар зүйл)-д дараахь зүйлийг шаарддаг:

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний (БОНБНУ) төлөвлөгөөний талаарх мэдээллийг нийтэд мэдээлэх ба өөрийн цахим хуудсанд байрлуулж танилцах боломжийг бүрдүүлнэ.
- Стратегийн үнэлгээнд олон нийтээс санал ирүүлэх хугацаа нь ажлын 30-аас дээшгүй өдөр байх бөгөөд амаар болон бичгээр санал авна.
- Төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна.

## 2. Төслийн тодорхойлолт

Төслийн хөгжлийн зорилго (ТХЗ) нь Монгол Улсын тээврийн холболтыг сайжруулж, стратегийн ач холбогдолтой гинжин хэлхээний ложистикийн үр ашгийг дээшлүүлж, замын дэд бүтцийн үндсэн хөрөнгийг нийлүүлэх, арчлах, удирдах, Зам, тээврийн хөгжлийн яамны чадавхыг бэхжүүлэхэд оршино. Төсөл нь доор тайлбарласны дагуу дөрвөн бүрэлдэхүүнтэй.

Бүрэлдэхүүн хэсэг	Үйл ажиллагаа
<b>Бүрэлдэхүүн</b> <b>1. Дэд бүтцийн хөрөнгө оруулалт</b>	<ul style="list-style-type: none"> <li>8 аймгийг холбосон стратегийн 2700 км авто замын тэргүүлэх ач холбогдол бүхий засвар үйлчилгээний үр дүнд суурилсан засвар үйлчилгээ (311 км).</li> <li>Орон нутгийн малчдыг улсын чанартай авто замын сүлжээнд холбох “Сүүлийн бээрийн холболтын зам” (~51 км).</li> <li>Замын хөрөнгийн удирдлагын систем ба тогтолцоо.</li> </ul>
<b>Бүрэлдэхүүн</b> <b>2. Тээвэр ба ложистикийн үйлчилгээ</b>	<ul style="list-style-type: none"> <li>Ложистикийн жишиг төв</li> <li>Ложистик, нийлүүлэлтийн гинжин хэлхээний платформ.</li> <li>Нийлүүлэлтийн гинжин хэлхээнд инноваци бий болгох туршилтын төслүүд: <ul style="list-style-type: none"> <li>Хүргэлтийг бодит цаг дээр хянах (Радио давтамжийн тодорхойлох хэрэгсэл, QR-код, Блокчейний үл мөрөөр мөрдөх).</li> <li>Ухаалаг сайн үйлдвэрлэлийн туршлага (СҮТ), агуулах ба автоматжуулалт (бохирдлоос урьдчилан сэргийлэх робот).</li> <li>Ухаалаг ачааны машин, чингэлэг, зөөвөрлөх технологи.</li> </ul> </li> <li>Гэрээт ложистикийн үйлчилгээний дүрэм, стандарт.</li> <li>Хүйтэн хэлхээний агуулахын ложистик.</li> </ul>
<b>Бүрэлдэхүүн</b> <b>3. Техникийн тусламж, чадавхыг бэхжүүлэх</b>	<ul style="list-style-type: none"> <li>Ложистикийн төвүүдийг бэлтгэх ажил</li> <li>Стратегийн судалгаа, мастер төлөвлөгөө.</li> <li>Чадавхыг бэхжүүлэх, сургалт.</li> </ul>
<b>Бүрэлдэхүүн</b> <b>4. Болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг (БОБУАХАБХ)</b>	<p>Энэхүү тэг долларын бүрэлдэхүүн хэсэг нь хямрал эсвэл онцгой байдлын үед шуурхай хариу арга хэмжээ авах зорилготой бөгөөд шаардлагатай үед яаралтай тусламжийн хариу арга хэмжээ авах, сэргээн босголтод дэмжлэг үзүүлэх төслийн санхүүжилтийг Дэлхийн банкнаас дахин хуваарилах хүсэлтийг үйлчлүүлэгчид өгөх боломжийг олгодог.</p>

Төслийн нарийвчилсан тайлбарыг энэхүү БОНМХ-ны Бүлэг 1-ээс харна уу.

### 3. Талуудын өмнөх оролцооны товч хураангуй

2021 оны 6-р сарын 30-ны өдрийн байдлаар Дэлхийн Банкны групп (ДБГ)-ээс үнэлгээ өгөхөөс өмнө төслийг бэлтгэх явцад хийсэн хянан шалгалт, уулзалтын жагсаалтыг дараагийн хүснэгтэд нэгтгэн харуулав.

Оролцогч тал	Сэдэв	Хугацаа	Саналуудын хураангуй
Гүйцэтгэгч/ Хэрэгжүүлэгч агентлаг - ЗТХЯ болон замыг хөгжүүлэх холбогдох байгууллагууд	Төслийн ерөнхий үзэл баримтлал, БОНХ болон холбогдох хэрэгслүүдийн шаардлага. БОНМХ болон БОНМТ төсөл боловсруулах оролцоо	2021 оны 03-р сараас 06-р сар хүртэл	Зам, тээврийн хөгжлийн яамны холбогдох албан тушаалтнуудад тогтмол мэдээлэл өгч байсан. Сонгогдсон эсвэл тухайлсан замын байршил, ашигтай бүсүүдийн талаар холбогдох судалгаа, нөөцийн талаар мэдээллийг солилцсон.
Үндэсний болон орон нутгийн төрийн бус байгууллагууд	Төслийн ерөнхий үзэл баримтлал, Байгаль орчин,	2021 оны 06 дугаар сарын 18- ны Баасан гараг	Төслийн ерөнхий үр дүн, замын зураг төсөл ба байгаль орчны нөлөө: • Ерөнхийдөө оролцогчид

<p>(бэлчээрийн менежментийн баг, замд хяналт тавих орон нутгийн ТББ-ын төлөөлөгчид, малчдын хоршоод, төслөөс ашиг хүртэх боломжтой сумд, орон нутгийн байгаль хамгаалагчид, судлаачид, бизнес эрхэлдэг эмэгтэйчүүдийн холбоо, эмэгтэйчүүдийн тэргүүлдаг хувийн хэвшлийн төлөөлөл) болон хөгжлийн түншүүд</p>	<p>нийгмийн эрсдэл ба нөлөөлөл</p>	<p>8 оролцогчтой цахим уулзалт</p>	<p>төлөвлөсөн ажил нь хүлээгдэж буй үр дүнг бий болгох эерэг хөгжүүлэлтийн үр дүнг бий болгоно гэж найдаж байна. Зам засварын болон сүүлийн бээрийн холболтын замыг сонгох шалгуур, түүнчлэн логистиктой холбоотой асуудлуудаас суралцах сонирхолтой байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Говь, тал хээр, мөнх цэвдэгтэй газруудад тохирсон ялгаатай зураг төслийг гаргах ёстой. Учир нь өмнө нь орон нутгийн замын ажил хийхдээ цаг уур, байгаль орчны болзошгүй эрсдлийг үнэлж, тооцоолдоггүй байна.</li> <li>• Зураг төсөл, барилга угсралтын болон засварын ажлын үед орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудын (ИНБ) замд тавих хяналт зайлшгүй чухал бөгөөд хөндлөнгийн гуравдагч талын хяналтыг хийх сонирхолтой байдаг. Дэлхийн банкны буцалтгүй тусламжаар 2013 оны Хөвсгөлд хийгдсэн кейс.</li> <li>• Хатуу хучилттай замд хурдны хязгаарлалт байнга зөрчигдөж, мал амьтад байнга ихээр хорогдож байгаа тул экологийн гарцыг барих шаардлагатай байна.</li> </ul> <p><b>Эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлт чадавхитай холбоотой асуудлууд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Эмэгтэйчүүдийн бизнест ихэвчлэн мэдээлэл, итгэл үнэмшил, сүлжээ холбоо дутмаг байдаг нь тэднийг худалдан авах ажиллагаанаас хасагдахад хүргэдэг. Тэдний хувьд боломж бага, эрэгтэйчүүд давамгайлсан салбар гэж тэд хардаг.</li> <li>• Бизнесийн удирдагч эмэгтэйчүүд махны үйлдвэрлэлийн стандартыг хэрхэн хангаж, ЕХ, Арабын зах зээлд нэвтрэх талаар мэдлэг, мэдээлэл дутмаг байдаг.</li> <li>• Эмэгтэйчүүдийн оролцоог хангах, чадавхыг бэхжүүлэх сургалтын хөтөлбөрүүд, зорилтот үйл ажиллагаануудыг төслийн үйл ажиллагаанд оруулах шаардлагатай.</li> <li>• Жендэрт суурилсан зөрчлийн (ЖСЗ) талаарх ерөнхий санаа зовоосон асуудал их, ажлын байран дахь ЖСЗ өндөр байна.</li> <li>• Ковид 19-ийн нөлөө жижиг дунд</li> </ul>
--	------------------------------------	------------------------------------	--

			<p>үйлдвэр, албан бус бизнесүүдэд сөргөөр нөлөөлсөн.</p> <ul style="list-style-type: none"> <li>Эмэгтэйчүүд тэргүүлсэн бизнесүүдийн хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.</li> </ul>
<p><b>Үндэсний агентлаг, ашиг хүртэгч 8 аймгийн нутгийн захиргааны байгууллагууд</b> (байгаль орчин, дархан цаазат газар, газар зохион байгуулалт, соёлын өв, хөгжил төлөвлөлтийн асуудал эрхэлсэн аймгийн захиргааны албан тушаалтнуудыг оруулна) <b>болон зам засвар арчлалтын төрийн өмчит компаниуд</b></p>	<p>Төслийн ерөнхий үзэл баримтлал, Байгаль орчин, нийгмийн эрсдэл ба нөлөөлөл</p>	<p><b>2021 оны 06 дугаар сарын 21-ний Даваа гараг</b> 30 оролцогчтой цахим уулзалт</p>	<p><b>Замын зураг төсөл ба тэргүүлэх чиглэл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Эдгээр шинэ замын зураг төсөл нь аливаа эвдрэлээс зайлсхийхийн тулд уул уурхай болон бусад хүнд даацын үйл ажиллагааг харгалзан үзэх ёстой.</li> <li>Барилгын ажлын явцад түр зам тавих шаардлагатай. Тоосжилт ихсэх тул зам талбайг хангалттай услах шаардлагатай.</li> <li>Зохион байгуулсан уулзалт зэрэг мэдээлэл сайтай уулзалтыг өндрөөр үнэлж, ийм ил тод, хүртээмжтэй уулзалтуудыг зохион байгуулж оролцох, шаардлагатай бол орон нутгийн мэдээлэл, статистик мэдээллээр хангах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн.</li> <li>Орон нутгийн аялал жуулчлал болон бусад үйл ажиллагааг дэмжих зам дээр сум сонгон шалгаруулахад орон нутгийн тэргүүлэх чиглэлүүдийг харгалзан үзнэ. Тодруулбал, Архангай аймаг морин аялалынхаа түүхээр нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд Чулуут сумыг аялал жуулчлалын чиглэлээр нэн тэргүүнд тавьж аймгийн ИТХ-аар батлуулжээ. Эрдэнэмандал сум махны үйлдвэрлэлийг туршилтаар явуулах боломжтой. Увс аймгийн хувьд Сагил, Түргэнээс бусад сумдын замыг анхаарч үзэх хэрэгтэй.</li> <li>Орон нутгийн гүүр, ус зайлуулах байгууламжийг засах шаардлагатай. Боломжтой бол их засвар хийж, үерийн болон ус зайлуулах хоолойг шинээр байрлуулах шаардлагатай.</li> <li>Орон нутгийн сумдын зам ашиглалтын хувь хэмжээ бага байгаа тул одоогийн зам засвар, арчлалтын ажлыг нэн тэргүүнд хийх ёстой.</li> </ul> <p><b>Байгаль орчинд үзүүлэх нөлөө:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Экологийн цагдаагийн албаны мэдээллийг шалгахдаа амьтдын ослын талаарх зарим статистикийг харж болно. Олон улсын стандарт</li> </ul>

			<p>болон орон нутгийн хууль тогтоомжид нийцсэн экологид болон амьтанд ээлтэй замуудыг тодорхой байршилд барих шаардлагатай.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Архангай аймгийн Булган сум зэрэг тодорхой байршилд модны хулгай ихсэх магадлалтай.</li> <li>• Замын нийтлэг материалыг олборлохын тулд малчид бэлчээр нутгаа өгөхөөс татгалзаж, маргаан үүсч магадлалтай.</li> </ul> <p><b>Талуудын оролцоо:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Аймгийн удирдлагууд, тэр дундаа Зам засвар арчлалтын компаниуд, болон Үндэсний хөгжлийн газар (ҮХГ) зэрэг байгууллагууд тэргүүлэх ач холбогдол өгөх, зураг төсөл боловсруулах, шинэ зам төлөвлөлтөд оролцох сонирхолтой байна.</li> <li>• Ковид 19-ийн хязгаарлалт тавигдахаар авто замын чиглэлийг сонгох, төслийн зураг төсөл боловсруулах талбайд очиж үзэхийг зөвлөж байна.</li> </ul>
--	--	--	--

#### 4. Оролцогч талуудыг тодорхойлох, дүн шинжилгээ хийх

Талуудын оролцоог хангах үйл ажиллагаа нь төслийн нийт хугацаанд явагддаг үйл явц бөгөөд энэ нь төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг амжилттай удирдахад чухал ач холбогдолтой бат бөх, бүтээлч, хариу үйлдэл үзүүлэх харилцааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой юм. Оролцогч талуудын оролцоог хангах үйл ажиллагааг төсөл боловсруулах үйл явцын эхний үе шатанд хэрэгжүүлэхэд хамгийн үр дүнтэй. Энэ нь төслийн эхэн үеийн шийдвэр, төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн үнэлгээ, удирдлага, мониторингийн салшгүй хэсэг юм.

Төслийг боловсруулах явцад оролцогч талуудтай хамтран ажиллах, хэлэлцээр хийхэд ихэвчлэн тухайн оролцогч талуудын бүлгийг төлөөлөх хууль ёсны төлөөлөгчийг шаарддаг. Тухайлбал, төсөлтэй хамтран ажиллах явцад бүлгийн ашиг сонирхлыг хамгаалах үүрэг хүлээсэн хүмүүс гэх мэт. Нутгийн иргэдийн төлөөлөгчид орон нутгийн нөхцөл байдлын талаар ашиг тустай ойлголтыг өгч, төсөлтэй холбоотой мэдээллийг түгээх гол суваг болж, төслийн зорилтот иргэд болон тэдгээрийн үүсгэн байгуулсан сүлжээнүүдийн хоорондын харилцаа холбооны үндсэн холбоос болж өгдөг. Оролцогч талуудын төлөөлөгчдийг баталгаажуулах (өөрөөр хэлбэл, тэдний төлөөлж буй нийгэмлэгийн хууль ёсны бөгөөд жинхэнэ төлөөлөгч мөн гэдгийг батлах) нь нутгийн иргэдийн оролцоотой оролцогч талуудтай холбоо тогтооход зайлшгүй шаардлагатай ажил хэвээр байна. Нутгийн иргэдийн төлөөлөгчдийг хууль ёсны эсэхийг баталгаажуулахын тулд нутгийн иргэдээс санамсаргүй байдлаар сонгон албан бусаар ярилцаж, тэдний ашиг сонирхлыг хамгийн үр дүнтэйгээр хэрхэн төлөөлөх талаар тэдний санал бодлыг анхаарч үзэх явдал юм. Коронавирус цар тахлын (Ковид-19 улмаас нутгийн иргэдийг цуглуулахад хязгаарлалт тавьсан эсхүл бүр хориглосон тул оролцогч талуудыг тодорхойлох ажил илүү хувь хүний үндсэн дээр явагдах бөгөөд нөлөөлөлд өртсөн хүмүүст янз бүрийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүрэх шаардлагатай болно гэсэн үг юм.



Оролцогч тал	Төсөлд гүйцэтгэх үүрэг	Сонирхол	Нөлөөлөл
Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яам (ЗТХЯ)	Гүйцэтгэгч, хэрэгжүүлэгч агентлаг: Техникийн зураг төсөл, зөвшөөрөл, төслийн удирдах хорооны гишүүн	Их	Их
Байгаль орчин, аялал жуулчлалын яам/Хот, аймгийн Байгаль орчны хэлтэс	БОАЖЯ нь байгаль орчны зөвшөөрөл олгох бөгөөд өөрийн үзэмжээр хяналт, шалгалт тавьж болно.	Дунд	Дунд
Сангийн яам (СЯ)	Монгол Улсын Сангийн сайдын 196 дугаар тушаал “Гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын биелэлтийг шалгах/мөрдөх	Дунд	Их
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)	Төсөл боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохицуулах	Их	Их
Үндэсний хөгжлийн агентлаг	Төсөл боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохицуулах	Их	Дунд
8 Аймгийн удирдлагууд, Аймгийн ЗДТГ, түүний харьяа агентлагууд	Төслийн хэрэгжилтэд оролцох	Их	Бага
Зам, тээврийн хөгжлийн төв	Төслийн хэрэгжилтэд оролцох	Их	Бага
Тээврийн цагдаагийн алба	Төслийн хэрэгжилтэд оролцох	Дунд	Бага
Аймаг, сумын газар зохион байгуулалтын алба	Газар өмчлөлийн бичиг баримт, газрын гэрчилгээ, газар ашиглах гэрээ, кадастрын зураг зэрэг бүрдүүлэлтийг газар зохион байгуулалтын алба, харьяа дүүргийн хэлтэс олгоно.	Дунд	Дунд
Нийслэл, аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Барилга угсралтын ажилд үе шатлалтай хяналт шалгалт хийх	Дунд	Их
Төслийн удирдах хороо	Монгол Улсын ЗГХЭГ тэргүүлдэг бөгөөд ЗТХЯ, ХХААХҮЯ, СЯ, ҮХГ, орон нутгийн засаг захиргаа, холбогдох байгууллагуудын төлөөллөөс бүрддэг. Монгол Улсын Засгийн газрын “Гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх” 196 дугаар журмын дагуу Төслийг хэрэгжүүлэх ерөнхий удирдамжаар хангах	Их	Их
Төслийн удирдлагын газар	Төслийн хэрэгжилтийг удирдан чиглүүлэх	Их	Их
Гүйцэтгэгч/Концесс эзэмшигч	Төслийн түншүүд	Их	Их
	Төслийн хэрэгжилтэд оролцох		
Зөвлөх	Төслийн түншүүд	Дунд	Дунд

	Төслийн хэрэгжилтэд оролцох		
Орон нутгийн судалгааны хүрээлэнгүүд	Боломжит төслийн хамтрагчид	Дунд	Бага
	Төслийн хэрэгжилтэд оролцох		
ТББ ба ашиг сонирхлын бүлгүүд	Боломжит төслийн хамтрагчид	Их	Дунд
	Төслийн хэрэгжилтэд оролцох		
Төсөлд өртсөн төрийн байгууллагууд	Төслийн хэрэгжилтэд оролцох	Их/Нөлөөлөлд өртсөн	Бага
Төслийн нөлөөлөлд өртсөн хувийн хэвшлийн байгууллагууд	Төслийн хэрэгжилтэд оролцох	Их/Нөлөөлөлд өртсөн	Бага
Төслийн нөлөөлөлд өртсөн оршин суугчид	Төслийн хэрэгжилтэд оролцох	Их/Нөлөөлөлд өртсөн	Бага
Төслийн нөлөөлөлд өртсөн эмзэг бүлэг (үндэсний цөөнхийн бүлэг байж болно)	Төслийн хэрэгжилтэд оролцох	Их/Нөлөөлөлд өртсөн	Бага
Хэрэглэгчид (явуулын)	Төслийн хэрэгжилтэд оролцох	Бага/ Нөлөөлөлд өртсөн	Бага

## 5. Аргачлал

Төслийн шилдэг туршлагын арга барилд нийцүүлэх үүднээс талуудын оролцоог хангах үйл ажиллагаандаа дараах зарчмуудыг баримтална:

*Нээлттэй байдал ба төслийн хугацаанд баримтлах арга барил:* Төсөл(үүд)-ийн талаарх олон нийтийн хэлэлцүүлгийг төслийн хугацаанд нээлттэйгээр, гадны нөлөөлөл, хөндлөнгийн оролцоо, албадлага, айлган сүрдүүлгээс ангид зохион байгуулна.

*Мэдээллээр хангагдсан оролцоо, санал хүсэлт:* мэдээллийг бүх оролцогч талуудад зохих хэлбэрээр хүргэж, өргөнөөр түгээнэ; оролцогч талуудын санал хүсэлттэй холбоотой харилцаа холбоо, эдгээр санал хүсэлт, тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийх, шийдвэрлэх боломжоор хангасан байна.


*Хүртээмжтэй, мэдрэмжтэй байдал:* Төсөлд оролцох үйл явц нь хүртээмжтэй буюу нийтийг хамарсан байна. Нэгдүгээрт, ТУГ нь төслийн бүх оролцогч талуудад мэдээллийн хүртээмжтэй байдлыг бүрдүүлж өгнө. Төслийн талуудын оролцооны арга хэлбэрийг сонгох үндсэн зарчим нь талуудын хэрэгцээг мэдрэх юм. ТУГ нь эмзэг бүлэг, ялангуяа өндөр настан, олон үндэстэн ястны бүлгүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулахыг онцлон тэмдэглэнэ.

*Уян хатан байдал:* хэрэв цар тахалтай холбоотой хоорондын зай барих нь оролцооны уламжлалт хэлбэрт хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэж байх нөхцөлд аргачлалыг оролцогч талуудтай харилцахад илүү дөхөм бусад хэлбэрүүд, тэр дундаа утасны дуудлага, интернет харилцааны хэлбэрт зохицуулан өөрчлөнө.

*Талуудын оролцоог хангах олон төрлийн арга хэрэгслүүд байдаг:* Эдгээр аргуудын нэг нь оролцогч талуудын хэрэгцээ шаардлагыг хангахуйц ирээдүйн тогтвортой хувилбаруудыг тодорхойлоход чиглэгдсэн тодорхойлсон ирээдүйн төсөөлөлөө араас нь ургаш хэрэгжүүлэх арга арга юм. (Quist, 2006) Энэ арга <sup>27</sup> нь засгийн газар, хувийн хэвшил, олон нийтийн ашиг сонирхлын бүлгүүд, шинжлэх ухааны

<sup>27</sup> Холмберг Ж (1998) Backcasting: тогтвортой хөгжлийг хэрэгжүүлэх алхам. GreenerManage Int 23:30-51

институц гэх мэт бүлгүүдийн өргөн хүрээний оролцогч талуудыг татан оролцуулах, асуудлыг тодорхойлж, шийдлийг хайх, алсын харааг хөгжүүлэх нэгдсэн арга барил юм.



Диаграмм 3. Back-Casting арга ашигласан оролцогч талуудын оролцооны жишээ

Үр дүнтэй, тохирсон оролцоог хангахын тулд төсөл (үүд)-ийн оролцогч талуудыг дараах үндсэн ангилалд хувааж болно:

**Нөлөөлөлд өртсөн талууд** – Төслийн (бодит эсвэл болзошгүй) шууд нөлөөлөлд өртсөн ба/эсвэл төсөлтэй холбоотой аливаа өөрчлөлтөд хамгийн өртөмтгий гэж тодорхойлсон ба тухайн нөлөөлөл, тэдгээрийн ач холбогдлыг тодорхойлох, нөлөөллийг бууруулах, удирдлагын арга хэмжээний талаар шийдвэр гаргахад нягт оролцох шаардлагатай бүлэг хүмүүс,

**Бусад сонирхогч талууд** – Төслөөс шууд нөлөөлөл үзүүлэхгүй байж болох ч өөрсдийн ашиг сонирхлыг нөлөөлөлд өртсөн гэж үзэж, ойлгож байгаа, төслийг хэрэгжүүлэх үйл явцад ямар нэгэн байдлаар нөлөөлөлд өртөх боломжтой хувь хүн/бүлэг/байгууллага;

**Эмзэг бүлгүүд** – эмзэг байдлын улмаас бусад бүлэгтэй харьцуулахад төслийн нөлөөлөлд пропорциональ бус байдлаар орох, эсвэл улам доройтож болзошгүй бөгөөд төсөлтэй холбоотой зөвлөлдөх, шийдвэр гаргах үйл явцад тэдний тэгш төлөөллийг хангахын тулд тусгай оролцоо шаардаж болох бүлэг хүмүүс.

Нөлөөлөлд өртсөн талуудад орон нутгийн иргэд болон төсөлд шууд нөлөөлж болох бусад талууд орно. Тодруулбал, дараах хувь хүмүүс болон бүлгүүд энэ ангилалд багтана:

- Тухайн замын бүх хэрэглэгчид
- Ойролцоо оршин суудаг бүх насны иргэд
- Бизнес эрхлэгчид
- Эмзэг бүлэг

Бусад сонирхогч талууд: төслийн оролцогч талуудад шууд нөлөөлөлд өртсөн иргэдээс бусад талууд багтана, үүнд:

- Бусад ажил үйлчилгээ эрхлэгчид буюу үйлчилгээ үзүүлэгч, ханган нийлүүлэгчид
- ШУ-ны институц буюу судалгааны хүрээлэнгүүд, олон улсын болон үндэсний зөвлөх байгууллагууд

- Үндэсний болон олон улсын бусад байгууллага
- Үндэсний болон орон нутгийн хэвлэл мэдээллийн компаниуд
- Олон нийт
- Шийдвэр гаргах эрх бүхий бүх байгууллага

Эмзэг бүлгийн иргэд. Төслийн нөлөөлөл нь эмзэг бүлгийн иргэдэд харьцангуйгаар нөлөөлөх боломжтой эсэхийг ойлгох нь чухал. Эмзэг байдал нь тухайн хүний гарал үүсэл, хүйс, нас, эрүүл мэндийн байдал, эдийн засгийн хомсдол, санхүүгийн баталгаагүй байдал, нийгэм дэх сул дорой байдал (жишээ нь, цөөнх эсвэл захын бүлэг), бусад хүмүүсээс хараат байдал, байгалийн баялгаас хамааралтай байж болно. Эмзэг бүлгийн иргэдийн оролцоотойгоор төсөлтэй холбоотой аливаа шийдвэр гаргахад тэдний оролцоог хөнгөвчлөх тусгай арга хэмжээ, тусламж шаардагддаг.

Төслийн хүрээнд эмзэг бүлэгт доорхи иргэд хамаарах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй:

- Хүүхдүүд
  - Залуучууд
  - Эмэгтэйчүүд
  - Өндөр настан
  - Ядуу иргэд
  - Бага орлоготой, өрх толгойлсон иргэд
  - Оршин суух болон өмчлөлийн газаргүй түр оршин суугчид (хөдөөгийн шилжин ирэгсэд).
  - Үндэстний цөөнх өрхийн иргэд
  - Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
- Шууд нэвтрэх шаардлагатай жижиг бизнесүүд.

### **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харилцах**

Харилцаа холбооны хүртээмжтэй байдлын хувьд өөр өөр байдаг. Дараах жишээнүүд байна:

- Сонсголгүй хүмүүст уулзалт дээр юу болж байгааг ойлгуулахын тулд дохионы хэлний орчуулга хийх шаардлагатай байж болно.
- Сонсголын аппарат ашигладаг хүмүүст loop system буюу сонсгол дэмжих систем шаардлагатай байж болно. Сонсгол дэмжих систем нь томоохон хурал уулзалтууд дээр сонсголыг хөнгөвчлөх зориулалтаар ашиглагддаг.
- Сургалтын бэрхшээлтэй хүмүүст техникийн нарийн ширийн зүйлийг ойлгуулахын тулд тараах материалыг уншихад илүү хялбаршуулсан хувилбар шаардлагатай байж болно.
- Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийн хувьд аливаа хурал уулзалтын үеэр доромжлуулах айдастай байдаг учир урьдчилсан уулзалт зохион байгуулах илүү үр дүнтэй байж болно. Гутаан доромжлолын талаарх санаа зовнилын асуудлыг нь шийдвэрлэснээр нийгмээс гадуурхагдсан бүх бүлгийг хамруулах давуу талтай.
- Хөдөлгөөний бэрхшээлтэй, тэргэнцэртэй хүмүүст зориулсан барилга руу орох налуу зам, лифт, барилга дотор явахад хангалттай зайтай, бие засах газартай байх шаардлагатай.

### **6. Оролцогч талуудын оролцоог хангах үйл ажиллагаа**

Улсын Онцгой комиссоос Ковид-19 халдварыг бууруулах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх хүртэл олон нийтийг гамшгаас хамгаалах бэлэн байдал зарлах шийдвэрийг хэд хэдэн удаа гаргасан. (УОК, 2021 он).

Ковид-19-ийн халдвараас урьдчилан сэргийлэх үүднээс хэлэлцүүлгийн явцад урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. Ковид-19-ийн одоогийн нөхцөл байдлыг харгалзан харилцаа холбоог сонгохдоо дараах зүйлсийг анхаарч үзэх хэрэгтэй.

- Хэрэв цөөн хүнтэй жижиг хэмжээний уулзалт хийхийг зөвшөөрсөн нөхцөлд тусгай бүлгийн уулзалт гэх мэт жижиг уулзалт, хуралдааныг зохион байгуулж хэлэлцэх ба хэрэв зөвшөөрөгдөөгүй нөхцөлд онлайнаар уулзалт зохион байгуулахын тулд бүхий л хүчин чармайлтаа гаргах шаардлагатай.
- Харилцаа холбооны хэрэгслийг төрөлжүүлж, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, онлайн сувгийг илүү ашиглах. Боломжтой бол оролцогч талуудын онцлогт тулгуурлан зорилгод нийцсэн тусгай онлайн платформ, чат группийг бий болгох.
- Оролцогч талуудын зүгээс онлайн харилцааг ашиглах боломжгүй эсвэл байнга ашигладаггүй тохиолдолд уламжлалт харилцааг (ТВ, сонин, радио, тусгай утасны шугам, шуудан) ашиглах. Уламжлалт харилцаа холбоо нь холбогдох мэдээллийг сонирхогч талуудад хүргэж, санал хүсэлтээ өгөхөд өндөр үр дүнтэй байдаг.
- Төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүс эсвэл төслийн үр өгөөжийг хүртэгчидтэй шууд харилцах шаардлагатай бол цахим шуудан, мессеж, шуудан, онлайн платформ, мэдээллийн оператор бүхий тусгай утасны шугамаар нөлөөлөлд өртсөн айл өрхүүд шууд харилцах боломжийг тодорхойлох.
- Үндэстний цөөнх өрхүүдийн хувьд сонирхогч талуудын оролцооны онцлог хэрэгцээг харгалзан үзэж, орчуулгын үйлчилгээ, тодорхой хэвлэл мэдээллийн харилцааг ашиглах зэргээр хөнгөвчлөх боломжтой.
- Санал болгож буй холбоо харилцаанд оролцогч талууд хэрхэн санал хүсэлт гаргаж харилцах талаар тодорхой зааж өгсөн байна.

Төслийн үйл ажиллагаа дуусмагц төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүсийг хайж илрүүлэх ажлыг хийнэ. Хамгийн гол нь эцсийн хэрэглэгчийн холболт болон ложистикийн төвийн нөлөөлөлд өртсөн олон нийтийг тодорхойлоход чиглэнэ. Нөлөөлөлд өртсөн иргэд (НӨИ)-тэй олон нийтийн хэлэлцүүлэг явуулахдаа эдгээр НӨИ-ээс санал хүсэлтийг хүлээн авахад хамгийн их ач холбогдол бүхий аргачлалыг ашиглана.

### Мэдээллийг ил тод болгох

Оролцогч талууд	Сонирхол	Харилцааны арга	Хариуцлага
Бүх оролцогч талууд	Төслийн мэдээллийг нийтэд нээлттэй болгох буюу задруулах	Бүх оролцогч талуудтай тогтмол ганцаарчилсан уулзалт хийж, эмзэг бүлгийнхэнд анхаарлаа хандуулж байх; Зар, захидал, вэбсайтууд	ЗТХЯ, ТУГ
Бүх оролцогч талууд	Дэд төслийн дизайны шаардлага	Бүх оролцогч талуудтай тогтмол ганцаарчилсан уулзалт хийж, эмзэг бүлгийнхэнд анхаарлаа хандуулж байх; Зар, захидал, вэбсайтууд	МУВ, ТУГ
Сангийн яам	Төслийн зөвшөөрөл	Албан бичиг, уулзалт	ЗТХЯ, ТУГ
Нийтийн аж ахуй, хот төлөвлөлтийн	Ашиглалтын тасалдлын төлөвлөгөө, зөвшөөрөл	Албан бичиг, уулзалт	ЗТХЯ, ТУГ

Оролцогч талууд	Сонирхол	Харилцааны арга	Хариуцлага
байгууллагууд			
Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар	Дэмжлэг ба хамтын ажиллагаа, талуудын оролцоо	Албан бичиг, уулзалт	ЗТХЯ, ТУГ
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Зөвшөөрөх, үнэлэх, батлах	Албан бичиг, Олон нийтэд нээлттэй Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНҮ) ба Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах (БОМТ)	ЗТХЯ, ТУГ
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	Зөвшөөрөл, шалгалт, баталгаажуулалт	Хурал, уулзалтууд	ЗТХЯ, ТУГ
Тухайн зам дагуух бизнес эрхлэгчид /оршин суугчид	Нүүлгэн шилжүүлэх дэмжлэг	Тогтмол ганцаарчилсан уулзалтууд	ЗТХЯ, ТУГ
Орон нутгийн нийгэмлэгүүд	Замын хөдөлгөөний саатал, явган хүний гарц	Иргэдийн нийтийн хурал, Барилгын ажлын мэдээллийн самбар, оршин суугчдад зориулсан захидал, олон нийтийн медиа платформ, цахим хуудас, ТВ, радио, сонин, НЗДТГ-ын цахим хуудас (www.ulaanbaatar.mn)	ЗТХЯ, ТУГ
Шинжлэх ухааны академи (ШУА)-ийн Археологийн хүрээлэн	Барилгын ажилтай холбоотой Археологийн эд зүйлсийн тохиолдлын олдворууд	Уулзалт, албан бичиг	ТУГ, IE
Үндэсний төрийн бус байгууллагууд	Дизайны санал, асуудлыг тодорхойлох, мэдлэгийн эх сурвалж, сургалт	Бүх оролцогч талуудтай тогтмол ганцаарчилсан уулзалт хийж, эмзэг бүлгийнхэнд анхаарлаа хандуулж байх; Зар, захидал, вэбсайтууд	ТУГ, IE
Үндэсний хэвлэл мэдээллийн хэрэгсэл	Төслийн сүүлийн үеийн мэдээлэл	Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд	ЗТХЯ, ТУГ, IE
Хандивлагч болон олон талт агентлагууд	Төслийн байршил	Төслийн зарлал, вэб сайт, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, уулзалтууд	ЗТХЯ, ТУГ

## **7. Хянах, тайлагнах**

ТУА-ны байгаль орчин, нийгмийн мэргэжилтнүүд энэхүү талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ)-ний дагуу оролцогч талуудтай тогтоосон харилцаа холбоо, оролцооны арга хэрэгсэл дээр тулгуурлан талуудын оролцоог хангана. Тухайлбал, ТУА нь төслийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны үр дүн, Байгаль орчин, нийгмийн амлалтын төлөвлөгөөнд тусгагдсан нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийн талаар оролцогч талуудаас санал авах болно.

Зөвлөлдөх, нийтэд ил тод болгох үйл ажиллагааг мөн нэгтгэн дүгнэж, Дэлхийн банкинд ирүүлэх төслийн хагас жилийн тайланд нэгтгэн оруулж тайлагнана. Гүйцэтгэлийн хэд хэдэн үндсэн үзүүлэлтүүдийг (KPI) мөн дараах үзүүлэлтийг багтаасан байдлаар ТУА-наас тогтмол хянаж байна:

- Тайлант хугацаанд явуулсан зөвлөлдөх уулзалт болон бусад олон нийтийн хэлэлцүүлэг/форумуудын тоо (жишээ нь, сар, улирал, жил бүр);
- Олон нийтийг хамарсан үйл ажиллагааны давтамж;
- Тайлангийн хугацаанд хүлээн авсан олон нийтээс хүлээн авсан гомдлын тоо (жишээ нь сар, улирал, жил бүр) болон тогтоосон хугацаанд шийдвэрлэсэн гомдлын тоо;
- Хүлээн авсан олон нийтийн гомдлын төрөл; болон
- Үндэсний хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэгдсэн/хэвлэгдсэн хэвлэлийн материалын тоо.

## **8. Талуудын оролцооны үйл ажиллагааны нөөц ба үүрэг хариуцлага**

Төслийн удирдлагын албыг Зам, тээврийн хөгжлийн яамнаас томилон байгуулах ба төслийн бэлтгэл, хяналт, үнэлгээ зэрэг төслийн үйл ажиллагаанд ерөнхий хяналтыг тавина. Төслийн хүрээнд оролцогч талуудын оролцоог хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зориулсан санхүүжилтийг ТУА-наас санхүүжүүлнэ.

ТУА нь энэхүү оролцогч талуудын оролцооны төлөвлөгөөний үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэнүүдтэй байна. Төслийн энэ бэлтгэл үе шатны хугацаанд төслийн бэлтгэлтэй холбоотой асуултуудыг ЗТХЯ-нд илгээж болно.

Мэргэжлийн чиг үүргийнхээ дагуу гадаад олон нийттэй харилцах харилцаанд оролцож болох ажилтнууд, түүнчлэн удирдах албан тушаалтнуудад ТОХТ-ын хэрэгжилттэй холбоотой шаардлагатай сургалтыг ЗТХЯ, ТУА-наас зохион байгуулна. Төсөлтэй холбоотой аливаа гомдол барагдуулах механизм/ГБМ/-ын дагуу оролцогч талуудын гомдлыг шийдвэрлэхээр томилогдсон ажилтнуудад тусгайлсан сургалтыг мөн зохион байгуулна. Төслийн ажилчид мөн Хөдөлмөрийн харилцааг зохицуулах журмын дагуу хөдөлмөрийн ГБМ -ын шаардлагатай зааварчилгааг авна.

## **9. Санал гомдлыг шийдвэрлэх**

Гомдол барагдуулах механизм(ГБМ) нь хүрээлэн буй орчинтой холбоотой гомдол, нөлөөлөлд өртсөн хүн/олон нийтийн асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй арга замыг бий болгодог. ТУА нь ГБМ-ыг хэрэгжүүлэх үндэслэлийг боловсруулж, ТУА-ны инженер техникийн ажилтнуудын гомдол, саналыг хянах, бүртгэх үйл ажиллагааг багтаасан ГБМ -ын санаачлагыг хэрэгжүүлэх, жижиг асуудлуудыг газар дээр нь шийдвэрлэх, төслийн бүх үе шатанд оролцогч талуудад гомдол гаргах, хариу өгөх заалтуудыг тусгасан байна.

Олон нийтийн хэлэлцүүлгийн үеэр ГБМ-ыг танилцуулж, төслийн хүрээнд оролцогч талуудад Монгол хэл дээр олон нийтэд нээлттэй болгоно. Гомдол гарсан тохиолдолд дараах байдлаар 4 хүртэлх үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

**1-р шат:** Орон нутгийн түвшинд, ГБМ дагуу шийдвэрлэх, ГБМ систем нь нөлөөлөлд өртсөн хүмүүст (орон нутгийн оршин суугчид, орон нутгийн аж ахуйн нэгжийн төлөөлөгчид, гэрээт гүйцэтгэгчдийн ажилчид гэх мэт) Засгийн газрын мөрдөгдөж буй журмын хүрээнд шууд утсаар, биечлэн бичих гэх мэт хэд хэдэн хувилбараас хамгийн боломжит хувилбарын сонгох байдлаар гомдол, санал хүсэлт гаргах боломжийг олгодог. Нөлөөлөлд өртсөн хүний гомдлыг бүх санал хүсэлтийн системд холбогдсон ЗТХЯ-ны дотоод төв вэб серверт шууд бүртгэнэ. Гомдлын бүртгэлд санал/гомдлын агуулга, нөлөөлөлд өртсөн хүний нэр, холбоо барих хаяг, гомдлын огноо зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан байна.

**2-р үе шат:** ЗТХЯ-ны гомдлыг үнэлэх, шийдвэрлэх. Хүлээн авсан гомдлыг ТУА-ны холбогдох ажилтнууд эсвэл ЗТХЯ -ын харьяа хэлтэс/нэгжид хуваарилна. ТУА-наас асуудлыг судалж, шийдвэрлэх арга хэмжээг авах ёстой ба үүний хүрээнд гэрээт гүйцэтгэгчид засч залруулах арга хэмжээ авах зааварчилгааг өгч болно. Тухайн гүйцэтгэгч нь хохирлыг барагдуулах арга хэмжээг авч, үр дүнг нь ТУА-нд уламжилж, ДБ-д мэдэгдэх үүрэгтэй. Санал гомдлын төрөл, нарийн түвэгтэй байдлаас шалтгаалан ТУА/ЗТХЯ нь тайлбар/гомдлыг хүлээн авснаас хойш 1-30 хоногийн дотор асуудлыг шийдвэрлэнэ.

**3-р шат:** Төслийн удирдах хорооны зүгээс гомдлыг шийдвэрлэх. ТУХ нь 3-р шатнаас хойш 10 хоногийн дотор оролцогч талуудын уулзалтыг зохион байгуулах бөгөөд үүний дараа 10 хоногийн дотор тухайн уулзалтаас гарсан шийдвэрийн биелэлтийг хангана. Олон талт оролцогчдын бүлэг нь орон нутгийн засаг захиргаа, хэрэгжүүлэгч агентлаг, орон нутгийн нийгмийн үйлчилгээ, орон нутгийн болон иргэний нийгмийн байгууллага, гэр хорооллын оршин суугчид, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хувийн хэвшил, төрийн болон төрийн бус байгууллагын тэнцүү тооны төлөөлөгчид болон хэвлэл мэдээллийн хэрэгслээс бүрдэж болох ба гомдол гаргасан талуудтай ашиг сонирхлын зөрчилгүй байх шаардлагатай.

**4-р шат:** Дээд эрх бүхий байгууллагын тогтоол. Хэрэв гомдлыг шийдвэрлэхгүй бол нөлөөлөлд өртсөн тал нь шүүхээр дамжуулан хууль ёсны эрхээ хамгаалуулах боломжтой.

Засгийн газрын одоо байгаа систем дээр үндэслэн төслийн ГБМ-ийг үр дүнтэй удирдах боломжтой. Төслийн бүх үе шатанд төслийн нөлөөлөлд өртсөн хувь хүн болон/эсвэл бусад сонирхогч талуудтай илүү сайн харилцаа өрнүүлж хэрэгжүүлэгч агентлагуудын оролцоог хөнгөвчлөх үүднээс ТУА нь ГБМ-ыг илүү сайжруулж боловсруулах боломжтой.

Одоогоор ашиглагдаж буй харилцааны сувгууд:

1. Засгийн газрын 1111 төв, шуурхай утас

Иргэд Төрийн ордны урд байрлах төвөөр үйлчлүүлэх эсвэл шуурхай утсаар холбогдох боломжтой.

Ерөнхийлөгчийн Тамгын газар, УИХ-ын Тамгын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Засгийн газрын агентлагууд бүгд тус төв, утсаар мэдээлэл авдаг. Мэдээлэл цуглуулах, холбогдох байгууллагад шилжүүлэх, шийдвэрлэлтийн явцыг хянах үүрэгтэй тус бүр нэг ажилтантай. Иргэдэд хариу өгөх, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хугацаа 30 хоногийн дотор байна.

Мэдээллийг 11-11.mn вэб сайтад бүртгэж байршуулдаг.

2. Вэб сайт

а) Зам тээврийн хөгжлийн яам



Албан ёсны цахим хуудас болох [www.mrtd.gov.mn](http://www.mrtd.gov.mn) дээр "Хүсэлт, гомдол" гэсэн товчлуур байгаа бөгөөд үүнийг дарахад иргэд бүртгүүлж, мэдээллээ үлдээх боломжтой болдог. Хариуцсан албан тушаалтан мэдээлэл хүлээн авмагц холбогдох газруудад нь шилжүүлнэ. Холбогдох албан тушаалтанд ирсэн өргөдөл, гомдлыг зохих хугацаанд (ихэвчлэн 30 хоног) шийдвэрлэж, хариу өгөх үүрэгтэй.

b) Ерөнхийлөгчийн Тамгын газар

Албан ёсны [www.president.mn](http://www.president.mn) вэб сайтад иргэн, аж ахуйн нэгж зөвхөн санал хүсэлтээ үлдээх хэсэг бий. Хариуцсан албан тушаалтан санал хүсэлтийг хүлээн авсны дараа холбогдох асуудлыг шийдвэрлэж, зохих байгууллагад шилжүүлнэ.

Иргэд маягт бөглөхдөө овог нэр, иргэний үнэмлэх, хаяг, утасны дугаараа заавал бичнэ.

3. Орон нутгийн засаг захиргааны өргөдөл гомдол хүлээн авдаг шууд утас

Төсөл нь бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл/дарамттай (SEA/SH) холбоотой зэрэг эмзэг, нууцлах шаардлагатай гомдлыг шийдвэрлэх бусад арга хэмжээг Дэлхийн банкны БОНХ-ний бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл/дарамттай холбоотой Сайн туршлагауудын тэмдэглэлийн дагуу авна. SEA/SH эрсдэлийг зохих ёсоор шийдвэрлэхийн тулд гүйцэтгэгч нүүлгэн шилжүүлэлт хийхээс өмнө ГБМ-ыг бий болгоно. Гүйцэтгэгчид болон зөвлөхүүдийн зэрэгцэн (дотоодоо ажиллуулж буй) ажиллуулж буй аливаа ГБМ нь төслийн гомдлын талаар үнэн зөв ойлголттой байхын тулд гомдлыг төслийн ГБМ-д шилжүүлэх үйл явцыг багтаасан байна. Жендерт суурилсан хүчирхийлэл (GBV), ялангуяа SEA/SH гомдлын хувьд хохирогчдын эсрэг гутаан доромжлох, татгалзах, хэлмэгдүүлэх эрсдэлтэй байдаг. Энэ нь чимээгүй байх уламжлалыг бий болгож, бэхжүүлдэг тул хохирсон хүмүүс төсөлд шууд хандахаас татгалздаг. Зарим хохирсон хүмүүс шууд үйлчилгээ авахыг сонгодог ба энэ нь хэзээ ч ГБМ-д мэдээлэгдэхгүй бөгөөд үүний улмаас мэдээлэгдсэн тохиолдлын тоо зөрүүтэй байж болзошгүй юм. Эмэгтэйчүүдийг ГБМ-д айх аюулгүй нэвтрэх боломжийг олгохын тулд гомдлыг аюулгүй, нууцлалтайгаар бүртгэх олон сувгуудыг идэвхжүүлж болно. ТУА-ны ажилтнууд болон гүйцэтгэгчид ГБМ-ын нууцлал, үр дүнтэй ажиллагааны талаар сургалтанд хамрагдах ёстой. ГМ-ын мэдээлэл нь ялангуяа гомдол гаргагчийн хувийн мэдээлэлтэй холбоотой нууцыг чандлан сахих ёстой.

## ХАВСРАЛТ 6: БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ЧАДАВХЫГ БИЙ БОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол улсын Зам, Тээврийн Хөгжлийн Яаманд байгаль орчны менежментийн талаар туршлагатай ажилчид дутмаг байдаг. ЗТХЯ-аас томилсон ажилтнууд болон Байгаль орчны менежментийн ТУА төслийн байгаль орчны менежментийн сургалт болон БОНХ /ESF/-ний хэрэгжилтийн сургалтанд хамрагдана. Байгаль орчны хяналтын инженерүүд байгаль орчныг хамгаалах сургалтанд хамрагдсан байх ба энэхүү төслийн байгаль орчны менежментийн сургалтанд хамрагдаж, байгаль орчны менежментийн мэдлэгийг олж авна. Гүйцэтгэгчийн хувьд, байгаль орчны менежментийг хэрэгжүүлэхэд байгаль орчны менежментийн тодорхой чадвартай техникийн боловсон хүчинд ач холбогдол өгч ажиллах ба техникийн боловсон хүчин нь энэхүү төслийн байгаль орчны менежментийн сургалтыг хүлээн зөвшөөрнө.

Байгаль орчин, нийгмийн эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэхийн тулд ажилтнууд, гүйцэтгэгч, бусад оролцогч талуудын мэдлэг, холбогдох чадамжуудыг хөгжүүлэх, чадавхыг бий болгох төлөвлөгөө боловсруулна. Чадавхыг бий болгох төлөвлөгөөг хэрэгжүүлэх, сайжруулах үйл явцад зохих сургалтыг хэрэгтэй хүнд, шаардлагатай үед орж чадаж байгаа эсэхийг тодорхойлох ач холбогдолтой.

Чадваржуулах сургалтын төлөвлөгөө нь чадамжийг дээшлүүлэх болон мэдээллийг түгээхэд чиглэнэ. Сургалтанд дараах нийтлэг шаардлагууд тавигдана. Үүнд:

- i. Орон нутгийн иргэд болон түр зам ашиглагчдад менежментийн сургалт, мэдээлэл өгөх

Зам ашиглагчдад зориулсан сургалтаар талбайн ХАБЭА-н дүрэм, журмыг товч танилцуулна. Түр зам ашиглагчид ХАБЭА-н болзошгүй эрсдэл, аюулгүй байдлын хяналт, ослын үеийн хариу арга хэмжээний горим, байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөө болон түр хугацааны замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөөнд тусгасан зөвлөмжийг зэрэг ХАБЭА-н бусад шаардлагуудыг мэддэг болно.

- ii. Ажилтан ба гүйцэтгэгчийн сургалт

Энэ сургалт нь Дэлхийн Банкны Групп, Үндэсний хэмжээний БОН-ийн Бодлого, журам, горимын талаар мэдээлэл өгнө. Үүнд (үүгээр хязгаарлагдахгүй):

- a. ДБГ-ийн БОН-ийн эрсдлүүдийг удирдах аргачлал
- b. Үндэсний Байгаль Орчин, Нийгмийн шаардлага
- c. Талбайн менежментийн тогтолцооны тусгай ажиллагаа
- d. ХАБЭА-н болзошгүй эрсдэл, үйл ажиллагаа
- e. ХАБЭА-н тусгай үүрэг, харицлага, хариуцлага хүлээх чадвар
- f. Үл тохирлын үр дагавар
- g. Ослын хариу арга хэмжээний горим ба залруулах үйл ажиллагааны төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэх хугацаанд дотоод ажилтнууд БОН-ийн мэргэжлийн зохицуулагч эсхүл байгаль орчин, нийгмийн асуудлуудыг тус тусад нь хариуцаж ажиллах аюулгүй байдлын 2 ажилтан болон гадны БОН-ын зөвлөхүүдийн томилгоог хариуцсан ажилтнуудаас бүрдэнэ. ДБ-ны БОН-ын Стандартын дагуу БОН-ийн зааварчилгааг бэлтгэх нэг ч ажилтан бэлтгэгдээгүй тул орон нутгийн мэргэжилтнүүдийн чадварыг сайжруулахын тулд тэдэнд туслах зайлшгүй шаардлагатай байна. Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш 12 сарын хугацаанд төслийг үр дүнтэй байлгахын тулд Дэлхийн Банкны аюулгүй байдлын багийн дэмжлэгтэйгээр олон улсын болон үндэсний хэмжээний мэргэжлийн зөвлөхүүдээр БОН-ийн тогтолцооны сургалт явуулах хэрэгтэй. Ажилчид, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад зохих үйлчилгээг үзүүлэх зэрэг гүйцэтгэгчийн гүйцэтгэлийг үр дүнтэй байлгахад БОНХ, БОНС-д заасныг дагаж мөрдөх шаардлагатай учраас энэ чиглэлээр тусгай сургалт явуулах шаардлагатай болно.

БОНХ-ны сургалт, чадваржуулах үйл ажиллагаа нь БОНХ, БОНС, шалгалт, эрсдлийн үнэлгээ, Байгаль Орчны Нийгмийн Менежментийн Хүрээ (БОНМХ), талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ), хөдөлмөрийн удирдлагын бодлого (ХУБ)-ын талаарх үндсэн агуулга, менежмент, ялангуяа хөдөлмөрийн менежмент, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал (ХАБЭА), оролцогч талуудыг үйл ажиллагаатай холбоотой БОН-ийн асуудалд тавих гүйцэтгэгчийн удирдлага, хяналтыг сурталчилан таниулж, ойлгуулахад чиглэнэ. БОН-ийн эрсдлийн менежментэд чиглэсэн зорилтот сургалтын хөтөлбөрүүд нь газар чөлөөлөлт, инженерийн шугам сүлжээний тасалдал болон бусад асуудлыг үр дүнтэй удирдахад чухал ач холбогдолтой байгууллага хоорондын зохицуулалт, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд туслах болно.

Хэрэгжилтийн үе шатанд, Хэрэгжүүлэгч Агентлаг болон холбогдох оролцогч талуудад БОН-ийн сургалт болон Техникийн тусламж үзүүлнэ. Дараах сэдвүүд нь сургалтын тэргүүлэх сэдвүүд болно. Үүнд:

- Байгаль Орчны Нийгмийн Менежментийн Хүрээ /БОНМХ/, Талуудын оролцоог хангах төлөвлөгөө /ТОХТ/, Хөдөлмөрийн Удирдлагын Бодлого /ХУБ/, Нүүлгэн Шижлүүлэлтийн

Бодлогын Хүрээ /НШБХ/-нд чиглэсэн БОН-ийн аргачлалуудын бэлтгэн гаргах, хэрэгжүүлэх, хянах Байгаль Орчны Нийгмийн Менежментийн Тогтолцоо /БОНМХ/-ний үйл явц, зааварчилгаа

- Нүүлгэн Шилжүүлэлтийн Бодлогын Хүрээ /НШБХ/ Нүүлгэн шилжүүлэлт, газар чөлөөлөлтийн төлөвлөгөө /НШГЧТ/, Байгаль Орчны Нийгмийн Менежментийн Хүрээ /БОНМХ/, Талуудын оролцоог хангах төлөвлөгөө /ТОХТ/, Хөдөлмөрийн Удирдлагын Бодлого /ХУБ/, түүнчлэн Гомдол барагдуулах механизм /ГБМ/-ийн төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх төрөлжсөн сургалт
- Маягт, тайлагнах явц, эрүүл мэнд, аюулгүй байдал, хүйс, хөндлөнгийн оролцооны талаарх үндсэн мэдлэг, мэдээлэл түгээх үйл ажиллагаа; орон нутгийн иргэд болон хүрээлэн буй орчинд үзүүлж буй болзошгүй нөлөөллийг бууруулахад чиглэсэн барилгын ажлын сайн туршлага; Гомдол барагдуулах механизм /ГБМ/-ийн горим, Жендерт суурилсан Хүчирхийлэлтэй холбоотой нийгмийн бусад асуудал, Ковид-19, бусад халдварт өвчин гэх мэт холбоотой гүйцэтгэгчийн гүйцэтгэлийг хянаж, шалгах тусгай сургалт

Эхний 2 жилийн хугацаанд, Төслийн Удирдлагын алба /ТУА/ нь Аюулгүй байдлын баримт бичгүүд, ялангуяа Байгаль Орчны Нийгмийн Менежментийн Хүрээ /БОНМХ/, Талуудын оролцоог хангах төлөвлөгөө ТОХТ, Хөдөлмөрийн Удирдлагын Бодлого /ХУБ/, байгаль орчны үйл ажиллагаа дүрэм /БОУАД/, Нүүлгэн шилжүүлэлт, газар чөлөөлөлтийн төлөвлөгөө /НШГЧТ/-тэй холбоотой баримт бичгүүдийг бэлтгэн гаргах Байгаль Орчны Нийгмийн Менежментийн Хүрээ /БОНМХ/-ийн үйл явц, хэрэгцээ шаардлагыг харгалзан жил бүр 2 удаа аюулгүй байдлын сургалтыг зохион байгуулах үүрэг хүлээнэ. Хөтөлбөрийн эхлэл үед зориулсан нэн чухал сургалтын зорилтот бүлгүүдийг Хүснэгт 1-т харуулав.

Хүснэгт 22. Төсөл хэрэгжиж эхлэх үед явагдах үеийн аюулгүй байдлын сургалтын хураангуй

No	Агуулга	Сургалтын зорилтот бүлгүүд
1	Байгаль Орчны Нийгмийн Менежментийн Хүрээ /БОНМХ/ - ны үйл явц, хэрэгжилт, хяналт; БОНХ-ны агуулга, Байгаль Орчин Нийгмийн Стандарт БОНС, Талуудын оролцоог хангах төлөвлөгөө ТОХТ, Хөдөлмөрийн Удирдлагын Бодлого /ХУБ/, түүнчлэн Байгаль орчны үйл ажиллагаа дүрэм, Жендерт суурилсан Хүчирхийлэл ЖСХ, Гомдол барагдуулах механизм /ГБМ/-ийг тайлагнах	ТУА, ОУ-ын Зөвлөх, хувь хүн эсхүл пүүсийн зөвлөхүүд
2	Нүүлгэн шилжүүлэлт, газар чөлөөлөлтийн төлөвлөгөө /НШГЧТ/-г багтаасан Нүүлгэн Шилжүүлэлтийн Бодлогын Хүрээ /НШБХ/	ТУА, ОУ-ын Зөвлөх, хувь хүн эсхүл пүүсийн зөвлөхүүд, орон нутгийн удирдлагууд
3	Байгаль Орчны Нийгмийн Менежментийн Хүрээ /БОНМХ/, Талуудын оролцоог хангах төлөвлөгөө /ТОХТ/, Хөдөлмөрийн Удирдлагын Бодлого /ХУБ/ -ийг бэлтгэх, хянах, түүнчлэн гүйцэтгэлийн менежмент, чадварын сайжуулах, үүнд SEA, Гомдол барагдуулах механизм /ГБМ/-ийн шаардлагуудыг тусгах	ТУА, ОУ-ын Зөвлөх, хувь хүн эсхүл пүүсийн зөвлөхүүд, гүйцэтгэгчид
4	Байгалт орчин, Нийгмийн хяналтын үр чадваруудыг сайжруулах	ТУА, талбайн инженерүүд, гүйцэтгэгчид, байгалт орчин, нийгмийн зөвлөхүүд, орон нутгийн удирдлагууд
5	SEA, Жендерт суурилсан Хүчирхийлэл ЖСХ-ийн Байгаль орчины үйл ажиллагаа дүрэм, СОС, байгаль орчин, эрүүл мэнд, ХАБ-ын арга хэмжээ, халдварт өвчин, Ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх тухай сургалт	талбайн инженерүүд, гүйцэтгэгчид, хувь хүмүүс эсхүл пүүсийн зөвлөхүүд, орон нутгийн удирдлагууд

БОН-ийн сургалтын хэрэгцээ шаардлага өөр, мөн агентлагуудын хүчин чадал хязгаарлагдмал учраас Төслийн Удирдлагын /Менежмент/ ажилтан нь хүлээсэн үүрэг хариуцлагын дагуу Байгаль Орчны Нийгмийн Менежментийн Хүрээ /БОНМХ/-ийг хэрэгжүүлэх, БОН-ийн баримт бичгүүд, жижиг төслүүдийн нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлоход туслах БОН-ийн зөвлөхүүд (хувь хүн, компани)-ийг ажилд авч, ажиллуулна. Байгаль Орчны Нийгмийн Менежментийн Хүрээ /БОНМХ/-ний хэрэгжилт болон БОНХ-ны агуулгыг танилцуулах сургалт, чадваржуулах сургалтын зардал ойролцоогоор 0.4 сая доллар байх ба ТУА энэхүү санхүүжилтийн менежментийг хариуцна.

Сургалт дараах сэдвүүдээс бүрдэнэ. ТУА зөвлөхүүдийн дэмжлэгтэйгээр хичээлийн тоо болон сургалт явуулах төслийн талбайг тодорхойлно. Сургалтуудыг бүх аймгууд болон Улаанбаатар хотод явуулахаар төлөвлөж байна. Төслийг хэрэгжүүлэх бүх шатанд дараах сургалтын төлөвлөгөөг ТУА-д санал болгож байна. Ойлгомжтой байлгах үүднээс бүх сургалтыг Монгол хэлээр явуулна.

Хүснэгт 23. Байгаль орчны нийгмийн менежментийн хүрээ /БОНМХ/-г гаргахад чадваржуулах сургалт

Сэдэв	Зорилго	Дэд сэдэв	Оролцогчид	Тооцоолсон зардал (USD)
Байгаль Орчны Нийгмийн Менежментийн Хүрээ /БОНМХ/-ний үйл явц, хэрэгжилт, хяналт, тайлагнал	Байгаль Орчны Нийгмийн Менежментийн Хүрээ /БОНМХ/, Байгаль Орчны Нийгмийн Менежментийн Бодлого /БОНМБ/-ын хэрэгжилттэй танилцуулах	БОНХ-ны агуулга, БОНС-ууд, Талуудын оролцоог хангах төлөвлөгөө, Хөдөлмөрийн Менежментийн төлөвлөгөө, түүнчлэн БОН-ны тухай Хууль, SEA, Гомдол барагдуулах механизм /ГБМ/-ийн горим, Жендерт	Төслийн хэрэгжилтэд оролцогч бүх талууд	400,000

Сэдэв	Зорилго	Дэд сэдэв	Оролцогчид	Тооцоолсон зардал (USD)
		суурилсан Хүчирхийллийн эсрэг Сахилгын Дүрэм		
<b>Хууль эрхзүйн орчин</b>	Монгол Улсын Засгийн газрын хууль тогтоомжууд, ДБГ-ийн байгаль орчин, нийгмийн стандарт, шаардлагууд Хүрээлэн буй орчны чанар, эрүүл мэнд, аюулгүй байдал, эмзэг газар нутгийг хамгаалахтай холбогдсон холбогдох журам, стандартууд болон санал болгож буй дэд төслүүдийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг зохицуулах бусад холбогдох зохицуулалттай танилцах.	Олон улсын шилдэг туршлагууд	Монгол улсын ЗТХЯ, аймгийн удирдлагууд, орон нутгийн байгаль орчин, нийгмийн агентлагууд	
<b>Суурь судалгаа</b>	Суурь судалгааны зорилго, түүний Байгаль орчинд Нөлөөлөх байдлын Үнэлгээн дэх ач холбогдол, суурь судалгаанд шаардлагатай мэдээллийн төрлийг ойлгох Суурь судалгааны мэдээллийг цуглуулах янз бүрийн аргачлалыг олж мэдэх	Суурь судалгааны мэдээллийг цуглуулах	Монгол улсын ЗТХЯ, ТУА болон холбогдох түншүүд	
<b>Талуудын оролцоог хангах төлөвлөгөө ТОХТ, Олон нийтийн хэлэлцүүлэг, мэдээллийг нээлттэй болгох</b>	Оролцогч талуудтай зөвлөлдөх зарчим, шаардлага, мөн ийм зорилгоор ашиглаж болох арга хэрэгсэл, техникийг /арга барил/ тодорхойлох.	Ач холбогдолтойгоор зөвлөлдөх, мэдээллийг задруулахтай холбоотой гомдлыг шийдвэрлэх механизм Жендэрт Суурилсан Хүчирхийлэл	Монгол улсын ЗТХЯ, ТУА болон холбогдох түншүүд	
<b>Нөлөөллийн Үнэлгээ, Нөлөөллийг бууруулах арга хэмжээ</b>	Төрөл бүрийн нөлөөллийг тодорхойлох, урьдчилан таамаглах, үнэлэхэд ашигладаг хэрэгсэл, аргуудыг товч танилцуулах БОНБУ-ний үйл явцад нөлөөллийг бууруулах арга хэмжээний үүрэг, нөлөөллийн менежментэд үзүүлэх ач холбогдлыг ойлгох	Нөлөөллийг тодорхойлох ба үнэлэх Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөлөл ба түүнийг бууруулах арга хэмжээ	Монгол улсын ЗТХЯ, ТУА болон холбогдох түншүүд	
<b>БОННУ, БОННУ, СЭБ, БНҮБ-ын бэлтгэл ба хяналт, үүнд гэрээний удирдлага, чадавхыг сайжруулах зэрэг жендерт суурилсан хүчирхийлэл, БМХ/БД-ын ёс зүйн стандартуудын шаардлагууд</b>	Бүх арга хэрэгсэл, нөлөөллийг бууруулах арга хэмжээг танилцуулах	Загвар, жишээгээр хангах	Монгол улсын ЗТХЯ, ТУА болон холбогдох түншүүд, гүйцэтгэгчид	
<b>Байгаль орчны Менежмент, Хяналтын Төлөвлөгөө (EMMP)</b>	Байгаль орчны Менежмент, Хяналтын Төлөвлөгөөг бэлтгэхэд ашигладаг зарчим, элемент, агуулгыг тодорхойлох БОНМТ-ийг хэрэгжүүлэх байгууллагын хэлэлцээр /зохицуулалт/-ийг	БО-ны хяналт, тайлагналын Орчны Нийгмийн Менежментийн Тогтолцоо /БОНМХ/-ний үндсэн зарчмууд	ТУА инженерүүд, Монгол улсын ЗТХЯ, Барилгын Хяналт шалгалтын багийн инженерүүд, Барилга угсралтын ажлын гүйцэтгэгч,	

Сэдэв	Зорилго	Дэд сэдэв	Оролцогчид	Тооцоолсон зардал (USD)
	дэмжих	БОНМХ-ийн хэрэгжилтийн зохицуулалт Байгууллагын үүрэг хариуцлага Байгаль орчны хяналт, тайлан Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд Хөдөлмөр, нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдал	орон нутгийн удирдлагууд, орон нутгийн ТББ-ууд	
Орчны дуу чимээ Барилгын менежмент	Гэрээ, тендерийн баримт бичиг, тэдгээрийн үр дагаварын байгаль орчны тодорхойлолт Барилгын салбар дах сайн туршлагын талаарх гарын авлага	Барилгын/Инженерийн практик Тендерийн баримт бичигт зориулсан Байгаль орчны үнэлгээ БОНБҮТ-г тендерийн баримт бичигт тусгах Байгаль орчны практик дүрэм Байгаль орчинд ээлтэй худалдан авалт	ТУА /РМО/ -ны холбогдох инженерүүд, Барилгын Хяналтын Багийн инженерүүд, Барилга угсралтын гүйцэтгэгчид	
Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын цар хүрээ, нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө	Нүүлгэн шилжүүлэлтийн горим	ТУА-ны бүх инженерүүд / гүйцэтгэгчид/	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд	
Жендерт суурилсан хучирхийлэл, БМХ/БД нийцлийн талаарх Байгаль орчны үйл ажиллагаа дүрэм болон СОС, болон хүрээлэн буй орчны эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлын арга хэмжээ, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, COVID 19-ийн талаарх сургалт	Бүх дүрэм, журмын дэлгэрэнгүй тодорхойлолт	Талбайн инженер, Гүйцэтгэгч, хувь хүн эсхүл компанийн зөвлөх, орон нутгийн удирдлагууд	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд	

Хүснэгт 24. БОНМТ-нд чиглэсэн чадваржуулах сургалтын төлөвлөгөө

Сургалтын сэдэв	Сургалтын зорилго, агуулгын талаарх товч дүгнэлт	Хүлээн авагч/ Оролцогчдын тоо	Давтамж эсхүл товлосон огноо	Тооцоолсон зардал (USD)
Түр замын хөдөлгөөний менежмент ХАБЭА-н удирдамж	Түр замын хөдөлгөөний менежмент, Байгаль орчны аюулгүй байдлын дүрэм, журмын талаархи тойм, үе шаттай зааварчилгаа өгөх	Орон нутгийн оршин суугчид, түр замыг ашиглагчид, олон нийт	Барилга угсралтын өмнөх болон барилгын ажлын явцад	Барилга угсралтын зардал/гүйцэтгэчийг хамруулах
БОНХТ-г танилцуулах	Талбайн мэдээлэл, бохирдлын эрсдэл, хяналт, хөтөлбөр зэргийг багтаасан БОНХТ-ийн тойм. Талбайд тусгайлан зориулсан БОНХТ-г бэлтгэх, барилгын компанийн ажилтнуудад хийх хэрэгжилтийн сургалт	ТУА-ны бүх инженерүүд / гүйцэтгэгчид/	Төслийн эхэнд	
БОНХТ-г хянах, БОНМБ-ийн давтан сургалт	БОНХТ-д оруулсан өөрчлөлт, шинэчлэлтүүдийг багтаасан БОНХТ-ийн тойм.	ТУА-ны бүх инженерүүд / гүйцэтгэгчид/	Төслийн эхэнд, шинэчлэл хийх үед	

Сургалтын сэдэв	Сургалтын зорилго, агуулгын талаарх товч дүгнэлт	Хүлээн авагч/Оролцогчдын тоо	Давтамж эсхүл товлосон огноо	Тооцоолсон зардал (USD)
Төслийн менежмент, хэрэгжилт	Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх. Орон нутгийн ашиг хүртэгч нарт Хандивлагч байгууллагуудын үзүүлэх дэмжлэгийн зарчим	ТУА-ны бүх инженерүүд / гүйцэтгэгчид/	Төслийн эхэнд	
<b>Бохирдлын эрсдэл, хяналтын талаарх сургалт</b>				
Сургалтын сэдэв	Сургалтын зорилго, агуулгын талаарх товч дүгнэлт	Хүлээн авагч/Оролцогчдын тоо	Давтамж эсхүл товлосон огноо	Тооцоолсон зардал (USD)
Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын цар хүрээ, нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө	Нүүлгэн шилжүүлэлтийн горим	ТУА-ны бүх инженерүүд / гүйцэтгэгчид/	Төсөл хэрэгжүүлэх явцад	
Ослын хариу арга хэмжээний төлөвлөгөө	Газар дээр нь "болзошгүй ослын хувилбар" болон болзошгүй ослын хариу арга хэмжээг хэрхэн төлөвлөхийг тодорхойлох.	ТУА-ны бүх инженерүүд / гүйцэтгэгчид/	Төсөл хэрэгжүүлэх явцад	Барилга угсралтын зардал/гүйцэтгэчийг хамруулах
Агаарын чанарын хяналт	Орчны Агаарын Чанар, Дэгдэмхий органик нэгдлүүд /VOCs/, Тоосонцор, Озон Задлагч бодисууд (ODS), Хүлэмжийн хий (GHG)	ТУА-ны бүх инженерүүд / гүйцэтгэгчид/	Төсөл хэрэгжүүлэх явцад	
Усны нөөц	Усны Хяналт ба Менежмент, Усыг дахин ашиглахаар боловсруулах ба Дахин боловсруулах	ТУА-ны бүх инженерүүд / гүйцэтгэгчид/	Төсөл хэрэгжүүлэх явцад	
Бохир ус, Орчны усны чанар	Шингэн Хаягдал усны Чанар, Хөрсний ус руу зайлуулах, Ариун цэврийн байгууламж руу зайлуулах, Цэвэршүүлсэн бохир усыг хэрэглэх газар, Муу усны систем, Бохир Усны менежмент	ТУА-ны бүх инженерүүд / гүйцэтгэгчид/	Төсөл хэрэгжүүлэх явцад	
Аюултай материалын менежмент	Аюултай материалын менежмент, Аюулын Үнэлгээ, Менежментийн үйл ажиллагаа	ТУА-ны бүх инженерүүд / гүйцэтгэгчид/	Төсөл хэрэгжүүлэх явцад	
Галын Аюулгүй байдал	Гал түймэр, Дэлбэрэлтээс Урьдчилан сэргийлэх, Хянах арга хэмжээ	ТУА-ны бүх инженерүүд / гүйцэтгэгчид/	Төсөл хэрэгжүүлэх явцад	
Хөдөлмөрийн Аюулгүй байдал, Эрүүл Ахуй, Аюулгүй байдал	Хөдөлмөрийн Эрүүл Ахуй, Аюулгүй Байдал Ослын Бэлэн байдал, Хариу арга хэмжээ Орон нутгийн иргэдийн оролцоо ба мэдээлэл	ТУА-ны бүх инженерүүд / гүйцэтгэгчид/	Төсөл хэрэгжүүлэх явцад	
Хог хаягдлын менежмент	Хог Хаягдлын Менежмент, Хог Хаягдлын Менежментийн Төлөвлөгөө, Дахин боловсруулалт, Дахин ашиглалт, Цэвэрлэх ба Зайлуулах, Хог хаягдлын Хадгалалт, Тээвэрлэлт, Цэвэрлэх ба Зайлуулах, Хог хаягдлыг зайлуулах Хувийн эсхүл Төрийн хэвшлийн гүйцэтгэгч, Эрүүл мэндийн хог хаягдал	ТУА-ны бүх инженерүүд / гүйцэтгэгчид/	Төсөл хэрэгжүүлэх явцад	

Сургалтын сэдэв	Сургалтын зорилго, агуулгын талаарх товч дүгнэлт	Хүлээн авагч/Оролцогчдын тоо	Давтамж эсхүл товлосон огноо	Тооцоолсон зардал (USD)
Цаг уурын өөрчлөлт ба дасан зохицох (хөтөлбөрийн хүрээнд сонгогдсон төслүүдэд хамаарна)	Монгол оронд тохиолддог цас, үер, зудын улмаас үүссэн уур амьсгалын өөрчлөлтийн хэтийн төлөв, тэдгээрийн барилга байгууламж, ашиглалтын явцад үзүүлэх нөлөө	ТУА-ны бүх инженерүүд / гүйцэтгэгчид/	Төсөл хэрэгжүүлэх явцад	
Нөлөөллийг бууруулах арга хэмжээ болгон ашиглах Инженерийн ба Барилгын сайн туршлага	Барилгын ажлын дуу чимээ	ТУА-ны бүх инженерүүд / гүйцэтгэгчид/	Төсөл хэрэгжүүлэх явцад	
Хөдөлмөрийн Менежментийн Тогтолцоо	Зөвшөөрөгдсөн бүх дадал хэвшил, үл тохирох байдлын талаархи шат дараалсан зааварчилгаа	ТУА-ны бүх инженерүүд / гүйцэтгэгчид/	Төсөл хэрэгжүүлэх явцад	ТУА-ны сургалтын төсөв
Байгаль орчны тухай хууль	Зөвшөөрөгдсөн бүх дадал хэвшил, үл тохирох байдлын талаархи шат дараалсан зааварчилгаа	ТУА-ны бүх инженерүүд / гүйцэтгэгчид/	Төсөл хэрэгжүүлэх явцад	ТУА-ны сургалтын төсөв
Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө	Зөвшөөрөгдсөн бүх дадал хэвшил, үл тохирох байдлын талаархи шат дараалсан зааварчилгаа	ТУА-ны бүх инженерүүд / гүйцэтгэгчид/	Төсөл хэрэгжүүлэх явцад	ТУА-ны сургалтын төсөв



## ХАВСРАЛТ 7: ДЭД ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (БОНМТ)

### ЗАГВАР

#### 1. Танилцуулга

Тайлангийн энэ хэсэгт төслийн зорилго мөн чанар, байршил, цар хүрээ, цаг хугацааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг оруулна. Мөн төслийг хэрэгжүүлэгч байгууллага болон үйл ажиллагааны нарийвчилсан тодорхойлолтыг оруулна.

#### 2. Дэд төсөл хэрэгжих газар нутгийн байгаль орчин, нийгэм, эдийн засгийн суурь үзүүлэлт

Дэд төслийн үйл ажиллагаа, хамрах хүрээтэй уялдуулан доорх сэдвээр бичнэ. Үүнд:

- 2.1. Геологи ба геоморфологи
- 2.2. Гадаргын ус
- 2.3. Гүний ус
- 2.4. Хөрс
- 2.5. Ургамал
- 2.6. Амьтны аймаг
- 2.7. Тусгай хамгаалалттай газар нутаг
- 2.8. Нийгэм-эдийн засгийн байдал

#### 3. Хууль эрх зүй, бодлогын хамрах хүрээ, зохицуулалтын шаардлага

Агаарын бохирдол, бохир усыг зайлуулах, дуу чимээнээс хамгаалах, хатуу хог хаягдлыг зөөвөрлөхөд мөрдөх стандартуудыг баримтлах, банкны аюулгүй байдлын бодлогод нөлөөлсөн дотоодын хууль тогтоомж, дүрэм журмыг жагсаана.

#### 4. Дэд төслийн Байгаль орчин, Аюулгүй байдалд үзүүлэх болзошгүй нөлөө

Дэд төслийн үйл ажиллагаатай хамааруулан бичнэ. Дэд төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг барилгын ажил болон ашиглалтын үе шатуудад тусад нь үнэлж бичнэ. Дэд төслийн Байгаль орчин, Аюулгүй байдалд үзүүлэх нөлөөг байгаль орчны хэмжигдэхүүнүүдээр үнэлэх ба үүнд:

- Агаар
- Хөрс
- Ус
- Хатуу хог хаягдал
- Дуу чимээ
- Биологийн олон төрөл зүйл
- Соёлын өв
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
- Нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдал
- Нийгэм-эдийн засаг орно.

##### 4.1 Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөө (Барилгын ажил, Үйл ажиллагааны үе шат)

- 4.1.1 Барилгын ажлын үе шат
- 4.1.2 Үйл ажиллагааны үе шат

4.2. Нийгэмд үзүүлэх болзошгүй нөлөө (барилга, ашиглалтын үе шат)

- 4.2.1 Барилгын ажлын үе шат
- 4.2.2 Үйл ажиллагааны үе шат

**5. Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөг бууруулах арга хэмжээ, хамгаалах үйл ажиллагаа**

Зураг төсөл, барилгын ажил, ашиглалт үйл ажиллагааны үе шатуудад нөлөөллийг бууруулах төлөвлөсөн арга хэмжээ, хамгаалах үйл ажиллагаа:

- 5.1 Зураг төслийн үе шат
- 5.2 Барилга угсралтын үе шат
- 5.3 Ашиглалт үйл ажиллагааны үе шат

Хүснэгт 1. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№ Барилгын ажлын үе шат					
	Нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх байгууллага	Хяналтын байгууллага	Зардал/Төсөв
Үйл ажиллагааны үе шат					
	Нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх байгууллага	Хяналтын байгууллага	Зардал/Төсөв

**6. Дэд төслийг хэрэгжүүлэх зохицуулалт, үүрэг хариуцлага, чадавхыг бэхжүүлэх**

Байгууллагын бүтцийг барилгын ажил болон ашиглалтын үе шатуудад тусад нь тайлбарла. Чадавхыг бэхжүүлэх, сургалтын төлөвлөгөө, зардлын тооцоог энд оруулна.

**7. Мэдээллийг ил тод болгох, олон нийттэй зөвлөлдөх**

БОНМТ-ийг боловсруулан бэлтгэх, хэрэгжүүлэх явцад оролцогч талуудын оролцоог хангах ёстой. Үүнд оролцогч талуудыг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, төслийн мэдээлэл болон БОНМТ-ийн төслийг ил тод болгох, БОНМТ-ийн төслийн талаар зөвлөлдөх, оролцогч талуудын санал, тайлбарыг хэрхэн авч үзэж, БОНМТ-д тусгах зэрэг багтана.

**8. Гомдол барагдуулах механизм**

Гомдол барагдуулах механизмын (ГБМ) зорилго нь ямар нэг гомдол гарсан тохиолдолд шийдвэрлэх явдал юм. Холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын практикт нийцүүлэн дэд төсөл тус бүрт ГБМ-ыг байгуулна.

### 9. Хяналт, тайлагнах

Төслийн менежментийн албанд дэд төслийг хэрэгжүүлэгч байгууллага, хяналтын инженерүүд, хөндлөнгийн хяналтын ажилтнууд тайлагнах үүрэг хариуцлага, шаардлагыг энд тусгана.

### 10. Байгаль орчны хяналт

дэд төслийг хэрэгжүүлэх явц нь БОНМТ-д хэр нийцсэн эсэхийг хэмжихэд Байгаль орчны хяналтын төлөвлөгөөг ашигладаг. Байгаль орчны хяналтын гол зорилго нь:

- БОНМТ-д санал болгож буй арга хэмжээ болон сөрөг нөлөөллийг бууруулахад дэд төсөл хэрэгжүүлэгчийн гүйцэтгэсэн ажлыг үнэлэх
- Урьдчилан тооцоолоогүй сөрөг нөлөөлөл эсвэл нөлөөлөл гэнэт өөрчлөгдсөн тухай мэдээлэл олгох
- Тухайн нөлөөлөл нь эргэлт буцалтгүй шинж чанартай эсэхийг тодорхойлж, шаардлагатай нөхөн сэргээх арга хэмжээ авах, хяналт тавих
- Шаардлагатай бол байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээг сайжруулах санал тавих;

#### Хүснэгт 2. Барилгын ажлын үе шатны хяналт

№	Хяналтын үзүүлэлтүүд	Хяналтын төрөл/хяналт тавих арга	Хяналтын давтамж	Үүрэг хариуцлага

#### Хүснэгт 3. Үйл ажиллагааны үе шатан дах хяналт

№	Хяналтын үзүүлэлтүүд	Хяналтын төрөл/хяналт тавих арга	Хяналтын давтамж	Үүрэг хариуцлага

## ХАВСРАЛТ 8: АВТО ЗАМ ЗАСВАРЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДҮРЭМ (БОУД)

Зүйл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ
<b>Хориглох зүйлс</b>	<p>Барилгын талбай дээр болон түүний ойролцоо дараахь үйл ажиллагааг хориглоно.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Барилгын зөвшөөрөгдсөн талбайн гаднах модыг аливаа шалтгаанаар тайрах, огтлох;</li> <li>- Барилгын хаягдал, буулгасан материалыг хууль бусаар хаях;</li> <li>- Хар тугалга агуулсан будаг, асбест гэх мэт зөвшөөрөгдөөгүй хортой материалыг ашиглах;</li> <li>- Архитектур, түүхийн үнэт зүйлсийг эвдэх хохирол учруулах;</li> <li>- Хог хаягдлыг шатаах;</li> </ul>
<b>Замын хөдөлгөөний аюулгүй байдал</b>	<p>Барилга угсралтын ажил эхлэхээс өмнө Гүйцэтгэгч нь Замын хөдөлгөөний удирдлагын төлөвлөгөөг боловсруулах ба үүнд үйлдвэрлэлийн аваар ослын шинжилгээг багтаах ёстой бөгөөд Хавсралт 9 Замын хөдөлгөөний удирдлагын төлөвлөгөөнд заасны дагуу Хяналтын Инженерээс зөвшөөрөл авсан байх ёстой.</p> <p>Барилгын ажлын машин техниктэй явган зорчигчид хутгалдан зорчихыг аль болох багасгах;</p> <p>Замын хөдөлгөөний анхааруулах тэмдэг, шөнийн гэрэлтүүлгийн хангамж, замын хөдөлгөөнийг удирдах бүрэлдэхүүн, хөдөлгөөний хяналтын зохицуулагчийг томилно. Үзэгдэх орчинг хангахын үүднээс тоос бууруулах арга хэмжээ авахгүй байх</p> <p>Замын эгнээнд ямар нэгэн материал өрж, байршуулахгүй байх;</p> <p>Барилга угсралтын шатанд ямар нэгэн онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд замын цагдаагийн зөвшөөрөлгүйгээр замын хөдөлгөөнд өөрчлөлт оруулахыг хориглоно;</p> <p>Олон нийтийн дунд болон төслийг хэрэгжүүлэхэд оролцож буй тээврийн хэрэгслийн жолооч нарт аюулгүй ажиллагааны боловсрол олгоход илүү их хүчин чармайлт гаргах;</p> <p>Хэт ядраахаас зайлсхийх үүднээс жолоочийн жолоо барих хугацааг богиносгох, ээлж хуваариар ажиллуулах;</p> <p>Барилга угсралтын явцад гарах осол эрсдлийг бууруулахын тулд аюултай замаар болон өдрийн эрсдэлт үед зорчихоос зайлсхийх;</p> <p>Ачааны машинд хурд хянах төхөөрөмж ашиглах, жолоочийн үйлдлийг алсаас хянах;</p> <p>Орон нутгийн иргэд, холбогдох байгууллагуудтай хамтран ялангуяа сургуулийн ойролцоо болон хүүхдүүд байж болзошгүй бусад газруудад замын тэмдэглэгээ, үзэгдэх орчин, замын хөдөлгөөний ерөнхий аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээ авах. Замын хөдөлгөөний болон явган зорчигчийн аюулгүй байдлын боловсролыг орон нутгийн иргэдэд олгох (жишээлбэл, боловсрол олгох кампанит ажил гэх мэт);</p> <p>Ослын үед зохих анхны тусламж үзүүлэх үүднээс түргэн тусламжийн ажилтнуудтай холбоотой ажиллах;</p> <p>Жолооч нарыг эмнэлгийн үзлэгт оруулж байх;</p> <p>Үзэгдэх орчин хязгаарлагдмал орчинд явж буй тээврийн хэрэгслийн арын хэсэгт дуут дохио тоноглох;</p> <p>Хавсралт 9 Замын хөдөлгөөний удирдлагын төлөвлөгөөнд тодорхойлсон аюулгүй байдлын бүх арга хэмжээг дагаж мөрдөнө.</p>
<b>Ажлын цаг</b>	<p>Үндсэн ажлын цаг нь ажлын өдрүүдэд 08:00-18:00, амралтын өдөр 08:00-13:00 цагийн хооронд байх ёстой. Төслийн удирдлагын албаны (ТУА) болон холбогдох байгууллагуудаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр эдгээр цагаас бусад үед дуу чимээ ихтэй үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Дээр өгүүлснээс өөр барилгын талбайн ажлын шаардлагыг тусгайлан авч үзнэ.</p>

Зүйл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ
<b>Ажлын байрны дэглэм сахих</b>	<p>Гүйцэтгэгч нь "Ажлын байрны дэглэм сахих" бодлогыг үргэлж баримтлах ёстой. Үүнд дараахь зүйлсийг багтаах ба үүгээр хязгаарлагдахгүй.</p> <p>Гүйцэтгэгчийн ажилтнууд анхаарал болгоомжтой ажиллах нөхцлийг хангах; Ил гал гаргахыг хориглох; Тоосжилтыг дарах, замыг цэвэр байлгах нөхцлийг хангах талаархи зохих заалтуудыг хэрэгжүүлэх; Хог хаягдлыг ойр ойрхон ачуулж, барилгын талбайг цэвэр, эмх цэгцтэй байлгах; Хүнсний хог хаягдлыг зайлуулах; Барилгын талбайн түр хашааг байнга шалгаж, засварлаж, шаардлагатай бол дахин будах; Хийсч болох зураг самбар, хайрцаг савыг аль болох хурдан буюу мэдэгдэл өгснөөс хойш 24 цагийн дотор зайлуулах; Ажилчдын жорлон, ариун цэврийн байгууламж болон бусад байгууламжийг арчилж тордох;</p>
<b>Олон нийтийн мэдээлэл, талбайд нэвтрэх</b>	<p>Барилгын талбай руу зөвшөөрөлгүй орох, гарахыг аль болох хязгаарлах ёстой. Хүсэлт гаргасан тохиолдолд Гүйцэтгэгч нь барилгын ажлын явц (эхлэх ба дуусах огноо), харилцах утасны дугаар зэргийг олон нийтэд мэдээлж болно.</p>
<b>Барилгын талбайн зохион байгуулалт, бүрдэл хэсгүүд</b>	<p>Барилгын талбайн хил зааг дотор аливаа түр сууц, оффисын байр, бие засах газар, үйлчилгээний байгууламжийг байрлуулах ёстой.</p>
<b>Доголдол, тоос шороо, дуу чимээний хяналт</b>	<p>Барилгын талбай дээрх аливаа доголдол, тоос шороо, дуу чимээг бууруулахын тулд Гүйцэтгэгч:</p> <p>ТУА эсвэл эрх бүхий байгууллага, холбогдох этгээд, байгууллага, барилгын эзэд болон орон нутгийн иргэдтэй зөвшилцөн үйл ажиллагааг төлөвлөх ба ингэснээр өндөр дуу чимээ гаргах аливаа үйл ажиллагааг өдрийн цагаар явуулж, хамгийн бага түвэг учруулахаар төлөвлөх.</p> <p>Аливаа цохилт доргилт, тэсэлгээний үед түр зуурын дуу чимээ бууруулагч, дефлектор гэх мэт дуу чимээг хянах төхөөрөмж, шаталтат хөдөлгүүрийн яндангаас гарах дууг чимээг намсгах төхөөрөмжийг ашиглана.</p> <p>Олон нийтийн хорооллоор төслийн хүнд даацын ачаа тээврийг явуулахаас зайлсхийх эсвэл багасгах</p> <p>Бүх үйлдвэрийн машин, тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээний түвшинг аль болох бага буюу 90 дБ -ээс доош байлгах.</p> <p>Барилгын үйл ажиллагаанаас үүдэлтэй чичиргээ, дуу чимээнээс үүсэх түвэг чирэгдлийг багасгахын тулд зохих арга хэмжээг авна.</p> <p>Эмзэг бүсэд (орон сууцны хороолол, эмнэлгийн ойролцоо гэх мэт) хэт их дуу чимээ гаргахаас урьдчилан сэргийлэх онцгой арга хэмжээг авна. Ийм газруудад эмзэг бүлгийн хүмүүст (хүүхэд, ахмад настан) учруулах сөрөг нөлөөнөөс сэргийлэхийн тулд тоос шороо, тоосонцор бужигнахыг багасгах хэрэгтэй.</p> <p>Аливаа байгууламжийг нураан буулгахын өмнө түүний бүтцэд байгаа асбест зэрэг агаарыг бохирдуулж болзошгүй хор хөнөөлтэй материалыг ялган зайлуулна.</p> <p>Барилгын талбайн эргэн тойронд тоосны шүүлтүүр байршуулж, талбайн хилийн дагуу хашаа барьж, утаа тоос нь ойр хөрш иргэдэд нөлөөлөхгүй байх, ялангуяа орон сууц, худалдаа үйлчилгээний газар, амралт зугаалгын байгууламжтай ойрхон газруудад онцгой анхаарал тавих ёстой.</p> <p>Барилгын талбай, ялангуяа орон сууцны ойролцоо байрлах талбайг шаардлагатай бол үе үе усаар шүршиж, чийглэнэ.</p>
<b>Барилгын хог хаягдлын менежмент</b>	<p>Хог хаягдлын менежментийн төлөвлөлт. Барилгын хог хаягдлыг бүтэц, эх үүсвэр, үйлдвэрлэсэн хог хаягдлын төрөл, үүсэх хэмжээ болон орон нутгийн дүрэм, журмын шаардлагын дагуу ангилан ялгана. Ангилсан хог хаягдлын хэмжээ, үүсэх хор аюулаас урьдчилан сэргийлэх эсвэл багасгахын тулд сайтар төлөвлөн, бэлтгэх боловсруулах ёстой. Жишээлбэл:</p> <p>Түүхий эдийг аюул хор багатай материалаар орлуулах; Ажлын байрны дэглэм сахих, үйл ажиллагааны сайн туршлагыг бий болгох Контейнер сав зэрэг дахин ашиглах боломжтой материалыг буцааж өгөх</p>

Зүйл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ
	<p>боломжийг олгосон худалдан авалтын арга хэмжээг авах;  Аюултай болон аюулгүй хог хаягдлыг холилдохоос урьдчилан сэргийлэхийн үүднээс хог хаягдлыг хатуу ангилан ялгах байдлаар аюултай хог хаягдлын хэмсжээг багасгах.</p> <p><i>Дахин боловсруулах төлөвлөлт.</i> Дахин боловсруулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх замаар хог хаягдлын нийт хэмжээг мэдэгдэхүйц бууруулах боломжтой. Үүнд, жишээлбэл, хог хаягдлыг боловсруулах үйлдвэрлэлд үнэлгээ хийх, дахин боловсруулах боломжтой хаягдал материалыг тодорхойлох зэрэг орно.</p> <p><i>Цэвэрлэгээний журам.</i> Хүний эрүүл мэнд, байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс сэргийлэхий тулд Гүйцэтгэгч нь барилгын хог хаягдлыг зохих зааврын дагуу байршуулах, цэвэрлэх, зайлуулах замаар барилгын талбайг өдөр бүр цэвэрлэх журмыг тогтоож мөрдүүлнэ. Хогны менежмент нь хог хаягдлын шинж чанар болон орон нутгийн журам зохицуулалтад нийцсэн байх ёстой бөгөөд дараахь хэдэн зарчмыг багтааж болно. Үүнд:  Талбайн дотор болон талбайн гаднах биологийн, химийн болон бодит хог хаягдлыг эцсийн цэгт булахаас өмнө хор хөнөөлгүй болгохын тулд боловсруулах эсвэл хог хаягдлыг хүлээн авахаар тусгайлан зохион бүтээсэн зөвшөөрөгдсөн байгууламжид цэвэрлэж эсвэл ялгана.  Тухайн барилга байгууламжийг буулган нураасны улмаас үүссэн хог хаягдлыг боломжийн хэмжээнд дахин ашиглах ёстой. Үлдсэн хог хаягдлыг зөвхөн орон нутгийн эрх бүхий этгээд, байгууллагын зааж тогтоосон, зөвшөөрсөн цэгүүд рүү зайлуулна.  Ямар ч тохиолдолд Гүйцэтгэгч аливаа материалыг байгаль орчинд халтай газарт хаяж болохгүй.  Барилга угсралтын явцад үүссэн бүх хог хаягдал, металл, ашигласан тослох бодис, илүүдэл материалыг зөвшөөрөгдсөн дахин боловсруулах цэг, материал тусгаарлах газарт хаях ёстой.  Барилгын талбайн ойролцоох газар дээр ямар нэгэн хог хаягдал, лаг хуримтлагдсан тохиолдолд Гүйцэтгэгч тухайн хог хаягдлыг нэн даруй зайлуулж, бохирдол нөлөөлөлд өртсөн талбайг анхны байдалд нь тохижуулан оруулж, ТУА болон эрх бүхий байгууллага, этгээдийн шаардлагад нийцүүлэн сэргээнэ.</p>
<p><b>Бага хэмжээний аюултай бодисууд</b></p>	<p>Барилга угсралтын болон нураан буулгах үйл ажиллагааны үеэр бага хэмжээний хортой, аюултай бодис ялгарах эрсдэл бий. Гүйцэтгэгч нь нураан буулгах үйл ажиллагаанаас өмнө барилгын иж бүрдэл болон боловсруулах тоног төхөөрөмжид агуулагдах хортой, аюултай материал, газрын тосны бүтээгдэхүүнүүдийн (жишээлбэл, PCB буюу полихлоржуулсан бифенил агуулсан цахилгаан тоног төхөөрөмж, асбест агуулсан барилгын материал, чийдэн эсвэл чийдэнгийн балласт, ашигласан батерей, будгийн хоосон сав зэрэг) агуулгыг шалгаж, үнэлэх ёстой ба тэднийг Дэлхийн Банкны БОЭААБ -ын Ерөнхий удирдамжийн (<a href="http://www.ifc.org/ehsguidelines">www.ifc.org/ehsguidelines</a>) Хэсэг 1.5, 1.6 Хортой материал, Аюултай хог хаягдлын Менежмент-ийн дагуу тэднийг ялган ангилах, боловсруулах, зайлуулах ажиллагааг гүйцэтгэнэ. Ялангуяа аюултай хог хаягдлыг аюулгүй хог хаягдлаас байнга ялган ангилж байх ёстой. Дээрх хог хаягдлын менежментийн ерөнхий аргыг хэрэгжүүлэх замаар аюултай хог хаягдал үүсэхээс урьдчилан сэргийлэх боломжгүй бол уг менежментийн аргыг дараахь нэмэлт зарчмуудын дагуу эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчинд хор хөнөөл учруулахаас урьдчилан сэргийлэхэд чиглүүлнэ. Үүнд:  Аюултай хог хаягдалд менежмент хийх үеийн бүхий л хугацаанд учирч болзошгүй аюул, хор хөнөөл, эрсдэлийг ойлгох, аюултай хог хаягдалтай харьцах, түүнийг боловсруулах, зайлуулах, устгах үүрэг бүхий гүйцэтгэгчид нь холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан, хог хаягдлыг боловсруулах олон улсын сайн практикийг дагаж мөрддөг нэр хүндтэй, хууль ёсны аж ахуйн нэгж байх ёстой.  Орон нутгийн болон олон улсын холбогдох дүрэм журамд нийцүүлж ажилладаг</p>

Зүйл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ
	байх.
<b>Бохир усыг зайлуулах</b>	<p>Хог хаягдлыг (хатуу болон шингэн) аливаа урсгал ус, гол мөрөн, суваг руу орохоос урьдчилан сэргийлэх, газрын гадарга, гүний ус бохирдох, усны түвшин, урсгалын чиглэл, усны ерөнхий чанар өөрчлөгдөх зэрэг бусад сөрөг нөлөөллөөс хамгаалах бүхий л хүчин чармайлт, арга хэмжээг Гүйцэтгэгч авах ёстой. Боломжтой бол Гүйцэтгэгч зайлуулах шаардлагатай бохир усны хэмжээг аль болох багасгах, зайлуулах бусад арга замыг хэрэгтэй. Барилгын талбайд тос тосолгооны материал, түлш шатахуун, газрын тосны шингэн гоожиж асарсан бол газар, газрын доорх усанд учруулж болзошгүй бохирдлыг багасгах үүднээс нэн даруй арга хэмжээ авна. Ажлын явцад үүссэн аливаа шүүрэлт болон бохир усыг Гүйцэтгэгч нь тунадасжуулах саванд цуглуулж, зайлуулах ёстой. Барилгын талбай болон эргэн тойрны хүрээлэн буй орчинд эвгүй үнэр тархах, эрүүл ахуйн шаардлага хангахгүй хуримтлал бий болгох нөхцөл байдлаас зайлсхийхийн тулд хурсан усыг урсгах, зайлуулах байгууламжийг төлөвлөх ёстой.</p>
<b>Карьер, хажуугийн бэлтгэл ба материал зайлуулах талбай</b>	<p>Газар дээр, гол мөрөн дотор эсвэл одоогийн талбай дээр шинээр карьер, хажуугийн бэлтгэл гаргахдаа төслийн инженерээс урьдчилан зөвшөөрөл авсны үндсэн дээр гүйцэтгэх ба Инженерээс зөвшөөрөл аваагүй бол Инженерийн зааварчилгаагаар үйл ажиллагааг зогсооно.</p> <p>Байгалийн болон төлөвлөгдсөн ус зайлуулалтын урсацад саад учруулж болзошгүй газарт карьер, хажуугийн бэлтгэл гаргаж ашиглахыг хориглоно. Гол мөрний эрэгт эвдрэл гэмтэл учруулах, хэт их хэмжээний нарийн ширхэгтэй материалыг доош унагаж зөөвөрлөх зэрэг тохиолдолд гол орчмын байршилд карьер, хажуугийн бэлтгэл гаргах байршил тогтоохыг хориглоно.</p> <p>Гүйцэтгэгч нь ашиглагдаж буй бүх карьер, хажуугийн бэлтгэлийг тэгш, эмх цэгцтэй, хажуугийн налуу тогтвортой байлгаж, шумуул үржихүйц тогтмол усны үүсгэхгүй байхаар зайлуулах ажлыг гүйцэтгэнэ.</p> <p>Голоос авсан чулуу, хайрга нь голын урсацыг алдагдуулахгүй, голын эргийг сүйтгэх, сүйтгэхгүй байлгахын тулд авсан материалыг хангалттай хол зайлуулах ба голын өргөний аравны нэгтэй тэнцэх хэмжээнээс илүүгүй гүнд материалыг ухаж авч болно.</p> <p>Бутлуурын байршилд Инженер зөвшөөрөл өгөх ба байгаль орчны эмзэг газар болон одоо байгаа суурин газруудад ойр байх ёсгүй бөгөөд тоосжилтыг хянах тохирсон төхөөрөмжийг суурилуулж үйл ажиллагааг явуулна.</p> <p>Гүйцэтгэгч нь карьер, хажуугийн бэлтгэл, материал зайлуулахад:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Овоолго, карьер, хажуугийн бэлтгэл газрын байршлыг тодорхойлж, хил хязгаарыг зааглаж, эгц налуу газар, элэгдэлд өртөмтгий хөрс, эмзэг усан гадагуу руу шууд урсдаг хэсэг зэрэг асуудал дагуулах газраас 15 метрийн зайд байлгах.</li> <li>• Зөвшөөрөгдсөн, хил хязгаарыг тогтоосон карьер, хажуугийн бэлтгэл газраас материал авахдаа хязгаартайгаар хэрэглэх.</li> <li>• Карьер, хажуугийн бэлтгэл газрыг анх нээхдээ өнгөн хөрсийг овоолно. Ашиглаж дууссаны дараа өмнө нь овоолсон өнгөн хөрсийг карьер, хажуугийн бэлтгэл газрын талбайд буцааж гөлгөр, жигд гадаргуутай болгож, ус зайлуулах налуутай болгож дэвсэнэ. Элэгдлээс хамгаалахын тулд эгц налуу дээр мөргөцөг эсвэл үелүүлж өгнө.</li> <li>• Тэгшилж тогтвортой болгож ургамалжуулна. Тохиромжтой тохиолдолд ургамалжилтыг дэмжихийн тулд эвдэрсэн талбайн дээгүүр органик хог хаягдал, органик үе давхрагыг тараана. Байгалийн ургамлыг илүүд үзэх хэрэгтэй.</li> <li>• Ашиглалтын нөлөөлөлд өртсөн газруудад одоо байгаа ус зайлуулах</li> </ul>

Зүйл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ
	<p>сувгуудыг хэт ачаалалд орохоос сэргийлэх.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ажил дууссаны дараа барилгын ажилд үүссэн бүх хог хаягдлыг талбайгаас зайлуулах шаардлагатай.</li> </ul>
<p><b>Барилгын ажлын аюулгүй байдал</b></p>	<p><i>Яаралтай тусламжийн арга хэмжээ:</i> Эрүүл ахуй, гал түймрийн онцгой байдал, түүнчлэн хүрээлэн буй орчны бохирдол (бензин, ашигласан тос болон химийн хорт бодис их хэмжээгээр асгарсан гэх мэт) үүссэн үед Гүйцэтгэгч үр дүнтэй арга хэмжээ авах журмыг боловсруулсан байх ёстой. Яаралтай тусламжийн үзүүлэх журамд яаралтай тусламж үзүүлэгчийн утасны дугаар, хууль ёсны эрх бүхий байгууллагад мэдэгдэх арга зэрэг мэдээллийг багтаасан байна. Гүйцэтгэгч компанийн эрх бүхий ажилтнуудын холбоо барих утасны дугаарыг мөн оруулах ёстой.</p> <p><i>Гал түймрээс урьдчилан сэргийлэх ба хяналт:</i> Барилгын талбай болон холбогдох бүх байр, эрүүл ахуйн үйлчилгээний байгууламжуудыг гал түймрээс урьдчилан сэргийлэхийн тулд зохих төлөвлөгөө, менежментийн хяналт бий болгосон байх ёстой. Талбайд гал түймэр гарах үед авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан байх ёстой бөгөөд үүнд засгийн газраас гаргасан холбогдох дүрэм журмыг зохих ёсоор харгалзан үзсэн байх ёстой. Эдгээр журмын талаар Гүйцэтгэгч ажилчдадаа хангалттай мэдлэг олгож, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийх явцад дагаж мөрдүүлэх ёстой. Үл шатах материал, бүтээгдэхүүн, сав баглаа боодлын техникийн үзүүлэлтүүдийг боломжийн хэмжээнд дагаж мөрдөх ёстой. Гүйцэтгэгч нь мөн тодорхой нөхцөл, байрлалд тохирсон Засгийн газрын шаардлагыг дагаж мөрдөх ёстой.</p> <p><i>Тоног төхөөрөмжийг ажиллуулах:</i> Эргэн тойрон, ойр орчмын хүн амьтан болон оршин суугчдын аюулгүй байдалд эрсдэл болон хүндрэл учруулахгүйгээр тоног төхөөрөмжийг ажиллуулахын тулд Гүйцэтгэгч бүх боломжит урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах ёстой. Кран болон бусад том оврын механизм, тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг байнгын хяналтанд явуулах ёстой. Зөвшөөрөл авах шаардлага гарч болно.</p> <p><i>Ослоос урьдчилан сэргийлэх.</i> Барилгын аваар ослоос бүхий л ажилтнууд, эргэн тойрны эд хөрөнгийг хамгаалах нь Гүйцэтгэгчийн үүрэг хариуцлага юм. Гүйцэтгэгч нь төр засгаас гаргасан аюулгүй байдлын бүх журам, шаардлагыг дагаж мөрдөх, ослоос урьдчилан сэргийлэхэд шаардлагатай бусад арга хэмжээг авахыг хариуцах ба үүнд дараах зүйлс орно:</p> <p>Барилгын талбайд анхааруулах тэмдэг, самбарыг зохих ёсоор байршуулна Хэрэв талбайн ойр сургуулийн хүүхдүүд байх бол хичээл сургууль ажиллах цагаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг зохицуулах ажилтнуудаар хөдөлгөөнийг зохицуулуулна; Ажил эхлэхийн өмнө барилгын ажилчдад аюулгүй ажиллагааны сургалт явуулах, зааварчилгаа өгнө; Барилгын ажилчдад шаардлагатай хувийн хамгаалах хэрэгсэл, хувцас (нүдний шил, бээлий, хийн баг хошуувч, тоосноос хамгаалах амны хаалт, хатуу малгай, ган хошуутай хамгаалалтын гутал гэх мэт) хангах, тэдгээрийг өмсөж хэрэглэж байгааг байнга хянан мөрдүүлнэ; Асбест агуулсан материал болон бусад хорт бодисыг зайлуулах ажлыг тусгайлан бэлтгэгдсэн ажилчид гүйцэтгэж, зайлуулах ёстой; Аливаа онцгой байдлын үед бүх ажлыг түр зогсооно.</p>
<p><b>Ажиллах хүч, ажилчдын эрүүл ахуйн байдал</b></p>	<p>Гүйцэтгэгч нь аль болох орон нутгаас ажиллах хүчний дийлэнхийг сонгон шалгаруулж ажилд авах ба шаардлагатай бол зохих сургалтад хамруулна. Гүйцэтгэгч нь барилгын талбай болон ойр орчмын талбайд хоол хийх, халаалтанд модыг түлш болгон ашиглахыг зөвшөөрөх ёсгүй.</p> <p>Талбай дах оффис, агуулах, засварын цехүүдийг зохих газарт байрлуулахыг Гүйцэтгэгч хариуцна. Жорлон бие засах газрыг байнга цэвэр байлгаж, арчилж байх</p>



Зүйл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ
	ёстой. Гүйцэтгэгч нь ажилчдыг шаардлагатай багаж хэрэгслээр бүрэн хангана.
<b>Олон нийтийн харилцаа</b>	Олон нийттэй харилцах харилцааг сайжруулахын тулд Гүйцэтгэгч доорх арга хэмжээг авна. Үүнд: Барилгын ажил, ажиллах цагийн хуваарь, үйлчилгээний тасалдал, замын хөдөлгөөнд өөрчлөлт орох, автобусны түр чиглэлийн талаар шаардлагатай бол орон нутгийн удирдлага, олон нийтэд мэдээлэх; Шөнийн цагаар ямар нэг барилгын ажил хийхгүй байх.
<b>Соёлын биет өв олдсон тохиолдолд авах арга хэмжээ</b>	Соёлын биет өв санамсаргүй олоход тохиолдох магадлал багатай боловч олдсон тохиолдолд аливаа арга хэмжээ авахын өмнө орон нутгийн археологийн дурсгалт газар, түүхийн дурсгалт газар, шарил бунхан эд зүйлсийг хамгаалах алба, хариуцсан албан тушаалтанд мэдэгдэнэ. Олдворын ач холбогдол, үнэ цэнийг соёлын өвтэй холбоотой төрөл бүрийн шалгуурын дагуу үнэлэх ба эдгээрт гоо зүй, түүх, шинжлэх ухаан, судалгаа, нийгэм, эдийн засгийн үнэт зүйлс зэрэг хүчин зүйлс багтана. Илэрсэн олдворыг хэрхэн шийдвэрлэх талаар холбогдох байгууллагууд шийдвэр гаргана; Үүнд (олдвор нь үл салах бүрдэл бүхий соёлын болон археологийн ач холбогдолтой бол гэх мэт) бүтэц үзэмжийг өөрчлөх, хамгаалах, хадгалах, нөхөн сэргээх, засварлах зэрэг багтаж болно. Археологийн дурсгалт газар, түүхийн дурсгалт газар, шарил бунхан эд зүйлс илэрсэн тохиолдолд Гүйцэтгэгч: Санамсаргүй олдвор илэрсэн талбай дах барилгын ажлыг зогсоох; Илэрсэн газар эсвэл талбайг тодорхойлох; Хөдөлгөж болох объектыг гэмтээх, алдахаас урьдчилан сэргийлэхийн тулд талбайг хамгаалалтанд авна. Хөдөлгөж болох хуучны эд зүйлс, шарил бунхан олдсон тохиолдолд тухайн орон нутгийн холбогдох байгууллага хариуцах хүртэл шөнийн харуулыг зохион байгуулж харгалзуулна; Хяналтын инженерт мэдэгдэж, тэр нь хариуцах орон нутгийн удирдлагуудад нэн даруй мэдэгдэх ёстой (24 цагийн дотор); Өвийг хамгаалах талаар орон нутгийн эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсны дараа барилгын ажлыг үргэлжлүүлнэ.
<b>Барилгын ажил дууссаны дараа талбайг чөлөөлөх</b>	Барилгын ажил бүрэн дууссаны дараа Гүйцэтгэгч бүх материал, хог хаягдлыг цэвэрлэж, түр зуурын бүх байгууламжийг зайлуулах ёстой. Барилгын талбайг ТУА эсвэл итгэмжлэгдсэн байгууллага, эрх баригчдын шаардлагад нийцүүлэн цэвэрхэн нөхцөлд байлгах ёстой.

## ХАВСРАЛТ 9: ЗАМЫН ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн замын хөдөлгөөнийг зохицуулах ерөнхий төлөвлөгөөний зааварчилгааг төслийн талбайн замын хөдөлгөөнийг зохицуулах төлөвлөгөөг боловсруулахад заавар өгөх, төслийн барилга угсралтын ажлын үеэр орон нутгийн иргэд болон барилга байгууламжийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор боловсруулсан. Энэхүү зааварчилгааг Улаанбаатар хотод мөрдөгдөж буй шаардлага, Дэлхийн банкны Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын зааварчилгаа, Дэлхийн банкны Замын аюулгүй байдлын сайн туршлагын санамж, түүн дотроос (i) Барилгын талбай дахь аюулгүй ажлын байр, (ii) Барилгын талбай дахь аюулгүй тээврийн хэрэгсэл, (iii) Аюулгүй жолооч ба

жолоочтой холбоотой туршлага, (iv) Замын хөдөлгөөний аюулгүй байдал, (v) Онцгой байдалд бэлтгэлтэй байх болон авах хариу арга хэмжээ зэргийг үндэслэн боловсруулсан.

## **I. Зорилго**

Энэхүү зааварчилгааны зорилго нь орон нутгийн иргэдийг төслийн шинэ зам засах, сайжруулах болон барих ажлын үеэр замын хөдөлгөөнд аюулгүй оролцуулах, ялангуяа явган хүн, ундаг дугуй унасан хүн, мотоциклтой хүн, ажилчид түүн дотроос материал нийлүүлэх ажилчид, барилгын ажилчид болон тээврийн хэрэгслийн жолооч нарыг хамгаалахад оршино.

## **II. Төслийн замын хөдөлгөөнийг зохицуулах төлөвлөгөөний бэлтгэл ажил**

Сонгогдсон гүйцэтгэгч нь тендерийн хэсэг болгож замын хөдөлгөөний төлөвлөгөөний төслийг ирүүлэх шаардлагатай ба энэ нь эцэстээ гүйцэтгэгчийн БОНМТ-ий нэг хэсэг болно. Ажил эхлэхээс өмнө шинэчилсэн замын хөдөлгөөнийг зохицуулах төлөвлөгөөг орон нутгийн засаг захиргаагаар батлуулж ТУН-д хүргүүлнэ. Тус төлөвлөгөөг ажилчдад байнга харагдах газар байршуулна.

Төслийн замын хөдөлгөөнийг зохицуулах төлөвлөгөө нь:

- a. Ажлын талбай дахь ажилчдын аюулгүй байдал, ажлын байртай ойролцоо эсхүл ажлын байраар дамжин өнгөрч буй ард иргэдийн аюулгүй байдлыг хангах;
- b. Гэрээт ажил гүйцэтгэх бүх түвшинд замын хөдөлгөөнийг зохицуулах аргачлал зэрэг замын хөдөлгөөнийг зохицуулах нийт стратегийг тодорхойлох;
- c. Барилга, засварын ажлын хаягдал, материалын нөөцийг тээвэрлэх хуваарь гаргах зэрэг гэрээт ажлын үе шат бүрт түр хугацааны замын хөдөлгөөнийг зохицуулах зохион байгуулалт хийх;
- d. Гэрээт ажлын үе шат бүрт шаардагдах замын хөдөлгөөн зохицуулагчийг зохион байгуулах, тоог зааж өгөх;
- e. Яаралтай тусламжийн гарц – ажилчид болон ажлын талбайгаар зорчиж буй яаралтай түргэн тусламжийн тээврийн хэрэгсэлд зориулсан аливаа энгийн бус аюул эсхүл сургуулийн ойролцоо болон цехэд нэвтрэх боломжтой зэрэг тухайн ажил үүрэгтэй холбоотой шаардлагын дагуу;
- f. Шаардлагатай үед ашиглах өөр зам эсхүл тойруу зам гаргаж өгөх;
- g. Хэт хүнд даацын тээврийн хэрэгсэл явах нөхцөлийг зааж өгөх;
- h. Явган хүн, дугуйтай хүн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд аюулгүй явах зам гаргаж өгөх;
- i. Нийтийн тээврийг бий болгох, үзүүлэх нөлөөг зааж өгөх (жишээлбэл, ) provision for, and impact on, public transport (e.g. автобус, трамвайн саатал, автобус, трамвайн буудал руу зорчигч нэвтрэхэд тавих хязгаарлалт, зэргэлдээх зам дээр дараалал үүсэх боломж) ба шаардлагатай бол нийтийн тээврийн эрэмбийг тодорхойлно;
- j. Хажуу дахь үл хөдлөх хөрөнгөд нэвтрэх эрх олгох;
- k. Гэрээт ажлыг гүйцэтгэх хугацаа, цаг (жишээ нь өдөр эсхүл орой ажиллах);
- l. Ажлын бус цагаар эсхүл ажлын талбайд ажилчид байхгүй үед ажлын байранд баримтлах замын хөдөлгөөнийг зохицуулах зохион байгуулалт;
- m. Ажлын талбайн замын хөдөлгөөн ихэссэний улмаас дарааллын төгсгөлд мөргөлдөх эрсдэлийг арилгах, хянах зохицуулалт;

- n. Яаралтай тусламжийн журам, холбоо барих мэдээлэл;
- o. Осол аваараас сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ – түүний дотроос эрсдэлийг бууруулж, ийм нөхцөл байдал дахин үүсэхээс сэргийлэхэд туслах үүднээс нэмэлт замын хөдөлгөөний зохицуулалт хийх шаардлагатай эсэхийг ойлгохын тулд үндсэн шалтгааныг тодруулах дүн шинжилгээ хийх шаардлага;
- p. Харилцаа холбооны зохицуулалт;

### **III. Замын хөдөлгөөнийг зохицуулах төлөвлөгөөнд тусгах арга хэмжээнүүд**

#### **a) Ерөнхий арга хэмжээ**

- Замын уулзвар, хүн ихтэй бүс ба эмнэлэг, сургууль, цэцэрлэг болон олон нийтийн үйл ажиллагаа хийдэг бусад газрууд зэрэг замын хөдөлгөөний аюулгүй байдал алдагдаж болох газруудад анхааруулах тэмдэг, шөнийн анхааруулах гэрлүүдийг байрлуулах;
- Анхааруулах тэмдэг болон хурдны хязгаарын тэмдгүүдийг байршуулж, замын хөдөлгөөнд нөлөөлж буй орон нутагт хийгдэж буй шугам хоолой угсрах ажлын талбай эсхүл орон нутагт нэвтэрч буй тээврийн хэрэгслийг зохицуулахаар томилсон бүтэн цагийн замын хөдөлгөөн зохицуулах ажилтантай байна.
- Яаралтай гарц руу гарах зам үргэлж ямар нэгэн саадгүй байна. Гарцуудыг түнэр харанхуйд ч харагдахуйц, тод тэмдэглэсэн байна. Яаралтай гарцны тоо болон хүчин чадал нь төслийн талбайд аль ч үед байх хамгийн их тооны хүнийг аюулгүй, эмх замбараатай гарахад хүрэлцэхуйц байна. Ажлын талбайгаас гарах дор хаяж хоёр гарц байна.
- Барилгын талбайд тээврийн хэрэгсэл нэвтэрсэнтэй холбоотой асуудлыг зохицуулахын тулд барилгын ажлын үеэр замын хөдөлгөөнийг зохицуулах албатай байнга холбоотой ажиллана.
- Барилгын ажил явагдаж буй барилгын талбай, гол зам, уулзвар болон түр замын хоёр талд тодорхой байршилд замын хөдөлгөөний тэмдэг болон байгууламжуудыг байршуулах; Эдгээр тэмдгүүдийн зүй зохистой засвар үйлчилгээг хариуцсан тусгай ажилтныг томилно. Барилга угсралтын үе шатанд хэрэгжүүлэх замын хөдөлгөөний зохицуулалтын шаардлагыг Улаанбаатар хотод баримталдаг журам, шаардлагуудтай нийцүүлж хийнэ.

#### **b) Нутгийн иргэдтэй ойролцоо явагдах барилгын ажилд зориулсан замын хөдөлгөөнийг зохицуулах арга хэмжээ**

- Замын хөдөлгөөнд нөлөөлж буй саад тотгорыг арилгаж, явган хүний замыг зохих журмын дагуу барьж алхаж явах зай гаргана.;
- Барилгын хаалттай дамжин өнгөрч тээврийн хэрэгслүүд гарахыг сануулах үүднээс замын уулзваруудад нүдэнд харагдахуйц тэмдэг байрлуулна. Ажлын талбайд замын тэмдэг болон замын хөдөлгөөнийг зааварчилах байгууламжуудыг байгуулна;
- Замын цагдаагийн газартай цаг тухайд нь холбоотой ажиллах бүтэн цагийн замын хөдөлгөөн зохицуулагчийг томилж ажиллуулна;
- Барилга угсралтын үеэр замын хөдөлгөөнийг өөрчлөх үүрэг бүхий тусгай ажилтныг томилж ажиллуулна.
- Замын гадаргууг барилгын тоосжилт үүсэхээс сэргийлж үргэлж цэвэр байлгана;

- Замын хөдөлгөөнийг зохицуулах газрыг замын хөдөлгөөний зохицуулах эрх бүхий тусгай нэгж болгон байгуулна;
- Тэмдэгүүдийг үндэсний стандартын дагуу байрлуулах ба замын уулзварын хашааг тэгшилж, дугуйруулсан байна;
- Авто зам дээр ямар нэгэн материал овоолохгүй;
- Барилга угсралтын үед онцгой тохиолдолд гарч замын цагдаагаас зөвшөөрөл өгөөгүй бол замын хөдөлгөөнд өөрчлөлт оруулахгүй;
- Орон нутгийн иргэдийн түвшинд болон төслийн хэрэгжилтэд оролцож тээвэрт ашиглах тээврийн хэрэгслийг жолоодох жолооч нарт аюулгүй байдлын талаар боловсрол олгох хүчин чармайлт гаргана;
- Жолооч нарт аюулгүй байдлын тал дээр онцгой анхаарал хандуулах;
- Жолоодох чадварыг сайжруулах, жолооч нарыг үнэмлэхтэй байхыг шаардах;
- Аялалын хугацааны хязгаарыг баталж, жолооч нарын ээлжийг зохион байгуулж хэт ядралтаас сэргийлэх;
- Осол аваар гарах эрсдэлийг бууруулах үүднээс аюулгүй зам, цагт хөдөлгөөнд оролцохгүй байх;
- Ачааны машинд хурд хянах төхөөрөмж (governor) ашиглах ба жолоочийн үйлдлийг зайнаас ажиглах;
- Тоног төхөөрөмж доголдох эсхүл хугацаанаас эрт ашиглалтаас гарах зэрэг шалтгааны улмаас ноцтой осол аваар гарах боломжийг бууруулах зорилгоор тээврийн хэрэгсэлд тогтмол засвар үйлчилгээ хийж, үйлдвэрлэгчийн баталсан эд ангиудыг ашиглах;
- Барилгын тээврийн хэрэгсэлтэй явган хүн харилцан үйлчлэлд орох боломжийг багасгах;
- Сургуулийн ойролцоо сунгасан зам эсхүл хүүхэд байж болох бусад газруудад тэмдэг тэмдэглэгээ, түүний харагдах байдал хийгээд замын аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр орон нутгийн иргэд, хариуцсан эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах. Замын хөдөлгөөний болон явган хүний аюулгүй байдлын талаар боловсрол олгох тал дээр орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах (жишээ нь: сургуулийн боловсролын аян зарлах);
- Осол аваар гарсан тохиолдолд зохих анхны тусламжийг үзүүлэх талаар яаралтай тусламж үзүүлэгч нарыг зохион байгуулах;
- Боломжтой бол орон нутгийн гаралтай материалыг ашиглаж тээврийн зайг багасгах. Ажилчдын кэмп зэрэг төсөлтэй холбоотой байгууламжуудыг төслийн талбайтай ойрхон байршуулж гадаад хөдөлгөөнийг багасгах үүднээс ажилчдын автобусыг зохион байгуулах.

**с) Аж үйлдвэрийн салбарт ашиглах тээврийн хэрэгслийг жолоодох ба төслийн талбайн хөдөлгөөн**

Туршлагагүй эсхүл муу сургагдсан аж үйлдвэрийн салбарт ашигладаг тээврийн хэрэгслийн жолооч нар бусад тээврийн хэрэгсэл, явган хүн болон тоног төхөөрөмжийг мөргөж гэмтээх эрсдэл өндөр байдаг. Аж үйлдвэрийн салбарт ашигладаг тээврийн хэрэгсэл болон хүргэлтийн тээврийн хэрэгслүүд төдийгүй төслийн талбай дээрх хувийн тээврийн хэрэгслүүд осол аваар гарах бий болох эрсдэлийг бүрдүүлдэг. Аж үйлдвэрийн салбарт ашигладаг тээврийн хэрэгслийг жолоодох ба төслийн талбайн хөдөлгөөний аюулгүй байдлын туршлага:

- Ажилтан тус бүрт ногдох талбай нь материал, бүтээгдэхүүнийг тээвэрлэх, түр хадгалах зэрэг бүх үйл ажиллагааг аюулгүй гүйцэтгэхэд хангалттай байна;
- Сэрээт өргөгч гэх мэт тусгай тээврийн хэрэгслийг аюулгүй ачилт, буулгалт хийх, ачааллах хязгаарыг давуулахгүй ажиллах зэрэг аюулгүй ажиллуулах чиглэлээр оператор нарыг сургаж, гэрчилгээ олгох;
- Жолооч нарыг эмнэлгийн үзлэгт хамруулах;
- Арын үзэгдэх орчин хязгаарлагдмал эргэдэг төхөөрөмжийг дуут дохиогоор тоноглон байх;
- Зөв хийх арга, талбайн хурдны хязгаар, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх шаардлага, ажиллуулах дүрэм ба журам (жишээ нь: сэрээ нь доошоо харсан байрлалд байхад сэрээт өргөгчийг ажиллуулахыг хориглох), замын хөдөлгөөний чиглэл, замыг хянах хяналтыг тогтоох;
- Хүргэлтийн болон хувийн тээврийн хэрэгслийн эргэлтийг тодорхой чиглэл, бүсээр хязгаарлаж, шаардлагатай бол "нэг чиглэлийн" эргэлтэд давуу эрх олгох.

#### **d) Гол замын тэмдэг, байгууламжууд**

- Барилгын талбайг машины замаас дор хаяж 2 мм-ийн зузаантай 1.8 м-ээс дээшгүй өндөртэй цайрдсан төмрөн атираат самбар (ногоон)-аар хийсэн хаалтаар тусгаарлана. Барилга угсралтын аюулгүй байдал, соёлтой барилга байгууламжийн тухай уриа лоозон барьж, гадны хүмүүсийг барилгын талбайд нэвтрүүлэхгүй байх.
- Барилгын талбайн тэмдэглэгээ нь нүдэнд харагдахуйц байна. Барилга угсралтын талбайгаас урагшаа болон хойшоо тодорхой зайд "Үүгээр өнгөр, урд барилгын ажил явагдаж байна" эсхүл "Хурдаа сааруул; Бүтээн байгуулалтын ажил явагдаж байна" гэх мэт тэмдгийг байрлуулна. Шөнийн цагаар анхааруулах гэрлээр бүрэн хангана.
- Барилгын орох, гарах хэсэгт тодорхой тэмдэглэгээг хийж өгч, зам барилгын механизм, өөрөө буулгагч машин барилгын талбайд орж, гарах үедээ барилгын бус тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөхөөс сэргийлэх, саад болох явдлыг бууруулахын тулд замын засвар үйлчилгээг хариуцсан тусгай ажилтныг томилно.
- Замын хөдөлгөөний удирдлагын байгууллагатай хамтран төрөл бүрийн уулзвар, түр замд замын хөдөлгөөний чиглүүлэх түр тэмдэг, хориглох тэмдгийг байрлуулж, түр замын хөдөлгөөнийг зөв зохион байгуулахад замын хөдөлгөөний удирдлагын байгууллагад туслалцаа үзүүлнэ.

#### **IV. Онцгой байдлын төлөвлөгөө**

Онцгой байдлын төлөвлөгөөг барилга угсралтын үеэр гарч болох хөдөлгөөний эрсдэлд үндэслэн боловсруулна. Үүнд:

- (i) Барилгын талбайг машины замаас дор хаяж 2 мм-ийн зузаантай 1.8 м-ээс дээшгүй өндөртэй цайрдсан төмрөн атираат самбар (ногоон)-аар хийсэн хаалтаар тусгаарлана. Барилга угсралтын аюулгүй байдал, соёлтой барилга байгууламжийн тухай уриа лоозон барьж, гадны хүмүүсийг барилгын талбайд нэвтрүүлэхгүй байх.
- (ii) Барилгын талбайн тэмдэглэгээ нь нүдэнд харагдахуйц байна. Барилга угсралтын талбайгаас урагшаа болон хойшоо тодорхой зайд "Үүгээр өнгөр, урд барилгын ажил явагдаж байна" эсхүл

"Хурдаа сааруул; Бүтээн байгуулалтын ажил явагдаж байна" гэх мэт тэмдгийг байрлуулна. Шөнийн цагаар анхааруулах гэрлээр бүрэн хангана.

- (iii) Барилгын орох, гарах хэсэгт тодорхой тэмдэглэгээг хийж өгч, зам барилгын механизм, өөрөө буулгагч машин барилгын талбайд орж, гарах үедээ барилгын бус тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөхөөс сэргийлэх, саад болох явдлыг бууруулахын тулд замын засвар үйлчилгээг хариуцсан тусгай ажилтныг томилно.
- (iv) Замын хөдөлгөөний удирдлагын байгууллагатай хамтран төрөл бүрийн уулзвар, түр замд замын хөдөлгөөний чиглүүлэх түр тэмдэг, хориглох тэмдгийг байрлуулж, түр замын хөдөлгөөнийг зөв зохион байгуулахад замын хөдөлгөөний удирдлагын байгууллагад туслалцаа үзүүлнэ.

Ажиллагсдын онцгой байдлын үеэр хариу арга хэмжээ авах чадавхыг сайжруулахын тулд холбогдох сургалт, дадлага сургуулилтад хамруулна.